



CORPUS SCRIPTORUM

TOMUS I

ЦЭНДИЙН БАТТУЛГА

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА
ДУРСГАЛУУД

Тэргүүн дэвтэр

УЛААНБААТАР

2005

УЛСЫН ХУУЛЬ
СЭНГЭЛ
* УЛСЫН ХУУЛЬ *
СЭНГЭЛ
* УЛСЫН ХУУЛЬ *
СЭНГЭЛ
* УЛСЫН ХУУЛЬ *



CORPUS SCRIPTORUM

TOMUS I

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СӨЁЛЫН СУРГУУЛЬ
ТҮРЭГ СУДЛАЛЫН ТӨВ

ЦЭНДИЙН БАТТУЛГА

**МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА
ДУРСГАЛУУД**

Тэргүүн дэвтэр

Эрхилэн нийтлүүлсэн профессор Ц.Шагдарсүрэн

УЛААНБААТАР
2005

DDC
494.23
Б-33

ЦЭНДИЙН БАТТУЛГА

Монголын руни бичгийн бага дурсгалууд

Хэвлэлийн эхийг цахим бичүүрт бэлтгэсэн Ц. Баттулга

ADMON ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN 99929-0-419-4

©2005, ЦЭНДИЙН БАТТУЛГА

CORPUS SCRIPTORUM цувралын тухайд

МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Түрэг судлалын төв (тэнхим) Монгол нутгаас олдсон эртний үсэг бичиг болоод монголчуудын хэрэглэж асан үсэг бичгийн хосгүй дурсгалуудын судалгааг нийтийн хүртээл болгох, ер үсэг бичгийн судлалыг хөхиүлэн дэмжих зорилгоор **CORPUS SCRIPTORUM** (Үсэг бичгийн чуулган) хэмээх цувралыг эрхилэн гаргаж байх болно.

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД номын тухайд

Монгол нутаг руни үсэг бичгээрээ нэн алдартай, тиймээс ч уг үсэг бичгийн дурсгалыг гадаад, дотоодын эрдэмтэд судлан шинжилж олон арван бүтээл туурвижээ. Тэдгээр судалгаа бүтээл Монголын руни бичгийн сонгодог дурсгалууд болох Билгэ хаан, Көлтигин, Туньюкук нарын зэрэг томоохон гэрэлт хөшөөний бичээсийг гол төлөв уншиж орчуулан судлахад чиглэгдэж байжээ.

Харин ганц хоёр буюу нэжгээд мөрөөс бүтэх “бага бичээс”-ийг тухайлан судалсан нь харьцангуй цөөн ажээ.

Ийм учраас “*Монголын руни бичгийн бага дурсгалууд*”-ыг гурван дэвтэр болгон хэвлэн нийтлэж судалгааны эргэлтэд оруулахыг зорьж буй билээ.

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД, Тэргүүн дэвтэр-т

-манай эрдэмтдийн туурвисан руни бичгийн холбогдолт ном зохиолд урьд өмнө хэвлэгдэж байгаагүй,

- судалгааны эргэлтэд орсон ч алдаа мадаг ихтэй,

- шинээр олдсон гэсэн үндсэн гурван шалгуурыг баримтлан энэ удаад руни бичгийн 12 бага дурсгал, бичээсийг сонгон орууллаа.

Тэдгээр 12 бичээс тус бүрийн эхийн сийрүүлэг, үсэг, үгийн галиг хийж зарим үгийн тайлбар, дурсгалд гарах үгийн толь хавсаргасан болно.

Хавсралтад цаашид нягтлан судлахад тус дэм болох үүднээс бичээс бүрийн дардасын болон эхийн гэрэл зургийг оруулав.

Бидний судалгааны ажилд алдаа эндэл, ташаа мадаг буй аваас шүүн үзэх мэргэд тольдон болгоож санал бодлоо харамгүй хайрлана уу.

Зохиогч

УДИРТГАЛ

1.1. МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН СУДЛАЛЫН ТҮҮХЭН ТОЙМ

1. Монголын руни буюу Орхон-Енисейн бичгийн судлалын нэгдүгээр үе (1889-1910-аад он)
2. Монголын руни бичгийн судлалын хоёрдугаар үе (1950-1980-аад он)
3. Монголын руни бичгийн орчин үеийн судалгаа (1990-ээд оноос хойш)

Монгол орны нэгэн гайхамшиг нь эртний үсэг бичгийн дурсгал бөгөөд монгол нутгаас брахми, согд, руни, уйгур, хятан, зөрчин, монгол, нангиад, ланз, сири, араб, перс, төвд, самгарди, дөрвөлжин, тод, манж, соёмбо, вагиндра зэрэг олон зүйлийн үсэг бичгээрх гэрэлт хөшөө, хад чулууны бичиг дурсгал олныг үзэж болно.

Үсэг бичгийн хосгүй гайхамшигт тэдгээр сурвалжуудаас руни бичгийн дурсгал олдож илэрсэн тоо хэмжээ, бичээсийн утга агуулга, илэрхийлэх уран яруу өгүүлэмжээрээ онцгой ялгардаг.

Монголын руни бичгийн дурсгалыг анх хэн олж илрүүлсэн, хэрхэн уншиж судалсан талаар дотоод гадаадын эрдэмтдийн олон арван бүтээлд тодорхой тэмдэглэгдэж бичигдсээр иржээ.

Хэдийгээр тийм боловч Монголын руни бичгийн дурсгалын судалгааг гурван үе шатанд хуваан товч өгүүлье.

1. Монголын руни буюу Орхон-Енисейн бичгийн судлалын нэгдүгээр үе (1889-1910-аад он)

Анх 1889 онд Николай Михайлович Ядринцев (1842-1894)-ийн удирдсан Оросын Газарзүйн Нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний анги Монгол оронд ирж Орхон голын хөндийд хосгүй хөшөө дурсгал буйг үзэж дэлхий дахинд мэдээлжээ¹.

1890 онд Москва хотод болсон Олон Улсын Археологийн VIII Хурлын үеэр Н.М.Ядринцев Монгол нутаг Орхоны хөндийгөөс эртний бичигт асар том, хөшөө дурсгал олсныг уг хуралд оролцсон Отто Доннер (Otto Donner, 1835-1909) , Р.Ашпелин (Johan Reinhold Aspelin, 1842-1915) нар анх сонсож улмаар түүнийг судлан шинжлэх их эрмэлзэл өвөрлөн буцаж Фин-Угорын нийгэмлэгээс А.Хейкел (Axel Olai Heikel, 1851-1924)-ээр удирдуулсан шинжилгээний ангийг 1890 онд Монгол оронд илгээсэн байна.

Археологич Р.Ашпелин нь 1888 онд Минусинскийн музейд буй Енисейн бичээсийн дурсгалын хуулбар авч судлахаар ажилласан нэгэн байсан билээ. Тэрээр Монгол оронд ирж улмаар 1890 оны 8-р сарын 16-наас Келтигин, Билгэ хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээсийн хэв дардас, хуулбар авсан гэдэг.

А.Хейкел асар холын замыг туулж олон гайхамшигт дурсгал үзсээр Иркутск, Томскоор өртөөлж 1891 оны 6 дугаар сард Хелсинкт буцаж хүрсэн байна. А.Хейкелийн удирдсан эл шинжилгээний ангийн ажлын үр дүнд Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсийн хуулбар болон бусад дурсгалын гэрэл зургийг багтаасан цомог ном хэвлэгдэн гарчээ².

¹ Н.М.Ядринцев, Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, -Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892, стр.27-40; Н.М.Ядринцев, Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд. Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892; Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году, - Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр.1-54.

² A.Heikel, Inscriptions de L'Orkhon recueillies par l'expédition finnoise 1890, et publiées par la Société Finno-Ougrienne, Helsingfors, 1892.

Тус хээрийн шинжилгээний ажлын үр дүнд нангиадч Георг Габеленц (Georg von Gabelentz, 1840-1893) Көлтигиний гэрэлт хөшөөний нангиад бичээсийг, нангиадч Габриел Девериа (Gabriel Deveria, 1844-1889) Билгэ хааны болон Хар балгасын гэрэлт хөшөөний нангиад бичээсийг тус тус орчуулсан байна.

Энэхүү судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээр нангиад сурвалжид “突厥 tujue” гэж гардаг нэгэн овог аймагтай холбоотой гэсэн таамаглалыг дэвшүүлж, Г.Хейкел цахилгаан утсаар Отто Доннерт мэдээлсэн гэдэг.

Отто Доннер (Otto Donner, 1835-1909) Енисей хийгээд Орхон бичгийн үсгийн харьцуулал, Көлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсийн “үсгийн цэс (the graphic index)” хийсэн бөгөөд Енисейн бичээсийн 34 дурсгалын “үсгийн толь (graphic dictionary)”³ хэвлүүлсэн ажээ. Фин-Угорын нийгэмлэгийн энэхүү эрдэм шинжилгээний идэвхтэй үйл ажиллагаа руни бичгийн дурсгалыг тайлж унших, судлахад асар их нөлөө үзүүлсэн төдийгүй эрдэмтэн, судлаачдын анхаарлыг ч тэр зүг хандуулж чадсан ажээ.

Оросын Шинжлэх Ухааны Академиас 1891 онд Монгол оронд эрдэм шинжилгээний тусгай ангийг В.В.Радлов (Wilhelm Radloff, 1837-1918)-оор удирдуулан Н.Ядринцев, С.М.Дудин, Д.Клеменц нарын зэрэг хэд хэдэн судлаачдын бүрэлдэхүүнтэй илгээжээ.

В.В.Радловын удирдсан шинжилгээний анги Орхоны хөндий дэх дурсгалыг судалж хэв дардас авсан төдийгүй бас бага бичгийн зарим дурсгалыг олж илрүүлжээ. Тус хээрийн шинжилгээний анги ажлын үр дүнгээ руни бичгийн том, бага олон дурсгалуудын хэв дардас, тахилын байгууламж, хүн чулуу, зэл чулуу зэрэг холбогдох бусад дурсгалын гэрэл зураг сэлтийг багтаасан цомог ном болгон гаргажээ⁴.

В.В.Радловын удирдсан шинжилгээний ангийн урьдчилсан судалгаа болон Орхоны дурсгалтай холбогдох бусад эрдэм шинжилгээний бүтээлүүд цувралаар гарчээ⁵. Тухайлбал В.Радловын урьдчилсан судалгааны таван өгүүллийг О.Халлер (O.Haller) герман хэлнээ орчуулсан байна.

Дээрх олон судалгааны эцсийн үр дүн тэдгээр хөшөө дурсгалын бичээсийг уншиж тайлахад оршиж байлаа.

Орхон ба Енисейн сав нутгаас олдсон эртний үл тайлагдах бичгийг анх Копенхагений их сургуулийн профессор, хэл шинжээч Вильхелм Людвиг Петер Томсен (Vilhelm Ludvig Peter Thomsen, 1842-1927) тайлан уншжээ.

Тэрээр Саами бичгийн нэг үгэнд нэгдүгээр үеэс хойш тохиолдох эгшгийг гэж бичих тогтолцоотой адил төсөөтэйг ухаарч, мөн үгийн төгсгөлд тохиолдох хамаатуулах төлөөний нэрийн й-и нөхцөл буйг анх олж тогтоосон байна.

Энэ тогтолцоонд тулгуурлан анх ᠳᠠᠬᠠ ᠰᠠᠭᠠᠨ -хаан, ᠲᠦᠭᠦᠨ ᠲᠦᠭᠦᠨ гэх үгийг уншсан ажээ. Эдгээр үгэнд орох үсэг бүхгүй ᠮᠦᠨᠦᠮᠦᠨ kül tig'n – көл тигин, ᠲᠦᠭᠦᠨ ᠶᠮᠦᠨ kōk ᠲᠦᠭᠦ-хөх тэнгэр гэдэг үгийг удаагаар тайлж улмаар ᠲᠦᠭᠦᠨ türk-түрэг, ᠬᠦᠭᠦᠨ tört-дөрөв, ᠮᠦᠨ kün-нар, ᠲᠦᠭᠦᠨ y'g'mi-хорь (хорин), ᠲᠦᠭᠦ ᠲᠦᠭᠦ-зураа, ᠲᠦᠭᠦ y'g-газар мэт үсгийг уншиж чадсан байна.

Ийнхүү 1893 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр энэ бичгийн дурсгалыг тайлан унших түлхүүр цагаан толгойг Вильхелм Людвиг Петер Томсен олжээ.

1883 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Дани улсын эзэн хааны эрдэм шинжилгээний нийгэмлэгийн хуралд “Déchiffrement des inscriptions de l'Orkhon et de l'Énéissei. Notice

³ Otto Donner, Wörterverzeichnis zu den Inscriptions de l'Énéissei, Helsingfors, 1892.

⁴ Атлас Древностей Монголии, Изданный по поручению Императорской Академии наукъ В.В.Радловымъ, - Труды Орхонской Экспедиции, Санктпетербургъ, 1892.

⁵ В.В.Радлов, Предварительный отчет о результатах экспедиции для археологического исследования бассейна р. Орхона, - Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892; W.Radloff, Vorläufiger Bericht über die Resultate der mit allerhöchster Genehmigung von der kaiserlichen Akademie der Wissenschaften ausgerüsteten Expedition zur archäologischen Erforschung des Orkhon-Beckens, Aus dem Russischen übersetzt von O. Haller, - Bulletin de l'Académie Impériale des Sciences de St.-Petersbourg, 1894, N S III (XXXV) pp.353-398; Mélanges Asiatiques, X/2, 1892, pp.392-436.

préliminaire”(Орхон ба Енисейн бичээсийг судалсан урьдчилсан тайлан илтгэл гэж М.Шинэхүү орчуулжээ) илтгэл хэлэлцүүлж уг бичээс нь 38 үсэгтэй авианы бичиг болохыг тогтоосон бөгөөд алдарт энэ нээлтээ 15 хуудсанд багтаан тайлбарласан ажээ⁶.

В.Томсен бичээсийг уншсан тухайгаа В.Радловт мэдэгдэж удалгүй өөрийнхөө илтгэлийн нэг хувийг түүнд илгээсэн байна.

Тэр үед В.В.Радлов 11 үсэг тэмдэгт (15 гэж бичсэн ч буй)-ийг тайлаад байсан гэдэг. Тэрбээр В.Томсений нээлт болон өөрийн судалгаандаа тулгуурлан Орхон болон Енисейн бичээсүүдийг уншиж судлах ажлаа маш эрчимтэй хийж цуврал бүтээлүүдээ нийтлүүлсэн бөлгөө.

Тэргүүн дэвтэр нь “Die alttürkischen Inschriften der Mongolei” (*Erste Lieferung: Die Denkmäler von Koscho-Zaidam (Text, Transcription und Übersetzung)*)⁷ нэртэйгээр 1894 онд хэвлэгдсэн аж.

Удаах дэвтэр “Die alttürkischen Inschriften der Mongolei” (*Zweite Lieferung: Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmäler von Koscho-Zaidam (Glossar, Index und die chinesischen Inschriften, übersetzt von W.P. Wassiljew)*)⁸ нэртэйгээр хэвлэгдсэн байна.

Энэ дэвтэртээ Уйгурын Хар балгасын гэрэлт хөшөөний нангиад бичээсийг уншиж тайлсан В.П.Васильевийн судалгаа орчуулгыг хамтатгасан байна.

Гутгаар дэвтэр “Die alttürkischen Inschriften der Mongolei” (*Dritte Lieferung: Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, die übrigen Denkmäler des Orchon-Beckens und die Denkmäler im Flußgebiete des Jenissei*)⁹ нь 1895 онд хэвлэгджүүхүй. 1987 онд эл гурван дэвтрийг эмхэтгэн “Die alttürkischen Inschriften der Mongolei”(Band: 1, Enthält die Lieferungen 1-3)¹⁰ хэмээх нэрээр цувралын нэгдүгээр боть болгон хэвлэжээ.

Уг боть их, бага 55 бичээсийн уншлага, галиг, орчуулгыг багтаасан нийт 460 (XI-460 pp.) хуудас, “Die alttürkischen Inschriften der östlichen Mongolei”, “Die alttürkischen Inschriften im Flussgebiete des Jenissei”, “Alphabetisches Verzeichniss der Steine” гэсэн үндсэн гурван бөлгөөс бүрдэх бөлгөө.

“Дорнод Монголын эртний түрэг бичээсүүд” хэмээх тэргүүн бөлөгт Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсийн бүрэн галиг, орчуулга, Онгийн гэрэлт хөшөө, Уйгурын Хар балгасын гэрэлт хөшөө, Их Хануй нуур, Хөл Асгат, Тайхар чулууны бичээсийн галиг орчуулга багтсан байна.

“Енисейн сав нутгийн эртний түрэг бичээсүүд” хэмээх удаах бөлөгт Енисей (Горлог)-н сав нутгаас олдсон 40 бичээсийн галиг орчуулга бүрнээ багтсан ажээ.

“Дурсгал (гэрэлт хөшөө, хад чулууны бичээс)-ын цагаан толгойн дараалалд оруулсан бүртгэл” хэмээх гутгаар бөлөгт бүх бичээсийг цагаан толгойн дараалалд оруулан жагсаажээ.

Нэрт эрдэмтэн В.Радлов эртний түрэгийн бичгийн дурсгалын хэлзүйн талаарх бүтээлээ 1897 онд “Die alttürkischen Inschriften der Mongolei” (Neue Folge: Grammatiche Skizze der alttürkischen Inschriften)¹¹ хэмээх нэрээр хэвлүүлсэн ажээ.

“Эртний түрэг бичээсийн хэлзүйн тойм”-доо Авианзүй (Zur Phonetik der alttürkischen Sprache), Үгзүй (Zur Morphologie der alttürkischen Sprache), Өгүүлбэрзүй (Zur Syntax der

⁶ Thomsen, Déchiffrement des inscriptions de l'Orkhon et de l'Iénissei. Notice préliminaire, -Bulletin de l'Académie Royale des Sciences et des Lettres de Danemark, 1893, Copenhague 1894, pp.285-299.

⁷ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Erste Lieferung: Die Denkmäler von Koscho-Zaidam (Text, Transcription und Übersetzung, Neudruck der Ausgabe St.Petersburg, 1894.

⁸ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Zweite Lieferung: Die Denkmäler von Koscho-Zaidam (Glossar, Index und die chinesischen Inschriften, übersetzt von W.P. Wassiljew), St.Petersburg, 1894.

⁹ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Erste Lieferung: Die Denkmäler von Koscho-Zaidam (Text, Transcription und Übersetzung), St.Petersburg, 1894.

¹⁰ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Band: 1, Enthält die Lieferungen 1-3, Osnabrück, 1987.

¹¹ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Neue Folge: Grammatiche Skizze der alttürkischen Inschriften, St.Petersburg, 1897.

alttürkischen Sprache)-н хүрээ (төвшин)-нд руни бичгийн дурсгалын буюу эртний түрэг хэлний хэлзүйг авч үзсэн байна.

Уг номд нэрт түүхч В.Бартольд "Эртний түрэгийн бичгийн дурсгалын түүхэн ач холбогдол" гэдэг 36 хуудас томоохон өгүүлийг хавсаргасан бөлгөө¹².

Тэрбээр 1889 онд хэвлүүлсэн бүтээлээ Туныюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн эх бичиг, хэл, түүхийн судалгаанд зориулжээ¹³. Энэ номыг В.Радлов, Ф.Хирт, В.Бартольд нарын хамтын бүтээл гэж үзэж болохоор аж. В.Радлов "Туныюкукийн гэрэлт хөшөөний бичээс (Die Inschriften des Tonjukuk /Vorwort, Text, Transcription und Uebersetzung)"-ийн эх бичиг, хэлзүйн судалгааг оруулсан байна. В.Радловын эл бүтээл 25 хуудас өмнөх үг, 122 хуудас судалгаанаас бүрдэнэ.

Фридрих Хиртийн "Тоныюкукийн бичээст зориулсан төгсгөлийн үг (Hangiad эх сурвалжийн VII-VIII зууны дорнод түрэгийн түүхнээ оруулах хувь нэмэр) [Куллузийн үе (Илтирив хаан)], ("Nachworte zur Inschrift des Tonjukuk" (Beiträge zur Geschichte der Ost-Türken im 7. und 8. Jahrhundert nach Chinesischen Quellen) [Zeit des Ku-tu-lu (Ilteres Khan)])¹⁴ хэмээх 140 хуудас томоохон бүтээл оржээ.

Василь Владимирович Бартольд (1869-1930)-ын бичсэн "Эртний түрэгийн бичээсүүд болон араб сурвалжууд" (Die Altürkischen Inschriften und die arabischen Quellen) нэртэй 36 хуудас томоохон өгүүлийг энд мөн хавсаргасан байна¹⁵.

Эл бүтээлийн дараа уг бичээсийг анх тайлж уншсан Вильхелм Томсен "Inscriptions de l'Orkhon déchiffrées" хэмээх 127 хуудас бүхүй томоохон бүтээл хэвлүүлжээ¹⁶. Тэрээр мөн "Études concernant l'interprétation des inscriptions turques de la Mongolie et de Sibérie" (Монгол ба Сибирийн түрэг бичээсүүдийн тайлбартай холбогдох судалгаа)¹⁷ гэдэг 101 хуудас бүхүй бүтээлээ туурвисан ажээ. Тус бүтээл В.Радловын судалгааны зарим алдаа мэдгийг зассан чамбай сайн бүтээл болсон хэмээн дэлхий нийтийн түрэг судлаачид ихээхэн үнэлсэн байдаг билээ.

В.Томсен уг номдоо Келтигин, Билгэ хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээсийн уншлага, галиг, франц орчуулгаас гадна Келтигиний гэрэлт хөшөөний нангиад бичээсийг Е.Х.Паркер (Е.Н.Паркер)-ийн орчуулгаар хавсарган хэвлүүлжээ.

Е.Х.Паркер Орхон бичгийн талаар тусгай өгүүлэл бичиж 1899 онд Шанхайд хэвлүүлсэн байдаг¹⁸.

Платон Михайлович Мелиоранский (1868-1906) Орхон ба Енисейн бичгийн судлалд ихээхэн хувь нэмэр оруулсан бүтээлүүд¹⁹ туурвиж байсныг энд дурдах нь зүйтэй. Тэрээр В.В.Радловын хамт Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний галиг, орос орчуулгыг хийжээ.

¹² W.Barthold (Nebst einer Abhandlung von W.Barthold), Die historische Bedeutung der alttürkischen Inschriften, - Die alttürkischen Inschriften der Mongolei, St.Petersburg, 1894, (36 pp).

¹³ W.Radloff, Die alttürkischen Inschriften der Mongolei, Zweite Folge, Neudruck der Ausgabe St.Petersburg 1899 (W.Radloff, Die Inschrift des Tonjukuk, Fr.Hirth, Nachworte zur Inschrift des Tonjukuk, W.Barthold, Die alttürkischen Inschriften und die arabischen Quellen).

¹⁴ Friedrich Hirth, Nachworte zur Inschrift des Tonjukuk (Beiträge zur Geschichte der Ost-Türken im 7. und 8. Jahrhundert nach Chinesischen Quellen) (Zeit des Ku-tulu (Ilteres Khan)), - Die alttürkischen inschriften der Mongolei, Neue Folge, St.Petersburg 1895, (140 pp).

¹⁵ W.Barthold, Die Altürkischen Inschriften und die Arabischen Quellen, - Die alttürkischen inschriften der Mongolei, Band 2: Enthält Neue Folge und 2. Folge, St.Petersburg 1895; Osnabürck, 1987.

¹⁶ Vilh. Thomsen, Inscriptions de l'Orkhon déchiffrées, -Mémoires de la Société Finno-Ougrienne V, Helsinki, 1896.

¹⁷ Vilhelm Thomsen, Études concernant l'interprétation des inscriptions turques de la Mongolie et de Sibérie, - Mémoires de la Société Finno-Ougrienne XXXVII, Helsinki, 1916.

¹⁸ E.H.Parker, Inscriptions de l'Orkhon, -Journal of the China Branch of the Royal Asiatic Society XXXI/1. (1896-1897), Shanghai 1899, pp.1-38.

¹⁹ П.М.Мелиоранский, Древне-туркские памятники в Кошо-Цайдам, -Сборник трудов Орхонской Экспедиции IV, Санктпетербург, 1897, стр. 45; П.М.Мелиоранский, Памятник в честь Кюль-тегина, -Записки Восточного отделения Русского Географического общества, Том.XII, Санктпетербург, 1899, стр.1-144; П.М.Мелиоранский, Об орхонских и енисейских надгробных памятниках с надписями, -Журнал Министерство Народного Просвещения, Москва, 1938, VI, стр.226.

“Орхон” хэмээн нэрлэгдсэн энэ бичгийн дурсгалыг анх олж илрүүлсэн хийгээд уг бичээсийг тайлж уншсан судалгааны анхдагч бүтээлүүдийн тоймыг үүгээр хязгаарлаж 1889-1910-аад оныг руни бичиг судлалын оргил үе буюу руни бичгийн судлалын нэгдүгээр үед хамааруулан үзэх санал дэвшүүлэн төгсгөсү.

Тэмдэглэхэд, Енисейн бичээсийг анх олсон хийгээд судалсан тухай энд огт дурдсангүй нь нэгд, Монголын руни бичгийн дурсгалын судалгааны тойм учир, хоёрт, манай түрэг судлаач эрдэмтдийн болон түрэг судлалын, ялангуяа орос хэлээрх ном бүтээлд энэ талаар хангалттай өгүүлсэн байдаг тул нуршин давтахаас зайлсхийснийх билээ.

2. Монголын руни бичгийн судлалын хоёрдугаар үе (1950-1980-аад он)

Орхон-Енисейн бичээсийг судлах ажил нэг хэсэг завсардсан нь дэлхийн нэгдүгээр дайн, Октябрийн хувьсгал зэрэг тухайн үеийн түүхэн үйл явдалтай шууд холбоотой байсан бизээ.

Дэлхий нийтийг донсолгосон түүхэн үйл явдлууд эцэс болж шинжлэх ухаан хөгжих шинэ боломж дахин нээгдэж эхэлсэн байна.

Энэ үеэс шинжлэх ухааны бусад олон салбаруудын нэгэн адил түрэг судлал, руни бичгийн судлалын салбар хөгжиж шинэ бүтээл туурвилууд хэвлэгдэн гарах болжээ. Тэдгээрийн төлөөлөл жишээ болгож цөөн хэдэн бүтээлийг дурдъя.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун (Hüseyin Namık Orkun) эртний түрэг бичгийн дурсгалыг дөрвөн дэвтрээр орчин цагийн турк хэлнээ орчуулан гаргасан бөгөөд В.В.Радловын бүтээлийг гол сурвалж, эх хэрэглэгдэхүүн болгон авсан байна²⁰.

Талат Текин (Talat Tekin) Келтигин, Билгэ хааны зэрэг томоохон гэрэлт хөшөөний бичээсийн үгийн санд тулгуурлан эртний түрэг хэлний зүйг судлан томоохон бүтээл гаргажээ²¹. Мөн Мухаррем Ергин (Muharrem Ergin) Келтигин, Билгэ хаан, Туныюкукийн гэрэлт хөшөөний бичээсийг орчин цагийн турк хэлнээ хөрвүүлсэн нь өнөө 28 дахь удаагаа хэвлэгдсэн байна²².

Францын эрдэмтэн Р.Жиро (René Giraud) Туныюкукийн гэрэлт хөшөөний бичээсийг уншиж судлан “Баянцогтын бичээс” нэртэйгээр хэвлүүлсэн нь В.В.Радлов, В.Гомсен нарын судалгааг үргэлжлүүлсэн, руни бичгийн судлалын чухал бүтээл болжээ²³.

Германы эрдэмтэн А.ф.Габэн (Annemarie von Gabain) эртний түрэг, уйгурын бичгийн хэлний зүйг судлан “Alttürkische Grammatik” хэмээх шилдэг бүтээлд туурвижээ²⁴.

Ж.Клоузон (Sir Gerard Clauson) түрэг хэлний үгийн гарлын толь бичиг²⁵, М.Рясänen (Martti Räsänen)-ий эх хэрэглэгдэхүүн, бүтээлүүд зохиосон нь өнөө эртний түрэг, уйгур судлаачдад чухал эх хэрэглэгдэхүүн болсоор байгаа нэн чухал ач холбогдолтой бүтээлүүд болохыг тэмдэглэх нь зүйтэй²⁶.

²⁰ H.N.Orkun, Eski Türk Yazitlari, Istanbul, I. 1936, II.1938, III. 1940, IV. 194; [2. Baskı: 1987; 3. Baskı: 1994.]

²¹ Talat Tekin, A Grammer of Orkhon Turkic, Bloomington, 1968.

²² Muharrem Ergin, Orhun Abideleri, Boğaziçi Yayınları N: 95, Istanbul, 2002.

²³ René Giraud, L'inscription de Bañ Tsokto, Paris, 1961.

²⁴ A. von Gabain, Alttürkische Grammatik, -Porta Linguarum Orientalium, Sammlung von Lehrbüchern für das Studium der Orientalischen Sprachen, Herausgegeben von Richard Hartmann, Leipzig, 1950; A. von Gabain, Eski Türkçenin Grameri, Ankara, 1988. çeviren Mehmet Akalan [1. Baskı: 1988; 2. Baskı:1995; 3. Baskı: 2000].

²⁵ Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford 1972.

²⁶ Martti Räsänen, Die tschuwassischen Lehnwörter im Tscheremissischen, -Mémoires de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1920; Martti Räsänen, Die tatarischen Lehnwörter im Tscheremissischen, Helsinki, 1923; Martti Räsänen, Materialien zur Lautgeschichte der türkischen Sprachen, -Studia Orientalia, Helsinki, 1949; Martti Räsänen, Materialien zur Morphologie der türkischen Sprachen, Helsinki, 1957; Martti Räsänen, Versuch eines etymologischen Wörterbuchs der Türksprachen, Lexica Societatis Fenno-Ugricae 17:1, 2, Helsinki, 1969; 1971; Martti Räsänen, Материалы по исторической фонетике тюркских языков, пер. с нем. А.А.Юлдашева, Москва, 1955.

Түүхч Линь Ган(林幹)“Түрэгүүдийн түүх (突厥史)” хэмээх бүтээлдээ Гэн Ши Мин (耿世民 Geng Shi Min)-ний “Түрэг бичээст хөшөөний орчуулга (突厥文碑铭译文 tu jue wen bei ming yi wen)” буюу Туныокукийн гэрэлт хөшөөний бичээс (噶欲谷碑 tun yu gu bei), Көлтигиний гэрэлт хөшөөний бичээс (闕特勤碑 jue te qin bei), Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээс (毗伽可汗碑 pi jia ke han bei), Көличурын гэрэлт хөшөөний бичээс (闕利吸碑 jue li chuai bei), Моюнчурын хөшөөний бичээс (磨延吸碑(回鹘) mo yan chuai bei (hui gu); 磨延吸碑译文 mo yan chuai yi wen)-ийн нангиад орчуулгыг хавсаргасан байна.

Тэрээр мөн “Хятад улс дахь Түрэгийн түүх судлалын сүүлийн 60 гаруй жилийн судалгааны тойм (近六十年来(1919-1984)国内突厥史研究述评)”²⁷-ыг өгүүлжээ.

Уг тоймоос Хятад дахь “Түрэг судлал”-ын байдал төлөв, чиг хандлагыг бүрнээ мэдэж болно. Хятад улсад Түрэгийн түүхийн судалгаа давамгай хөгжиж байгаа нь эртний түүх шастирын баялаг өв сан байдагтай холбоотой биз ээ.

Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны дараа Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-д түрэг судлал нэн эрчимтэй хөгжиж түрэг судлалаар дэлхий дахинд тэргүүлэх байр суурь эзлэх болсон нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд Төв болон Дундад Азийн түрэг хэлтэн олон улс багтаж, тэдний түүх, хэл соёлыг судлах нийгэм, улс төрийн болоод бусад зайлшгүй шалтгаан байсантай холбоотой буй за.

Тухайн үед Зөвлөлт (Орос)-ийн эрдэмтдийн, түрэг судлалын сор болсон бүтээлүүд нийтлэгдэж эхэлсэн бөгөөд тэдний шилдэг туурвилууд одоо ч үнэ цэнэтэй хэвээр байгаа билээ. Иймд Зөвлөлт Холбоот Улсын эрдэмтдийн зарим бүтээлээс товч дурдсу.

С.Е.Малов 1951-1959 онуудад томоохон бүтээл туурвисан²⁸ нь түрэг судлаачдын ширээний ном болж байжээ.

Г.Айдаровын Монголын руни бичгийн сонгодог дурсгалын орчуулга, судалгаа²⁹, В.Г.Кондратьевийн эртний түрэг хэлзүйг судалсан бүтээл эдүгээ ч чухал ач холбогдолтой хэвээр байна³⁰. Мөн А.Н.Кононов “Грамматика языка тюркских рунических памятников (VII-IX вв.)” хэмээх номдоо эртний түрэг төдийгүй уйгур хэлний зүйд хамаарах олон асуудлыг хөндөж онолын үүднээс судлан тайлбарласан ажээ³¹. И.В.Стеблева Монголын руни бичгийн сонгодог дурсгалууд эртний түрэгийн яруу найраг, уран зохиолын хосгүй дурсгал мөн болохыг нуталсан бүтээл туурвижээ³².

В.М.Наделев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак нарын зохиосон³³ эртний түрэг хэлний толь энэ үеийн томоохон суурь бүтээлийн нэгд зүй ёсоор тооцогддог билээ.

Түүнчлэн Э.В.Севортяны³⁴ толиудыг ч дахин давтагдашгүй сайн бүтээл хэмээн эрдэмтэд санал нэгтэй тэмдэглэсэн нь буй.

²⁷ 林幹. 突厥史. 内蒙古人民出版社. 1988. 呼和浩特. pp.243-301; Lin Gan, Türgüd-ün teüke- Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, köke-qota, 1998, 391-465 duyar tal-a.

²⁸ С.Е.Малов, Памятники древнетюркской письменности, Москва-Ленинград, 1951; С.Е.Малов, Енисейская письменность тюрков, Москва-Ленинград, 1952; С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959.

²⁹ Г.Айдаров, Язык Орхонского памятника Билге-хагана, Алма-Ата, 1966; Г.Айдаров, Язык Орхонских памятников древнетюркской письменности VIII века, Алма-Ата, 1971.

³⁰ В.Г.Кондратьев, Очерк грамматики древнетюркского языка, Ленинград, 1970; В.Г.Кондратьев, Грамматический строй языка памятников древнетюркской письменности VIII-XI вв, Ленинград, 1981.

³¹ А.Н.Кононов, Грамматика языка тюркских рунических памятников (VII-IX в), Ленинград, 1980.

³² И.В.Стеблева, Поэзия тюрков VI-VIII веков, Москва, 1965.

³³ В.М.Наделев и друг., Древнетюркский словарь, Ленинград, 1969.

³⁴ Э.В.Севортян, Этимологический словарь тюркских языков, Том. 1, Москва, 1974, Том. 2, Москва, 1978; Том. 3, Москва, 1980.

Д.Д. Васильев³⁵, И.В.Кормушин³⁶, Л.Р.Кызласов³⁷ нарын Енисейн бичээс болон руни бичгийн талаарх судалгааг ч энд бас дурдах нь зүйтэй.

С.Г.Кляшторный руни бичгийн сонгодог дурсгал эртний түрэгний түүхэн сурвалж болохыг нуталсан ном бичсэнээс³⁸ гадна Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсгийг ахлан олон жил ажиллаж Монгол нутгаас олдсон олон бичээсийг уншиж тайлах судлал шинжлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Орост Түрэг судлал хөгжихөд “Тюркологический сборник”, “Советская Тюркология” сэтгүүлүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эртний Түрэг, Уйгурын түүх, археологи, соёл, угсаатны зүй, хэл шинжлэл зэрэг өргөн хүрээг хамарсан эрдэм шинжилгээний, хамгийн чанартай сэтгүүлүүд байв.

Түүнчлэн *Советская археология*, *Советская этнография* (Москва), *Советское Востоковедение* (Москва-Ленинград), *Studia Turcica* (Budapest), *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae* (Budapest), *Journal de la Société Finno-Ougrienne* (Helsinki), *Journal of the Royal Asiatic Society* (London), *Journal Asiatique* (Paris), *Zeitschrift der Deutschen Morgenländischen Gesellschaft* (Leipzig, Wiesbaden), *Sitzungsberichte der Königlich Preussischen Academie der Wissenschaften* (Berlin), *Harvard Journal of Asiatic Studies* (Cambridge, Mass), *Philologicae Turcicae Fundamenta* (Wiesbaden), *Rocznik Orientalistyczny* (Krakow/ Lwow/ Warszawa), *Ural-altaische Jahrbücher* (Weisbaden), *Türk Dili Araştırmaları Yıllığı Belleten* (Ankara), *Хэл зохиол судлал*, *Studia Linguae et Litterarum*, *Археологийн судлал*, *Studia Archaeologica*, *Түүхийн судлал* *Studia Historica*, *Mongolica*, (*Ulaambaatar*) зэрэг гадаад, дотоодын нэр хүндтэй сэтгүүлүүдэд руни бичгийн дурсгалтай холбогдох олон арван чанартай сайн өгүүлэл, бүтээл хэвлэгдэн гарсан бөгөөд одоо ч зарим сэтгүүл уламжлалаа хадгалсаар бөлгөө. Эрдэм шинжилгээний тэдгээр өгүүлүүд түрэг судлал, нэн ялангуяа монголын руни бичгийн судлалд ихээхэн хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Монголын руни бичгийн судлалын хоёрдугаар үед холбогдох Мажар, Франц, Япон, Финлянд, Америк, Чех, Польш, Англи, Хятад, Швед зэрэг олон орны эрдэмтдийн бүтээл туурвилаас тэр бүр оруулж эс чадсандаа хүлцэл өчсү.

Монгол нутаг дахь руни бичгийн судлалын хөгжилд 1969 оноос эхлэн 1980-аад оны дунд үе хүртэл үргэлжилсэн “Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедиц”-ийн хадны зураг, бичээс судлалын хэсэг ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Монголын руни бичгийн дурсгалын бараг талаас илүү хувийг энэхүү хээрийн шинжилгээний анги олж илрүүлсэн ба шинжилгээний ажлын үр дүн хамтын бүтээл бус дан ганц судлаач эрдэмтний судалгааны өгүүллийн хэлбэрээр хэвлэгдэж байснаараа онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, 20 илүү жилийн судалгааны дүнг нэгтгэсэн хамтарсан цогц бүтээл гараагүй байна. М.Шинэхүү гуайн төлөвлөсөн “*Орхон бичгийн атлас*” нь хамтын бүтээл болж хэвлэгдэх байсан³⁹ буй за.

³⁵ Д.Д. Васильев, К вопросу о культурно-письменных центрах Тюркского каганата, -(И.Я.Бичурин и его вклад в русское востоковедение, К 200-летию со дня рождения) Материалы конференции, Часть 2, Москва, 1977; Д.Д. Васильев, Графический фонд памятников тюркской рунической письменности азиатского ареала, Москва, 1983; Д.Д. Васильев, Корпус тюркских рунических памятников бассейна Енисея, Ленинград, 1983.

³⁶ И.В.Кормушин, К основным понятиям тюркской рунической палеографии, -Советская тюркология, №2, Баку, 1975; И.В.Кормушин, Текстологические исследования по древнетюркским памятникам I, -Тюркологический сборник 1977, Москва, 1981.

³⁷ Л.Р.Кызласов, Новая датировка памятников енисейских письменности, - Советская археология, №3, Москва, 1960; Л.Р.Кызласов, О значении термина балбал древнетюркских надписей, -Тюркологический сборник, Москва, 1966; Л.Р.Кызласов, О датировке памятников енисейской письменности, - Советская археология, №3, Москва, 1965.

³⁸ С.Г.Кляшторный, Древнетюркские рунические памятники как источники по истории Средней Азии, Москва, 1964.

³⁹ М.Шинэхүү, гар бичмэл, мөн *1.5.0. Манай эрдэмтдийн туурвисан руни бичгийн холбогдолт нам хэсгээс* үзнэ үү.

3. Монголын руни бичгийн орчин үеийн судалгаа (1990 оноос хойш)

Бид 1990 оноос хойшхи, Монгол нутаг дахь руни бичгийн судалгааны хамтарсан төсөл, бичил судалгааг энэ хэсэгт хамааруулан өгүүлэхийг хичээлээ. 1990 оноос хойш буюу сүүлийн арав гаруй жилийн хугацаанд гадаадын эрдэмтдтэй хамтарсан, руни бичгийн судлалд холбогдох томоохон хоёр төсөл хэрэгжиж судалгааны урьдчилсан үр дүн ном болж хэвлэгдэн гарсан байна.

Руни бичгийн шинэ шинэ дурсгалууд Алтай нутаг, Баян-Өлгий аймгаас хэд хэд олдсон бөгөөд тэдгээр бичээсийг уншиж тайлах, судлан шинжлэх ажил ч цаг алдалгүй хийгдсээр ажээ.

1. Монгол-Японы эрдэмтдийн хамтарсан судалгаа

1990 оны сүүл үеэс, тухайлбал 1996 оноос Монгол-Японы хамтарсан “Бичээс” төсөл хэрэгжиж эхэлсэн нь нэг хэсэгт завсарлаад байсан руни бичгийн судлалд дэлхийн түрэг судлаачдын анхаарлыг дахин хандуулж чадсан байна.

Тус хамтарсан хээрийн шинжилгээний анги Монгол орны төв нутаг дахь руни бичгийн дурсгалыг дахин нягтлан судлахад анхаарч ажилласан ажээ.

1996-1998 оны хооронд хэрэгжсэн “Бичээс” төслийн тайлан илтгэлээ Японы эрдэмтэд хэвлэн нийтлүүлсэн нь Монголын төв нутаг дахь руни бичгийн дурсгалын өнөөгийн байдал төлөв, өмнөх судалгааны зарим алдаа мадаг, зөрүүг тодруулан үзэхэд чухал эх хэрэглэгдэхүүн болсоор байна⁴⁰.

2. Монгол-Туркийн эрдэмтдийн хамтарсан судалгаа

Монгол Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу, Туркийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (ТИКА) санхүүжүүлэн хэрэгжүүлж байсан “Орхоны хөндий дэх түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах” төсөл 1997 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн билээ.

Уг төслийн хүрээнд Келтигин, Билгэ хаан, Туныокукийн тахилын онгоны дурсгалуудыг сэргээн засварласнаас гадна Билгэ хааны тахилын онгонд археологийн малтлага хийсэн ажээ.

Энэхүү хамтарсан төслийн “Бичээс судлал” хэсэг Келтигин, Билгэ хаан, Туныокукийн гэрэлт хөшөөний бичээсийг өмнө нь хэвлэгдсэн хуулбаруудтай тулгаж нягталснаас гадна Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалыг тойм байдлаар үзэж судалсан юм.

“Бичээс судлал”-ын хэсэгт ажилласан Туркийн Ататурк их сургуулийн багш, доктор Женгиз Алийлмаз ихээхэн санаачлага гаргаж үр бүтээлтэй ажиллаж байсныг ганзага нийлсэн судлаачийн хувьд энд зориуд онцлон тэмдэглэе.

Тус хамтарсан төслийн хүрээнд проф. О.Ф.Серткая (Osman Fikri Sertkaya), Женгиз Алийлмаз (Cengiz Alyılmaz), Ц.Баттулга нар хамтран “Moğolistan’daki Türk anıtları projesi albümü (Album of the Turkish monuments in Mongolia)” хэмээх бүтээлийг турк, англи хэлээр хэвлүүлсэн нь Монгол нутаг дахь түрэг, уйгурын үеийн хөшөө дурсгалын өнөөгийн байдал,

⁴⁰モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・責任編集・森安 孝夫・オチル・中央ユーラシア学研究会・1999年3月 (Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999, Edited by Takao Moriyasu and Ayudai Ochir.)

ерөнхий төлөв, тус хамтарсан төслийн судалгааны ажлын олдвор олз зэргийг олноо танилцуулсан чухал бүтээл болсон ажээ⁴¹.

3. Түрэг судлалын төв /тэнхим/-өөс эрхилжэ буй сургалт, судалгаа

Түрэг судлаач нарыг бэлтгэжэ буй талаар:

МУИС-ийн Монгол хэл соёлын сургуульд Түрэг судлалын тэнхим (төв) байгуулагдсанаар (2000 онд) Монгол улсад анх удаа энэ чиглэлээр боловсон хүчин бэлтгэж эхэлсэн билээ.

Түрэг судлалын ангийн сургалтын хөтөлбөрт орчин цагийн турк, дунд үе (осман)-ийн турк, эртний түрэгийн хэл шинжлэл, хэл бичиг, түрэгийн түүх, археологи зэрэг хичээлүүд багтаж буй. Мөн зуны хээрийн дадлага, судалгаагаар явж Монгол нутаг дахь эртний түрэг, уйгурын үеийн гэрэлт хөшөө, бичгийн дурсгал, онгон тахилын байгууламж, хүн чулуу зэрэг түүх археологийн дурсгал үзэж онолоор олсон мэдлэгээ бататган гүнзгийрүүлэх боломжтойгоороо давуу талтай.

Түрэг судлалын ангийн оюутнуудын эрдэм шинжилгээний өгүүллийн товхимол хэвлүүлж байгаа⁴² нь хожмын сайн судлаач эрдэмтдийг бэлтгэхэд ихээхэн тустай ажил болж байна.

Тус ангийн оюутнууд түрэгийн түүх, археологи, хэл шинжлэл, аман зохиол, уран зохиолоор мэргэшин төгсөж байна.

Монголын руни бичгийн судлал, нэн ялангуяа Монгол дахь “Түрэг судлал” цаашид улам өргөжин хөгжиж, бэлтгэгдсэн боловсон хүчин эрдэм шинжилгээ, судалгааны шинэ соргог бүтээл олныг туурвиж ихийг бүтээх буй за.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар:

Түрэг судлалын төв (тэнхим)-өөс эрхилэн хийж буй эрдэм шинжилгээ, судалгааны зарим ажлаас товч дурдъя.

Монголын руни бичгийн бага дурсгалуудыг уншиж судлах ажилд голлон анхаарч цуврал өгүүлэл, мэдээ, тэмдэглэл нийтлүүлэхээс гадна дурсгалын бүртгэл (каталоги) хийж, Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалуудын цахим сан бүрдүүлж байгаа билээ.

Түрэг судлалын төв (тэнхим)-өөс жил бүр руни бичиг судлалын хээрийн шинжилгээний ангийг тогтмол зохион байгуулж судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулахаас гадна өмнөх судалгааг гүнзгийрүүлэн лавшруулсаар билээ.

Эл ажлын хүрээнд Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын хэв дардсын сан хөмрөг бүрдүүлэх талаар ихээхэн санаачлага зүтгэл гарган ажиллаж байна.

Зүтгэл хичээлийн үр дүнд Түрэг судлалын тэнхимд зөвхөн руни төдийгүй уйгур, монгол, нангиад, зүрчин, араб, перс, ланз, дөрвөлжин, төвд, манж зэрэг эртний бичгийн дурсгалын хэв дардасын баялаг сан хөмрөгтэй болсон нь уг дурсгалыг заавал очиж үзэх шаардлагагүй, хэв дардаст тулгуурлан үнэн зөв унших боломж нээгдэж буй чухал ач холбогдолтойг дурдалтай. Өөрөөр хэлбэл, уул усны бартаат замыг туулан эрж бэдрэн очих холын дурсгалыг ойртуулж, зарим бичээсийн өмнө нь нийтлүүлсэн эхийн үсэг тэмдэгтийн алдаа мадаг, зөрүү бурууг баттай үзэж мэдэх боломж, бодит найдвартай эх хэрэглэгдэхүүн бүрдүүлсэнд “Бичээсийн хэв дардасын сан хөмрөг”-ийн судалгааны гол үнэ цэнэ оршиж

⁴¹ Osman Fikri Sertkaya, Cengiz Alyilmaz, Tsendiin Battulga, Moğolistan'daki Türk anıtları projesi albümü (Album of the Turkish monuments in Mongolia). - Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2001.

⁴² Түрэг Монгол судлал (Türk Moğol Araştırmaları (Turkica and Mongolica)), МУИС, Монгол хэл соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим, I боть, I-IV дэвтэр, эрхилсэн Бүлэнт Гүл, Ц.Баттулга, Улаанбаатар, 2001; Түрэг судлал (Türk Moğol Araştırmaları (Turkic Studies)), МУИС, Монгол хэл соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим, II боть, I-8-р дэвтэр, эрхилсэн Ц.Баттулга, Улаанбаатар, 2003.

байгаа юм. Бичээсийн хэв дардсын сан хөмрөгөөс гадна хадны зураг, тамга тэмдэг, буган чулуу, эртний хот балгадын туйр зэрэг түүхийн дурсгалуудын гэрэл зургийн сан буй.

Монголын Түрэг судлалын чиглэлээрх судалгааны ажлыг эдүгээ шүүн үзвээс тус орноос олдсон руни үсэг бичгийн дурсгалыг уншиж тайлах, орчуулах, түрэг уйгурын үеийн цөөн булш цогцолборыг малтан шинжилсэн дүн хийгээд хүн чулууны судалгаанаас хэтрээгүй гэж үзэж болохоор ажээ.

“Түрэг судлал, түрэг судлаач” гэхээр руни бичиг судлалыг буюу руни бичиг судлаач нарыг хэлдэг хэмээн туйлын явцуу хүрээнд ойлгож мэддэг нь дээрх судалгааны ажлын цар хүрээ, хамарсан сэдвээс үүдсэн хэрэг буй за.

Тиймээс цаашид эртний түрэг, уйгур хэл, монгол-түрэг хэлний харьцуулсан судалгаа, монгол нутагт аж төрж байсан түрэг угсаатны түүх, соёл, ёс заншлыг шинжлэх ухааны өнөөгийн төвшинд судалж, онол аргагүйн хувьд ахин дэвшиж ажиллах зайлшгүй шаардлагатайг сануулах юун. Монгол түрэг хэлний харьцуулсан судалгаа зөвхөн хоёр хэлний төдий бус нийт Алтай хэлний асуудлыг хөндөж энэ талаарх онолын маргаантай зарим асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болох нь дамжиггүй. Ийм ч учраас Монгол дахь “Түрэг судлал” өмнөх эрдэмтдийн судалгааны хүрээнд эргэлдэх бус тэдний боловсруулсан онол аргазүйг шинэчлэн баяжуулж дэлгэрүүлэн хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Түрэгийн хэл, түүх, угсаатны зүй, соёлын судалгаа дан Түрэгүүдэд хамаатай бус Төв Азийн нүүдэлчдийн, нэн ялангуяа Монголчуудын хэл, түүх, соёлын судлалд ч үнэлж баршгүй ач холбогдолтой билээ.

1.2.0. РУНИ БИЧГИЙН ҮҮСЭЛ ГАРАЛ, ХОЛБОО ХАМААРАЛ

1.2.1. Руни үсгийн үүсэл гарал

Дэлхий дахинаа “руни (runic)” хэмээн нэршиж хэвшсэн эл үсэг бичгийн гарал үүслийн талаарх эрдэмтдийн саналыг товч төдий боловч өгүүлсү.

Руни буюу нууц, далд гэж нэрлэгдсэн эл бичээс олдож мэдэгдсэн цагаас эхлэн түүнийг уншиж тайлах түлхүүр олохын тулд эн түрүүнд гарал үүслийг нь тогтоохыг хичээж байсан бөлгөө. Тухайлбал, Отто Доннер (Otto Donner, 1835-1909) уул бичээсийг Бага Азийн үсгүүд тухайлбал кари болон лики цагаан толгой Енисейн дурсгалуудын үсэг тэмдэгт лүгээ төсөөтэйг ажиглаж Енисейн бичээсүүд магадгүй түүнээс үүсэл гаралтай байж болох юм гэж үзжээ⁴³. Енисейн сав дагуух газраас олдсон руни бичээсийг Т.Байер кельт⁴⁴, Тихзен гот бичиг⁴⁵, Г.Ю.Клапорт, Роммель нар грек-готоос гаралтай грек бичигтэй төсөөтэй бичиг⁴⁶, В.Флоринский славян гаралтай бичиг хэмээн үзсэн гэнэ⁴⁷. Г.И.Спасский 1818 онд бичсэн бүтээлдээ Сибирээс олдсон уг бичээсийг монгол халимаг нартай холбоотой байж мэдэх юм гэж байсан боловч хожим хүннүгийн бичиг хэмээсэн байна⁴⁸. Ж.Ашпелин (Johan Reinhold Aspelin, 1842-1915) баруун гараас зүүн тийш хөөж бичиж уншдаг, хүрлийн үеийн соёлд холбогдох бичиг гэжээ⁴⁹. Хожим Г.Ю.Клапорт, Т.Байер, Тихзен, Аппельгрэн нарын судлаачид өмнөх саналаасаа няцаж уг бичээс хүннүгээс гаралтай бөгөөд монгол, түрэг аймгуудын дунд тархсан гэж үзсэн гэдэг⁵⁰. Эдгээр санал руни бичгийн дурсгалыг тайлж уншихаас өмнө гарсан байна.

Уг үсэг бичиг нэгэнт тайлагдсаны хойно ч чухам ямар язгуур үндэстэй, хаанаас эх улбаа, гарал үүсэлтэй болох талаар судлаачид олон санал дэвшүүлжээ.

Нилээд олон эрдэмтэд руни бичгийг эртний овог аймгийн болоод малын тамга тэмдгээс үүсэлтэй гэж үзсэн болой.

Үүнд гадаадын судлаачдаас Г.И.Спасский⁵¹, А.А.Шифнер⁵², А.Вамбери (Armin Vámbéry, 1832-1913)⁵³, Н.А.Аристов⁵⁴, Д.Н.Соколов, Н.О.Малицкий⁵⁵, С.В.Киселев⁵⁶, А.Махмутов⁵⁷ нарын эрдэмтдийг нэрлэж болно. Манай эрдэмтэд ч энэ талаар судалгааны хэд хэдэн өгүүлэл нийтлүүлжээ.

⁴³ Otto Donner, *Inscriptions de l'Orkhon, helsingfors*, 1892, pp.XLXXX.

⁴⁴ Th.Bayer, *Vetus inscriptio prussica, Commentarii Academiae Scientiarum Imperialis Petropolitanae, Petropoli*, 1729.

⁴⁵ М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Tom.VIII, fasc.I, Улаанбаатар, 1980, 5, 13 дугаар тал.

⁴⁶ А.Н.Бернштам, Социально-экономический строй Орхоно-Енисейских тюрков VI-VIII веков, Москва-Ленинград, 1946, стр.14.

⁴⁷ А.Н.Бернштам, Социально-экономический строй Орхоно-Енисейских тюрков VI-VIII веков, Москва-Ленинград, 1946, стр.24.

⁴⁸ Г.Спасский, Записки о Сибирских древностях, -Сибирский Вестик, часть I, Санктпетербург, 1818, стр.67-85; часть II, стр.147-177.

⁴⁹ J.Aspelein, *Fels und Stein-Inschriften am oberen Jenissei*, -Zeitschrift für Ethnologie, 1887, pp.529.

⁵⁰ J.Aspelein, *Fels und Stein-Inschriften am oberen Jenissei*, -Zeitschrift für Ethnologie, 1887, pp.530.

⁵¹ Г.И.Спасский, Восточная библиографи, -Азиатский вестник, Том, 4, 1825, стр.285-303

⁵² А.А.Шифнер, Об этнографической важности знаков собственности, -Учение записки Академии наук, I и III отделения, Том 3, 1855, стр.606.

⁵³ A.Vámbéry, *Das Turkenvolk in Seinen ethnologischen und ethnographischen Beziehungen*, Leipzig, 1885, pp.342.

⁵⁴ Н.А.Аристов, Опыт выяснения этнического состава киргиз-казаков Большой орды и каракиргизов, - Живая старина, 1894, вып. 3-4, 391; 486 дугаар тал.

⁵⁵ Н.О.Малицкий, О связи тюркских тамг с орхонскими письменами, -Протоколы Туркестанского кружка любителей археологии, том III, 1897-1898, стр.43-47.

⁵⁶ С.В.Киселев, Древняя история южной Сибири, -Материалы и исследования по археологии СССР, №9, Москва-Ленинград, 1949, стр.285.

⁵⁷ А.Махмутов, Как возник древнетюркский алфавит, -Исследования по тюркологии. Алма-Ата, 1969, стр.141-147.

Б.Ринчен академич “The petroglyphs of Tsagan gol” хэмээх өгүүлэлдээ Цагаан голын хадны тамга нь хүннүгийн үед холбогдохыг дурдаад Орхон-Енисейн түрэгүүдийн руни бичигтэй төстэйг тэмдэглэсэн нь⁵⁸ угтаа түүний гарал язгуур нэн эртнээс улбаатайг өгүүлсэн хэрэг буй за. Нэрт түүхч Х.Пэрлээ гуай энэ бичиг овог аймгийн тамгаас үүсэлтэй нь магад гээд малын тамгатай ямар нэгэн хэмжээгээр зайлшгүй холбогдож болохыг тэмдэглэжээ⁵⁹. Уг саналд тулгуурлан М.Шинэхүү “Орхон-Енисейн бичиг монгол малын тамгатай холбогдох нь” гэдэг сонирхолтой өгүүлэл нийтлүүлж⁶⁰ улмаар “Төв Азийн ард түмэн тухайлбал, монгол, түрэг овогтны өмчийн тамга тэмдгийн эртний нийтлэг хэлбэр, руни бичиг хоёрыг нэгэн гарвалтай гэж болохоос гадна уг бичгийг “тамга бичиг” хэмээн бас нэрлэж болох юм”⁶¹ хэмээн үзсэн буй.

Профессор Ц.Шагдарсүрэн бүтээлдээ “Рүн” хэмээх тамга бичиг анх хэрхэн буй болсон талаар нийт судлагчид санал нэгдээгүй боловч энэ хир ерөнхийд нь гурав ангилж болно. Үүнд:

1. тухайн нутаг усныхины бичиг үсэг буюу уугуул бичиг
2. бусад улс аймгаас авсан буюу авмал бичиг
3. уугуул болон авмал бичгийн дундаас буй болсон бичиг гэж санал хуваагддаг ажээ. Бидний бодоход дээрх гурван саналын аль нэг нь зөв, бусад нь ташаарал гэж үзэх аргагүй бөгөөд эрт язгуур цагаас Төв Ази даяар нүүдэлчдийн хэрэглэж байсан тамга маагийн “рүн” бичиг болоод Европ дахинд хэрэглэж байсан бүх “рүн” бичгийн зүйлийг хэрхэн үүссэн талаар нэг янзын тайлбар байж болохгүй нь мэдээж билээ⁶² гэж онцлон тэмдэглэжээ. Үнэхээр ч Төв Азийн (Орхон-Енисей (Горлог)-н) руни үсгийн гарлыг бусад үсэг бичгээс хайж тэдний нэгээс үүссэн, эсвээс эртний аль нэг үсгийн элемент, язгуур махбоди оролцсон, үгүй ядаж нөлөө тусгал үзүүлсэн гэж үзэх онол санал олон буй. Гэвч тэдгээр санал бүр нүүдэлчдийн тамга-үсэг бичгийн гарал үүслийг уугуул (тэдний) язгуурын бус хэмээсэнгүй, харин тамга нь авианы бичиг болон хөгжихөд тэдгээрийн оролцоо, нөлөөллийн талаар ихэвчлэн өгүүлсэн байх бөлгөө. Иймд руни үсэг бичгийн үүсэл гарлын талаарх зарим санал онолоос товч өгүүлье.

Францын эрдэмтэн Е.Блоше(Е. Blochet)⁶³ “Орхоны түрэгүүдийн бичгийг хүннү буюу хүн нарын бичгээс дам салбарласан гэж үзвэл хүннү нарын анхдагч бичиг буюу өөрөөр хэлбэл түүн дээр түрэгүүдийн нэмж оруулсан тэмдэгтүүдийг хасчихлаа гэхэд тэр бичиг нь арамей гаралтай болохын баталгаа хангалттай буй...” хэмээжүхүй. А.Рона-Таш (А. Rona-Tas) руни бичиг арамей цагаан толгойн нэг төрлөөс үүсч гарсан⁶⁴, О.Прицак (Omelyan Pritsak) сами үет бичгээс үүссэн⁶⁵, В.А.Лившиц руни цагаан толгойн гарлыг согд үсэг дугаа харьцуулах замаар тогтооно⁶⁶, Ж.Клоузон (Sir Gerard Clauson) түүний үүсэл гарлыг согд,

⁵⁸ Rintchen, The petroglyphs of Tsagan gol, -Journal de la Societe Finno-Ougrienne, 68, Helsinki, 1966, pp.66-67.

⁵⁹ Х.Пэрлээ, Карта рунических писем на территории МНР, - Studia Muzeologica, Tom.I, fasc.1-8, Улаанбаатар, 1968, 11 дүгээр тал.

⁶⁰ М.Шинэхүү, Орхон-Енисейн бичиг монгол малын тамгатай холбогдох нь, -Монголын этнографийн асуудал, Studia Ethnographica, Tom.V, fasc.I, Улаанбаатар, 1977, 59-72.

⁶¹ М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Tom.VIII, fasc I, Улаанбаатар, 1980, 14 дүгээр тал.

⁶² Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон (Үсэгзүйн судалгаа), - Bibliotheca Mongolica: Monograph 1, Centre for Mongol Studies, National University of Mongolia, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 16-17 дугаар тал; А.Рона-Тас, On the Development and Origin of the East Turkic “Runic” Script, -Acta Orientalia Hungaricae, Tom.XLI, Budapest, 1987, pp.7-14.

⁶³ E. Blochet, Les inscriptions turques de l’Orkhon, -Revue Archeologique, Troisieme serie, XXXII, Mai-Juin, Paris, 1898.

⁶⁴ A. Rona-Tas, On the Development and Origin of the East Turkic “Runic” Script, -Acta Orientalia Hungaricae, Tom.XLI, Budapest, 1987, pp.7-14.

⁶⁵ O.Pritsak, Turkology and the Comparative Study of Altaic Languages, -Journal of Turkish Studies, Türklük Bilgisi Araştırmaları, Vol.4, Harvard University Printing Office, 1980, pp.83-100.

⁶⁶ В.А.Лившиц, О происхождении древнетюркской рунической письменности, -Советская Тюркология, 1978, №4, Москва, стр.84-98.

пехлеви болоод бактри цагаан толгойгоос эрэх хэрэгтэй⁶⁷, Е.Д.Поливанов руни бичгийн гарлыг тамгаас эхтэй бөгөөд үсэг бичлэгийн хувьд арамей-согд болон пехлеви үсэг зүйтэй тохирч байна хэмээсэн бөлгөө⁶⁸. Руни үсгийн гарлыг ерөнхийдөө арамей, согд үсэг бичиг лүгээ ямар нэгэн хэмжээгээр холбоотойг дээрх эрдэмтэд тодорхой өгүүлсэн бөгөөд тэдэнтэй Польшийн нэрт эрдэмтэн Э.Трыарски (Edward Tryjarski)⁶⁹ болоод Е.Хаудхауген (Even Haudhaugen)⁷⁰ нарын санал ч нэгдэж байна. Дээр өгүүлсэн саналаас ангид бас бус санал ч буй. Жишээ нь, Казахын эрдэмтэн А.С.Аманжолов руни бичгийн гарал үүслийг эртний сами болоод Бага Азийн цагаан толгойгоос хайх хэрэгтэй⁷¹, Туркийн эрдэмтэн А.Жеват Емре (Ahmet Cevat Emre) руни бичиг нь санаа бичиг (ideography) бөгөөд гарал үүслийн хувьд шүмэр бичиг лүгээ холбоотой байж болох юм гэжээ⁷². Харин В.В.Иванов тохар авиазүй, брахми бичигт суурилан эртний түрэг бичгийн цагаан толгой үүсчээ⁷³ гэж үзсэн байна. Мажарын нэрт эрдэмтэн Рона-Таш “Түрэгийн нэг бөлөг хойт арамей хэлбэрийн үсэг авсан бөгөөд тэр нь эртний согд, арамей хийгээд пехлеви цагаан толгойтой төсөөтэй боловч алинтай нь ч адилгүй” гээд уг бичиг нийт түрэг хэлтний дунд түгээмэл хэрэглэгдэх болж, үсгийн орон нутгийн хувилбарууд ч үүссэн⁷⁴ хэмээн тэмдэглэжээ.

Профессор Ц.Шагдарсүрэн хүн(нү) нарт холбогдох дурсгал, эд өлөг тэргүүтнээс олж цуглуулсан тамга үсгийг (61 үсэг тэмдэгт), Мажарын Яношидын Авар нарын булшинаас олдсон зүүний хайрцаг дээрх бичээс, “Орхон”, “Енисейн” бичээсийн хэлбэр дүрстэй харьцуулан судлаад “Төв Азийн нүүдэлчдийн хэрэглэж байсан тамга бичиг нь согдуудын эртний өвөг дээдсийн үсэг бичгийн нөлөө авсан байж бүрэн болох бөгөөд цаг хугацааны хувьд НТӨ II-1 зуунаас явч наашгүй гэж үзэх боломжтой юм. Хүн(нү) нарын хэрэглэж байсан тамга бичгийг Түрэгүүд уламжлан авч улам нарийсган боловсруулж өөрийнхөө хэлэнд нийцүүлсэн бөгөөд үүнээс үндэслэж Төв Азийн нүүдэлчдийн дотроос хамгийн түрүүнд Түрэгүүд авианы бичигтэй болсон гэдэг үзэл баримтлалыг эргэж нягтлуулштай байна”⁷⁵ хэмээн тэмдэглэжээ.

Тамга тэмдэгээс авианы бичиг болж ерийн тэмдэг утгаас сонгодог дурсгалын яруу тансаг найруулгатай бичээс (Келтигин, Билгэ хаан, Туньюкук)-ийг үйлдэх хүртэл хөгжлийн олон үе шатыг туулсан нь мэдээж. Тэгээд ч руни хэмээх энэ бичгийн үсгийн махбоди нь Төв Азийн нүүдэлчдийн овог, аймгийн язгуур тамга тэмдэг мөн бөгөөд олон зуун жилийн худалдаа, соёлын харилцааны үрээр согд зэрэг бусад үсэг бичгийн нөлөөгөөр улам баяжин хөгжлийн сүүл шатандаа хүрсэн нь Түрэгийн хоёрдугаар хаант улсын үе бололтой.

⁶⁷ Sir Gerard Clauson, The Origin of the Turkish “Runic” Alphabet, - Acta Orientalia, vol. XXXII, (Kopenhagen), 1970, pp.51-76.

⁶⁸ Е.Д.Поливанов, Идеографический мотив в формировании орхонского алфавита, -Бюллетен Средне-Азиатского Государственный Университет, Ташкент, 1925, стр.9.

⁶⁹ Edward Tryjarski, Altes und Neues zur Entstehung der Turkischen Runnen Schrift, -Rocznik Orientalistyczny, Tom.XLV, z.1, Warszawa, 1985, pp.59-80; Edward Tryjarski, Anonymity, Adaptation and Diffusion of the Asian and European Runic Scripts, -Türk Dili Araştırmaları Yıllığı (Yearbook of Turkic Studies), Belletin 1993, Ankara, 1995, s.35-42.

⁷⁰ Even Haudhaugen, The Structure and Origin of the Turkish Runic Alphabet, -1. Milletlerarası Türkoloji Kongresi, pp.470-478.

⁷¹ А.С.Аманжолов, Проблема происхождения тюркского рунического алфавита, -Казак тили мен едевияти, 8 шығыш, Алма-Ата, 1976, стр.60; А.С.Аманжолов, К генезису тюркских рун, -Вопросы Языкознания, Москва, 1978 /2, стр.82.

⁷² Ahmet Cevat Emre, Eski Türk Yazısının Menşegi, İstanbul, 1938; A.C.Emre, Sur l'origine de l'alphabet vieux-turc (dit alphabet runique de Sibérie), İstanbul, 1938.

⁷³ В.В.Иванов, Тохари, -Восточная Туркстан в древности и раннем средневековие, Москва, 1992, стр.28-29.

⁷⁴ A.Róna-Tas, On the development and origin of the East-Turkic “Runic”. Acta Orientalia Hungaricae, Tom.XLI, Budapest, 1987, pp.7-14; A.Róna-Tas, An Introduction to Turkology, Szeged, 1991, pp.55-626.

⁷⁵ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон (Үсэгзүйн судалгаа), - Bibliotheca Mongolica: Monograph 1, Centre for Mongol Studies, National University of Mongolia, нэмж зассан хоёрдугаар хэвэл, Улаанбаатар, 2001, 16 дугаар тал.

1.2.2. Түрэгтийн руни бичгийн өмнөх үе

Язгуурт ихэсийн түүх, намтар цадигийг бичихдээ түүхэн бодит үйл явдлыг тоочин дурдах бус шүлэг, хэлц хэллэг, зүйр цэцэн үг, мэргэн үг шигтгэн яруу тансаг найруулан өгүүлсэн нь зөвхөн Келтигийн, Билгэ хаан, Туныоуккийн гэрэлт хөшөөнд холбогдох найруулга бус харин эртний нүүдэлчдийн түүх цадиг бичдэг уламжлалтай яах аргагүй холбоотой болов уу.

Нүүдэлчдийн түүх бичлэгийн энэхүү өвөрмөц онцлог, уламжлалыг хожмын Уйгурын Моюунчур (Могойн шинэ ус), Тариат, Тэсийн гэрэлт хөшөөний бичээс, түүнчлэн “Монголын Нууц Товчоо” зэрэг олон сурвалжуудаас ч тодорхой мэдэж болно.

Лавшруулан үзвээс Төв Азийн нүүдэлчдийн дунд хаад ихэс, улс орныхоо түүхийг бичихдээ дуу, шүлэг, үлгэр, домог, зүйр цэцэн үгээр баяжуулж яруу найруулгатай бичдэг уламжлал түгээмэл байсныг гэрчлэн баталж болох мэт.

Хэрэвзээ тийн үзвэл Хүннүгээс Түрэг хүртэлх Төв Азийн өндөрлөгт оршин асан бүх улс, овог аймгууд өөрсдийн хаад ихэс, язгууртнуудын цадиг, улс орныхоо түүх, угсаа гарвалаа хэрхэн уламжлуулдаг, ямар үсгээр тэмдэглэж бичдэг байв гэсэн асуулт зүй ёсоор гарна.

Руни бичгийг Түрэгтийн хаант улсын үед хамаадуулан үзэх нь зөвхөн тэдний үлдээсэн дурсгалын тухайд болохоос бус харин гарал үүслийнх нь хувьд өнө эртний улбаатайг өгүүлэх юун. Тиймээс ч эрдэмтэд руни бичгийг Хүннү хийгээд эртний нүүдэлчин улсуудын үсэг бичигтэй холбон үзсэн нь цөөнгүй, ялангуяа эртний улсуудын түүх, археологи судлагчид олон арван бүтээл туурвижээ.

Эртний нүүдэлчид, тухайлбал Жужан нар руни үсэг бичиг хэрэглэж асны энгийн нэгэн жишээ болгож Аварын Яношидын бичээсийн судалгааг товч эшлэе.

Анх Мажарын эрдэмтэн И.Эрдэли (István Erdélyi) Яношид (Jánosföld)-ын авар булшийг малтан шинжлэх явцад гурван талдаа зураасан бичиг бүхий зүүний сав олсон гэдэг.⁷⁶

Зүүний сав дээрх уг бичээсийн зөвхөн 4 үсэг тэмдэгтийг И.Вазари (I.Vásáry) анх авиачлан буулгаж зүүнээс баруунш унших⁷⁷, харин И.Эрдэли баруунаас зүүн тийш унших санал дэвшүүлсэн ажээ.⁷⁸

Мажарын эрдэмтэн Г.Ласло (Gyula László) дээрх зүүний хайрцаг нь гурван талдаа бичээстэйгээс гадна хүн дүрст тамга ч буй талаар дэлгэрэнгүй мэдээлсэн байна.⁷⁹ Аварын Яношидын булш дурсгалаас гарсан эд өлгийн зүйл дээрх үсэг бичээсийг Мажарын эрдэмтэн Я.Харматта (János Harmatta) нарийвчлан шинжилж тухайлсан өгүүлэл бичиж хэвлүүлсэн нь олон зүйлийн маргааныг тасалж учрыг таниулсан чухал судалгаа болжээ.⁸⁰

Тэрбээр зүүний хайрцагийн гуравдугаар тал дахь бичээсийг “q̄-⁰z-⁰η : kü-²g : ²y-²d” гэж галиглаад “q̄z̄η küdi yedi –Бүсгүй (хүний)-н нэр төр оёдол (La couture, c'est la dignité d'une fille)” хэмээн уншсан байна.

⁷⁶ I.Erdélyi. Új magyarországi rovásfelirat, - Archaeológiai Értesítő, 88, 1961, pp.279.

⁷⁷ I. Vásáry. Runiform Signs on Objects of the Avar Period, -Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, 25, 1972, pp.337.

⁷⁸ I.Erdélyi. Új magyarországi rovásfelirat, - Archaeológiai Értesítő, 88, 1961, pp.279-280.

⁷⁹ Gy. László. Etudes archéologiques sur l'histoire de la société des Avars, -Ancient Hungarian, 34, Budapest, 1955, pp.161.

⁸⁰ János Harmatta, Avarların Dili Sorununa Dair; Doğu Avrupa'da Türk Oyma Yazıtli kitabeler, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Atatürk Kültür Merkezi Yayını, sayı 26, çeviren Hieran Akın, Türk Tarih Kurumu Basım Evi, Ankara, 1988; János Harmatta, De la question concernant la langue des Avars; Inscriptions Runiques Turques en Europe Orientale, Gleanings from Turkish Culture, № 13, Türkçeden Fransızcaya çeviren Gönül Yılmaz, Türk Tarih Kurumu Basım Evi, Ankara, 1988.

Зүүний хайрцагийн хоёрдугаар талын бичээсийг “iq/ qī¹ b¹ l¹ γ¹ b¹ l¹ i¹ ē” хэмээн галиглаж “qīblγ bol iče- Эгч аз жаргалтай бай[г] (Soeur, sois heureuse!)” гэж амилуулан уншжээ.

Харин 4-р нүүрийн бичээсийг “] η/ ⁰η¹ r⁰ η¹ d⁰ qī qī¹ l⁰ nē² b² b² g² t² g⁰ η¹ a” гэж галиглаад “] ηηη idugē qīl inē eb bögtäg ага-Тэнгэрийн элч түүнд амар амгаланг хайрла[арай] (Ange de Dieu (ou du Ciel) donne-lui tranquillité et salut !)”⁸¹ хэмээн тайлсан билгөө.

Профессор Я.Харматта авар хэлний талаар “Яношидын булшнаас олдсон гурван бичээс монгол хэлээр бус харин түрэг хэлээр байгаа нь тодорхой байна. ... мэдэгдэж байгаагчлан аваруудын угсаа /etnik/ бүрдэл нь маш их холимог шинжтэй. ... Алтайгаас нүүдэллэн ирсэн аваруудын хэл аялгуу нь “z”-тэй түрэг хэл байжээ”⁸² хэмээн өгүүлжээ.

Тэрбээр Мажарын Аварын руни бичгийн үсгийн хэлбэр Орхон, Енисейн үсэгтэй таарч буйг анх удаа тодорхой баримттайгаар нуталсан байна. Дээрх судалгаа болон руни төрлийн үсэг бичгийн бусад судалгаанд тулгуурлан Польшийн эрдэмтэн Э.Триярски Төв Азийн руни бичиг, Европын руни бичигтэй үсэг тэмдэгтийн хэлбэр дүрс ихэвчлэн тохирч буйгаас гадна дуудлагын хувьд ч зарим тохиолдолд төстэй байгааг олж тогтоосон ажээ⁸³.

Аварын бичгийн дурсгалд өгүүлсэн мэдээ баримтаас Жужан нар баруунш нүүдэллэхээс өмнө руни хэлбэрийн бичигтэй байсан гэдэгтэй эрдэмтэд нэгэнт санал нийлсээр байна. Жишээ нь, Ф.Алтайхйм “Хүн(нү) Азиас үсэг бичгээс гадна өөрчлөлт шинэчлэлтийн олон зүйлийг Европ дахинд хүргэсэн” гэж дүгнэсэн гэдэг⁸⁴.

Энэ мэт Жужан (Жоужань 柔然 rouzan)-ны түүх соёл, үсэг бичгээс улбаалан Тоба, Моюан, Ухуань, Сяньби, Хүннүгийн үсэг бичгийн асуудал зайлшгүй хөндөгдөнө. Монголчуудын түүх соёл, угсаа гарвалтай холбогдох дээрх олон аймаг, улсын хэрэглэж асан үсэг бичгийн тухайд тэр бүр нарийвчлан судалсан нь цөөн, тэгээд ч голлон Хүннү, Сяньбигээр төлөөлүүлэн өгүүлсээр иржээ.

Хүннү нарын үсэг бичиг хийгээд түүнээс улбаалсан тамга, руни бичгийн талаар манай эрдэмтэд судалгааны цөөнгүй бүтээл туурвижээ.

Хүннүгийн үсэг бичгийн тухайд А.Лувсандэндэв⁸⁵, Ц.Доржсүрэн⁸⁶, А.Дамдинсүрэн⁸⁷, Н.Сэр-Оджав, Г.Сүхбаатар, Ц.Шагдарсүрэн, Б.Сумъябаатар⁸⁸, Л.Чулуунбаатар⁸⁹, З.Батсайхан⁹⁰, П.Дэлгэржаргал⁹¹ нарын зэрэг эрдэмтэд ном бүтээлдээ тэмдэглэсэн байна.

⁸¹ János Harmatta, Avarların Dili Sorununa Dair; Doğu Avrupa'da Türk Oyma Yazıtlı kitabeler., Ankara, 1988, s. 16; -, De la question concernant la langue des Avars; Inscriptions Runiques Turques en Europe Orientale., pp.10-15.

⁸² János Harmatta, Avarların Dili Sorununa Dair; Doğu Avrupa'da Türk Oyma Yazıtlı kitabeler., Ankara, 1988, s. 16; 18; János Harmatta, De la question concernant la langue des Avars; Inscriptions Runiques Turques en Europe Orientale., pp.17; 19.

⁸³ Edward Trijarski, Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift, -Rocznik Orientalistyczny, Tom.XLX, z.1, Warszawa, 1985, pp.59-80.

⁸⁴ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон (Үсэгзүйн судалгаа), - Bibliotheca Mongolica: Monograph 1, Centre for Mongol Studies, National University of Mongolia, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 16 дугаар тал.

⁸⁵ Lubsangdendub, Mongyol bičig-ün teülke-eēe, - Mongyol kele jokiyal, teülke, köke qota, 1959, 39-47 дугар тал-а.

⁸⁶ Ц.Доржсүрэн, Умард Хүннү, Улаанбаатар, 1961, 104-105 дугаар тал.

⁸⁷ А.Дамдинсүрэн, Археологийн шинжилгээгээр олдсон Хүннүгийн бичгийн дурсгал, -Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, Том.V, Fasc. 8 (3-13), Улаанбаатар, 1972, 99-111 дугаар тал.

⁸⁸ Д.Наваан, Б.Сумъябаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987.

⁸⁹ Л.Чулуунбаатар, Нүүдэлчин монголчуудын үсэг бичгийн соёл, Улаанбаатар, 2002.

⁹⁰ З.Батсайхан, Сюнүгийн кему бичиг түүний холбогдол (Туршиц судалгаа), -Археологийн судлал, Боть XIV, дэвтэр 6, Улаанбаатар, 1994, 108-120 дугаар тал; З.Батсайхан, Хүннүгийн бичиг соёлын асуудалд, -Acta Mongolica, Vol.2(208), Centre for Mongol Studies, National University of Mongolia, Ulaanbaatar, 2003, 165-168 дугаар тал; З.Батсайхан, Хүннү, Улаанбаатар, 2003, 227 дугаар тал.

⁹¹ П.Дэлгэржаргал, Монголчуудын угсаа гарвалыг нэхэн сурвалжлахуй, (Доктор (Ph)-ын диссертаци), Улаанбаатар, 2005.

Тухайлбал, археологич Н.Сэр-Оджав гуай “Монголд мандаж асан эртний аймгууд мод хэрчиж санаагаа тэмдэглэдэг байсан нь хожим улам нарийсан боловсорч түрэг бичгийн эхийг тавьсан бололтой”⁹² гэж үзжээ.

Нэрт түүхч Г.Сүхбаатар гуай нангиад хэл бичгээрх эртний түүхэн сурвалж дахь нүүдэлчдийн бичиг үсгийн тухай баримт нуталгааг шүүн үзээд хүннү, сяньби, тоба, жужан нар анхандаа руни бичиг хэрэглэж байсан ба тэдний бие биедээ мэдээ дамжуулдаг гэх “мод сийлэх буюу кэму” бичиг нь модыг энгүүнээр сийлж хэрчих, хээлэхийн нэр огтхон ч бус, харин нэгэн зүйл бичиг бөгөөд бичих арга нь Орхоны руни бичигтэй тохирч байгаа талаар тодорхой өгүүлсэн ажээ⁹³.

Өвгөнтийн булшнаас олдсон “Алтан хүн” дээрх бичээсийг Хүннүгийн үед холбогдуулан үзэх нь буй.

1983 онд Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийнхан Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Их Дулааны салбар, Өвгөнт, Үүдэнт хэмээх уулын завсар “Өвгөнтийн булш” хэмээн хожим нэршсэн эл дурсгалыг, анх малтан шинжилсэн археологичид Хүннүгийн үед холбогдуулан үзжээ⁹⁴.

“Өвгөнтийн булш”-наас олдсон ховор чухаг олдвор болох “Алтан хүн” дээрх бичээсийг профессор Б.Сумъяабаатар олон зүйл үсэг бичигтэй харгуулан нягтлаад хоёр хувилбараар амилуулан уншжээ. Тэрээр эхний [Г]тэмдэгтийг “q, k” гэж үзвэл “qaᠠᠨᠤ tama᠒a, qa ᠠᠨᠤ tama᠒a; “s, š” гэж үзвэл “saᠠᠨᠤ tama᠒a, qa ᠠᠨᠤ tama᠒a”, “saᠠᠨᠤ tama᠒a, ša ᠠᠨᠤ tama᠒a” гэж унших боломжтой, “хааны тамга” буюу “шаньюйн тамга” хэмээх утгатай ба уг бичиг нь финикээс гаралтай авианы бичиг бөгөөд хэл нь хүннү нарын хэл мөн гэж үзжээ⁹⁵.

Зөвлөлт (Орос)-ийн археологич Д.Савинов, В.Шкода нар уг булш дурсгалыг цаг хугацааны хувьд хүннү нарт огт холбогдолгүй хэмээн үзэж олон зүйл нуталгаа дурджээ.

Тэд “Хэдийгээр Өвгөнтийн булш тоногдож түүнээс гарсан эд өлгийн зүйлс анхных нь байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа боловч тэнд оршуулагдсан хүн Уйгурын хаант улс мөхсний дараа умард Монголыг эзлэн өргөн тархсан Енисейн Кыргызийн язгууртнуудад холбогдохыг бид бүрэн итгэлтэйгээр баталж байна”⁹⁶ хэмээжээ.

“Алтан хүн” дээрх бичээсийг С.Г.Кляшторный хоёр мөрөөс бүтсэн руни бичиг гэж үзээд эхний мөрнөө “t a ᠒ r”, хоёрдугаар мөрнөө “b g” үсэг буйг тэмдэглээд “ta᠒ er beg” гэж амилуулан уншсан⁹⁷ бөлгөө.

Тэрбээр “ta᠒” гэх үг эртний түрэг хэлнээ “үүрийн гэгээ”, эртний уйгурын бурхны шашны зохиолд “гайхамшигтай, ер бусын, ховор” гэсэн утгатайгаар хүний нэр, цолын үүргээр тохиолддох ба “er beg” нь “эр ноён, дайчин ноён” хэмээсэн утгатай гэжээ. Дээрх эрдэмтдийн уг булш, дурсгалын талаар:

-Өвгөнтийн булшны археологийн цогц дурсгал нь Сибир-Төв Азийн эртний түрэгтийн бусад дурсгалтай нэг хүрээнд байна.

-Алтан брактеат нь Византийн Ираклий ба Леонтий хааны зоосны согд хуулбар бөгөөд Согдын төв нутгийн гадна үйлдэгдсэн байна.

⁹² Н.Сэр-Оджав, Түрэгтийн соёл, -БНМАУ-ын түүх, I боть, Улаанбаатар, 1966, 130 дугаар тал.

⁹³ Г.Сүхбаатар, Хүннү бичигтэй байсан тухай, -Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, №2, Улаанбаатар, 1967, 73-81 дүгээр тал; Г.Сүхбаатар, Сяньби, Улаанбаатар, 1971, 108; 110 дугаар тал; Г.Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг, Улаанбаатар, 1980, 111-125 дугаар тал.

⁹⁴ Д.Наван, Археологийн судалгаа, -Өвөг монгол хэл, бичгийн чухаг нэгэн дурсгал, Улаанбаатар, 1987, 5-14 дүгээр тал.

⁹⁵ Б.Сумъяабаатар, Хэл, бичгийн судалгаа, -Өвөг монгол хэл, бичгийн чухаг нэгэн дурсгал, Улаанбаатар, 1987, (31-116) 99, 116 дугаар тал.

⁹⁶ С.Кляшторный, Д.Савинов, В.Шкода, Монголоос олдсон алтан брактеат Төв Азийн гоёл чимэглэлийн урлаг дахь Византийн өгүүлэмж, орчуулсан Ц.Төрбат, -Археологийн судлал, Том.XIX, fasc.1-16, Улаанбаатар, 1999, 157 дугаар тал.

⁹⁷ С.Кляшторный, Д.Савинов, В.Шкода, Монголоос олдсон алтан брактеат Төв Азийн гоёл чимэглэлийн урлаг дахь Византийн өгүүлэмж, орчуулсан Ц.Төрбат -Археологийн судлал, Том.XIX, fasc.1-16, Улаанбаатар, 1999, 156 дугаар тал.

-Брактеат дээрх хүний дүрс ба үрлэн хээн тойргийн хооронд байх тэмдэгтүүд нь хожуу үеийн үсэгзүйн онцлогтой эртний түрэгийн руни бичээс байна

-Өвгөнтийн булшны он цаг бүх шинжүүдээрээ нийтийн тооллын VIII-IX зуунд холбогдох бололтой гэсэн дүгнэлт гаргажээ.

“Алтан хүн” дээрх уг бичээсийн руни хэмээн үзэж унших боломж [руни үсгийн махбодь (ʿ г € g)] буй ч нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный абугайн уул бичээсийг тэнхэрүүлэн хэрэгээж уншсантай санал бүрэн нийлэхгүй байна. Хэрэвзээ үнэхээр руни бичиг байна хэмээн үзвэл “t”, “b” гэж сэргээн уншсан нь эх бичиг (Алтан хүний өнгөт гэрэл зураг)-тэй харьцуулан үзэхэд “t-ᠲ-ᠳ-ᠲ”, “b-ᠪ-ᠪ” үсгийн хувилбар байх магадлал туйлын бага мэт. Харин “b” үсэг тэмдэгт гэж үзсэн дүрс Монголын болон Енисей, Таласын руни бичгийн дурсгалын “ᠪ, ᠪ-nt” болон “ᠪ-ᠪ” үсэг тэмдэгт байх үндэслэл харьцангуй их буй. Юутай ч “Алтан хүн” дээрх бичээсийг дахин нягтлан судлууштайг тэмдэглэе.

Сүүлийн жилүүдэд Хүннү нар үсэг бичигтэй байсныг нутлах баримт археологийн судалгаагаар илэрч олдсоор байна.

Жишээ нь, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд хийсэн археологийн малтлага судалгаагаар, 1996 онд Бурхан толгойн 26, 28-р булшнаас билүүдэж зассан, захаараа хар толботой хоёр ижил нимгэн хавтгай чулуу олдсоныг археологичид “эртний хүмүүсийн хэрэглэж байсан бийр нийлдэг чулуун янтай болох нь илэрхий байна”⁹⁸ гэж тодорхойлжээ.

Бурхан толгойн 26, 28-р булшнаас олдсон тэдгээр олдворуудыг Францын Луврын музейн лабораторид шинжлүүлэхэд зассан чулуун дээрх толбо хятад хар бэх болох нь тогтоогдсон байна. Янтай хэдийгээр хятад гаралтай эд боловч Хүннүгийн янтай нь нэгэн цаг үед зэрэгцэн оршиж асан Хан улсын янтайгаас хэлбэр, хийцээрээ эрс ялгаатай байдаг ажээ⁹⁹.

Нийтийн тооллын өмнөх 192 онд Хүннүгийн их хаан Моодун шан-юй Хан улсын хатан хаан Гао-хэү-д захидал илгээж байсан хийгээд нийтийн тооллын 46-47 оны үеийн мэдээнд хүннүчүүд газрын зурагтай байсан тухай түүхэн мэдээ¹⁰⁰ нь тэдний үсэг бичгийн боловсролыг мод чулуунд хэрчлээс гаргах тэдүйхнээр төсөөлж огт болохгүйг илтгэх бөгөөд бийр янтай, бэх хэрэглэхээр барахгүй орчуулж хэлмэрчлэх, уул ус, газар нутгаа хавтгайд буулган тэмдэглэх арга ухаан нь аль хэдийн боловсорч хэвшсэн байсныг гэрчилнэ.

Тэгээд ч Хүннү(匈奴 xiongnu)-гийн хаан Модун(匈奴冒顿 xiongnu maodun) боловсон харилцаа, ёс (дипломат)-ыг эрхэмлэн сахиж Хан(汉 han) улсын хатан хаанд захидал¹⁰¹ илгээсэн нь тийм ч бүдүүлэг улсын шинж биш гэлтэй.

⁹⁸ Д.Эрдэнэбаатар, У.Эрдэнэбат, Ц.Төрбат, Монгол-Францын хамтарсан экспедицийн тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1996, 8, 16, 69 дугаар тал; Д.Эрдэнэбаатар, У.Эрдэнэбат, Ц.Төрбат, Хүннүгийн үеийн шинэ олдворууд (Судалгааны урьдчилсан үр дүнгээс), -Археологийн судлал, Том.ХІХ, fasc.1-16, Улаанбаатар, 1999, 65-66 дугаар тал; Ц.Төрбат, Ч.Амаргүвшин, У.Эрдэнэбат, Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд, Улаанбаатар, 2003, 64-65 дугаар тал.

⁹⁹ З.Батсайхан, Хүннү, Улаанбаатар, 2003, 227 дугаар тал.

¹⁰⁰ И.Я.Бичурин, Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена, Том.І, (Том.І-ІІ, 1950/1953) Москва-Ленинград, 1950, стр.55, 117; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон (Үсэгзүйн судалгаа), - Bibliotheca Mongolica: Monograph 1, Centre for Mongol Studies, National University of Mongolia, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 16 дугаар тал.

¹⁰¹ Б.Сумьяабаатар, Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал, Улаанбаатар, 1975, 10 дугаар тал; Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть ХVІІІ (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 89-91 дүгээр тал. Хүннүгийн Модун хаанаас Хан улсын хатан хаан Гао-хэүд илгээсэн захидлыг Б.Соднам, Цоггэрэл нарын монголчилсон нь “Өнчрөн өтөлсөн эзэн би шалбааг намгийн дунд төрж, хөдөө тал газарт алуу үхэрийн дотор өсөөд, Дундад улсын дотуур зугаалахаар хүсэмжилж, таны хязгаарт хэдэн удаа нэвтэрсэн билээ. Хатан хаан та ганцаар, өнчрөн өтөлсөн би энд мөн ганцаар сууж байна. (Ингэж) хоёр эзэн уйтгарлаж сууцгааж, биестээ сэтгэл тэжээх юу ч алга байх юм. (Энэ) алга байгаа зүйлээ таны алга байгаа зүйлтэй арилжихыг хүсэж байна би.” -Ш.Эгшиг, дурдсан өгүүлэл, 90 дүгээр тал.

“Түүхэн тэмдэглэл”-д (史記) бидний үед уламжлагдаж ирсэн эл захидлын талаар “Хатан хааны хилэнг бадрааж олон түшмэлээ цуглуулж захидал авчирсан элчийг цаазлаж, Хүннү улс руу дайлаар мордохыг тушаасан боловч мэргэн сайдын үгээр арга буюу түдгэлзэж хариу бичихэд хүргэсэн гэх энэхүү бичвэрийг уншихад, хэдийгээр хятад тэмдэглэлд уг захидлыг давлиун шазруун гэж тодорхойлсон ч гэсэн хятад орчуулга бүрэн бус гэж үзэх үндэс байна. Үүнд: энэхүү орчуулгад бидний дээр өгүүлсэнчлэн захидлын хамгийн гол гэсэн зүйлийг хэсэгчлэн багтаасан бөгөөд албан харилцааны бичигт байдаг тогтсон ёсны зүйл буюу эхлэл, төгсгөлийг орхисон нь маргаангүй буй заа. Энэ нь ордоны уг тэмдэглэлд ч юм уу, эс бөгөөс Сы Ма-цяны (司馬遷) зүгээс ч юм уу, хамгийн эгзэгтэй хэсгийг нь тусгай бодлогоор хэсэглэн авсан байх магадлал ажиглагдаж байна” хэмээн захидал бүрэн эхээрээ уул түүх бичигт лавтай байхгүйг хятад судлаач Ш.Эгшиг тэмдэглэжээ¹⁰².

Хүннү нар нийтийн тооллын өмнөх 121 оны үед баттай дуулж байсан гэх хоёр дууны хятад орчуулга буй¹⁰³ төдийгүй монгол хэлнээ ч орчуулсан¹⁰⁴ билээ.

Сяньби нарын тухай, тэдний дуу шүлгийн тухай энэ мэт олон мэдээ буй.

Түүхэн сурвалжаас үзвэл тэдний тухай “Зинь шү”-гийн 108 дугаар бөлөгт дунху нар “Хүннү (匈奴 xiongnu)-тэй нэг зэрэг мандан гарсан бөгөөд нум сумт цэрэг хоёр зуу мянга (二十万) гаруй ба зан заншил, түшмэдийн цол нь хүннүтэй адил. Цинь (秦 qin), Хан (汉 han) улсын зааг үед хүннүд цохигдон Сяньби уул (鮮卑山) –нд нутаглах болсон, чингээд ийнхүү [Сяньби гэж] нэрлэгджээ”¹⁰⁵ гэж тэмдэглэсэн гэнэ. Түүхч Г.Сүхбаатар гуай Сяньби нар, Сяньби ууланд очсоноор энэ нэрийг авсан биш, харин тэднийг очсоноос хойш тэр уулыг Сяньби уул гэж нэрлэх болсон хэмээн үзсэн буй¹⁰⁶.

Наагиадч Я.Ганбаатар хятад хэлэн дэх хар үг хэллэгийн толь (Шанхай, 1984, 371 дүгээр тал)-д “Сяньби , энэ бол нэгэн төрөл араатан амьтны нэр. Эрт цагт Сяньби нар энэ амьтныг эрхэмлэн шүтдэгээс үүдэн өөрийн аймгаа түүний нэрээр нэрлэсэн. Тэгээд ч түүний дүрс бүхий аралтай бүс бүслэх агаад Сиби, Шиби гэж нэрлэдэг байжээ. Энэ Сиби бүсийг Хүннүгээр Гавраг, Гавлаг гэдгийг нангиадаар Голо, Голүо гэж дуудна гэдгээс улбаалаад Сяньби нарын шүтээн нь шар ирвэс байсан бололтой гэж үзжээ. Тэрбээр мөн О.Менчен-Хелфен зэрэг эрдэмтэд “(Сяньби) Энэ бол алтан бус, аралыг хэлсэн энэтхэг-европ язгуурын хэлний үг. Сэрби, Шэрби, Чэрби гэх мэттэй ойролцоо дуудлагатай ...” гэсэн нь сонин боловч төдий л оновчтой бус, чингэхүл түвд, самгарди хэлний “сэр”-алт гэдэг үгтэй хэлбэр талаас нь холбон тайлбарлаж ч болно. Ямар ч гэсэн энэ бол хаад дээдсийн эдэлж хэрэглэдэг алтан (аралтай) бүсийг заасан үг болох нь гарцаагүй бөгөөд “Алтан бүстэн” гэсэн утгатай нэр мөн. Монгол ёсонд эртнээс янагш бүс эрхэм чухагт тооцогдож байсныг бид мэдэх билээ. Үүнээс үндэслэн хэлэхэд: XIII зууны үеийн чэрби гэдэг цол хэргэм Сяньбитай холбогдмоор шиг байна. Сяньби бол алтан бүстэн гэсэн нүүдэлчин аймаг улсын нэр байснаа сүүлдээ цэвэр цол хэргэмийн шинжтэй үг болж хувирсан байна. “Монголын нууц товчоо”-нд гардаг Үгэлэн чэрби, Доголху чэрби, Долун чэрби-ийн чэрби гэдэг үг бол энэ үед “алтан бүстэн” гэсэн үндсэн утгаа алдаад ноёд дээдэст оноох цол хэргэмийн шинжтэй болсон байж болох талтай”¹⁰⁷ хэмээснийг анхааран үзүүштэй санагдана.

¹⁰² Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 90-91 дүгээр тал.

¹⁰³ В.С.Таскин, Материалы по истории Сиюнь, Москва, 1968, стр.47; Б.Сумъяабаатар, Монгол Сологос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуулал, Улаанбаатар, 1975, 4 дүгээр тал.

¹⁰⁴ Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 77 дугаар тал.

¹⁰⁵ 晋书(jin shu). 卷 108, 中华书局.1999. 第 1873 页. ,П.Дэлгэржаргал, Монголчуудын угсаа гарвалыг нэхэн сурвалжлахуй, (Доктор (Ph)-ын диссертаци), Улаанбаатар, 2005.

¹⁰⁶ Г.Сүхбаатар, Сяньби, Улаанбаатар, 1971, 78 дугаар тал.

¹⁰⁷ Я.Ганбаатар, Хятад хэлэнд орсон Сяньби үг, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 8(122), IV дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1997, 34-35 дугаар тал.

Сяньби нарын нилээд шүлэг найраг хятад хэлээр орчуулагдан үлджээ. Тэднээс хамгийн алдартай нь “Ахын дуу”¹⁰⁸ бөлгөө. Энэ дууг Т.Каррол¹⁰⁹, академич Л.Лигети¹¹⁰, түүхч Г.Сүхбаатар¹¹¹, Ш.Эгшиг¹¹² нар орчуулсан ажээ. Сяньби нарт холбогдох бас нэг алдартай дуу “Чилө-гийн дуу” хэмээх нэрийг олсон “Төлө (tölö)”-гийн дуу гэж байдаг байна¹¹³. Энэ дууг Л.Лигети¹¹⁴ орос, франц, Д.Цэдэв¹¹⁵, Г.Сүхбаатар¹¹⁶, Ш.Эгшиг¹¹⁷ нар монгол хэлнээ тус тус орчуулсан байна. Бас F.Tökei франц, Огава Тамаки англи хэлнээ орчуулжээ¹¹⁸. Түүнчлэн Уд модыг хугачсан дуулал, Хүрэн хэвэр морины дуу, Лан яа вангийн дуу ч гэж буй бөлгөө. Тэдний дуулахыг сонсоод, эсвээс дуу шүлгийн үгийг хэлүүлээд тэр даруй орчуулж буулгана гэж үгүй биз ээ. Энэ олон дууны цаана тэдний үсэг

¹⁰⁸ Тэд зөвхөн ном зохиол орчуулаад зогссонгүй “агань жи гэ” (阿干之歌 aganzhige) буюу “ахын дуу”-г зохион дуулсан гэж “Зинь шү”-ийн 97 дугаар бүлэг “Тогоны шаштир” болон “Вэй шү”-ийн 101 дүээр бүлэг “Тогоны шаштир”, “Сун шү”-ийн 96 дугаар бүлэг “Тогоны шаштир”-т тус тус өгүүлжээ. “Сяньби хэлээр ахы агань (阿干 agan) гэдэг, тиймээс Түгүхүнь ахыгаа дурсан санаж, [Муон] Гүй (龐 gui) “ахын дуу” (“агань жи гэ” 阿干之歌 aganzhige)-г зохион, амьдралынхаа сүүлийн жилүүдэд ихэд гуниглан энэхүү дууг байнга дуулдаг байсан” хэмээн өгүүлжээ. П.Дэлгэржаргал, Монголчуудын угсаа гарвалыг нэхэн сурвалжлахуй, (Доктор (Ph)-ын диссертаци). Улаанбаатар, 2005.

¹⁰⁹ Th.Carrol, Account of the T'u-yu-hun in the history of the chin Dynasty, Berkeley and Los Angeles, 19538 pp.4, 19-20.

¹¹⁰ L.Ligeti. Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi, -Mongolian Studies, edited by L.Ligeti, Budapest. 1970, pp.283.

¹¹¹ Г.Сүхбаатар, Сяньби, Улаанбаатар, 1971, 123 дугаар тал.

¹¹² Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 77-79 дугаар тал.

¹¹³ Энэ дууг 488-567 онд лавтайгаа дуулж байсан гэж үзэх хүн ч буй. 546 онд Умард Ци (Pei-Ts'i) улсыг байгуулсан Гао-хуан (Као-Ноуан) их цэргийнхээ хамт Дорнод Вэй (Tong Wei) улсын Ю-би (Yu-pi) цайзыг бүслэн байлдсаар хоёр сарын нүүрийг үзэж эр цэргийнхээ гуравны нэгийг алдаад сэтгэлээр унан овчин олоод байхдаа гуниг зовлонгоо мартагнах гэж Мин-юэ (Ming-yue) хочит Ху-лю Цин (Hou-liu Kin) гэгчид “Чи-лэ-гийн дуу”-г дуул гэж тушааж байсан тухай түүхнээ тэмдэглэгдэж үлдсэн бөгөөд уг дууг Сяньби хэлнээс орчуулсан гэдэг мэдээ “Умард Ци улсын түүх” (Pei Ts'i-chou, II, 14b), “...” (Tchong-kouo jen-ming ta tseu-tien, p.983b) болон O.Franke, G.Schreiber зэрэг нангиадач эрдэмтдийн бүтээлд байдаг тухай Л.Лигети академич тэмдэглэжээ. Үүнийг улам тодруулах ялангуяа дууны шүлгийн талаархи мэдээ баримт “Yo-fou che tsi” буюу “Ордоны дууны судлалд”-д байсныг F.Tökei бүтээлдээ эшлэн дурдсан байдаг (Гэвч уг дуу “Ордоны дууны түүвэр”-т багтаагүй). Үүнд: “...бачимдаж өвчин олсон... Гао-уан (=Chen Wou) цэрэг эрээс зоригжуулах гэж хүчлэн босч суугаад бүх эрхтэн дархануудаа цуглуулж Ху-лю Цин (Hou-liu Kin)-д “Чи-лэ-гийн дуу”-г дуул гэж тушаажээ. Шэн Вү (Chen Wou) ч өөрөө дагаж дуулжээ. Энэ дуу нь Сяньби хэлээрээ бүдүүн барагдуу; түүнийг Ци (Ts'i) хэлээр орчуулав. Тийм учраас шүлгийн мөрүүд нь (үеийн тоогоор Ш.Э) харилцан тэнцүүргүй болжухуй” гэсэнээ үзэхэд уг дууг сяньби хэлнээс хятадаар орчуулахдаа шүлгийн бүтцийг анхааран дагасан гэдэг нь тодорхой харагдаж байна. ... Бас “Чи-лэ-гийн дуу”-г пийнаа хөгжмөөр дагаж тоглодог байсан мэдээг Г.Шрайбер (G.Schreiber) бүтээлдээ дурдсан байдаг. Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001,80 дугаар тал.

¹¹⁴ Л.Лигети, Табгачский язык, -диалект Сяньбийского, - Народы Азии и Африки. № 1, Москва, 1969, стр. 317; L.Ligeti. Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi, -Mongolian Studies, edited by L.Ligeti, Budapest. 1970, pp.283.

¹¹⁵ Л.Лигети, Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь, орчуулсан Л.Маналжав -Хэл зохиол, VII боть, 1-13 дугаар дэвтэр, Улаанбаатар, 1969, 231 дүгээр тал

¹¹⁶ Г.Сүхбаатар, Сяньби, Улаанбаатар, 1971, 123 дугаар тал.

¹¹⁷ Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 79-83 дугаар тал.

¹¹⁸ Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 79-83 дугаар тал; F.Tökei. Poëse chinoise et poësie des peuples du Nord, - Acta Orientalia Hung., Tom.VIII, fasc.3, Budapest, 1958, pp. 317; Ogawa Tamaki, The Song of Ch'ih-le, -Chinese translation of Turkic Folk Songs and their influence on Chinese Poetry, - Acta Asiatica, No1,Tokyo, 1960, pp.43-57.

бичиг буй нь тодорхой төдийгүй сяньби нар болоод хятадууд бие биесийн хэл бичгээс харилцан шүлэг найраг орчуулж байсан гэж үзэлтэй. Тэгээд ч Сяньби улсын үед олон ном орчуулж байсан мэдээ хятадын он дараалалын бичиг, түүхэнд тодорхой тэмдэглэгджээ¹¹⁹.

Мэдээж хэрэг, тэдгээр ном зохиолыг орчуулж тэр бүрийг ханзаар буулгадаггүй байсан нь лавтай. Тэгвэл Сяньби нар ямар үсэг бичигтэй байв гэсэн асуулт зүй ёсоор гарна.

Нангад сурвалжид Дунху (东胡 donghu) –гийн хойчис гэгдэх Ухуань (烏桓 Wuhuan), мөн түүнчлэн Сяньби (鮮卑 Xianbei), Тоба (Таггачи) (拓跋 Tuoba), Түфа (禿發 Tufa) нарыг “үсэг бичиггүй” гэх мөртлөө “мод сийлж кэмү (刻木 kemu) [бичиг]-гээр тэмдэглэл үйлддэг байсан хийгээд тэдний бичиг (書字 shuzi) нь өөр хоорондоо төсөөтэй хэмээн тэмдэглэснийг эрдэмтэд олонтоо дурдсан байдаг ажгуу. Монгол нутгаас олдож буй түрэг, уйгурын үед холбогдох руни бичгийн өвөг нь кэмү (刻木 kemu) төрлийн үсэг бичиг магад мөн бололтой.

Проф.Ц.Шагдарсүрэн “...хятадын түүхэн тэмдэглэлийн зүйлд бусад улс үндэстэнд бичиг үсэг байхгүй гэж үгүйсгэсэн тохиолдолд “үсэг бичиг” гэдэг үгийг гол төлөв **wenzi** (文字) буюу “нангиад бичиг” гэсэн утга бүхий ханзаар тэмдэглэсэн байдаг ажээ. Ийм жишээ Хүн(нү) нараас гадна ухуан, сяньби, тэр ч битгий хэл, нийт даяар бичиг үсэгтэйгийг нь хүлээн зөвшөөрдөгөөр барахгүй, бичгийн дурсгал хоцрол нь бидний үед одий төдийгөөрөө уларин ирсэн эртний түрэг зэрэг улс үндэсний тухайд ч “бичиг үсэггүй” гэхдээ уг ханзыг хэрэглэсэн байдаг ажгуу. Ийм учраас судлагчид дээр дурдсан “бичиггүй” гэсэн үгийн ард “хятадын ойлголтоор” гэх буюу “хятадаар **вынь цзы** гэдэг нь зөвхөн хятад бичгийг хэлдэг” гэж тусхай тэмдэглэл үйлдсэн байдагийг анхааралгүй орхих аргагүй юм”¹²⁰ гэж тэмдэглэснийг Төв Азийн нүүдэлчдийн түүх соёл, нэн ялангуяа үсэг бичиг судлаачид “ямагт анхааруштай” санагдана.

Дээрх олон улс, аймгуудын үсэг бичиг төдийгүй хэл аялгуу ч төсөөтэй байсан буй за. Харин тэдний хэлний баримтуудыг хятад хэлнээс шүүн судалж сэргээн тэнхэрүүлэх нь тэдний угсаа гарал, хэл соёлын олон асуудлыг шийдэх чухал судалгаа болох нь дамжиггүй. Нангиад Я. Ганбаатар хятад хэлэнд орсон ху, сяньби, хятан үгийн талаар хэд хэдэн

¹¹⁹ Сүй шү”-ийн 32 дугаар бөлгийн номын бүртгэлийн хэсэгт Сяньби хэлээр бичсэн номын нэрийн бүртгэл буйг дурдлаас.

1. “国语”, 十五卷 (guoyu, shiwujuan)-Төрийн хэл, 15 бөлөг
2. “国语”, 十卷 (guoyu, shijuan)-төрийн хэл, 10 бөлөг
3. “鲜卑语”, 五卷 (xianbeiyu, wujuan)-Сяньби хэл, 5 бөлөг
4. “国语物名”, 四卷 (guoyuwuming, shijuan)- төрийн хэлээрх юмны нэр, 4 бөлөг. Хоуфухоу цолтой Кэси мин зохиосон.
5. “国语真歌”, 十卷 (guoyuzhenge, shijuan)- төрийн хэлээрх жинхэнэ дуунууд, 10 бөлөг
6. “国语杂名”, 三卷 (guoyuzaming, sanjuan)- төрийн хэлээрх янз бүрийн номын нэр, 3 бөлөг Хоуфухоу цолтой Кэси мин зохиосон.
7. “国语十八傅”, 一卷 (guoyushibafu, yijuan)- төрийн хэлээрх 18 наадиг, 1 бөлөг
8. “国语御歌”, 十一卷 (guoyuyuge, shiyijuan)- төрийн хэлээрх ордны дуу, 11 бөлөг
9. “鲜卑语”, 十卷 (xianbeiyu, shijuan)-Сяньби хэл, 10 бөлөг
10. “国语号令”, 四卷 (guoyuhaoling, sijuan) -төрийн хэлээрх зарлиг тушаалууд, 4 бөлөг
11. “国语杂文”, 十五卷 (guoyuzawen, shiwujuan)-төрийн хэлээрх янз бүрийн зохиолууд, 15 бөлөг
12. “鲜卑号令”, 一卷 (xianbeihaoling, yijuan)¹¹⁹-Сяньбийн зарлиг тушаалууд, 1 бөлөг Жоугийн эзэн хаан У-ди зохиосон гэх эдгээр бүтээлүүдээс гадна

13. 国语孝经, 一卷 (guoyuxiaojing, yijuan)-ачлалт ном төрийн хэлээр, 1 бөлөг зохиолыг нэрлэж болно. П.Дэлгэржаргал, Монголчуудын угсаа гарвалыг нэхэн сурвалжлахуй. (Түүхийн ухааны доктор (Ph)-ын диссертаци). Улаанбаатар, 2005.

¹²⁰ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон (Үсэгзүйн судалгаа), - Bibliotheca Mongolica: Monograph 1, Centre for Mongol Studies, National University of Mongolia, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2001, 12 дугаар тал.

өгүүлэл¹²¹, Ш.Эгшиг хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс сурвалжилан судалсан байна¹²². Профессор Ц.Шагдарсүрэн Хүннү (Шюннү) нарын хэлний баримтаас¹²³, Ухуани нарын хэлний нэг баримт [ku-ku <*ku-kwet –“хөхөл” (kōkūl)], мөн Тоба¹²⁴, Авар¹²⁵ нарын хэлний баримтаас дурдсан томоохон өгүүлэл¹²⁶ нийтлүүлсэн нь энэ чиглэлийн судалгааны суурь бүтээл болжээ.

Энэ мэтчилэн түрэг, уйгурын үед холбогдох руни бичгийн дурсгалын үгийн санг аль болох өмнөх үеийн түрэг, монгол хэл, төрөл хэлнүүдийн их хэрэглэгдэхүүнтэй харьцуулж, бат нуттай баримтаар сурвалжлан судалбал монгол түрэг хэлний судлалд үлэмж чухал ач холбогдолтой ажил болох нь лавтай.

Академич Д.Төмөртоогогийн монгол хэлний түүхэн авиазүй¹²⁷, монгол хэлний хөгжлийн түүх, монгол хэлний авиа, үгийн түүхэн хувьсалын талаарх бүтээлүүд¹²⁸, Б.Ринчен академич¹²⁹, Ж.Надмид¹³⁰, Ш, Чоймаа¹³¹, М.Базаррагчаа¹³², Мандах нар¹³³,

¹²¹ Я.Ганбаатар, Хятад хэлэнд орсон Сянбы үг, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 8 (116), 1-17 дэвтэр. МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1997, 31-36 дугаар тал; Я.Ганбаатар, Хятад хэлэнд орсон Хятан үг, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 10 (122), 1-17 дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1997, 20-26 дугаар тал; Я.Ганбаатар, “Ху”-гийн тухай, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 13 (139), МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1998, 129-138 дугаар тал; Я.Ганбаатар, Нүүдлийн соёл иргэншлийн түүхийг эртний яруу найргийн зүйлээс эрэлхийлэх нь, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIV (139), МУИС, Монгол судлалын сургууль, Улаанбаатар, 1999, 137-148 дугаар тал.

¹²² Ш.Эгшиг, Хятад орчуулга болон галигаар хүрэлцэн ирсэн монгол хэрэглэгдэхүүний зүйлээс, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть XVIII (178), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 76-108 дугаар тал; Ш.Эгшиг, Хятадын Шаньдун муж дахь Монгол үндэстний гэрэлт хоошөөний учир, Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIV (151), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 149-161 дүгээр тал.

¹²³ Шүннү нарын хэлийг, П.Р. Паллас (P.R.Pallas), Б.Бергман (B.Bergmann) нар монгол, Абель-Ремюза (Abel-Remusat), Ж.Кларрот (J.Klaproth), К. Ширатори (K.Shiratori, 1902), О.Прицак (O.Pritsak, 1954) нар түрэг, Сэнт-Мартин (Saint-Martin) фин, Е.Паркер (E.A.Parker), Л.Кайн (L.Cahun) нар түрэг-монгол дундын, К.Ширатори (K.Shiratori, 1923) монгол-хамнинг дундын, М.А.Кастрен (M.A.Castren) түрэг-монгол-хамнинг-фин дундын, Э.Мүүр (E.Moor, 1963) иран, Л.Лигети (Ligeti, 1950), Е.Г. Пуллейблэнк (E.G. Pulleyblanc, 1962) нар Горлог буюу Енисейн саваар нутаглаж байсан Хет нарын хэлний бөлөгт багтана гэж янз бүрээр үзсэн байна. Харин баруун тийш нүүн одсон хүннү нарын хэлний тухайд герер-европ зүгийн баримт ээлтэд тулгуурлан Дегинь (Deguignes), П.Р. Паллас (P.R.Pallas) нар монгол, Абель-Ремюза (Abel-Remusat), Сэнт-Мартин (Saint-Martin) нар фин, Венелин (Venelin), Иловайский (Ivolajskij), Флоринский (Florinskij) нар слав. Ж.Кларрот (J.Klaproth) мажар, К.Иностранцев (K.Inostrancev) түрэг-фин дундын, Э.Мүүр (E.Moor) кавказ, О.Прицак (O.Pritsak), В.В.Бартольд (V.V.Barthold) нар балгар-түрэг, Алтхайм-Стиел (Altheim-Stiehl) эртний түрэг хэлтэн байсан гэж үзжээ. Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм (Эргэцүүлэл), -Эртний монгол хэлний судлал, Монгол судлалын сонгомол өгүүлэлийн эрхи I хэлмэли: монгол бичиг, II дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1999, 86-92 дугаар тал.

¹²⁴ Тоба нарын гарлын талаар хятад сурвалжид зөрөөтэй мэдээ байдаг боловч хэлний үүднээс тэд ямар ч атугай сяньби хэл буюу наад зах нь сяньби хэлний нэг аялгуугаар ярьдаг байсан нь эргэлзээгүй гэж эрдэмтэд үзээр байна. Ц.Шагдарсүрэн, мөн тэнд, 94-98 дугаар тал.

¹²⁵ Хүннү, Жүжаны холбоонд багтаж байгаад 555 онд Жүжан нарыг Түрэгүүдийн харьяат болоход дагаж орохгүй гээд ала баруун тийшээ их нүүдлээр одсон Дунай (I) Аваруудын хэлийг судласан академик Янош Харматта болон Самүэл Шадецкий-Кардос нарын бүтээлээс үзэхэд kaghan, khan(?), dar kghan, tudun, tarkhan, katun, yugurus гэх зэрэг нэр томъёоны чанартай үгс, Ap sich, Bayan, Ermitzias, Koch, Samur, Solachos, Targites зэрэг хүний нэр буй бөгөөд монгол хэлний үүднээс авч үзэхэд “цөөдхөөргүй” сонин дурсгал гэж хэлж болно. Ц.Шагдарсүрэн мөн тэнд, 100-102 дугаар тал.

¹²⁶ Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм (Эргэцүүлэл), -Эртний монгол хэлний судлал, Монгол судлалын сонгомол өгүүлэлийн эрхи I хэлмэли: монгол бичиг, II дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1999, 67-126 дугаар тал; Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм (Эргэцүүлэл), mongolian Studies, The Korean Association for Mongol Studies, 2000, pp.61-140.

¹²⁷ Д.Төмөртоого, Монгол хэлний түүхэн үндэс (Монгол хэлний авиазүй), I дэвтэр, Улаанбаатар, 1992.

¹²⁸ Д.Төмөртоого, Монгол хэлшинжилгээний онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002.

¹²⁹ Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, I-IV, Улаанбаатар, 1964.

¹³⁰ Ж.Надмид, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм, Улаанбаатар, 1967.

¹³¹ Ш.Чоймаа, Монгол судлалын өгүүлүүд, Улаанбаатар, 2003.

¹³² М.Базаррагчаа, Монгол хэлний үгийн гарлыг мөшгөх нь, I-Y, Улаанбаатар, 1992-1995.

¹³³ Ö.Manduču, Garudı, Yuan Sou, Dumdadu erten-ü mongyol kele, köke qota, 1997.

Хасбагана¹³⁴, Гарьд¹³⁵ нарын зэрэг монгол эрдэмтдийн туурвисан дундад зуун хийгээд дундад эртний монгол хэл, сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын судалгаа, үгийн гарлын судалгаа, мөн И.Я.Шмидт¹³⁶, А.Бобровников¹³⁷, Г.И.Рамстедт¹³⁸, Б.Я.Владимирцов¹³⁹, Н.Поппе¹⁴⁰, Г.Д.Санжеев¹⁴¹, М.Вайерс¹⁴² зэрэг гадаадын нэрт судлаачдын сонгодог монгол бичгийн өмнөх үетэй холбогдох суурь бүтээлүүдийг энд бас холбогдуулан дурдаж болно.

Учир нь төрөлх эх хэл, тодруулбал өвөг болоод эртний монгол хэл, ер монгол хэл, салбар аялгуунуудынхаа авиазүй, хэлзүйн онцлогийг мэдэхгүйгээр түрэг хийгээд түрэг төрөл хэл, эртний түрэг хэл, руни бичгийн дурсгалыг судлана гэдэг боломжгүй зүйл.

Гэхдээ хэт явцуурч нэг хэлний түлхүүрээр бусад хэлүүдийн нууцын цоожийг онгойлгох гэж дэмий оролдох бус, дан ганц хэлний цонхоор харж бүгдийг тайлбарлах гэж хичээх биш уг хэлний хөгжлийн эрт, дунд, хожуу үеийг зөв сэргээн тэнхэрүүлсэн, төрөл хэлүүдтэй нь харьцуулсан судалгаа хийх шаардлагатай юм.

Түрэг, монгол хэлний харьцуулсан судлалаар сүүлийн найман жилд олон өгүүлэл, бүтээл хэвлэгдсэнээс А.М.Щербак¹⁴³, Го.Зоригт¹⁴⁴ нарын ном, М.Ууганбаярын докторын бүтээл¹⁴⁵ зэргийг дурдаж болно.

Руни бичиг судлагч, түрэг судлаач манай эрдэмтэд цаашид бичээсийг зөвхөн тайлж унших бус хэлшинжлэлийн үүднээс онолын үндэстэйгээр судлах шаардлагатайг энэ далимд онцлон тэмдэглэе.

¹³⁴ Qasbayan-a, Dumdadu jayun-u mongyol kelen -ü sudulul, köke qota, 1996.

¹³⁵ Garudi, Dumdadu erten-ü mongyol kelen -ü sudulul, köke qota, 2001.

¹³⁶ I.J.Schmidt, Grammatik der mongolischen Sprache, Sankt-Peterburg, 1831; И.Я.Шмидт, Грамматика монгольского языка, Санкт-Петербург, 1832.

¹³⁷ А.А.Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849.

¹³⁸ G.J.Ramstedt, Das Schrift mongolische und die Urgamunder phonetisch Verglichen, Journal de la Société Finno-Ougrienne 21, 1903; Г.И.Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-урганского говора, Санкт-Петербург, 1908; Г.И.Рамстедт, Монгол ном бичгийн хэл хүрээний аман аялгуу хоёрыг авиазүйгээр харшуулсан нь, герман хэлнээ орчуулсан Г.Лувсанцэрэн, -Хэл зохиол, Боть IV, Улаанбаатар, 1967, 115-169 дугаар тал.

¹³⁹ Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, В ведение и фонетика, Ленинград, 1929.

¹⁴⁰ Н.Н.Поппе, Грамматика письменно-монгольского языка, Москва-Ленинград, 1937; N.Poppe, Grammar of Written Mongolia, Wiesbaden, 1954.

¹⁴¹ Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Том I, Москва, 1953; Г.Д.Санжеев, Старописьменный монгольский язык, Москва, 1964.

¹⁴² M.Weirs, Untersuchungen zu einer historischen Grammatik des präklassischen Schriftmongolisch, -Asiatische Forschungen, Bd.28, Wiesbaden, 1969.

¹⁴³ А.М.Щербак, Ранние тюркско-монгольские языковые связи (VIII-XIV вв.), Санкт-Петербург, 1997.

¹⁴⁴ Го.Жоригт, Mongyol törl-ün kele ba түрүк төрөл-үн келен-ү үгес-үн қаріаулуысан судулul, köke qota, 2000.

¹⁴⁵ M.Uganbayar, Türkiye Türkçesi ve Halha Moğolcasında fiil zaman şekilleri, Ankara Üniversitesi, Dil ve Tarih-Coğrafya Fakültesi, Çağdaş Türk Lehçeleri ve Edebiyatları Bölümü, Ana Bilim Dalı, Ankara, 2004.

1.2.3. Тамга тэмдэг хийгээд руни бичиг

Монголын руни бичгийн сонгодог болоод бага дурсгалуудыг тамга тэмдгээс ангид авч үзэх, тамга тэмдэггүйгээр төсөөлөхөд бэрхтэй.

Гэрэлт хөшөө, хад чулууны бичээсийн хамт байх тамга тэмдэг уг хөшөө босгуулагч, дурсгал үлдээгч, үйлдэгчийн овог, аймагтай холбоотой гэж үзэж болох ч тэдгээрийн чанад утга, бэлгэдэл санааг ухааж мэдэх, тайлж унших нь туйлаас чухал болохыг өгүүлэх юун.

Монголын руни бичгийн дурсгалууд хамт орших олон тамга тэмдэг чухам ямар овог аймгийнх болохыг ялган салгаж баг нуттайгаар оноон тогтоосон судалгаа чамлалтай, ашина овгийн тамга “янги́р” гэхээс цаашгүй байна. Тамга тэмдэгийг хөшөө дурсгалын он цагаар барамжаалан түрэгийн, уйгурын тамга гэж ерөнхий ангилдаг нь ч үнэхээр учир дутагдалтай юм. Эртний овог аймгийнхны хувьд тамга нь сүлд бэлгэдэл, хамгаас эрхэм зүйл учраас дайн тулалдаан болсон газар нутаг, ав хоморго хийсэн уул ус, онгон тахилга, хөшөө чулуу, шүтлэгт уул, бууц сууцныхаа хад чулуунаа овгийн тамгаа сийлж үлдээдэг уламжлалтай байсан бололтой. Тэгээд ч тамгаар барагцаалан аль овгийнхны нутаг, ямар овгийн хүний хөшөө дурсгал, хэн хэний овгийнхон ав хоморого хийсэн хийгээд яваар ирээр одсон, аль овгийнхны нутаглаж асан нутаг зэргийн мэддэг байсан биз ээ.

Тамга гэж тус тусад нь бус салгаж бус хаданд цохисон эх байдлаас нь үзэхэд бичиг баймаар тамга ч олон бий. Монгол нутаг тамга тэмдэг, зургаар нэн баян ч өнөөг хүртэл гагцхүү үсэг бичгийн зүйлийг тайлан унших, судлах нь голлож харин элдэв зүйл тамга тэмдэгийн үсэг бичигтэй холбогдох хийгээд түүний утга санааг бусад бичиг лүгээ харьцуулан тайлж унших судалгаа оролдлого туйлын бага, хомс байсаар иржээ.

Иймд тамга судлалаар тухайлсан судалгаа хийвэл эрхбиш Жужан (Авар) биш юм аа гэхэд Түрэгийн буюу тогтож хэвшсэн руни бичиг (Зүүн Түрэгийн хаант улс, Уйгурын үеийн сонгодог болоод бага бичээс)-ээс өмнөх үеийн руни үсэг тэмдэгт хэлбэрийн, эртний улс, аймгуудад холбогдох үсэг бичиг, бичээс олдох нь лавтай. Монгол нутгаас олдож буй руни бичгийн дурсгалууд ихэвчлэн олон мөр, цөөндөө л нэг мөр ба тэдгээр нь хэд хэдэн (5-аас дээш) тэмдэгтээс бүрддэг тул хоёр гурав буюу таруу бичигдсэн тамга бичээсийг бичиг хэмээн тоож тооцдоггүй, хаа сайгүй тохиолдох тамга хэмээн “үл тоомсорлон, баярхах” муу зуршил бий.

Монгол нутаг дахь тамга тэмдгийг *хөшөөний тамга, хад чулууны тамга, эд өлөг дээрх тамга, малын тамга* гэсэн үндсэн дөрвөн зүйлд хуваан үзэж болох юм.

Монгол нутагт эртний тамга, тэмдэг судлалын үндсэн эх хэрэглэгдэхүүн болсон олон дурсгал буйгаас Хэнтий аймгийн Биндэрийн Рашаан хад, Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны тамга зураг, Булган аймгийн Баян-Агт сумын нутаг, Хануй, Хүнүй голын бэлчир дэх Шивээт Улааны тахилын онгоны цогцолбор дурсгалын засмал дөрвөлжин чулуун суурьтай, дан тамгаас бүтсэн гэрэлт хөшөө бусдаас илүү онцлог ажээ.

Хад чулуу, хөшөөнөө сийлсэн болоод археологийн малтлага судалгаагаар илэрч байгаа эд өлгийн зүйл дээрх тамга, тэмдгийн бэлгэдэл санаа, учир холбогдол, илэрхийлэх утга зэргийг шинжлэх нь дан ганц тамга судлалд ч төдийгүй үсэг бичиг судлалд ч чухал ач холбогдолтой юм.

Тамга тэмдэгтэд холбогдох манай эрдэмтдийн бүтээлийг ерөнхийд нь үзвээс хад чулуу, гэрэлт хөшөө, эртний эд өлгийн зүйл дээрх тамганы судалгаа, овог аймаг, малын тамга зэргийг харьцуулсан холимог шинжтэй судалгаа, мөн монгол угсаат олон овог, ястан элхэний тамгын дагнасан судалгаа эдгээр болно. Үүнд, Нэрт түүхч Х.Пэрлээ гуай “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь”¹⁴⁶ бүтээлдээ Монгол нутаг дахь олон зүйл (хад, гэрэлт хөшөөний болоод овог аймаг, эд өлөг, малын гэх мэт) тамга, тэмдгийг Төв Азийн бусад нүүдэлчдийн тамгуудтай харьцуулан судалсан нь өнөө чухал эх хэрэглэгдэхүүн болсоор буй билээ. Угсаатны зүй, түүхийн судалгааны хүрээнд монголын олон ястан, овог

¹⁴⁶ Х.Пэрлээ, Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь, Улаанбаатар, 1976.

элкэний тамгыг дагнаж шинжилсэн нийтлэл, өгүүлэл, тамганы бэлгэдэл зүйн талаар ном гарчээ¹⁴⁷.

Тамганы тухайд дээрх мэт судалгаа буй боловч тэдгээрийг зураг бичиг, санаа бичигтэй холбон шинжилсэн нь үгүй бололтой.

Харин гадаадын эрдэмтдээс Монгол нутаг дахь тамга тэмдэг, дүрс зургийн зүйлийг эх хэрэглэгдэхүүн болгон ашиглаж зураг бичгийн хүрээнд судлан шинжилсэн бүтээл мэр сэр буй. Энэ чиглэлээр гарсан хамгийн сүүлийн үеийн бүтээлд А.В.Тиваненкогийн “Төв Азийн болон Сибирийн хадны зураг бичиг”¹⁴⁸ хэмээх номыг нэрлэж болно. “Судалгааны тойм (К истории вопроса)”, “Үсэг бичиг тайлж унших онолын асуудал (Теоретические вопросы дешифровки)”, “Үсэг бичиг тайлан унших эх сурвалж (Источниковая база дешифровки)”, “Үсэг бичиг тайлан унших ерөнхий зарчим (Основные принципы дешифровки)” гэх дөрвөн бөлгөөс бүтэх уг бүтээлд хадны зураг, тамга тэмдэг, зураг бичээсийг өргөн хүрээг хамруулан системтэй судлан тайлбарлахыг эрмэлзжээ.

Мажар, Хазар Булгар, ихэвчлэн Европоос олдож илэрсэн тамга тэмдэгтэд тулгуурлаж “Prototürk” хэл¹⁴⁹, бичиг гэгдэх тамга тэмдэг, элдэв дүрс тэмдгийг уншиж тайлах судалгаа хийгджээ. Тухайлбал, Казым Миршан (Kâzım Miršan) 1970 оноос эхлэн “Prototürk” хэл бичгийн талаар сонирхолтой хэд хэдэн ном хэвлүүлжээ¹⁵⁰. Түүний судалгаа нь тамга тэмдэгтүүд, тэдгээрийн илэрхийлэх утгыг тайлж уншихад чиглэсэн байна.

Уг судалгаанд тулгуурлан Халук Таржан (Halûk Tarcan) эртний түрэгүүдийн үсэг бичгийн гарал үүсэл, хувьсал, утга бэлгэдлийн талаар тусгайлан ном бичсэн ажээ¹⁵¹.

Энэхүү “Prototürk” хэмээн томъёолсон тамга тэмдэгтийн утга санааг тайлан унших оролдлого судалгааг ч бид цаашид анхааран үзүүштэй.

Хэдийгээр шууд холбогдолгүй ч тамга судлалд нэмэр санаж монгол угсаатны болоод сурвалжид тэмдэглэгдсэн тамганы талаарх зарим мэдээ сэлтийг цухас өгүүлье.

Түүхэн сурвалжуудын мэдээнд тулгуурлан овог аймгийн тамгыг язгуур тамга, соёрхосон тамга, холимог тамга хэмээн хуваан үзэж болох юм.

Язгуур тамга

Нэг аймгийн овог элхэн олноор салбарлан гарсан ч язгуур тамгаа гол болгож, түүний хувилбар тамга буй болгон өвлөдөг байсан нь монгол овог аймгуудын тамганаас

¹⁴⁷ Х.Пэрлээ, Эртний монгол овгийн тамганы товч учир, - Шинжлэх ухаан амьдрал, № 2, 1975, 79-80 дугаар тал; Д.Доржравдан, Захчин ясны малын уламжлалт им тамга, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, № 3, 1961, 69-72 дугаар тал; Б.Цэрэл, Дорвөд, Баядын малын им, тамгын тухай, Шинжлэх ухаан амьдрал, № 6, 1967, 39-41 дугаар тал; Г.Сүхбаатар, О тамгах и мах табунов Дариганги, - Studia Ethnographica, Tom. 1, fasc.6, Улаанбаатар, 1960; Luvsanjav, Choi, Some Brands of two districts of Westren Mongolia, -Эрдэм шинжилгээний сонсгол, МУИС, № 12, Улаанбаатар, 1968, 12-14 дүгээр тал; Н.Намсрай, Өөлдийн гарал заншлын тухай, - Түүхийн судлал, Том XXII, Улаанбаатар, 1989, 87 дугаар тал; Г.Мэнэс, Захчин, -Монгол улсын угсаатны зүй 2, (Ойралдын угсаатны зүй), Улаанбаатар, 1996, 334-360 дугаар тал; Ц.Гантулга, Алтайн Урианхайчууд, Улаанбаатар, 2000, 166-169 дугаар тал; А.Очир, Т.Дисан, Монгол Улсын Өөлдүүд, Улаанбаатар, 1999, 92-95; С.Дулам, Дүрсийн бэлгэдэл зүй, Тамгадын бэлгэдэл зүй, -Монгол бэлгэдэл зүй, гутгаар дэвтэр, Дүрсийн бэлгэдэл зүй, Дохио зангааны бэлгэдэл зүй, Улаанбаатар, 2001, 3-110 дугаар тал.

¹⁴⁸ А.В.Тиваненко, Наскальная пиктографическая письменность Центральной Азии и Сибири (Основные принципы дешифровки), - Новосибирский Институт Экономики и Менеджмента, Кафедра Гуманитарных Наук, Улан- Удэ, 2003.

¹⁴⁹ Bazin L, Un texte prototurc du IV-ème siècle du distique Hiong-nou de Tsин-chou, -Oriens.Vol.1, 1948.

¹⁵⁰ Kazım Miršan, Prototürkçe Yazıtları, Ankara,1970; Altı Yarıq Tigin (Altı Sпetrum Aksionu), Ankara, 1978; Anadolu Prototürkleri, Ankara, 1985; Alfabetik Yazı Başlangıcı, Bodrum, 1994; Side Bitigtaşları, Bodrum, 1995; Preportekiz Bitigtaşları, Bodrum, 1996; Etrüskler, Tarihleri, Yazıları ve Dilleri, Bodrum, 1998; Türk Takvimi, Bodrum, 1999; Prototürkische Grammatik, 1993, Preportungiesische Inschriften, 1996; Die Spuren des Prototürkischen in verschiedenen Sprachen, 1996; Eттürkhische Inschriften, 1997.

¹⁵¹ Halûk Tarcan, Ön-Türk Tarihi, Istanbul, 1998.

тодорхой харагддаг. Тийнхүү нэн эртнээс уламжлагдсаныг язгуур тамга гэж нэрлэж байгаа юм. Жишээ нь,

Гал тамгатай Өөлдүүд

Ганзага имтэй Өөлдүүд

Галданбошготын Өөлдүүд гэх буюу

Дөрвөн нүдтэй халтар

Долж хуцаад байна

Дөрвөд, Урианхай хоёрын хэн нь бол?

Нуг нуг шогшиж явбал Дөрвөд л биз

Нуман тамгатай, шуугиулж явбал Урианхай л биз гэх мэтээр ардын дунд

хэлэлцсээр иржээ. Урианхайчууд нуман тамгатай бөгөөд түүний хорин хэдэн хувилбар буй, Өөлдийн гал тамга ч мөн төдий олон хувилбартай билээ.

Х.Пэрлээ гуай “Овгууд шинээр салбарлах тусам овгийн хуучин үндсэн тамганы дүрсэнд нэмэлт зүүлт хийж үүсгэмэл тамга нэмэгдэхийн хамт шинэ үндсэн тамга ч гаргаж, овгийн нийт тамга олширч, олон овгийн их хуралдай цуглаанд ирэгчид, тэр цагийн нэртэй сүртэй хад цохионд тамгаа сийлж хоцоргох, нийгэм олноор хэрэглэх ус болчээрийг эзэмших эдлэх эрхээ бататган, мөн тэндэхийн хад чулуунд нэгэн дор овгийн тамгаа сийлэн үлдээх явдал байжээ”¹⁵² хэмээн нэгэнтээ тэмдэглэсэн буй.

Проф.Ц.Шагдарсүрэн “Хил хязгаарын зааг газар, уул даван дээр овоо босгон тэмдэглэдэг, хад чулуун дээр тэр газрынхаа нэрийг сийлж тэмдэглэдэг, түүнийгээ нутгийн дээс хэмээж нэрлэдэг байсан” тухай тэмдэглээд Түшээт хан аймгийн Зоригт вангийн буюу Гүнцэл чивчид уулын хошууны нутагийн нэгэн дээс, одоогийн Төв аймгийн Эрдэнэ-Сант сумнаа хадан дээр “Гүнцэлийн Цүүгэл булаг энэ” хэмээн сийлсэн байдгийг жишээ татаж бичээсийн хэвийг хавсаргажээ¹⁵³.

Нутгийн хил заагийг овоо босгох, газрын нэр бичихээс гадна овог аймгийнхаа тамгыг сийлж тодотгон заагладаг байжээ. Нэгэн баримт, домог дурдваас, Урианхайн баруун гарын өвгөн ноён Жожоо нь Амгалан зангид “Захчин хошууных манай нутгаас газар авна гэж хятадын хэв амбанд зарга мэдүүлжээ. Би очиж хэлэлцээд чадсангүй. Чи очиж үз!” гэжээ. Амгалан зангийг очиход Хэв амбан “Захчин, урианхайн хошууны нутгийн хилийг дээр үед танай Хужирт голын амаар тогтоосон байжээ. (Энэ нь одоогийн Баян-Өлгий аймгийн Булган сумын төвийн доод талд Булган гол цутгадаг, зүүнээс нь орсон Хужирт хэмээх гол юм) Захчин хошууны ноёдын заргын бичгийг бие хүн авч иржээ. Таних тэмдэг ч байна гээд уулын хавтгай чулууны нэг талд нь Урианхайн нуман тамга, нөгөө талд нь Захчны дэгрээ тамгыг сийлсэн чулууг гаргаж үзүүлээд энэ тамгат чулуу Хужиртын амны Бор толгой дээрх Хялгасан үүрт хадгалагдсныг авч иржээ гэж гэнэ. Ийм явдал болохыг Амгалан занги урьдаас мэдсэн тул Хужиртын уулаас нэг хавтгай хөх чулуу ганзаглаж очсон байж. Уг хоёр чулууг зэрэгцүүлж үзэхэд нэг газрын чулуу биш нь тодорхой болжээ. Тамгатай энэ чулуу манай нутгийн чулуу биш, Захчин нутгийнх байна. Угаасаа энэ хоёр хошууны хилийг ингэж тогтоосон нь түүхэнд үгүй билээ. Энэ чинь зохиомол баримт байна. Би зөвшөөрөхгүй ...гэжээ. Хэв амбан Захчин хошуунаас хатан авсан учраас Урианхайн нутгаас газар авч өгөхөөр Захчин хошууны ноёнттой хувилдаад Урианхайн зангийг дийлээгүй юм гэдэг. Эндээс санаа сургаж авч Урианхайн ноёд Захчин хошуутай хэлэлцээ хийн, нутгийн хилийг тогтоохоор болж одоогийн Баян-Өлгий аймгийн Булган сумын Дээд Нарийны зүүн салааг Захчин хошуунд өгч, Захчин салаа нэр өгсөн нь одоо ч тэр хэвээр нэрлэгдсээр байна. Тэр үед Захчин хошууны хүрээ хийд одоогийн Баян-Өлгий аймгийн Булган сумын Цүнхэл багийн зуслан Дуганы эргийн эхэнд байсан аж. Урианхайн Долдаа Амгалан Захчин хошууны хүрээнд очиж, дуганы дотор нь “мөрөө үзэж” баганыг нь бүсэндээ хавчуулж аваачсан сүхээрээ цавчихаад ноёных нь гэрт ороход ноён нь:

¹⁵² Х. Пэрлээ, Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь, Улаанбаатар, 1976, 9 дүгээр тал.

¹⁵³ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын утга соёлын товчоон, Bibliotheca Mongolica: Monograph II, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Ulaanbaatar, 2003, 20 дугаар тал.

- Та сүм дуганы дотор мөрөө үзэж баганыг цавчлаа. Улаан залаат хүн байтлаа шажин төрд харш зүйл үйлдлээ” гэхэд Долдаа* Амгалан:

- Би Захчин хошууны сүм дуган дотор “мөрөө хараагүй, өөрийнхөө нутгийн газарт мөрөө харав” харгай мод цавчлаа гэжээ. Захчин хошууны сүм байгуулагдсан газар үнэхээрийн Урианхайн хошууны нутаг байсан тул дуугарч чадаагүй, удалгүй сүм дуганаа нүүлгээд явсан гэдэг. Одоо ч гэсэн байшин балгасны суурь, элдэв ул мөр нь арилагагүй байгаа билээ. Дээр дурдсан явдлаас болоод албан ёсны хилээ тогтоож Мухар Нарийн, Үй хэв хэмээх газраар нутгаа зааглаж том хадны нэг талд Урианхайн нуман тамга, нөгөө талд нь Захчины дэгрээ тамгыг сийлсэн нь одоо ч Үенч, Булган сумын хилийн тамгат багана болсон хэвээрээ ба тэр газрыг Тамгат гэж нэрлэдэг байна¹⁵⁴.

Эдгээр мэдээ монгол овог, аймгийн язгуур тамганы талаарх нилээд хожуу үеийн жишээ юм.

Соёрхсон тамга

Хаад ихээхэс гавъяа зүтгэлт хүмүүст тамга соёрхож өгснөөр тэдний овог, аймаг шинэ “соёрхсон тамга”-тай болох тохиолдол ч байсан бололтой.

Жишээлбэл, татар хэл, араб бичгээр уламжлагдсан “Däftär-i Ćingiz-nāmā” сурвалжид Чингис хаан овог, аймгуудад тамга, уриа, шувуу соёрхсон тухай мэдээ байна¹⁵⁵. “Däftär-i

* Долдаа хэмээх нэр магадгүй төвд хэлний “ ᠰᠢᠭᠳᠣᠯ -дол” гэтэлгэх, нангиад хэлний “ ᠰᠠ da-da ” их гэсэн хоёр үгийг нийлүүлж (дол-да), мэргэн ухаан, арга самбаагаараа хошуу нутгаа олон удаа авран гэтэлгэж байсан учраас “ гэтэлгэгч их буюу их гэтэлгэгч-Дол да” хэмээх өргөмж нэр хайрласан байж болох юм.

¹⁵⁴ Нуман тамгат хадны домог, -Захчин ардын аман зохиол, Эмхтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний удиртгал бичсэн, Б.Катуу, Э.Пүрэвжав, Улаанбаатар, 2004, 206-208 дугаар тал.

¹⁵⁵ Däftär-i Ćingiz-nāmā, үгчилсэн орчуулга, [f.23r] (1) Түүний хойно Жингиз хаан тэрхүү ноёдын (2) хэсэгт тус бүрт нь тамга, шувуу, мод уриа (3) өгч багц нэгдмэл ард болгон салгав. Урьд (4) эхэлж Бодонжарын ховгүүн Кыяат-д айлдав: Чиний (5) мод чинь харгай болог. Шувуу чинь шонхор (6) болог. Уриа чинь Ару Жаан болог. Тамга чинь (7)

чодор өвс болог. өөрөөр хэлбэл өвсөн тамга болог хэмээв. (8) Дүрс нь энэ буюу X Мөн түүний хойно (9) Жингиз хаан Конграт ноёны ховгүүн Сэнглэ-д айлдав: Аяа (10) Сэнглэ чиний мод чинь алимны мод болог. Шувуу чинь (11) начин

болог. Уриа чинь Конграт болог (12) тамга чинь саран тамга болог Дүрс нь энэ буюу O (13) Мөн түүний хойно Жингиз хаан айлдав: Аяа Уяшын (14) Маякы ноён чиний мод чинь хар мод болог. (15) Шувуу чинь хар шувуу болог. Уриа чинь

Салават болог. (16) тамга чинь шөрөг болог. Дүрс нь энэ буюу U [f.23v] (1) Мөн түүний хойно Жингиз хаан Ордаж ноёд айлдав: Аяа (2) мянган саадат Ордаж, өөрөөр хэлбэл мянган Тэмэжлик Түүнээс (3) үлдсэн Ордаж ноён маш л баян хүн болгоё. Тулаанд (4) гарах болбоос мянган саадат хүнтэй гарах болгоё. (5) Жингиз хаан Ордаж-л айлдав: Аяа Ордаж чиний мод чинь (6) хус болог. Шувуу чинь харцага болог. Уриа чинь Алаж (7) болог. Тамга чинь шувуун хавирга болог

хэмээв. Дүрс нь (8) энэ буюу S Мөн түүний хойно Жингиз хаан (9) айлдав: Аяа Тамяан ноён чиний мод чинь

улиангар болог. Шувуу чинь хяргуй болог. Уриа чинь Тутяа болог. (11) тамга чинь дэгээ болог. Дүрс нь энэ буюу P (12) Мөн түүний хойно Жингиз хаан айлдав: Аяа Кыпчак (13) ноён чиний мод чинь хайлаас болог. Шувуу чинь Бүргэд (14)

болог. Уриа чинь Ток Саба болог. Тамга чинь (15) сам болог. Дүрс нь энэ буюу JE (16) Түүний хойно Жингиз хаан айлдав: Аяа (17) Жорматы ноён чиний мод чинь уд мод болог. Шувуу чинь [f.24r] (1) идлэг шонхор болог уриа чинь Ак

Тайлак болог. Тамга чинь (2) Сыныл Сигэж болог хэмээв. Дүрс нь энэ буюу Y (3) Түүний хойно Жингиз хаан айлдав: Аяа Кэрэйт ноён чиний (4) мод чинь далдуу мод болог. Шувуу чинь галуу болог. Уриа чинь (5) Ар Бөрү болог. Тамга чинь нүдэн тамга болог хэмээв. (6) Дүрс нь энэ буюу A Мөн түүний хойно (7) Жингиз хаан айлдав: Аяа Мутяан ноён чиний мод чинь (8) хадрыг болог. Шувуу чинь тогоруу болог. Уриа чинь (9) Баягонграт болог. Тамга чинь Куушошган

болог. (10) Дүрс нь энэ буюу Y Түүний хойно мөн (11) Жингиз хаан айлдав: Аяа Буржан ноён чиний мод чинь (12) шарс болог. Шувуу чинь Күчүгэн болог. Уриа чинь (13) Актоган болог. Тамга чинь жагалбай болог. (14) хэмээв. Дүрс нь энэ буюу U Түүний хойно мөн (15) Жингиз хаан айлдав: Аяа Боркыт ноён чиний мод чинь (16) агч болог. Шувуу чинь

өөсөлж болог. Уриа чинь (17) Буруж болог. Тамга чинь хамза болог. Дүрс нь [f.24v] (1) энэ буюу S Түүний хойно мөн Жингиз хаан (2) айлдав: Кагын-жарын ховгүүн Катая-д чиний мод чинь (3) арц болог. Шувуу чинь өрөвтас болог. Уриа

чинь (4) Тайлак болог. Тамга чинь Сэрү болог хэмээв. (5) Дүрс нь энэ буюу + Түүний хойно мөн (6) Жингиз хаан

Çingiz-nämä” хэмээх зургаан бөлөг (I: *Faşl-i dāstān-i nāsl-i Jingiz*, II: *Faşl-i fī bāyān-i dāstān-i Aşaq Temir*, III: *Faşl-i fī bāyān-i dāstān-i ‘İsa oĝli Amāt*, IV: *Faşl-i fī bāyān-i dāstān-i Edigā Biy*, V: *Faşl-i fī bāyān-i mājālis wā-l mākān*, VI: *Faşl-i fī bāyān-i dāstān-u-t tārīh*)-тэй эл сурвалж нь олон гар хуулбараар тархах явцдаа анхны эхээсээ маш их зөрүүтэй болсон хэмээн үздэг¹⁵⁶. Уг сурвалжийн талаар дурдсан нь цөөн¹⁵⁷, тухайлсан бүрэн хэмжээний судалгаа энэ хир хийгдээгүй бололтой. Түрэг угсаатны түүхэн сурвалжууд ч мөн тамга соёрхдог байсан тухай мэдээ бий.

Жишээ нь, Огуз хааны домогт түүний том хүү Күн хаан мэргэн сайдынхаа зөвлөснөөр, хожмын цагт түүний үр хойчис нь эд бараа, эрх мэдлээс болж эе эвдрэлцэх вий хэмээн тус бүрт нь тамга тэмдэг зэргийг тусгайлан зааж өгсөн тухай буй¹⁵⁸.


Н.Гөргүная (Neriman Görgünay) Огуз хааны домогт дурдагдах тамгууд, түүхч Языжи-Оглу (Yazıcı-Oĝlu) Рашид-ад-Дин болон Кашгарын Махмут нарын зурж тэмдэглэсэн тамгуудыг харьцуулан улмаар руни бичигтэй холбон судлаад тэдгээр нь бага зэрэг өөрчлөгдсөн боловч үндсэн хэлбэр нь тодорхой хэмжээгээр эдүгээ Түрэг угсаатны хивс, хувцас, мөнгөн тэмдэгт зэрэг эд өлгийн зүйлд уламжлагдаж үлдсэн хэмээн тэмдэглэжээ¹⁵⁹. Гэвч түрэг угсаатны сурвалжид тэмдэглэгдсэн тамга араб үсгийн цагаан толгойтой илүү ойр, харин эртний хэлбэртэй тохирох тамга маш цөөн ажээ.

Эбүл Гази Бахадыр хааны туурвисан “Туркменчүүдийн гарал угсаа” хэмээх бүтээлд ч овог тус бүрийн тамга тэмдэг, бэлгэдлийн талаар өгүүлсэн¹⁶⁰ нь түрэг угсаатны тамганы гарал үүслийг тодруулах чухал сурвалж болсоор байна. Монголын түүхэн сурвалжуудад овог аймагт тамга соёрхсон тухай мэдээ тааралдахгүй байна, гэхдээ цаашид судлууштай юм.

айлдав: Аяа Калдар ноён чиний мод чинь (7) зандан болог. Шувуу чинь тагтаа болог. (8) Уриа чинь Арнав болог. Тамга

чинь бүтээгч болог (9) хэмээв. Дүрс нь энэ буюу  Мөн түүний хойно (10) Жингиз хаан айлдав: Аяа Салжут ноён чиний мод чинь (11) яшил болог. Шувуу чинь алтан гургалдай болог. Уриа чинь (12) Барлас болог. Тамга чинь Байшин тамга болог хэмээв. (13) Дүрс нь энэ буюу  Түүний хойно мөн (14) Жингиз хаан айлдав: Аяа Тэмир Кутлу ноён чи хари хүнээс (15) баялагаараа, арвин эд хоронгөөрөө ноён цолыг олсон (16) чиний мод чинь нигүрс болог. Шувуу чинь (17)

шаазгай болог. Уриа чинь Табан болог. (18) тамга чинь хагас сам болог хэмээв. Дүрс нь [f25r] (1) энэ буюу  Мөн Жингиз хааны өөрийнх нь (2) уриа нь Жаан Каба хэмээх бөлгөө. Жингиз хааны энэхүү (3) дурдсан ноёд бүр дагалдах дарга хийж (4) шрэг авч мордох бөлгөө. Тэр их хүнд цагт (5) ард түмэн нэг нэгтээ уриа урианаар нь олох (6) бөлгөө. Эдүгээ зарим урианых нь нэрс эдгээр (7) билээ. Урьдаар хаан уриа нь Жаан Каба түүний хойно зарим (8) ноёдынх нь уриа эдгээр бөлгөө. Арув Жаан, Конграт, (9) Салават, Алаж, Тутяа, Ток Саба, Ак Тайлак, Ар Бөрү (10) Баягонрат, Ак Тоған, Буруж, Тайлак, Тайлак, Арнав, Барлас, (11) Табан Мөн язгууртан болбоос Жингиз хаан хэзээ ч (12) гөрөөс авлаар гарах ахул энэхүү дурдсан ноёдыг (13) шувуудтай нь авч гарах бөлгөө. Эдүгээ (14) тэр шувуудын нэрснийг нэгтгэн (15) дурдъя: Урьд Жингиз хааны өөрийнх нь шувуу хоёр (16) толгойт хар шувуу бөлгөө. Өөрийн ноёдынх нь шувууд (17) эдгээр бөлгөө. Шонхор, начин, хар шувуу, хариага, (18) харгүй, бүргэл, илгэ шонхор, галуу, тогоруу, күчүгэн, өвөөлж, [f25v] (1) өрөөтас, тагтаа, алтан гургалдай, шаазгай. Мөн язгууртан (2) болбоос Жингиз хааны өөрийнх нь мод (3) чинар бөлгөө. Өөрийн ноёдын моддыг (4) нэгтгэн дурдъя: харгай, алмын мод (5) хар мод, хус, улиангар, хайлаас, уд мод, дайлуу, хадыр, (6) шарс, агч, арч, зандан, яшил, нигүрс (7) Мөн язгууртан болбоос Жингиз хааны өөрийнх нь тамга (8) шувуун толгой хэмээх тамга бөлгөө. Дүрс нь энэ бөлгөө. (9)  өөрийн ноёдынх нь тамгуудыг (10) нэгтгэн

дурдъя  (11)

¹⁵⁶ Maria Ivanics, Mirkasym A.Usmanov, Däflär-i Çingiz-nämä (Das Buch der Dschingis-Legende) I, Studia Uraloaltaica, Szeged, 2002.

¹⁵⁷ Ch.Rieu, Catalog of the Turkish Manuscripts in the British Museum, London, 1888; A. Rāxım, G.Gäziz, Tatar ädbiyati tarixi, Kazan, 1925, Abdükadir İnan, Destân-i Nesl-i Çengiz Han kitabı hakkında, Azerbayacan Yurt Bilgisi, yıl 3, Nr 25, 1934; Abdükadir İnan, Destan-i Nesli Çengiz Han kitabı hakkında, Azerbayacan Yurt Bilgisi, yıl 3, Nr 25, 1934; Abdükadir İnan, Makaleler ve İncelemeler, I.Cilt, Türk Tarih Kurumu, Ankara, 1998, s.198-206.

¹⁵⁸ W. Bang, G.R. Rahmeti. Oĝuz Kağan Destanı, Istanbul, 1936.

¹⁵⁹ Neriman Görgünay, Oĝuz Damgaları ve Göktürk Harflerinin El Sanatlarımızdaki İzleri, Ankara, 2002, s. 5-11, 54-61.

¹⁶⁰ Bahaeddin Ögel, Türk Mitolojisi, c.I, Ankara, 1998, s. 214-221

Холимог тамга

Овог аймаг доройтож мөхөх, дайн тулалдаанд ялагдаж язгуур тамга нь үгүйсгэгдэх зэрэг түүхэн тодорхой шалтгаанаар мартагдаад үе улирсны хойно зарим овог аймаг дахин сэргэж шинэ тамга үүсгэх, бүрэлдэхүүн, харьяанд нь багтаж байгаа, эсвээс нүүдэллэн шилжиж суурьшсан нутгийн зон олны зэрэг өөрийн язгуур гаралтай ямар ч холбоогүй аймгийн тамганд тулгуурлан шинэ тамга зохиох, шашин, номын үсгээр (монгол угсаатан төвд [᠘ da, ᠮ ma, ᠡ ja, ᠬ cha ᠰ za, гэх мэт] үсгээр*, түрэг угсаатан араб [ح ج ك, ح ه, ح س s, ح ه гэх мэт] үсгээр) тамга хийх тохиолдол элбэг байсан ажээ. Ийм байдлаар үүссэн тамгыг холимог тамга хэмээн нэрлэж байгаа юм.

Өөрсдийн уг шаг, язгуур түүхийн сурвалж, эх хэрэглэгдэхүүнийг сайн мэдэхгүйгээр, угсаатан судлал, үсэг бичиг судлалын наад захын мэдлэггүйгээр тамга судална гэж үгүй, цаашлаад эртний тамганы үндэс, улбаа холбоо, учир бэлгэдлийн талаар өгүүлнэ гэж санахын ч хэрэггүй билээ.

* Тийнхүү төвд үсгээр тамгалах болсноор

"Ташаан дээр нь дарсан тамга нь

Тангад номын үсэг дээ хо" хэмээн дуулах болжээ.

1.2.3. Руни ба уйгур бичиг

Руни бичгийг уйгурууд төрийн бичиг болгон залгамжлан авсан боловч төдий л удалгүй уйгур бичгээр сольсон ажээ. Уйгурын хаант улсын эхэн үеийн томоохон дурсгалууд (Моюнчурын гэрэлт хөшөө, Тариатын гэрэлт хөшөө, Тэсийн гэрэлт хөшөө, Хар балгасын гэрэлт хөшөө гэх мэт) бүгд руни бичгээр буй нь тэр үед уг үсэг бичиг ямар их дэлгэрч тархсан хийгээд Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд багтаж байсан бусад овог аймгуудын хэл сэтгэлгээнд ч ихэд нийцсэн болохыг харуулж байгаа хэрэг билээ.

Эл үсэг бичиг нүүдэлчдийн хэдэн зууны турш үе дамжин хэрэглэж ирсэн олон овог аймгийн тамга тэмдэгтэд тулгуурлан үүссэн тул нүдэлж тогтооход хялбар төдийгүй сийлж бичихэд туйлын дөхөм зэрэг он удаан жил хэрэглэж хэвшсэний үндэслэл олныг дурдаж болно. Уйгур нар төр улсаа байгуулсан эхний хорь илүү жил руни бичгийг төрийн бичиг болгон хэрэглэж байсныг түүхийн олон баримт нутлан гэрчилнэ. Монгол нутгаас л гэхэд уйгур нарт холбогдох бичгийн цөөнгүй дурсгал олдсон нь уйгур нарын үсэг бичиг, соёл, хэл аялгууны чухаг баримт болох төдийгүй тухайн үеийн түүхэн хэрэг явдлыг тэмдэглэсэн түүхэн сурвалж байдагаараа нэн онцлогтой.

Уйгур нарт холбогдох, Монгол нутаг дахь бичгийн дурсгалыг,

Руни бичгийн сонгодог дурсгалууд

- Моюунчурын гэрэлт хөшөөний бичээс
- Тариатын гэрэлт хөшөөний бичээс
- Тайхар чулууны бичээс
- Тэсийн гэрэлт хөшөөний бичээс

Руни бичгийн бага дурсгалууд

- Арханангийн бичээс
- Гурвалжин уулын бичээс
- Гурванмандалын бичээс
- Хангидайн хадны бичээс

Руни, согд, нангиад гурван хэл бичгийн дурсгал

- Хар балгасын гэрэлт хөшөөний бичээс

Руни, согд хос бичгийн дурсгал

- Сэврэйн бичээс

Руни, уйгур хос бичгийн дурсгалууд

- Долоогойдойн гэрэлт хөшөөний бичээс
- Их бичигтийн бичээс

Уйгур бичгийн дурсгал

- Тайхар чулууны уйгур бичээс
- Бичигт Хангайн уйгур бичээс хэмээн ангилж болно.

Хятадын Тан улсад Ань Лушан (安史之乱 an shi zhi luan)-ны бослого гарч аргагүйтэхийн эрхэнд Уйгураас тусламж гуйсанд хүсэлт гуйлтыг ёсоор болгож 756, 757, 759, 762 онуудад цэрэг илгээж бослогыг даралцжээ. Эл түүхэн хэрэг явдал уйгуруудад ашигтай нөхцөл бүрдүүлж уйгурын улс төр, эдийн засгийн хувьд бэхжихэд ихээхэн нөлөөлсөн төдийгүй согдуудын худалдаа арилжаа эрх мэдэл нэмэгдэх шашин соёлын нөлөө ихсэх үндэс суурийг тавьжээ. Түүхэн сурвалжуудад Бөгү хаан* 762 онд Маанийн шашинт дөрвөн согд ламыг Орхон голын хөвөөнд орших их нийслэл Ордубальк (одоогийн Хар балгас)-г дагуулан ирж улмаар маанийн шашныг төрийн шашинаа болгосон хэмээн тэмдэглэгджээ. Уйгурууд үсэг бичгээ солиход нөлөөлсөн хүчин зүйлийн нэг нь яах аргагүй маанийн шашин мөн юм.

*Моюнчур хаан 759 онд нас барж түүний орыг бага хүү Бөгү залгамжилж хаан ширээнд суужээ. Бөгү "Tengride bolmiš il tutmuš alp qutluq bilge (Тэнгэрт болгоогдсон улсыг хураасан баатар элийт мэргэн)" хаан цолтой байсан бөгөөд нангиад сурвалжид уг цолыг "Тэнгэрт төрж, улсаа удирдсан, баатар омголон хаан гэсэн утгатай" хэмээн тайлбарласан байна. Түүхэнд Бөгү хаан анх удаа шашны шинэтгэл хийснээрээ алдаршжээ.

Дээрх түүхэн нөхцөл байдал уйгуруудын дунд суурьшмал соёл иргэншлийн эхлэлийг тавьжхуудалдаа арилжаа өргөжин хот суурин газар Маанийн шашны сүм хийд баригдаж лам хувраг, номлогч нар олширч судар ном бичиг цаас арвидан дэлгэрчээ.

Бурханы болоод Маанийн шашны судар ном унших, эх (уйгур) хэлнээ орчуулан буулгах зайлшгүй шаардлага гарч руни бичиг нь үйс цааснаа бичих, ном судар орчуулан буулгахад тэр бүр бичгийн шаардлагыг төгс хангаж эс чадсанд шинэ үсэг зохиох, тэрхүү хэрэгцээг ном бичигт мэргэшсэн (согд) мэргэдийн туслалцаатайгаар шийдэх “тохироо бүрэлдэж” аандаа согд үсэгт дулдуйдаж суурилсан *уйгур цагаан толгой, уйгур бичиг үүсчээ*. Шашин ном дэлгэрүүлэх шалтгаанаар анх “сэтгэгдэн” үүдсэн эл бичиг тун удалгүй төр, түмний бичиг болж өөрийн “үндэсний хэв шинж”-ийг олж ихэд дэлгэрэн түгжээ.

Хаан хийгээд хаант төрөөс ихэд тэтгэгдэн соёрхогдсон уйгур бичиг дэлгэрснээр руни бичиг аажмаар мартагдаж эхэлсэн бололтой. Гэхдээ руни бичгийг тийнхүү тэр даруй орхигдож мартагдсан хэмээн үзэж огт болохгүй. “Төрийн бичиг” байхаа болсон ч багагүй хугацаанд сурч дадсан руни бичгээр бичиж, хэрэглэсээр байсан ажээ. Түүний нэг нуталгаа нь Турфаны цуглуулгын руни бичигт ном судар юм.

Дорнод Туркестаны Тэнгэр уулын бэл, Турфаны хотгорын газраас уйгурын түүх, соёлтой холбогдох асар их үнэ цэнэтэй өв илэрч улмаар Герман, Англи, Франц, Орос, Япон зэрэг улсын хээрийн шинжилгээний ангиуд 1890-1916 оны хооронд очиж судалгаа хийсэн түүхтэй. Тухайлбал, 1902-1914 оны хооронд Германы эрдэмтэн А.Ф.Ле Кох (A. von Le Coq), А.Грунведел (A. Grünwedel) нарын нийт дөрвөн удаа удирдан зохион байгуулсан хээрийн хайгуул шинжилгээний ангийн ажлын хүрээнд олон арван бичгийн дурсгал олжээ. Тэднээс нэн ховор чухаг нь Хар Хожо хотыг малтан шинжлэх явцад руни, нангиад, сири, брахми, согд, төвд зэрэг 30-аад зүйлийн бичиг, 15 орчим хэлнээ туурвисан олон арван ном судар олдсон явдал юм. Энэхүү баялаг өвийн дотор руни бичгээр цаасан дээр бичсэн ном судар байсан нь эдүгээ Англи, Франц, Япон, Орос, Герман зэрэг орны томоохон номын сан, гар бичмэлийн цуглуулга, сан хөмрөгт хадгалагдаж байна.

Английн Стейн (Sir Aurel Stein)-ы цуглуулгад нийтдээ 12 хэсэг (№ 1-3. 8212/76; № 4. 8212/77; № 5-9. 8212/78; № 10. 8212/79; № 11. 8212/104; № 12. 8212/161) руни бичигт ном судар буй. Түүнээс хамгийн алдартай нь “Säkiz Yükmäk” болно.

1907 оны 11-р сарын 24-ны өдөр Яар Хотогоос олдсон 450 хуудастай, № 11. 8212/104 дугаартай хураангуй “Найман гэгээн (ᠨᠠᠶᠢᠮᠠᠨ ᠭᠡᠭᠡᠨ)” судрын нэг хуудас руни бичигтэй бөлгөө. Уг бичээсийн В.Бан, А.фон Габен, Р.Рахмати (W.Bang, A.von Gabain, G.R.Rachmati)¹⁶¹, Марти Расянен (Martii Räsänen)¹⁶², А.Н.Бернштам¹⁶³ нарын эрдэмтэд тухайлан судалсан ажээ.

* Бөгү (759-779 оны хооронд төр барьсан) хааны (магадгүй) зарлигаар согд бичигт дулдуйдаж уйгур бичиг зохиосон нь, хожмын цагт Хубилай (1215-1294) хааны зарлигаар 1269 онд Пагва лам (*Phags-pa bla-ma) хэмээн алдаршсан Лодойжалцан (bLo-gros rgal-mchan 1234-1279) төвд үсэгт суурилан дөрвөлжин бичиг зохиосон, Тайзү хуанди (Тайзүн гэгээн соёлт хуанди буюу Цэцэн хаан, Дээд эрдэмт (Тянь зунг) (1627-1635 /1639-1644)-ийн зарлигаар Манж нар Эрдэнэ багш, Дахай оточ нар монгол бичигт тулгуурлан манж бичиг (Дусал бинтгүй бичгийн үе /1599-1632/, бүрнээ боловсорч төрийн бичиг болсон үе /1632-1911/) зохиосон нь цугаар үлгэр адил гэлтэй.

¹⁶¹ Bang W, Gabain A.v, Analytischer Index zu den fünf ersten Stücken der türkischen Turfan-Texte, - Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, Phil.-hist.Kl, Band XVII, 1931; Bang W, Gabain A.v, Türkische Turfan-Texte, V, -Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, Band XIV, 1931; Bang W, Gabain A.v, Rachmati G.R, Türkische Turfantexte, 6, Das Buddhistische Sutra Säkiz Yükmäk, - Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, Phil.-hist.Kl, Band X, 1934; Bang W, Gabain A.v, Türkische Turfan-Texte, I, - Sitzungsberichte der Königlichen Preussischen Academie der Wissenschaften, 1929; Bang W, Gabain A.v, Türkische Turfan-Texte, II, -Sprachwissenschaftlich Ergebnisse der deutsche Turran-Forschung, Band 2, Leipzig, 1972; Bang W, Gabain A.v, Türkische Turfan-Texte, III, -Sprachwissenschaftlich Ergebnisse der deutsche Turran-Forschung, Band 2, Leipzig, 1972; W.Bang, A.von Gabain, G.R.Rachmati, Das buddhistische Sutra

“İrq bitig” буюу №12. 8212/161 дугаартай “Мэргэ төлгийн ном” олдсон нь руни бичгийн ховор чухал сурвалжид зүй ёсоор тооцогддог билээ. “İrq bitig” хэмээх судар нь хоёр талдаа бичигтэй 65 хуудсанд 104 мөр руни бичиг байх аж. Мөн судрын хуудснаа нангиад бичиг (ханз) ч буй. Эл номыг анх түрүүн В.Томсен (Vilhelm Thomsen)¹⁶⁴, хожим Х.Н.Орхун (Hüseyin Namik Orkun)¹⁶⁵, С.Е.Малов¹⁶⁶, Ж.Клаузон (Sir Gerard Clauson)¹⁶⁷, О.Прицак (Omeljan Pritsak)¹⁶⁸, Ж.Хамилтон (James Russell Hamilton)¹⁶⁹, М.Ердал (Marsel Erdal)¹⁷⁰ нарын зэрэг олон эрдэмтэд судалжээ.

Япон улсын “Kont Ōtani Kozui” цуглуулга (Ryukoku University)-д мөн руни бичигт дурсгал буй ажээ¹⁷¹.

Оросын шинжилгээний анги Тоюкоос олсон 6 хуудас руни бичгийн дурсгалыг анх В.В.Радлов уншиж хэвлүүлсэн байна¹⁷².

Францын үндэсний номын сангийн П.Пеллиогийн сан хөмрөгийн “Төвдийн бөлөг”-т №2132 дугаартай, зөвхөн нүүрэн талдаа ихэд балархай руни бичигтэй 4 хуудас судар байдаг ажээ¹⁷³.

Турфанаас олдсон олон судар номын хамгийн баялаг цуглуулга Герман улсад бий бөгөөд хуучин цагт баруун Берлин (Staatsbibliothek, Preussischer Kulturbesitz, Orientalabteilung болоод Museum für Indische Kunst -MIK), зүүн Берлин (Akademie der Wissenschaften der DDR) гэж хоёр хуваагдаж байснаас дурсгалыг мөн тийн ялган нэрлэжээ.

Герман улсад хадгалагдаж буй Турфаны цуглуулга дахь “руни” бичигт дурсгалын тоо 34 орчим (О.Ф.Серткая профессорын бүртгэлээс үзвэл) юм¹⁷⁴. Тэдгээр дурсгалын нилээдийг А.Кох (Albert August von Le Coq)¹⁷⁵, Т II, Т 14 дугаартай бичээсийг В.Томсен (Vilhelm Thomsen)¹⁷⁶, 30 Т II, Т х 6 / U.181 дугаартай бичээсийг Семих Тезжан(Semih

Säkiz Yükmäk, - Türkische Turfan-texte, IV, Sitzungsberichte der Preußischen Akademie der Wissenschaften, Phil. -hist, Klasse, Berlin, 1934, pp.93-192.

¹⁶² Martii Räsänen, Zu dem türkischen Runenschriftentrag in der uigurischen Übersetzung des buddhistischen Sūtra Säkiz Yükmäk, -Studia orientalia, 6/1, Helsinki, 1936.

¹⁶³ А.Н.Бернштам, Руническая надпись в уйгурской рукописи, -Записки Института Востоковедения, Академии Наук СССР, Москва, 1939, №7, стр. 303-305.

¹⁶⁴ V.Thomsen, Dr. M.A. Stein's manuscripts in Turkish "Runic" script from Miran and Tun-Huang, -Journal of the Royal Asiatic Society, 1912, pp.181-227.

¹⁶⁵ Hüseyin Namik Orkun, Eski Türk Yazıtları, II, İstanbul, 1938, s.61-68.

¹⁶⁶ С.Е.Малов, Памятники Древнетюркской Письменности, Москва-Ленинград, 1951, стр.80-92.

¹⁶⁷ Sir Gerard Clauson, Notes on the İrk Bitig, -Ural-Altäische Jahrbücher, 33, 1961, pp.218-235.

¹⁶⁸ Omeljan Pritsak, Zum Parallelismus im Altürkischen, -Studia Orientalia, 28/6, Helsinki, 1964, pp.1-8.

¹⁶⁹ J.R.Hamilton, Sur deux présages de l'İrq Bitig, -Quand le crible était dans la paille, Paris, 1978, pp.247-254;

J.R.Hamilton, Le colophon de l'İrq Bitig, -Turcica, Revue d'Études Turques, 7, 1975, pp.7-19.

¹⁷⁰ Marsel Erdal, İrk Bitig üzerine yeni notlar, -Türk Dili Araştırmaları Yıllığı-Belleten 1977, Ankara, 1978, s.87-119.

¹⁷¹ Akira Hanenda, Nobuo Yamada, A list of the manuscript remains in Uighur script preserved in Ryukoku Library. In: Buddhist Manuscripts and secular documents of the ancient languages in Central Asia, Monumenta Serindica, 6, Kyoto, 1961, Taf.29.

¹⁷² Wilhelm Radloff, Ein Fragment in altürkischer Runenschrift, - Altürkischen Studien, III, 1, Известия Императорской Академии Наук (Bulletin de l'Académie Imperiale des Sciences de St.Péterbourg), 1910, 1025-1029.

¹⁷³ Marchelle Laou, Inventaire des Manuscrits tibétains de Touen-houang, conservés à la Bibliothèque Nationale (Fonds Pelliot tibétain), Nos: 1283-2216, fasc.III, Paris, 1961.

¹⁷⁴ Osman Fikri Sertkaya, Kâğıda yazılı Göktürk metinleri ve kâğıda yazılı Göktürk alfabeleri, -Türk Dili Araştırmaları Yıllığı-Belleten 1990, Ankara, 1994, s.167-181; Osman Fikri Sertkaya, Kâğıda yazılı Göktürk metinleri ve kâğıda yazılı Göktürk alfabeleri, -Göktürk Tarihinin meseleleri, Türk Kültürü Araştırma Enstitüsü, Yayınları: 131, Seri: IV, Sayı: A.40, s.104-108.

¹⁷⁵ A. von Le Coq, Köktürkische aus Turfan (Manuskriptfragmente in köktürkischen "runen" aus Toyoq und İdikut-Schähri [Oase von Turfan]), - Sitzungsberichte der Preußischen Akademie der Wissenschaften, Phil. -hist, Klasse, 1909, 41, pp.1047-1061.

¹⁷⁶ Vilhelm Thomsen, Ein Blatt in türkischer "Runen" schrift aus Turfan, - Sitzungsberichte der Preußischen Akademie der Wissenschaften, Phil. -hist, Klasse, 1910, 15, pp.296-306.

Tezcan), Петер Цийме (Peter Zieme)¹⁷⁷ болон О.Ф.Серткаяя (Osman Fikri Sertkaya)¹⁷⁸ нар тус тус уншиж судалсан байна.

Турфаны цуглуулгын уйгур гэрээ бичгийн талаарх Н.Яамада (Nobuo Yamada)-гийн судалгааг эмхэтгэн гурван ботиор хэвлэсэн¹⁷⁹ нь уйгур гэрээ бичиг төдийгүй сонгодог монгол бичгийн өмнөх үеийн монгол бичгийн зарим гэрээ, уйгур, монгол хэл, бичгийг харьцуулан судлахад ашиглах чухаг эх хэрэглэгдэхүүн болжээ.

¹⁷⁷ Semih Tezcan, Peter Zieme, Uigurische Brieffragmente, -Studia Turcica, Budapest, 1971, pp.451-460.

¹⁷⁸ Osman Fikri Sertkaya, Fragmente in alttürkischer Runenschrift aus den Turfan-Funden, Runen, Tamgas und Graffiti aus Asien und Osteuropa, Wiesbaden, 1985, pp.133-164; Osman F.Sertkaya, Kâğıda yazılı Göktürk metinleri ve kâğıda yazılı Göktürk alfabeleri, - Göktürk Tarihinin Meseleleri, Türk Kültürü Araştırma Enstitüsü, Yayınları : 131, Seri: IV, Sayı: A.40, Ankara, 1995, s.277-292.

¹⁷⁹ ウイグル 文契文約書集成・著者 山田信夫・編者・小田壽典・P.フイーム・梅村 坦・森安孝夫・大阪学出版会 (Nobuo Yamada, Sammlung Uigurischer Kontrakte, Band I-III, Herausgegeben von Juten Oda, Peter Zieme, Hiroshi Umemura, Takao Moriyasu, Osaka University Press), 1993.

1.3.0. МОНГОЛЫН РУНИ БИЧИГ, ДУРСГАЛЫН АНГИЛАЛ

1.3.1. Монголын руни бичиг нэрийн талаар

XIX зууны сүүл үеэс үеэс бичгийн судлалд “Енисейн бичиг, Орхон бичиг” гэсэн шинэ нэр үүсч, улмаар “Орхон бичиг” нь монгол нутгаас олдож буй руни бичгийг нэрлэх нэг нэр болж уламжлагдсан байна.

Тянь бао-гийн 751 онд анх шав тавьж байгуулагдсан Уйгур улсын их нийслэл “Хан Балык, Орду Балык (Qanbalıq)” хотын туйранд үлдсэн уйгур, согд, нангиад үсэг, хэл бичгээрх гэрэлт хөшөөг анх Н.М.Ядринцев олж улмаар Түрэгийн Билгэ хаан, түүний дүү Келтигин нарт зориулан босгосон гэрэлт хөшөөг Орхон голын хөвөөнөөс илрүүлснээр энэ дурсгалуудын хэмжээ хэлбэр, бичээсийг сийлсэн янз байдал өмнөх нээлт болох Енисейн бичээстэй зүйрлэшгүй ялгаатайг илтгэн харуулахын тулд “Орхон бичиг” гэж нэрлэсэн гэдэг.

“Орхон бичиг” хэмээх нэр тухайн үед маш оновчтой байсан хэдий ч хожим, дараа дараагийн судалгаа, руни бичгийн дурсгалын шинэ шинэ нээлтүүд уг нэрийг тэр бүр хэрэглэх боломжгүй, учир дутагдалтай болохыг харуулжээ.

Нэн ялангуяа монгол нутгаас олдсон бага бичээсүүдийг “Орхон бичиг” хэмээн нэрлэх зохимжгүй байснаас, бичээсийн үсэгзүй, бичлэгийн хэлбэрийг зөв тодорхойлох үүднээс “Енисейн бичээстэй ижил, төсөөтэй”, “үсэг тэмдэгт, зурлага нь Енисейн бичигтэй адилхан хэлбэртэй” хэмээн тодотгож голдуу бага буюу ганц нэг мөр бичээсийг тодорхойлох “хэвшмэл тодорхойлолт” болж уламжлагдсан байна. Энэ нь нэг талаар монгол орон дэлхийд руни бичгийн дурсгалаараа алдартай ч уг үсэг бичгийн дурсгалыг ерөнхийд нь нэрлэж хэвшсэн нэр, шинжлэх ухааны хүрээнд хэрэглэх хэмжээнд тогтсон нэр байхгүй байсантай холбоотой.

Тиймээс ч манай судлаач, эрдэмтэд “түүрэг бичиг, тюрк бичиг, түрэг бичиг, Орхон-Енисейн бичиг, Орхон-Сэлэнгийн руни бичиг, тамга бичиг, руни бичиг” гэж тус тус өөрийн саналд нийцүүлэн нэрлэх болжээ.

Жишээ нь, М.Шинэхүү абугай өгүүлэл, нэг сэдэвт зохиолдоо энэ бичгийг “тамга бичиг” гэж нэрлэх санал дэвшүүлсэн нь¹⁸⁰ өмчийн тамга, малын тамгаас энэ бичиг гарал үүсэлтэй гэж үзсэн хэрэг. Академич А.Лувсандэндэв тюрк, эрдэмтэн Б.Базылхан эртний түрэг, түрэг бичээс, доктор Л.Болд сүүл үед “Орхон бичиг” хэмээн нэрлэж буй. Түүхч А.Амар, Н.Сэр-Оджав нар түрэг, түүрэг бичээс хэмээн тэмдэглэсэн бөлгөө.

Эдгээр олон нэр монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалуудыг оновчтой, зөв нэрлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Оновчтой, зохирсон зөв нэр оноохын тулд уг бичгийн дурсгал олдож буй газар нутаг, тархацыг зөв тогтоох, дурсгалын хэмжээ, хэлбэр хийц, бичлэгийн онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй мэт санагдана.

Руни бичгийн дурсгал манай оронд зөвхөн Орхон, Сэлэнгийн сав газраас бус Хангай, Хэнтий, Алтайн их уул нуруу, дунд, өмнөд Говь, мөн түүнчлэн Дорнодын талаас олдож байгаа нь энэ бичээсийн тархац, хамрах газар нутаг хичнээн өргөн их уудам болохыг илтгэнэ.

Монгол орноос гадна Саяны уулс, Енисей мөрөн, Талас хийгээд Шинжан (Дорнод Туркестан)-ы хязгаар (Турфаны бичмэл сурвалжууд) нутгаас ч руни бичгийн дурсгал олджээ.

Харин тэдгээр дурсгалыг Енисейн бичээс, Орхоны бичээс гэж нэрлэсэн нь хэр оновчтой гэж үзэх вэ?

Тувагийн манай улстай хил залгаа нутгаас олдсон руни бичгийн дурсгалыг “Енисейн бичээс” гэж нэрлэвэл түүнээс 50-60 км зайтай, монгол нутгаас олдсон бичээсийг “Орхон бичээс” гэх үү, эсвэл “Енисейн бичээс” гэж нэрлэх үү гэсэн асуулт яах аргагүй

¹⁸⁰ М.Шинэхүү, Орхон-Енисейн бичиг Монголын малын тамгатай холбогдох нь, -Монголын этнографийн асуудал, Tom.V, fasc.I, 59-72 дугаар тал; М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Tom.VIII, fasc. I, Улаанбаатар, 1976, 14 дүгээр тал.

гардаг. Энэ хоёр бичгийн дурсгалаас Енисей мөрөн ч, Орхон гол ч хол. Үүнээс үзэхэд, Енисейн бичиг, Орхон бичиг нэрийн аль аль нь уг дурсгалын газар зүйн байршил, бүс бүслүүрт тохирч таарахгүй нь тодорхой байна. Нөгөө талаар Орхон бичиг, Енисейн бичиг чухам юугаараа ялгаатайг бас бодож үзэх хэрэгтэй байх. Эл хоёр нэрийн ялгаатайг тэр бүр мэддэггүй, мэдсэн ч тоож хэлэлцдэггүй тал бий.

Анх Билгэ хаан, Келтигин нарын дурсгалд зориулан босгосон гайхамшигт уран яруу хэллэгтэй, сонгодог цохимол бичээсийг “*Орхон бичиг, Орхоны руни бичээс*” хэмээн нэрлэж хожим түүнтэй дүйцэхүйц, Туул голын саваас олдсон Туньюкукын зэрэг томоохон гэрэлт хөшөөний бичээсийг үүнд хамааруулах болсон байна.

Енисей мөрний сав газраас олдох болсон ганц хоёр буюу цөөн хэдэн мөрөөс бүтсэн, үсэг зурлага хичээнгүй бус бичээсийг “*Енисейн бичиг, Енисейн руни бичээс*” гэж ерөнхийд нь нэрлэх болжээ.

Тиймээс ч монгол нутгаас олдсон руни бичгийн бага дурсгалуудыг Енисейн бичээстэй адилтгаж, гэхдээ монгол нутгаас олдсныг харгалзан “Орхон-Енисейн бичээс” гэж нэрлэх болсон бололтой. Орхон-Енисейн бичээс гэдэг нь үнэндээ монгол нутгаас олдсон Енисейн бичээс гэсэн үг бололтой.

Руни бичгийн ганц нэг, цөөн хэдэн мөрөөс бүтэх бичээсийн төрлийг Енисей голын нэрээр “Енисейн”, хаад ихэст зориулан босгосон том гэрэлт хөшөөний бичээсийн төрлийг Орхон голын нэрээр “Орхон” гэж тус тус нэрлэснээс бус “руни бичиг”-ийн нэрийг халж сольсон хэрэг огт биш юм.

Эртний түрэг, уйгур улс тухайн үед асар их өргөн уудам нутаг эзэмшиж байсныг түүх бэлхэнээ гэрчлэх тул руни бичиг тэр газар бүрт ямар нэгэн байдлаар хүрч тархсан, тэгээд ч бичиж хэрэглэдэг байсан гэж үзэх бүрэн үндэстэй.

Гэтэл тэр их өргөн уудам нутгаас олдож буй түрэг, уйгурын үед холбогдох руни бичгийн дурсгалыг Орхон бичээс, Енисейн бичээс гэсэн хоёр зүйлд хуваан нэрлэх нь зарим талаар ихээхэн учир дутагдалтай байна. Орхон, Енисейн гэхгүйгээр руни бичиг гэж нэрлэх нь бий.

Руни бичгийн дурсгал хаанаас олдож байгаа нь сонирхол татдаг. Өөрөөр хэлбэл, аль улсын нутгаас ямар нэртэй газраас руни бичгийн дурсгал олдсон нь чухал байдаг.

Тиймээс Монгол улсаас олдож буй руни бичгийн дурсгалыг *Монголын руни* гэж нэрлэвэл илүү тодорхой болох мэт санагдана.

Энэ нэр ерөнхийгөөс тодорхой нэгжид шилжүүлж байгаа болохоос тодорхойг ерөнхий болгож буй хэрэг огт биш. Тодруулбал, улс бүрээр овоглосон “руни бичиг” байгаа мэт ч үнэндээ руни бичгийн дурсгал аль улсын нутагт байхыг ялган зааж төвөггүй мэдэх боломж олгож байгаа юм.

Енисейн бичээс гэвэл Тувагаас олдсон юм уу, Киргизээс олдсон юм уу гэдгийг тухайн сэдвийг уншиж байж сая мэддэг шүү дээ. Тийм ч учраас олон улсын жишигт, жишээ нь Киргиз улсаас олдож буйг Киргизийн, Тува улсаас олдож буйг Тувагийн гэх мэтээр уг дурсгал олдсон улс орноор нэрлэж тодорхойлсон нь буй билээ.

Монгол нутгаас олдож буй руни бичгийн бүх дурсгалыг Орхон бичиг хэмээн нэрлэхэд хүрвэл Хэнтийн Орхон бичиг, Алтайн нурууны Орхон бичиг, Говийн Орхон бичгийн дурсгал гэж бичих шаардлагатай болох бөгөөд сонгодог хичээнгүй цохимол дурсгалыг руни бичгийн бага бичээсүүдээс үсэгзүй, бичлэгийн тиг хэлбэр, агуулга, зорилгоороо ч жишиж харьцуулшгүй ялгаатайг тодотгож оноосон “Орхон бичиг” нэр үгүйсгэгдэж, их багын, хэлбэр агуулгын харьцаа алдагдана. Товчхондоо, ганц хоёр мөр бичээсийг “Орхон бичиг” гэж нэрлэсэн нь дурсгалын хэмжээ, бичээсийн агуулгад хэзээ ч нийцэхгүй.

Үүндээ Орхон голын хөндийгээс руни бичгийн дөрвөн дурсгал (*Үйгурын хар балгасын бичээс, Көл тигин, Бидэ хааны гэрэлт хошооний бичээс, Гурбалжин уулын бичээс мэт сонгодог бичээст гурван хошоо, хадны гагц мөр бичээс*) олджээ.

Өмнө өгүүлдсэнчлэн, Орхон бичиг, Орхон-Енисейн бичиг, тамга бичиг, түрэг бичиг гэх олон нэрийг нэг мөр болгож “Монголын руни бичиг” хэмээн нэрлэх нь илүү зохимжтой санагдана.

Учир нь, нэгд дэлхийн үсэг бичгийн судлалд Европ зүгээс олдсон руни бичгийн дурсгалыг германы “руни”, мажарын “руни”, скандинавын “руни” гэх мэтээр нэрлэдэг уламжлалтайг анхааран үзсэн ч,

Хоёрт, уг үсэг бичгийн дурсгал зөвхөн Орхоны хөндийгөөс бус монгол улсын нийт нутгаар их, бага хэмжээгээр тархсаныг онцолж одоо ч олдсоор байгааг харгалзан үзсэн ч,

Гуравт, Енисей, Талас болон Кавказын руни бичгийн дурсгалуудтай харьцуулахад үсэг тэмдэгт, бичлэгийн өвөрмөц онцлог, цар хэмжээг анхаарч үзсэн ч “Монголын руни бичиг, монголын руни бичгийн дурсгал” гэх нь илүү зөв, оновчтой болох буй за.

Нууцыг нэгэнт тайлаад зуу илүү жил өнгөрсөн атал “руни бичиг” буюу “нууц тайлагдашгүй бичиг” гэж нэрлэсээр байх нь зарим талаар учир дутагдалтай ч дэлхий дахинаа уг үсэг бичгийг нэрлэх нэр болон хэвшснийг бас анхаарахгүй байж болохгүй. Харин “монголын руни бичиг”-ийн дурсгалыг сонгодог, бага бичгийн дурсгал хэмээн хоёр зүйл хуваан үзэх нь зүйтэй болов уу.

Оросын түрэг судлалд Лена мөрөн, Байгаль, Алс Дорнод хавийн бичээсийг “руноподобный”, Енисей, Алтай, Тувагийн бичээсийг “мелкие” гэж нэрлэж буй.

Харин Монгол нутгаас олдсон сонгодог цохимол бичээсийг “классический”, “большой”, бага бичгийн дурсгалыг нь “мелкие” хэмээн нэрлэдэг болохыг дурдахад илүүдэхгүй биз ээ.

1.3.2. Монголын руни бичгийн дурсгалын ангилал

Руни бичгийн гарал үүслийн талаар эрдэмтдийн санал ерөнхийдөө нэг мөр болжээ. Харин тэдгээр гарал төрлийн холбоот руни бичгийн дурсгалуудыг хэрхэн ангилах нь нилээд маргаантай, өнөөг болтол хүлээн зөвшөөрөгдсөн буюу тогтсон ангилал үгүй болгөө. Аль ч талаас нь аваад үзсэн хэн бүхний санаанд яв цав таарахаар ангилал хийх нэн бэрхтэй билээ. Судлаач бүр өөрийн судалгааны хамрах хүрээ, чиглэлтэй холбогдуулан руни бичгийн дурсгалуудыг ангилж байгаагаас бус, тэдгээр дурсгалуудыг үсэг зурлагын онцлог, хэл аялгуу, хамаарах он цагийн хүрээнд нарийвчлан тодруулж, харьцуулан шинжлээд хэл, түүхийн бүрэн үндэстэй хийсэн ангилал цөөхөн бололтой.

Монголын руни бичгийн дурсгалууд бусад газар нутгаас олдсон руни бичгийн дурсгалуудтай салшгүй холбоотой учир эрдэмтэн судлаачид руни бичгийн холбогдолт ном бүтээлдээ бусад руни бичгийн дурсгалуудтай харьцуулан ангилсаар ирсэн байна. Иймд зарим эрдэмтдийн руни бичгийн ангилсан байдлыг товч дурдъя.

Казакстаны эрдэмтэн Г.Айдаров руни бичгийн дурсгалыг

1. Енисейн буюу Азийн
2. Таласын буюу Дундад Азийн
3. Орхоны буюу Огузын бичээс гэж тус ангилах санал дэвшүүлсэн байна¹⁸¹.

И.А.Батманов, З.Б.Арагачи, Г.Ф.Бабушкин нар Енисейн бичээстэй холбогдуулан

1. Хакас болоод Тувагаас олдсон Енисейн дурсгалууд
2. Дундад Азийн дурсгалууд
3. Мажарын дурсгалууд *(Енисей болоод Таласын дурсгалтай үсэг зурлага нь төсөөтэй)*
4. Орхоны дурсгалууд
5. Орхоны жижиг дурсгалууд хийгээд Сэлэнгийн сав газрын дурсгал
6. Зүүн Туркестаны дурсгал
7. Монгол нутаг, Байгал нуур, Лена мөрөн орчмоос олдсон хад чулуу, зоос, сав суулга, хүрэл, төмөр эдлэл дээрх бичээс гэж ангиласан байна¹⁸².

Нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный руни бичгийн дурсгалыг

1. Монголын хойт нутгийн
2. Енисейн хөндийн
3. Лена хийгээд Байгал орчмын
4. Алтайн
5. Зүүн /Дорнод/Түрэгстаны
6. Дорнод Азийн дурсгалууд хэмээн хуваан үзжээ болох болоод түүх-угсаа гарал, улс хил хязгаар нутгаар нь
 1. Зүүн Түрэгийн хаант улсын
 2. Баруун Түрэгийн хаант улсын
 3. Монгол дахь Уйгурын хаант улсын
 4. Курыканы холбооны
 5. Зүүн Туркестаны
 6. Киргизийн хэмээн ангилж болохыг дурджээ¹⁸⁴.

М.Шинэхүү гуай Орхон-Сэлэнгийн руни бичгийн судалгааны тоймдоо руни бичгийн дурсгалыг

1. Орхон, Сэлэнгэ, Туул голын сав газрын дагуух том, жижиг дурсгалууд

¹⁸¹ Г.Айдаров, Язык Орхонских памятников древнетюркской письменности VIII века, Алма-Ата, 1971, стр.12.

¹⁸² И.А.Батманов, З.Б.Арагачи, Г.Ф.Бабушкин, Современная и древняя Енисейка, Фрунзе, 1962, стр.16-17.

¹⁸³ С.Г.Кляшторный, Древнетюркские рунические памятники, Москва, 1964, стр.51-52.

¹⁸⁴ С.Г.Кляшторный, Древнетюркские рунические памятники, Москва, 1964, стр.53.

2. Алтайн их уулсын дурсгалууд
3. Енисейн сав газрын дагуух дурсгалууд
4. Дундад Азийн дурсгалууд
5. Бусад газрын дурсгалууд гэсэн таван үндсэн ангилалд хуваан үзэх санал дэвшүүлсэн байна¹⁸⁵.

Европын руни бичгийн дурсгалыг С.Я.Байчаров уншиж судлаад Хойд Кавказ, Туна, Волго-Дон, Секлерийн дурсгалуудын үсэг тэмдэгтүүдийг өөр хооронд нь харьцуулж тэдний үүсэл гарлын холбоо хамаарал, галиглах тогтолцооны талаар тухайлан өгүүлсэн ажээ¹⁸⁶.

Өөрөөр хэлбэл Европын руни бичгийн дурсгалыг тэрээр өөрийнхөө судалгааны хүрээнд

1. Хойд Кавказын
2. Тунагийн
3. Волго-Донын гэж ангилан авч үзжээ.

Эрдэмтэн Л.Р.Кызласов руни бичгийн дурсгалыг газарзүйн байрлалаар нь,

1. Евроазийн руни бичгийн дурсгалууд
2. Азийн руни бичгийн дурсгалууд гэсэн хоёр том болөгт хуваан үзжээ.

Тэрбээр Евроазийн руни бичгийн дурсгалуудыг дотор нь,

- Донын
- Кубан
- Дон-кубаны
- Ачикташын
- Исфарын (Исфара гол)
- Өмнөд Енисейн бичээс гэж хуваан ангилсан байна.

Азийн хэсэгт хамаарах бичгийн дурсгалыг

- Орхон-Енисейн
- Дээд Енисейн (Енисейн бичээсүүдэд уламжлагдсан Енисейн бус үсгүүд:
Дээд Енисейн цагаан толгойн ул мөр)
- Таласын гэсэн гурван хэсгээс бүрдэнэ¹⁸⁷ хэмээсэн байна.

Исмайл Доган (İsmail Doğan) “Кавказ дахь хөхгүрэг (руни)-ийн тамга бичээсүүд” цомог бүтээлийнхээ оршилд руни бичгийн дурсгалыг

1. Орхон бичиг
2. Секлер(мажаар)-ийн
3. Прото-Булгарын
4. Хазарын
5. Таласын
6. Енисейн
7. Хойт Кавказ (Дон, Волго, Кубан, Терек голын)-ын бичээсүүд гэж ангилан өгүүлжээ¹⁸⁸.

Үүнээс үзвэл руни бичгийн дурсгалыг ихэвчлэн холбогдох эртний улс, эсбөгөөс уул нуруу, томоохон гол мөрний ай савд хамаатуулан ангилсан байна. Энэ нь бага буюу ганц нэг мөр бичгийн дурсгалын хувьд тийм ч зөв ангилал биш бололтой.

¹⁸⁵ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, Улаанбаатар, 1975, 23 дугаар тал.

¹⁸⁶ S.Ya. Вауцагов, Ачгара'nın Türk Runik Abideleri, Ankara, 1996, s.37; 99.

¹⁸⁷ Л.Р.Кызласов, Рунические письменности Евроазиатских степей, Москва, 1994, стр.13-98; 241-289.

¹⁸⁸ İsmail Doğan, Kafkasya'daki Göktürk (Runik) İşaretleli Yazıtları, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu: Türk Dil Kurumu Yayınları: 736, Göktürk (Runik) Yazılı Belge Yazıt ve Anıtların Albümü Projesi: 1, Ankara, 2000, s.2-6.

Учир нь холбогдох он цаг тогтоох боломжгүй бага бичээсүүдийг аль улсын үед хамааруулах, үсэг зурлага, бичлэгийн хэлбэрт дулдуйдаж ерөнхийлэн нэрлэх үү, эсвэл газарзүйн байрлалаар нь ангилах уу гэсэн олон асуулт гарна.

Монголын өргөн уудам нутагт тархасан руни бичиг, дурсгал бүрийг ойролцоох уул, нуруу, гол усанд хамаатуулан нэрлэх боломжгүй юм.

Тиймээс Монголын руни бичгийн дурсгалуудыг газарзүйн байрлалаар

1. Алтайн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалууд
2. Хангай, Хэнтийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалууд
3. Тал хээрийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалууд
3. Говийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалууд хэмээн ангилж болох юм.

Юуны түрүүнд руни бичиг хаана байгааг олж, дараа нь тархацыг тогтоож улмаар үсэгзүйн онцлог зэрэгт тулгуурлан холбоо хамаарал, үүсэл гарлыг нь тогтоон тодруулснаар уг бичгээр дурсгалуудыг зөв ангилах боломж нөхцөл бүрдэнэ.

Уг үсэг бичгийн гарал үүслийг нь тогтооход үсэгзүйн харьцуулсан судалгаа нэн чухал бөгөөд түүнийг улс орныхоо хил хязгаарын доторх цөөн бичээсийн хүрээнд хийж хэт явцуурах буюу эсвээс одоогийн улс орны нутгаар зааглаж эдүгээчлэн сэтгэж огт болохгүй нь мэдээж.

Гэвч нөхцөл байдлаас үзэхэд нэгд, гарал үүсэл хийгээд бичгийн дурсгалын онцлогийн ялган тодруулах үүднээс эрдэмтэд өөр өөрсдийн орны руни бичгийн дурсгалыг нарийвчлан судалж улмаар нэгтгэн дүгнэх, хоёрт, хамтарсан шинжилгээний анги зохион байгуулж тус тусын улсын нутаг дэвсгэр дэх бичгийн дурсгалыг харилцан үзэж судлах, мэдээлэл солилцох гэсэн үндсэн хоёр арга зам байна.

М.Шинэхүү гуай руни бичгийн дурсгалуудыг өгүүлэн буй агуулгынх нь хувьд

1. Түүхт үйл-намтар цадигийн сэдэвтэй
2. Оршуулгын уй гашуу, уянгын сэдэвтэй
3. Үүрд сангалзах сэдэвтэй
4. Ид шид, шашин шүтлэгийн сэдэвтэй
5. Хууль цаазны сэдэвтэй
6. Хүрэл, зоос, төмөр, шавар, ваар, сав суулга, тээг чагт зэрэг ахуйн хэргэсэл дээр сийлсэн нэр, цол, тамга тэмдэг гэх мэтээр ангилсныг¹⁸⁹ бид төдий л оновчтой ангилал гэж үзэхгүй байна.

Руни бичгийн дурсгалуудын судалгаа цэгцэрч нэг бичээсийг хоёр, гурван янзаар унших хувилбар, маргаан шийдэгдсэн хойно бичээсүүдийн агуулга, утгын ангилал хийж болох юм.

Монгол нутгаас олдоод байгаа руни бичгийн дурсгалыг чухам юун дээр бичиж үйлдсэнээр нь

1. Гэрэлт хөшөөний
2. Хөшөө чулууны
3. Чулууны
4. Хадны
5. Хүн чулууны
6. Зэл /балбал/ чулууны
7. Мэлхий чулууны
8. Зоосны
9. Тамганы
10. Тахилын хавтангийн
11. Номын баринтагийн тээг дээрх ?

¹⁸⁹ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Tom. VI, fasc. 1, Улаанбаатар, 1975, 24 дүгээр тал.

12. Шавар, ваарын бичээс гэсэн ангилал¹⁹⁰ хийж болох юм.

Эртний нүүдэлчдийн үсэг бичгийн асар их дурсгал тэр бүр хадгалагдаж үлдээгүй нь лавтай. Цаас, даавуу, модноо бичсэн руни мэт эртний үсэг бичиг олдохгүй байгаа нь үүний гэрч бөгөөд байгаль цаг уурын үзэгдэл хийгээд бусад элдэв сүйтгэлд хялбар үл өртөх зүйл дээр бичигдсэн цөөн тооны дурсгал он цагийн шалгуурыг давж бидний үед уламжлагджээ. Олон зүйл дээр бичигдсэний адил Монголын руни бичгийн дурсгалууд нь бичсэн арга барил, бичлэгийн тигийн хувьд бие биенээс ялгарах онцлогтой.

Энэ нь уг бичээсийг үйлдсэн зорилго, тухайн цаг үеийн байдалтай шалшгүй холбоотойгоос гадна бас нэр төр, алдар гавьяа, хэргэм, зэрэг дэвийн ялгамж ч үүнд ихээхэн хамаатай биз ээ.

Монгол нутаг дахь руни бичигт гэрэлт хөшөө, хад чулууны бичээсийг бичиж үйлдсэн арга, барил, бичлэгийн хэлбэр, үзэгдэх байдлаар нь

- Сонгодог, хичээнгүй цохимол бичээс
- Цохимол бичээс
- Зураасан /зурчмал/ бичээс
- Бэхэн бичээс хэмээн дорвөн ангилалд хувааж болох юм.

Сонгодог, хичээнгүй цохимол бичээс (Гэрэлт хөшөөний бичээс)

Хаад ихэс, язгууртан, цэргийн жанжин нарт зориулан тусгайлан зассан чулуунд уран яруу хэллэгтэй, тансаг найруулгатай бичээсийг хичээнгүй, гэн цохиж үйлдсэнийг сонгодог цохимол бичээс гэж нэрлэж байгаа билээ.

Сонгодог, цохимол бичээст;

- Көлтигинд зориулсан гэрэлт хөшөөний бичээс
- Билгэ хаанд зориулсан гэрэлт хөшөөний бичээс
- Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээс
- Онгийн гэрэлт хөшөөний бичээс
- Моюнчурын гэрэлт хөшөөний бичээс
- Тариатын гэрэлт хөшөөний бичээс зэрэг олон томоохон

дурсгалуудыг оруулж байна.

Цохимол бичээс

Хад, чулууны зөвхөн өнгөн хэсгийг холцруулан үсгийг төдий л гүнзгий бус, харьцангуй өргөн цохисон бичиг цөөнгүй тохиолдмуй. Ийм аргаар бичиж үйлдсэнийг "цохимол бичээс" хэмээн нэрлэж байна. Цохимол бичээсийг харахад тод, тодорхой мэт боловч гүнзгий бус тул хэв дардас, гэрэл зурагт төдий л сайн буудаггүй онцлогтой. Тиймээс цохимол буюу энэ төрлийн бичээсийн хэв, дардсан эх хэрэглэгдэхүүн авах, цуглуулах боломж харьцангуй хомс болой.

Цохимол бичээсийн дурсгалд;

- Их Бичигтийн бичээс
- Их Хануй нуурын бичээс
- Хөл Асгатын бичээс
- Гурванмандалын бичээс
- Гурвалжин уулын бичээс зэргийг оруулж болно.

¹⁹⁰Ц.Баттулга, Монголын руни бичгийн дурсгалыг судлах тухайд, -Түүхийн хавсарга ухаан. МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Улаанбаатар. 2003, 110-115 дугаар тал; Ц.Баттулга, Шавар ваар дээрх руни бичээс, -Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Боть XX (194), XXIII дэвтэр, Улаанбаатар, 2003, 182-192 дугаар тал.

Монголын руни бичгийн бага дурсгалуудыг ихэвчлэн цохих, зурчих үндсэн хоёр аргаар бичиж үйлдсэн байх бөгөөд энэ нь нүүдэлчдийн ахуй амьдралтай салшгүй холбоотой юм.

Нүүдэлчид хутга, зэв сум зэрэг зүйлийг байнга авч явдаг тэдгээр багаж зэвсэг шаардлагатай үед бичиг бичих хэрэгсэл (үзэг харандаа), харин хад чулуу нь цаас дэвтэр болдог байсан гэхэд их ташаарсан хэрэг, хэтийдүүлсэн явдал болохгүй буй за.

Зураасан /зурчмал/ бичээс

Хурц үзүүртэй зүйлээр маш нарийн зурж бичсэн дурсгал монгол нутгаас нилээд хэд олджээ. Ер нь хад чулууны бичээсийг ийнхүү ихэвчлэн зурах, зурчих арга, барилаар бичсэн байх нь ажиглагдаж байна. Тийн үйлдсэн, нэгэн зүйл нарийн, зураасан бичээсийг бид “зураасан / зурчмал / бичээс” хэмээн нэрлэх саналтай байна. Зурчиж бичсэн гэхээр хурц үзүүртэй зүйлээр давхарлан зурчсан мэт сэтгэгдэл төрүүлж магад. Бидний өгүүлж буй зурчмал бичээс нь хурц үзүүртэй зүйлээр дан ганц зураасаар, олон дахин зурчилгүй бичсэн байдгийг тэмдэглэе.

Тэгээд ч хурц үзүүртэй зүйлээр маш нарийн зурчиж сийлж бичсэн эдгээр бичээсийн хэв дардсыг үзэгсэд “Ёстой зураасан бичиг, хялгасан бичиг юм” гэгцгээж байсныг онцлон дурдсу.

Зураасан /зурчмал/ бичгийн дурсгалд:

- Ар Ханангийн бичээс
- Хангидайн хадны бичээс
- Дэл уулын I, II, III, IV бичээс
- Эрээн Харганатын бичээс
- Хар Магнайн бичээс гэх мэт нилээд хэдэн бичээс багтана.

Бэхэн бичээс

Сонгодог хичээнгүй цохимол, зураасан, цохимол бичээсээс ангид, онцлог нэгэн зүйл бол бэхэн бичээс юм. Архангай аймгийн Их Тамир сумын нугагт монгол түмэн, зон олноо Тайхар чулууны бичээс, судалгааны харь хэлээрх зохиол, бүтээлүүдэд Хойт Тамирын бичээс гэж алдаршсан, руни, согд, монгол, төвд, нангиад, дөрвөлжин, тод, соёмбо, ланз, манж зэрэг олон зүйл үсэг бичиг бүхүй хосгүй дурсгал бий. Энэ бичиг дурсгалын хамгийн эртнийх нь руни бичиг магад мөн бөгөөд бидний судалгаагаар 30 илүү руни бичээс буйн ихэнхийг хар бэхээр, цөөн хэд, ганц хоёрыг улаан бэхээр бичсэн ажээ. Эдгээр 30 гаруй бичээс руни бичгийн бичмэл дурсгал буюу бэхэн бичээс гэсэн ангилалд зүй ёсоор багтана.

Хад чулуунд руни үсэг бичгээр, бэхээр бичсэн дэлхийд ховор содон дурсгалд Тайхар чулууны бичээсээс гадна Хэнтий аймгийн Биндэрийн Рашаан хадны бичээс¹⁹¹ мөн орно.

Нүүдэлчид “Түмэн өдөр, мянган жил улиравч үл балрах бэх”-ээр Тайхар чулуунаа тэнгэрийн бошиг, хишиг, итгэл бишрэл, үе үеийн хэрэг, үйл явдлаа туурвин туурвисаар ирсэн нь нэн гайхамшигтай.

Бид өмнө руни бичгийн дурсгалыг юун дээр бичиж үйлдсэнээр арван хоёр ангилж товч жагсаасан билээ. Ангилал тус бүрийн талаар товч өгүүлье.

¹⁹¹ Х.Пэрлээ, Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс), -Шинжлэх ухаан амьдрал, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал; Ц.Шагдарсүрэн, 1987 оны шинжилгээний ангийн тайлан, -Хэл зохиолын хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг; С.Харжаубай, Монгол нутгаас шинээр олсон түрэг бичээсүүд, -Хэл зохиол, 16-р боть, 1-19 дэвтэр, Улаанбаатар, 1987, 79-85 дугаар тал.

Гэрэлт хөшөөний бичээс

Хаад ихээ, язгууртанд зориулан босгосон сонгодог хичээнгүй цохимол бичээст хөшөөг “*Гэрэлт хөшөө*” хэмээн нэрлэдэг.

Хөшөөний бичээс

Монголчууд эрт цагаас гэрэлт хөшөө, хөшөө чулууны бичээс гэж ялган нэрлэсээр иржээ. Учир нь хэмжээ, хэлбэр хийц, агуулга утгаараа гэрэлт хөшөө, хөшөө чулууны бичээс өөр хоорондоо ихээхэн ялгаатай болохыг өгүүлсэн хэрэг юм.

Иймд дээрх нэрээс сэдэвлэн хэлбэр хэмжээ, ур хийц, бичээсийн агуулгаараа гэрэлт хөшөөнд хүрэхгүй зарим бага (бэсрэг) хөшөө чулууны бичээс хийгээд түүнчлэн байгалийн чулууг тэгшилж янзлалгүй босгосон хөшөө чулуунд бичсэн, мөн хиргисүүрийн цулгүй хөшөөг ашиглан бичсэн бичээсийг ерөнхийд нь “*Хөшөө чулууны бичээс*” хэмээн нэрлэж байна.

Жишээ нь, Сүүжийн давааны бичээс¹⁹², Долоогойдойн бичээс¹⁹³ хэмжээний хувьд ч бичээсийн агуулгын хувьд ч гэрэлт хөшөөтэй зэрэгцүүлэхэд үнэхээр бага, бэсрэг хөшөө гэхээс аргагүй. Алсаас харахад өндөр сүртэй харагддаг ч, урт гонзгой чулууг сайн засаж янзлалгүй босгож ганц хоёр мөр бичээс цохисон байх бөгөөд ийм дурсгалд Увс аймгийн Бөхмөрөн сумын Ачит нуурын Шанаган хэв хэмээх газар байдаг Ачит нуурын бичээс¹⁹⁴, Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумдын зааг нутаг “Бага газрын чулуу” уулын Ханангийн бууцны бичээс¹⁹⁵ орно. Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг Хатуугийн голын баруун эрэг, Нохой хуцдаг уулын баруун бэл дэх Эрэн Харганатын бичээс¹⁹⁶ хиргисүүрийн цулгүй хөшөөнд бичигдсэн, хөшөө чулууны зураасан /зурчмал/ бичээс юм.

Чулууны бичээс

Хөшөө хийгээд, хадны бичээсийн аль алинд үл хамаарах нэгэн төрөл бол чулууны бичээс юм. Ханан хад, зориудын хөшөө чулуунд бус барагцаалан хэлбэл тэвэрт багтам, аргамжааны гэмээр чулууг засаж тэгшлэх буюу зарим тохиолдолд огт янзлалгүй бичиг бичдэг байжээ. Өмнөговь аймгийн Сэврэй сумын Нарангийн энгэрийн цагаан чулуу буюу Сэврэйн¹⁹⁷, Өвөрхангай аймгийн Богд сумын нутгаас олдсон, одоо Археологийн

¹⁹² G.J.Ramstedt. Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei. -Journal de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1913. pp. 30-3. 63. +3pls; Г.И.Рамстедт. Как был найден “Селенгинский камень”, & Перевод надписи Селенгинского камня. -Труды Троицкосавско-Хянтинского Отделения Приамурского Отдела Императорского Русского Географического Общества 15-1, стр.34-39, 40-49; G.J.Ramstedt, Seven Journeys Eastward 1898-1912, Tr. from the Swedish & ed. by J.R.Krueger, Bloomington, 1978.

¹⁹³ Ц.Доржсүрэн, Долоогойдойн булш ба түүний хөшөө, -Шинжлэх ухаан, техник. Улаанбаатар, 1957, № 5/6, 25-26 дугаар тал; С.Г.Кляшторный, К историографической оценке Уланкомской надписи, -Эпиграфика Востока 14. Москва, 1961, стр.26-28; А.М.Щербак, Надпись на древнеуйгурском языке из Монголии, Эпиграфика Востока 14. Москва, 1961, стр.23-25; Э.Вандуй, Увсын Хар Усны гэрэлт хөшөө, -Шинжлэх ухаан, техник. Улаанбаатар, 1958, №3 (55), стр.45-47.

¹⁹⁴ С.Г.Кляшторный, Эпиграфические работы в Монголии, Москва, 1980; С.Харжаубай, Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүд. -Хэл зохиол судлал, 16-р боть, 1-19-р дэвтэр, Улаанбаатар, 1987, 79-80 дугаар тал; Л.Болд, Ачит нуурын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 19-20 дугаар тал.

¹⁹⁵ Ч.Амартүвшин, Ц.Баттулга, Ханан бууцны бичээс, -Археологийн судлал, Том XII, fasc.3. Улаанбаатар, 2005, 82-86 дугаар тал.

¹⁹⁶ Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймагт ажилласан хээрийн шинжилгээний тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөг; Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, -Ил товчоо сонин, 1994, 3-р сар, № 9 (112); Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээс, -Археологийн судлал, Том XV, fasc.6, Улаанбаатар, 1995, 65-69 дугаар тал; Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээсийг дахин нягтлах нь, -The Korean Association for Mongol Studies. Mongolian Studies: 10, Seoul, 2000, pp. 147-153.

¹⁹⁷ Сэврэйн бичээс хэсгээс лавлан үзнэ үү.

хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа Тэвшийн¹⁹⁸, Өвөрхангай аймгийн орон нутгийг судлах музейд буй “Өвөрхангайн бичээс”¹⁹⁹-ийг хүн даахуйц, хавтгай бус чулууны толигор талыг ашиглан бичсэн байдаг нь нэн онцлог тул эдгээр бичээсийг “чулууны бичээс” гэсэн ангилалд багтаах саналтай байна.

Хадны бичээс

Хадны бичээс ихэвчлэн өвөлжөө, хаваржааны ханан хаданд тохиолдож байгаа нь хэдэн зууныг дамжиж ирсэн нүүдлийн соёл, амьдрал ахуйтай холбоотой биз ээ.

Ан ав ихтэй, ус ургамалтай, бууц хондтой газар ч хадны зураг, тамга тэмдгийн дунд бичээс цохисон байх нь элбэг.

Хадны бичээсэд;

Арханангийн (өвөлжөөний) бичээс

Гурвалжин уулын (өвөлжөөний) бичээс

Дэл уулын (өвөлжөөний) бичээс

Хангидайн(өвөлжөөний) бичээс

Их бичигтийн (өвөлжөөний) бичээс

Зүүн оройн өвөлжөөний бичээс

Гурванмандалын бичээс

Ямаан усны буюу Ханын хадны бичээс гэх мэт нилээд хэдэн

дурсгал багтана.

Дээрх бичээс бүхүй газруудыг өвөлжөө гэж байгаа боловч байнга өвөлждөг газар хэмээн ойлгож огт болохгүй, цаг улирлын байдлаас шалтгаалан хаваржих, намаржих, бас өвөлжөө байснаа хаваржаа болж, хаваржаа нь өвөлжөө болж солигдох, хонд бууц болон мартагдах нь ч бий.

Хүн чулууны бичээс

Монгол нутаг дахь түрэгтийн үеийн хүн чулуунд үсэг бичиг, тамга тэмдэг цохисон байх нь тун ховор болой. Хүн чулууны бичээс буюу бичигтэй, тамгатай хүн чулуу одоогоор цор ганц олдлоод буй нь Чойрын хүн чулуу²⁰⁰ ажээ.

Зэл (балбал) чулууны бичээс

Түрэгтийн оршуулга, тахилын онгонд олонтоо тохиолдох цувран үргэлжлэх олон чулууг Монголчууд “зэл” чулуу хэмээн нэрлэж ирсэн уламжлалтай бөгөөд харин шинжлэх ухаанд Түрэгтийн руни бичгийн дурсгалд тохиолдох хэлбэрээр нь “балбал (𐰇𐰏𐰅 balbal)” гэж нэрлэдэг.

Хаад ихэс, язгууртны тахилын онгон цогцолборын чухал бүрдэл хэсгийн нэг зэл /балбал/ чулуу мөн билээ. Зэл чулууг эрдэмтэд,

- уг баатрын амьдаа алсан дайсны тоо (Н.И.Бичурин²⁰¹)

- оршуулгад оролцогсдын тоо (тэдний морины уяа) (С.И.Руденко²⁰², М.Шинэхүү²⁰³
В.Д.Кубарев²⁰⁴, Д.Баяр²⁰⁵, С.С.Сорокин²⁰⁶, В.Е.Войтов²⁰⁷)

¹⁹⁸ Тэвшийн бичээс хэсгээс лавлан үзнэ үү.

¹⁹⁹ Л.Болд, Шинээр олдсон түрэг бичээс, -Хэл зохиол, XVI боть, 1-19-р дэвтэр, Улаанбаатар, 1987, 68-71 дүгээр тал; Л.Болд, Өвөрхангайн бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 83-84 дүгээр тал.

²⁰⁰ Дахин нягтлууштай дурсгал хэсгээс лавлан үзнэ үү.

²⁰¹ Н.Я.Бичурин, Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена, Том I, Москва-Ленинград, 1950, стр.130.

²⁰² С.И.Руденко, Культура населения Центрального Алтая в Скифское время, Москва-Ленинград, 1960, стр.326.

- тахилд өргөсөн хонь, адууны тоо (Я.А.Шер²⁰⁸)
 - талийгаачийн сүнс нөгөө ертөнцөд очих зам мөр, зүг чиг заагч (Ц.Баттулга²⁰⁹),
 - эртний нүүдэлчдийн оршуулгын “сэргэ”-тэй холбоотой зан үйл (Ц.Төрбат²¹⁰) хэмээн үзэж тайлбарласан ажээ.

Монгол орны нутаг дэвсгэр дэх зэл чулууг дөрвөн төрөлд ангилж болох байна. Үүнд;
 - цулгүй зэл чулуу

- тамгат зэл чулуу

- хүн дүрст зэл чулуу /тамгатай/

- бичигт зэл чулуу /бичигтэй, тамгатай / эдгээр болно.

“Зэл чулууны бичээс”-т Онгийн цогцолбор дурсгалын зэл чулууны бичээс, Билгэ хааны тахилын онгоны зэл чулууны бичээсийг тус тус хамааруулж байна.

Онгийн гэрэлт хөшөөт онгоны зэл чулууны бичээс

Онгийн гэрэлт хөшөө бүхий онгоны зэл чулууны руни бичээсийг В.В.Радлов анх уншсан билээ. Түүний судалгааг толилуулбал,

Эхийн хуулбар:

Үсгийн галиг:

Үгийн галиг:

ᠨᠶᠠᠳᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠ

šbra trkn blbli

Сабра таркан балбалы

Герман орчуулга:

*Der Steinfleier des Sabra-Tarkan*²¹¹ ийм болой.

Онгийн гэрэлт хөшөө аянганд ниргэгдэн бутарч унаснаас одоо гэрэлт хөшөөний бичигтэй хоёр, гуравхан хугархай үлдсэн бөгөөд “Сабра тарханы балбал” гэсэн бичигт зэл чулуу ч үгүй болжээ.

Билгэ хааны онгоны зэл чулууны бичээс

Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Хөгшин Орхон голын хөвөө, Хөшөө Цайдам хэмээх газар буй Билгэ хааны тахилын цогцолборын зэл чулууны бичээсийг В.В.Радлов уншиж судалсан бөлгөө. В.В.Радловын судалгааг толилуулбал;

Эхийн хуулбар:

ᠰᠢᠷᠭᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠ

Үсгийн галиг;

šols šdn ts blbli bol

Үгийн галиг;

Tölac шадың таи балбалы болмыш

Герман орчуулга:

*Dies ist der Steinfleier (zu Ehren) des Schad der Töläs*²¹²

²⁰³ М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Tom.VIII, fasc.1, Улаанбаатар, 1980, 21 дүгээр тал.

²⁰⁴ В.Д.Кубарев, Древнетюркские изваяния, Новосибирск, 1984, стр.81.

²⁰⁵ Д.Баяр, Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу, Улаанбаатар, 1997, 36 дугаар тал.

²⁰⁶ С.С. Сорокин, К вопросу о толковании вискеранных памятников ранних кочевников Азии, Ленинград, 1981, стр.36.

²⁰⁷ В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания (В культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв.), -Государственный музей Востока, Москва, 1996, стр.86.

²⁰⁸ Я.А.Шер, Каменные изваяния Семиречья, Москва-Ленинград, 1966, стр.56.

²⁰⁹ Ц.Баттулга, Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын зарим судалгаа, 1999, 125 дугаар тал.

²¹⁰ Ц.Төрбат, “Сэргэ” эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент, - Studia Archaeologica, Tom XII, fasc.14, Улаанбаатар, 2000,

²¹¹ W.Radloff, Das Denkmal am Ongin, -Die Altürkischen Inschriften der Mongolei, St.Petersburg 1895; Osnabrück 1987, pp.252.

Орчин цагийн монгол хэлнээ орчуулбал;

"Төлис шадын чулуун балбал бол(муй)" гэсэн утгатай ажээ. Төгсгөлийн хоёр үсгийг тэрбээр сэргээн уншсан байна.

1897 онд орос хэлээр гарсан орчуулгад уг зэл чулууг "Надпись на первомъ камнѣ изъ вереницы камней, стоящихъ у могилы Бильге хана" хэмээн нэрлэж "Töläs шадын таш балбалы бол- Это каменный балбалы въ память шада Төлесовъ"²¹³ гэж галиглан орчуулсан бөлгөө.

Уг зэл (балбал) чулуу шороонд дараастай байсныг Монгол-Туркийн хамтарсан шинжилгээний ангийн археологийн хэсэг 2000 онд дахин олж илрүүлсэн билээ²¹⁴.

Онгийн болон Билгэ хааны цогцолборын бичигт зэл чулууны зургийг В.Е.Войтов номдоо оруулж хэвлүүлсэн ба хүн дүрст болон тамгат зэл чулууны талаар түүний бүтээлээс лавшруулан үзнэ үү²¹⁵.

Зэл чулууны тамга, түүний бичээсийн утга бэлгэдэл, учир холбогдлын талаар тусгайлан судалсан зүйл одоогоор алга байна. Тамга, бичээс нь түүний үүсэл гарал, утга бэлгэдэлтэй ямар холбоотойг хожмын эрдэмтэд анхааран судлах бизээ.

Мэлхий чулууны бичээс

Эрт цагт хөшөө, гэрэлт хөшөөг мэлхий чулууны нуруун дээр босгодог уламжлал ихээхэн өргөн дэлгэр байсныг монгол нутгаас олдож буй мэлхий суурьт хөшөө болон, мэлхий чулуун суурь нуталж байна.

Монгол нутгаас олдсон мэлхий суурьт гэрэлт хөшөөг тоочвоос;

1. Бугатын гэрэлт хөшөө
2. Көлтигиний гэрэлт хөшөө
3. Билгэ хааны гэрэлт хөшөө
4. Тариатын гэрэлт хөшөө
5. Моюнчур /Могойн шинэ ус/-ын гэрэлт хөшөө
6. Онгийн гэрэлт хөшөө (эвдэрч ихэд сүйдснээс бараг танигдамгүй болжээ) (В.Е.Войтов, мэлхий чулуу хоёр буй гэжээ)
7. Хар балгасын гэрэлт хөшөө (урьд цагт байсан гэх) эдгээр болно.

Гэрэлт хөшөө нь олдоогүй мэлхий чулууд

1. Улхын булангийн, эдүгээ Төв аймгийн орон нутгийг судлах музейн үүдэнд байгаа мэлхий чулуу (янгир, могой тамгатай, В.Е.Войтов, (Мухарын цогцолбор- Мухарский комплекс))
2. Архангай аймгийн Хайрхан сумын Хөшөөн талын мэлхий чулуу
3. Хар Хорумын Мэлхий толгой дээр буй хоёр гуян дээрээ шувууны уран сийлбэртэй мэлхий чулуу (үүнээс гадна Эрдэнэ зуу хийдийн орчим мэлхий чулуу хоёр буй бөгөөд Хар Хорум хотын туйраас баруун урагш 30 км-т дутуу хийгээд орхисон нэгэн мэлхий чулуу байсныг овилгогүй нэгэн гүйцээн хийх нэрийдлээр сүйтгэсэн байна)
4. Завхан аймгийн Их Уул сумын Цэцүүхийн дурсгалын мэлхий чулуу

²¹³ W.Radloff, Verbesserungen, Zusätze und Erklärungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, -Die Altürkischen Inschriften der Mongolei, St.Petersburg 1895, (Atlas der Alterthümer der Mongolei, Taf.XI, fig.11 and Taf.XXVI, fig.7); Osnabrück 1987, pp.243.

²¹⁴ В.В. Радловъ, П.М.Мелиоранскій, Древне-Тюркскіе памятники въ Кошо-Цайдамъ, - Сборникъ трудовъ Орхонской экспедиціи IV, Санктпетербургъ, 1897, стр.45.

²¹⁵ Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2000 Yılı Çalışmaları, -Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara 2000, s.177.

²¹⁶ В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания (В кульгово-поминальных памятниках Монголии VI-VIII вв.), -Государственный музей Востока, Москва, 1996, стр.86-87.

5. Чин толгойн балгасаас олдсон, одоо Хар Бухын балгасын музейд буй мэлхий чулуу.
 6. Мөн тэндээс олдсон Хар Бухын балгасын музейд буй мэлхий чулуу эдгээр болно. Одоогийн байдлаар Монгол нутгаас нийтдээ мэлхий чулуун суурь 13 олдож илрээд байна. Монгол нутаг дахь түрэг, уйгурын үеийн тахилын цогцолбор, тахилын хавтан, зэл чулуу, мэлхий чулуун суурийн талаар В.Е.Войтов номдоо дэлгэрэнгүй өгүүлсэн буй²¹⁶.

Мэлхий чулууны утга бэлгэдлийн талаар М.Шинэхүү гуай “Дорно дахиныхны эртнээс нааш уламжилсан заншлаар бол мэлхий нь урт настай билигдэлт амьтан тул гэрэлт хөшөөгөө түүн лүгээ адил өнө мөнх сүндэрлэж байхыг билигдэн тийнхүү мэлхий чулууны нуруун дээр босгосон байж болох юм. Монголын их гүрний нийслэл Хархорум хотод байсан уйгуржин, араб, нангиад бичигтэй хөшөөнүүдийг хүртэл мэлхий чулуун дээр босгосон нь дээрх заншлын уламжлал байх гэж үзнэ. Үүнтэй уялдуулан Тариатын гэрэлт хөшөөг ажиглахуул эртний түрэг, уйгур улс зассан чулуунд гавьяат үйлсээ мөнхжүүлэн үлдээх бичгийг сийлэхдээ чулууныхаа дээд оройн хэсгийг наран, саран, тэнгэр, их биений хүмүүн төрөлтөн, суурь мэлхий чулууг газар дэлхий хэмээн хувааж үздэг байсан бололтой”²¹⁷ гэж тэмдэглэсэн нь бий.

Мэлхий чулуун суурь гэрэлт хөшөөний нэг хэсэг мөн боловч чухам юун дээр үйлдэж бичсэн талаас нь авч үзвээс яах аргагүй “*мэлхий чулууны бичээс*” хэмээх ангилалд хамаарах нь лавтай.

Колтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь

Колтигиний гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь хагарч унаснаас түүн дээр байсан бичээс ч бүрэн бүтнээр бидэнд уламжлагдан ирээгүй нь харамсалтай. Мэлхий чулуун дээрх найман мөр бичээсийн гэрэл зургийг Б.Ринчен гуай нийтлүүлж²¹⁸, Б.Базылхан²¹⁹, (Akio Katayama)²²⁰ нар уншиж судалжээ.

Колтигиний гэрэлт хөшөөний мэлхий чулуун сууринд ямар нэгэн тамга тэмдэг үгүй бөгөөд малтлагаар илэрсэн Билгэ хааны гэрэлт хөшөөний мэлхий чулуун сууринд мөн адил тамга, бүр бичээс ч үгүй байсан билээ.

Тариатын гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь

Тариатын гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурийн баруун бөөрөн дээрх нэг мөр бичээсийг эрдэмтэд олон хувилбараар тайлан уншжээ.

Мэлхий чулуун суурийн бичээсийн эхийг сийрүүлбэл;

ᠮᠡᠯᠬᠡᠢ ᠴᠢᠯᠠᠭᠤ ᠰᠤᠷᠢᠨᠢ ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠢ

М.Шинэхүүгийн судалгаа

Бичээсийн галиг;

buni jaratiṃba bōka tutim

Сонгодог монгол бичгийн хэлнээ;

²¹⁶ В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания (В культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв.), -Государственный музей Востока, Москва, 1996, стр.27-31.

²¹⁷ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Tom. VI, fasc. I, Улаанбаатар, 1975, 45-46 дугаар тал.

²¹⁸ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. I, Oulanbator, 1968, pp.40.

²¹⁹ Б.Базылхан, Күл-тегиний хөшөөний мэлхий чулууны түрэг бичээс, -Хэл зохиол, Том VII, fasc. 1-13, Улаанбаатар, 1969, 253-255 дугаар тал.

²²⁰ 片山章雄・キヨル＝テギン亀趺銘文・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Akio Katayama, Epitaph on the Tortoise-Shaped Socle of Kōl-Tegin Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 147.

egün-i бүтүүлгэжү бөке тойтагалыбай (саруилагүлбай) би

Орчин цагийн монгол хэлнээ;

Үүнийг бүтээлгэж бөх тогтоолгов (суурилуулав) би

Орос хэлнээ орчуулсан нь;

этого создали и крепко установили (по моему велению он был создан и крепко установлен)²²¹

Тэрээр 1980 онд хэвлүүлсэн бүтээлдээ “үүнийг (бүтээлгэж) босгож, (бат) бэх (суурилуулав) тогтоолгов би” хэмээн найруулан засчээ²²².

С.Г.Кляшторныйн судалгаа

Бичээсийн галиг;

bunī yaratiŋma bökä –tutam

Англи орчуулга;

*He who made this (monuments) is Bökä Tutam*²²³

Талат Текин (Talat Tekin)-ний судалгаа

Тэрээр Тариатын гэрэлт хөшөөний бичээсийг уншиж тайлсан судалгаагаа англи, турк хэлээр хэвлүүлсэн²²⁴ байна.

Бичээсийн галиг;

bunī y(a)r(a)t(f)ŋma bökä tut(a)m

Англи орчуулга;

He who created this is Bökä Tutam

Орчин цагийн турк хэлнээ хөрвүүлсэн нь;

buni yaratan (veya yaran) Bökä Tutam (dir)

Б.Базылханы орчуулга

Үүнийг бичигч чулуун хөшөөнд минь бөх тулгуур гэж үзнэм²²⁵

Акио Катаяама (Akio Katayama)-гийн судалгаа

Япон орчуулга;

これを造つたのはボケ=トウタム

Англи орчуулга;

*He who inscribed this (stone) is Bökä Tutam*²²⁶

Л.Болд гуай эл бичээсийг “*buni yaratiŋma bükä tutum*” хэмээн галиглаж “үүнийг бүтээсэн Бүке тутам”²²⁷, С.Харжаубай “*buni yaratiŋma bükä tutam*” гэж галиглаад орос хэлнээ “*Поклоняюсь дракону, создателю с его*” хэмээн тус тус орчуулжээ²²⁸.

²²¹ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Том.VI, fasc.1, Улаанбаатар, 1975, 35 дугаар тал.

²²² М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Том.VIII, fasc.1, Улаанбаатар, 1980, 23 дугаар тал.

²²³ S.G.Klyashtorny, The Terkhin Inscription, -Acta Orientalia Academiae Scientiarum Hung.Tom XXXVI(1-3), 335-366 (1982).

²²⁴ Talat Tekin, The Tariat (Terkhin) Inscription, -Acta Orientalia Academiae Scientiarum Hung.Tom XXXVII(1-3), 43-68 (1982); Talat Tekin, Kuzey Moğolistan'da yeni bir Uygur anıtı: Tariat (Terhin) kitabesi, -BELLETEN, Türk Tarih Kurumu, Tom.XLVI, Sa.184, Ekim 1982, Ankara 1983, s.795-836.

²²⁵ Б.Базылхан, Тэрхийн түргэ бичээс, -Studia Archaeologica, Том.VII (15), fasc.1-15, Улаанбаатар, 1980, 163-175 дугаар тал.

²²⁶ 片山章雄・タリят碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Akio Katayama, Tariat Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 172, 174.

²²⁷ Л.Болд, Тариатын Орхон бичээс, - Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 176-209 дугаар тал.

²²⁸ С.Каржаубай, Объединенный каганат тюрок в 745-760 годах, Астана, 2002, стр. 44, 48.

Гадаадын судалгааны ном зохиолд голдуу Тэрхийн бичээс хэмээн нэрлэж хэвшсэн нь Тэрхийн голоор нэрлэх саналтай нийцүүлсэн хэрэг.

Колтигиний гэрэлт хөшөөний хойт талын 13-р мөрөнд: “barq itgüci bediz yaratiŷma bitig taš itgüci tabyač qayan čiqanī čaŷ saŷün kälti” хэмээн гарах бөлгөө.

Сонгодог бичгийн дурсгалд мэлхий чулуун суурийн бичээст гарч буй “yaratiŷma” гэх үг “*bediz yaratiŷma*” гэсэн холбоо үгээр тохиолдож байна.

Энд чухам яагаад “barq itgüci, bitig taš itgüci” гэсэн атлаа “*bediz itgüci*” гэхгүй “*bediz yaratiŷma*” хэмээн бичих болов?

“barq itgüci, bediz yaratiŷci, bitig taš itgüci tabyač qayan čiqanī čaŷ saŷün kälti “ гэж бичээгүйн учир юунд байна гэсэн асуулт зүй ёсоор гарна. Уг үгийг задлан үзвэл $yaqa + t + \gamma(k) + m(a) = yarati - ti - \gamma(k)m(a)$ бүтээлгэсэн нь (бүтээлгэгч нь бүтээлцэгч нь) гэсэн бүтэцтэй байна. Иймд нэг мөр бичээсийг “үүнийг бүтээлцсэн (бүтээлцэгч) нь Бөх (Бөкэ) Тутум” гэсэн утгатай хэмээн үзэж байна.

Зоосны бичээс

Зоос судлал (numismatics) хэмээх салбар ухаан нь зоосноо бичигдсэн үсэг бичгийг тайлан унших, он цагийг тогтоох тэргүүт олон чиглэл, зорилготой бөлгөө.

Зоосны цуглуулгын ховорхон үзмэрийн нэгнээ руни бичигт зоос ордог ажээ.

Монгол нутгаас дэлхий дахинаа тун цөөхөнд тооцогдох руни бичигтэй нэгэн зоос олдсон нь эл үсэг бичгийн өлгий нутгийн хувьд байж болох ч, ижилгүй ховорт тооцогдох чухар олдвор билээ. Нэн харамсалтай нь “үгүйд үүрүүлжээ”²²⁹.

Уг олдвор, зоосоор баримжаалан эртний түрэг, уйгурын худалдаа арилжаа, гүйлгээн дэх зоосон мөнгөний хэрэглээ, мөн түүнчлэн хүндэтгэлийн зоос дэлдэх, дурсгалын зоосноо бичиг бичих уламжлалын талаар тодорхой хэмжээнд хөндөж болох байсан биз ээ.

Тамгын бичээс (Мутрын тэмдэг)

Эртний улс аймгууд өөрийн сүлд, тамгатай байсныг түүх археологийн сурвалж баттай гэрчлэх бөгөөд тамга нь овог аймгууд бие даан тусгаар оршин тогтнохын үндэс, нуталгаа болдог байжээ.

Нэн эрт цагаас нүүдэлчид төрийн, албаны тамгатай төдийгүй эрх, эрдэм бүхүй хувь хүн ч мутрын тэмдэгтэй байсны өчүүхэн гэрч баримт бол хүрлээр цутгаж хийсэн, руни үсгээр “ 𐰽𐰺𐰍 qutluy -Кутлуг” хэмээх ганц үгийг хоёр мөр болгон бичсэн тамга²³⁰ мөн болно.

Тахилын хавтан, хашлага чулууны бичээс

Өвөрмөц ангилалд хамаарах бичээсийн нэгэн төрөл бол тахилын хашлага чулууны бичээс билээ. Онгоны хашлага чулуунаа бичээс бичиж чимэглэн хээлэх нь зөвхөн, түрэг, уйгурын үед буй болсон шинэ ёс заншил огтхон ч бус, Европ зүгийнхний эртний грек, ромын үед шарилын бунхныг чулуугаар гайхамшигтай сайхан урлаж чимэглэх, элдэв зураг зурах, бичээс бичих уламжлалаас, Дорно дахиныхны, тухайлбал, нангиадуудын эртний улсуудын бунхант тахил, түүний хана, туурганы чимэглэл, албат ард, цэрэг, түшмэд (хүн чулуу), тахил (хонь), сахиулын амьтан (арслан)-ы урлалын уламжлалаас улбаатай, хаад,

²²⁹ Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх (Түүхэн найруулал), Улаанбаатар, 1977, 41-42 дугаар тал; С.Г.Кляшторный, Монета с рунической надписью из Монголии, -Тюркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338; С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 32 дугаар тал; Л.Болд, Зоосон дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 31-33 дугаар тал.

²³⁰ Х.Лувсанбалдан, Өчүүхэн түрэг бичээс, -Шинжлэх ухаан амьдрал, 1962, №4, 68 дугаар тал; Б.Базылхан, Эртний тюрк бичээстэй мутрын тэмдэг, -Шинжлэх ухаан амьдрал, №1, Улаанбаатар, 1964, 74-75 дугаар тал.

язгууртны оршуулгын эртний соёлын нөлөө тусгал гэлтэй. Мэдээж хэрэг, дээрх үлгэр загвар тодорхой хэмжээгээр туссан ч үндэсний язгуур онцлогоо ч мөн хадгалсан байдгийг үгүйсгэх аргагүй юм.

Гэхдээ онгоны цогцолбор, тахилын хашлагын чимэглэл нь анх удаа түрэг, уйгурын үед суурьшмал соёл иргэншилт улс гүрнүүдийн хаад ихэс, язгууртныг онголох загвар жишигт дөхөж очсон төдийгүй тэд язгуур сэтгэхүй, сүсэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, өвөрмөц ёс заншлаа бүрэн шингээн үйлдсэн нь гарцаагүй.

Харин тэдгээр өвөрмөц язгуур соёлыг илрүүлэн судлах зайлшгүй шаардлагатай байна. Монгол нутаг дахь түрэг, уйгурын үеийн онгон, тахилын хашлага нь дотроо

-цулгүй

-тамгатай

-тамга, ханан хээтэй

-дан ханан хээтэй

-ханан хээ, цэцгэн хээтэй

- үлгэр домгийн шинжтэй шувуу, жимс дүрсэлсэн чимэг хээтэй

-бичээстэй

-хүн чулуу, шувуу, хээ чимэглэл, тамга, бичээстэй гэсэн хэдэн төрөл байна.

Хаад ихэс, цэргийн жанждад зориулан босгодог байсан нүсэр том онгон, цогцолбор аажмаар хумигдан багассаар хураангуйлагдан цомхон болж хашлага чулуунд бичээс, хүн чулуу, тамга зэрэг цогцолбор дурсгалд байх бүхий л зүйлийг багтааж төлөөлүүлэн дүрсэлдэг болсон бололтой. Нэг хэсэг түгээмэл дэлгэрсэн, хүч хөрөнгө шаардах чирэгдэл ихтэй онголох ёслол нь нүүдлийн соёлд төдий л зохилдохгүй байснаас дээрх мэт хураангуйлагдсаар мартагдсан байж мэдэх юм.

Хүн чулуу, тамга, хээ чимэглэл, шувуу, бичээсийг нэг хавтгайд багтаасан тахилын хавтангийн сонгодог урлал бол Булган аймгийн Могод сумын Түлээ уулын хормойд орших Хөл Асгатын дурсгал билээ.

Ер нь түрэг, уйгурын үед холбогдох археологийн дурсгалуудаас онгон, цогцолбор дурсгалууд нь хэлбэр хийц, холбогдох зан үйл, агуулга, ач холбогдлоороо өвөрмөц онцлогтой бөгөөд тэдгээрийн тус тусын үүрэг зориулалт, утга агуулгыг цаанид нарийвчлан судалж тодотгох хэрэгтэй. Онгон, хашлагын чимэглэл сүнсээ тахиулагчийн хэргэм зэрэг, нийгэмд эзлэх байр суурийг тодорхой хэмжээгээр илтгэх нь дамжиггүй.

Онгон, хашлага чулууны бичээс:

-Их Хануй нуурын бичээс

- Хөл асгатын бичээс эдгээр орно.

Номын баринтгийн тээг дээрх бичээс

Улсын нийтийн номын санд хадгалагдаж байсан “Гучин хоёр модон хүний үлгэр” гэдэг номын баринтгийн тээг дээр байсан гэдэг.

Үнэхээр, уг бичээс байсан, хуурамч биш бол руни бичгийн хэрэглээ хэр зэрэг өргөн дэлгэр байсныг илтгэх чухаг баримт болох төдийгүй анх ямар үүрэг зориулалттай хийгдсэнийг ч мэдэж болох байсан биз ээ²³¹.

Харамсалтай нь номын баринтгийн тээг дээрх бичээс алга болжээ.

²³¹ Дэлгэрэнгүйг алга болсон дурсгалууд хэсгээс үзнэ үү.



Шавар, ваар дээрх бичээс

Сав суулга, эдлэл хэрэглэл, ваар дээр бичсэн руни бичгийн дурсгал манай орноос одоогоор олдоогүй байна. Харин бичээс бүхий дээврийн нөмрөг ваар, тахилын сүмийн ханын шаваасын зэрэг барилгын хэрэглэгдэхүүн олджээ. Манай орноос олдсон шавар ваарын төрөл дээрх бичээсийг тоочвол;

- 1.Налайхаас олдсон шавар (ceramic) эдлэлийн хэлтэрхий дээрх бичээс
- 2.Туньюкукийн тахилын сүмийн ханын шаваас дээрх бичээс
- 3.Дээврийн нөмрөг ваарын хэлтэрхий дээрх бичээс³³² эдгээр болно.

Ахуйн хэрэглээний эдлэл дээр бичсэн руни бичиг манай орноос хараахан олдоогүй нь эртний түрэг уйгурын үед холбогдох булш хиргисүүр, хот балгадын туйрыг малтан шинжилсэн судалгаа ховор байгаатай холбоотой бизээ.

Бид чухам юун дээр үйлдэж бичсэн руни бичгийн дурсгал монгол орноос олдсоныг тодруулан танилцуулахыг зорьсноос бус руни бичгийн дурсгалыг нарийвчлан ангилж буй хэрэг огтхон ч биш юм.

³³² Ц.Баттулга, Шавар ваар дээрх руни бичээс. -Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС. Монгол хэл, соёлын сургууль, Боть. XX (194), XXIII дэвтэр, Улаанбаатар, 2003, 182-192 дугаар тал.

1.4.0. МОНГОЛ НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Монголын руни бичгийн дурсгалын судалгааг манай эрдэмтэд тоймлон нийтлэхдээ ямар үр дүнд хүрсэн, судалгааны цаашдын зорилт, хэтийн төлөв байдлыг тодорхойлоор ирсэн уламжлалтай билээ.

1968 онд археологич Н.Сэр-Оджав “БНМАУ-д түрэг бичээсийн дурсгалыг судалж байгаа нь” хэмээх тойм бичсэн нь монголын түрэг судлал нэн ялангуяа руни бичгийн судлалын тухайн үеийн байдлыг дотоод, гадаадын эрдэмтдэд тоймлон мэдээлснээрээ ихээхэн ач холбогдолтой болсон байна²³³.

Тэрбээр өгүүлэлдээ Монгол нутаг дахь эртний бичгийн дурсгалыг манай эрдэмтдээс 1950-аад оноос 1960 оны эхэн үе хүртэлхи хугацаанаа олж судалсан байдлыг товч дүгнэн өгүүлээд “Бидний нийтэлж буй өгүүлэлд сүүлийн жилийн зарим нэгэн судалгааны ажил орсон бөгөөд бүгдийг багтаан оруулсан гэж үзэж болохгүй нь мэдээж бөгөөд дараа хэвлэгдэх дэвтэрт судалгааны тоймыг үргэлжлүүлэн нийтлүүлэх учрыг дурдана”²³⁴ хэмээжээ.

Доктор Л.Болд “БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал” хэмээх тоймд 1950-аад оноос 1980-аад оны дунд үе хүртэлх 30 гаруй жилийн судалгааны дүн, 40 дурсгалыг олж илрүүлсэн, судлагдсан байдал зэргийг хамруулж багтаасан байна²³⁵.

Тус тоймд руни бичгийн дурсгалыг хаанаас хэдэн онд хэн олсон, аль аймаг, сумын нутагт орших, газрын байршил зэргийг тодорхой дурдаж оруулснаараа чухал ач холбогдолтой болжээ.

Эдгээр судалгааны тойм гарснаас хойш бараг 20 гаруй жил болж буй тул энэ завсар урьд олдсон дурсгалуудыг дахин нягтлан судалсан, шинээр олдсон бичээсүүдийг уншиж тайлсан шинэлэг олон судалгаа, бүтээл гарчээ.

Энэ хугацаанд эртний бичгийн дурсгалыг унших, эх бичгийг судлах аргазүй улам боловсронгуй болсоноос гадна орчин үеийн шинжлэх ухааны техникийн дэвшилтэт багаж хэрэгслийг ашиглан илүү бодитой, зөв уншиж судлах боломж нөхцөл бүрджээ.

Эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагаа улам өргөжин хөгжиж олон улсын хамтарсан төслүүд хэрэгжих болсноор и.э. х.о-ын бүс нутагт хэрийн судалгааны ажил хийж шинэ дурсгал нээж илрүүлэх болсон байна.

Сүүлийн үеийн судалгааны үр дүн, монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын шинэ бүртгэл, дурсгалын ангилал, дахин нягтлан судлуштай, олж илрүүлсэн ч хараахан судлаагүй байгаа, мөн түүнчлэн шинжлэх ухаанч бус хүний хар гарт өртөж үрэгдсэн, алга болсон дурсгалуудын талаар судалгааны тоймд өгүүлэхийг хичээсэн болно.

Монголын руни бичгийн дурсгалыг

Алтайн бүс нутаг дахь

Хангай, Хэнтийн бүс нутаг дахь

Тал хээрийн бүс нутаг дахь

Говийн бүс нутаг дахь гэж орших бүс нутгаар ангилах нь илүү зохимжтой мэт санагдана. Хэдийгээр газарзүйн шинжлэх ухааны ангилалд төдий л нийцэхгүй ч Монгол

²³³ Н.Сэр-Оджав, БНМАУ-д түрэг бичээсийн дурсгалыг судалж байгаа нь, - Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, Fasc 1. Улаанбаатар (Oulanbator), 1968, pp. IX-XIII.

²³⁴ Н.Сэр-Оджав, БНМАУ-д түрэг бичээсийн дурсгалыг судалж байгаа нь, - Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, Fasc 1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp. X.

²³⁵ Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №3, 65-87 дугаар тал.

орон дахь руни бичгийн дурсгалын тархалтыг харуулах чухал ач холбогдолтой хэмээн үзэж буй хэрэг.

Нүүдэлчдийн түүх соёлд газарзүйн байрлал маш чухал ач холбогдолтой байдаг. Ус ургамал тэгш, байгаль цаг уурын таатай нөхцөл бүрэлдсэн газар нутагт улс төр нь төвлөрдөг болохыг эртний хотын туйр, археологийн баримтууд нуталдаг билээ. Тэгэхээр улсын төр төвлөрсөн бүс нутгийн дурсгал, хязгаар алс нутгийн дурсгал ач холбогдол, хэмжээ хэлбэр, үнэ цэнийн хувьд ямар харьцаатай байх нь тодорхой.

Бүс нутгуудад хувааснаар ямар арга (сийлэх, цохих, зурж-зурчих) хэлбэрээр бичсэн, бичлэгийн ямар онцлогтой дурсгал аль бүс нутагт зонхилж байгааг нарийвчлан гаргах, бичээсийн тархцыг тодорхойлох бүрэн боломжтой санагдана.

Монголын руни бичгийн дурсгалуудыг бүс нутагт хуваан нарийвчлан нягталж үзвэл бүс нутгийн бичээсийн үсэг тэмдэгтийн онцлог, цаашилбал хэл аялгууны ялгааг ч тодруулах боломж олдож түүгээр дамжуулан эртний түрэг хэлний аялгуунуудыг сэргээх сурвалжлах нэгэн арга зам, аргагүйн шинэ хувилбар нээгдэж болох юм.

Дурсгалуудын байгалийн элэгдэл хорогдол бүс нутгийн цаг уур, газарзүйн байрлалтай шууд холбоотой учир цаашид эртний бичгийн дурсгалуудыг хадгалан хамгаалах, зарим дурсгалыг бүрэн сүйдэж үгүй болох аюулаас аврах талаар бүс нутагт тохирох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд ч энэ ангилал ач тустай хэмээн санана.

1.4.1. АЛТАЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Алтайн бүс нутагт Монгол улсын одоогийн цагаг захиргааны хуваарнаар Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгууд хамрагдана.

Энэ бүс нутагт археологийн болон дүсэг бичгийн дурсгалын судалгаа бараг хийгдээгүй учир түүх соёлын асар их дурсгал нууц хэвээр хадгалагдан оршоор байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд Алтайн бүс нутгаас цөөн хэдэн мөрөөс бүтсэн руни бичээс олдсоор байгаа бөгөөд цаашид ч зөвхөн руни төдийгүй бусад бичгийн дурсгал ч олноо гэдэгт эргэлзэх зүйлгүй юм.

Баян-Өлгий аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Бага Ойгорын бичээс

Дэлүүн сумын төвийн бичээс

Зүүн оройн овогжөөний бичээс

Зүрх уулын бичээс

Олон нуурын бичээс

Хар Магнайн бичээс

Эрэн Харганатын бичээс

Бага Ойгорын бичээс

“Эртний Алтай” төслийн хүрээнд доктор Д.Цэвээндорж нар Алтай Таван Богд уулын залгаа Бага Ойгор хэмээх уулнаас асар их хэмжээний хадны зураг олж илрүүлжээ. Тэдгээр хадны сүг зургийн дотор нэг мөр руни бичээс, хэд хэдэн тамга байсныг доктор Д.Цэвээндорж хуулж авсан бөгөөд Ц.Баттулга эл бичээсийг уншиж судалсан байна.²³⁶

Э.Якобсон, В.Кубарев, Д.Цэвээндорж нарын Франц улсад хэвлүүлсэн Цагаан салаа, Бага Ойгорын хадны зургийн номд хэвлэгджээ²³⁷.

Уг Б.Напил өмнөх судалгааг казак хэлээр орчуулж өөрийн хувилбар уншлагааг толилуулсан байна²³⁸.

Бага Ойгорын хадны зургаар гурван боть ном гарсан нь Алтай нутаг, нэн ялангуяа Алтай таван богдын уулын эргэн тойрон нэн эртнээс олон соёл оршиж үеийн үед хүмүүс аж төрж нутагласаар ирсэн тул түүх-археологийн дурсгалаар ихэд баялаг, ирээдүйтэй судалгааны объект газар нутаг болохыг нутлан харуулж байгаа юм.

Дэлүүн сумын төвийн бичээс

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвд айлын хашаанд руни бичигтэй хөшөө байгааг археологич Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар олж илрүүлжээ²³⁹. Одоогоор уншиж

²³⁶ Ц.Баттулга, Бага Ойгорын эртний түрэг бичээс, - Алтан аргамжаа (Altan Argamj), Vol. 2, 2/1998, МУИС, Олон улсын дээд сургууль, Улаанбаатар, 1998, 80-83 дугаар тал; Tsendijn Battulga, Moğolistan'da yeni bulunan Gökürk yazitlari, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58; Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (2008), 85-90 дугаар тал.

²³⁷ E.Jacobson, V.Kubarev, D.Tseveendorj, Misson Archéologique Française en Asie Centrale. Tom.V.6. Répertoire des Pétrogllyphes d'Asie Centrale Fascicule 6: Mongolie du Nord-Ouest Tsagaan salaa / Бага Ойгор. Vol. I. texte et Figures, De Boccard, Paris, 2001, pp.124, pl. 350.

²³⁸ Н.Базылханұлы, Монголияда жаңадан табылган түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000. стр.. 70-71.

тайлсан судалгаа байхгүй байна. О.Ф.Серткаяа “Deliun somon (Ortalik?) yazıtı ” гэж тэмдэглэжээ²⁴⁰.

Зүүн оройн өвөлжөөний бичээс

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг, Бага Ойгорын “Зүүн оройн өвөлжөө”-нөөс доктор Д.Цэвээндорж нарын удирдсан “Эртний Алтай” төслийнх нь 1994 онд олж илрүүлжээ.

Д.Цэвээндорж, Ц.Баттулга нар энэхүү бичээсийг уншиж судалсан эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна²⁴¹.

Б.Напил мөн өмнөх судлагааг казак хэлээр орчуулж дахин нягталсан ажээ²⁴².

Зүрх уулын бичээс

Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын төвөөс 40 гаруй км-т Хар магнайн хөндийн урд Хөшөөт хэмээх том уулын салбар Зүрх уулнаас археологич Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар 1989 онд олж илрүүлжээ²⁴³.

Доктор Д.Баяр Монгол Алтайгаас шинээр олж илрүүлсэн бичээсүүдийн талаар өгүүлэлдээ Зүрх уулын бичээсийн талаар анх мэдээлсэн бөлгөө²⁴⁴.

Археологич Д.Эрдэнэбаатар 1990 онд уг бичээсийг дахин нягталж²⁴⁵ улмаар анх хуулсан хийгээд Д.Баяр гуайн нийтлүүлсэн эхэд алдаа мадаг гарсныг залруулан 1994 онд дахин мэдээлсэн байна²⁴⁶.

Ц.Баттулга 1998 онд Зүрх уулын бичээсийг уншиж тайлсан судалгаагаа хэвлүүлсэн ажээ²⁴⁷.

Олон нуурын бичээс

Энэхүү дурсгалыг археологич Д.Эрдэнэбаатар анх олж илрүүлжээ.

Тэрээр уг бичээсийг хээрийн шинжилгээний ажлын тайландаа “Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын төвөөс 40 гаруй км зайд Цамбагарав уулын ар хормойн Хөх хөтөл хэмээх газар 1м өндөртэй 50см орчим өргөн, 20-30см орчим зузаан хөх чулуугаар хийсэн

²³⁹ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиглуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

²⁴⁰ Osman Fikri Sertkaya, Göktürk yazıtları, Orkun, Türkçü dergî, 1.sayı, Mart 1998, s.24-25.

²⁴¹ Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Зүүн Оройн өвөлжөөний бичээс, -Археологийн судлал, Том.ХV, fasc.9, Улаанбаатар, 1999, 91-93 дугаар тал; Tsendiyn Battulga, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58; Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90 дугаар тал.

²⁴² Н.Базылханұлы, Монголияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр. 71-72.

²⁴³ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиглуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

²⁴⁴ Д.Баяр, Баруун Монголд шинээр илэрсэн эртний бичгийн дурсгалууд, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, № 6, Улаанбаатар, 1990.

²⁴⁵ Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймгийн нутгаар явуулсан археологийн хайгуулын ангийн тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1991.

²⁴⁶ Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, - Ил товчоо (сонин), №6 (112), 1994.

²⁴⁷ Ц.Баттулга, Зүрх уулын бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, боть VII, дэвтэр 6, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1998, 88-90 дүгээр тал; Tsendiyn Battulga, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58; Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90 дугаар тал.

хөшөөний зүүн урд талд нь газрын хөрснөөс 12см-ийн өндөрт таван үсэг зурлага бүхий бичээс байна²⁴⁸ хэмээн тодорхойлж гар болон гэрэл зураг хавсаргасан байдаг.

Д.Эрдэнэбаатар Олон нуурын бичээсийг шинжлэх ухааны эргэлтэнд оруулах зорилгоор 1994 онд хэвлэн мэдээлсэн билээ²⁴⁹. Ц.Баттулга 1995 онд уг бичээсийг Д.Эрдэнэбаатарын хуулбарт тулгуурлан уншиж тайлсан ажээ²⁵⁰. Б.Напил өмнөх судалгааг казак хэлээр орчуулж судалсан байна²⁵¹.

О.Ф.Серткаяа “Olon –Nur (Çok Göb) yazıtı” гэж нэрлэсэн байдаг²⁵².

Бид түүний гар хуулбар болон гэрэл зурагт дулдуйдан уншиж судалсан бөгөөд Монгол-Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу, Туркийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг /ТКА (Turkish International Cooperation Administration)/ санхүүжүүлэн хэрэгжүүлж байсан “Орхоны хөндий дэх түрэгтийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах” төслийн “Бичээс судлал”-ын хэсгийн ажлын хүрээнд Туркийн эрдэмтэн Женгиз Алийлмаз, түрэг судлаач С.Харжаубай нарын хамт Олон нуурын бичээсийг сурвалжлан хүрсэн боловч археологич Д.Эрдэнэбаатарын тайланд хавсаргасан гэрэл болон гар зурагт нийцэх бичиг олоогүй, харин бичээстэй гэж нийтлүүлсэн хөшөөний хэлбэр хэмжээтэй ихэд төсөөтэй нэгэн хөшөө чулуунд хожуу цохисон бололтой тоо гэмээр зүйл байсныг үзсэн юм. Цаг хугацаа давчууд өнжин хонон хайгаагүй билээ. Бид энэ талаар өмнө мөн өгүүлсэн²⁵³ бөгөөд магадгүй тэр хөшөөг олж үзээгүй, өөр хөшөөтэй андуурсан байхыг ч үгүйсгэх аргагүй юм. Иймд дээрх бичээсийг дахин хайж нягтлан шалгах зайлшгүй шаардлагатай байна.

Хар Магнайн бичээс

Баян-Өлгий аймгийн Цагаан нуур сумын төвөөс зүүн хойш 4-5 км-т орших Хармагнай хэмээх уулнаас 1994 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Д.Цэвээндорж, Америкийн Орегоны Их сургуулийн проф. Э.Якобсон, Оросын ШУА-ийн Новосибирскийн салбарын Эртний судлал-Угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор В.Д.Кубарев нарын удирдсан “Эртний Алтай” төслийнх нь анх олж илрүүлжээ.

В.Д.Кубарев “Рабочая трибуна” сонинд Алтай нутгаар хийсэн судалгааны ажлынхаа үр дүнг нийтлүүлэх далимдаа анх уул бичээсийн талаар мэдээлсэн байна²⁵⁴. Ц.Баттулга энэ бичээсийг уншиж судалсан ажээ²⁵⁵.

О.Ф.Серткаяа “Kara-Mangday (турк: Kara alın)” хэмээн казахар орчуулан нэрлэсэн байна²⁵⁶.

²⁴⁸ Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймгийн нутгаар явуулсан археологийн хайгуулын ангийн тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөг, 1991.

²⁴⁹ Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, - Ил товчоо (сонин), №6 (112), 1994.

²⁵⁰ Ц.Баттулга, Олон нуурын түрэг бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIII (139), дэвтэр 3, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1995, 101-103 дугаар тал; Tsendiyin Battulga, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58; Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90 дугаар тал.

²⁵¹ Н.Базылханұлы, Монголияда жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр. 72-73.

²⁵² Osman Fikri Sertkaya, Göktürk yazıtları, Orkun, Türkçe dergî, 1.sayı, Mart 1998, s.24-25.

²⁵³ Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90 дугаар тал.

²⁵⁴ В.Д.Кубарев, “Магеллан” открывает Алтай, -Рабочая трибуна, 1 апреля, 1994 г, №6 (3605).

²⁵⁵ Ц.Баттулга, Хар Магнайн эртний түрэг бичээс, -Археологийн судлал, Tom.XIX, fasc.11, Улаанбаатар, 1999, 91-93 дугаар тал; Tsendiyin Battulga, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58.

²⁵⁶ Osman Fikri Sertkaya, Göktürk yazıtları, Orkun, Türkçe dergî, 1.sayı, Mart 1998, s.24-25.

Баян-Өлгий аймгийн Бугат сумаас зүүн урагш, Хатуугийн голын ойролцоо, Эрэн Харганат хөндийн Нохой хуцдаг уулын бэлд байсныг 1990 онд археологич Д.Эрдэнэбаатар олж илрүүлжээ²⁵⁷. Тэрбээр уг дурсгалыг “Хөшөө 286 см өндөр, дөрвөн тал нь тэгш хар чулуугаар засаж хийсэн, дөрвөн талын өргөн тус бүр 50-55 см хэмжээтэй, нар салхинд элэгдэн яг голоороо цуурсан боловч хагарч унаагүй бүтэн байна. Хөшөөний чанх урагшаа наран тал руу харсан ирмэгт газрын хөрснөөс дээш 80 см өндөрт 17 үсэг зурлага бүхий руни бичээс сийлжээ” гэж тодорхойлжээ.

Бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор 1994 онд “Ил товчоо” сонинд нийтлүүлжээ²⁵⁸.

Ц.Баттулга эл бичээсийг археологич Д.Эрдэнэбаатарын гар хуулбар, гэрэл зурагт тулгуурлан 1995 онд анх уншиж судалсан байна²⁵⁹.

Тэрээр бичээсийг нүдээр үзэж судалсны дараа “Эрэн Харганатын бичээсийг дахин нягтлах нь” хэмээх өгүүлэл бичиж Солонгос улсад хэвлүүлжээ²⁶⁰. Б.Напил өмнөх судалгааг казак хэлээр орчуулж өөрийнхөө хувилбар уншлага судалгааг толилуулжээ²⁶¹.

Туркийн эрдэмтэн О.Ф.Серткая “Hatuв su yaziti-Хатув су (гийн) бичээс” хэмээн нэрлэж тэмдэглэжээ²⁶². Уг бичээс бүхүй газрыг одоо ч Хатуугийн гол, Эрэн Харганат хэмээн нэрлэсээр атал мөн казах нэрээр нэрлэсэн нь магадгүй, анх зааж өгсөн хүн тийн хэлж нэрлүүлснээс үүдсэн бололтой.

²⁵⁷ Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймгийн нутгаар явуулсан археологийн хайгуулын ангийн тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1991.

²⁵⁸ Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, - Ил товчоо (сонин), №6 (112), 1994.

²⁵⁹ Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээс, - Археологийн судлал, Том XV, fasc.10, Улаанбаатар, 1995, 65-67 дугаар тал; Tsendiyn Battulga, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları, -Türk Dili Araştırmaları Yıllığı Bellete, 2000, Ankara, 2001, s.47-58; Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), Улаанбаатар, 2003, 85-90 дугаар тал.

²⁶⁰ Ц.Баттулга, Эрэн Харганатын түрэг бичээсийг дахин нягтлах нь, -Mongolian Studies, №10, Seul 2000, pp.147-153.

²⁶¹ Н.Базылханұлы, Монголияда жанадан табылган түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000. стр. 68-70.

²⁶² Osman Fikri Sertkaya, Göktürk yazıtları, Orkun, Türkçü derği, 1.sayı, Mart 1998, s.24-25.

Говь-Алтай аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Бигэрийн бичээс

Шаахар толгойн бичээс

Бигэрийн бичээс

Говь-Алтай аймгийн Бигэр сумын төвөөс арван долоо орчим км-т нутгийнхан Хар Аарагийн бичигт хад, Хар Аарагийн бичигт бууц гэж нэрлэх өвөлжөө бууцны хадны бичээсийг анх 1969 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлыг судлах шинжилгээний анги олж илрүүлсэн байна.

Уг бичээс нэгэн бууц бүхий хадтай ганц хар толгойн баруун, баруун урд, урд гурван талын хаданд сийлжээ.

1971 онд түрэг судлаач М.Шинэхүү энэ бичээсийг тайлж уншсанаас²⁶³ хойш дахин нягталсан судалгаа хараахан гараагүй бололтой.

Тэрээр “Хар ааргийн бичээс” хэмээн анх нэрлэж байснаа хожим уг дурсгал олдсон сумынх нь нэрээр нэрлэж шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ.

Шаахар толгойн бичээс

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Шаахар толгой гэх газраас “Монголын түүх, соёлын дурсгайн сэдэвчилсэн лавлах” төслийн хүрээнд уг бичээсийг анх олж мэдээлсэн байна”. Таван үсэг тэмдэгтээс бүрдэх уул дурсгалыг судлаач Ю.Болдбаатар анх уншиж судлан шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ²⁶⁴.

Ю.Болдбаатарын судалгааг Б.Напил казак хэлээр орчуулж танилцуулсан байна²⁶⁵.

Увс аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Ачит нуурын түрэг бичээс

Долоогойдойн хөшөөний бичээс

Төмөр цоргын түрэг бичээс

Ачит нуурын түрэг бичээс

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Ачит нуураас 17 орчим км хол орших Шанаган хэв хэмээх газраас 1979 онд Н.Сэр-Оджав, Д.Дорж нар анх олж илрүүлсэн бөгөөд 1980 онд Монгол Зөвлөлтийн хамтарсан хээрийн шинжилгээний ангийнхан очиж судалжээ.

Зэрэгцүүлэн босгосон гурван хөшөөнд руни бичээс байсан боловч он цагийн уртад нар, салхи, бороо цасны усанд идэгдэж, бас хөшөө чулуу насжин үйрснээс бичиг нь ихэд сүйдэж зөвхөн 1-р хөшөөний бичээсийг бүрэн барагчлан унших төдий болсон байна.

Ачит нуурын гэж нэрлэгдсэн эл бичгийн дурсгалыг С.Г.Кляшторный²⁶⁶ С.Харжаубай²⁶⁷ нар тус тус уншиж судалжээ.

²⁶³ М.Шинэхүү, Бигэрийн эртний түрэг бичээс, - Шинжлэх ухаан амьдрал, №1, Улаанбаатар, 1971, 37-40 дүгээр тал.

²⁶⁴ Соёлын овийн төвийн ажилтан Г.Гонгоржав, Г.Энхбат, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Ж.Болд, гэрэл зурагчин н.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй анги олж илрүүлжээ.

²⁶⁵ Ю.Болдбаатар, Шаахарын түрэг бичээс, -Altaica I, Улаанбаатар, 2001, 171-173 дугаар тал.

²⁶⁶ Н.Базылханұлы, Монголияда жаңадан табылган түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр. 77-78.

²⁶⁷ С.Г.Кляшторный, Эпиграфические работы в Монголии, Археологические Открытия 1976 года, Москва, 1977, стр.588-589.

Ачит нуурын нэгдүгээр гэрэлт хөшөөг зөөн Баян-Өлгий аймгийн Орон нутгийг судлах музейд тээвэрлэн авчрах явцад оройн хэсэг нь хугарч унасан байна²⁶⁸.

Долоогойдойн хөшөөний бичээс

1956 онд археологич Ц.Доржсүрэн Увс аймгийн Түргэн сумын нутаг Хар ус гэдэг газар орших Долоогойдойн булшнаас олсон байна²⁶⁹.

Улаан хүрэн өнгийн хоёр хөшөө чулуу тус бүрт руни, уйгур бичээс буй. Нутгийнхан Долоогойдойн булш хэмээн нэрлэх томоохон хиргисүүрийн овоолго чулуун дотор эл хоёр хөшөө байсан ажээ.

Б.Ринчен академич бүтээлдээ уг хоёр хөшөөний бичээсийн гэрэл зургийг оруулан хэвлүүлжээ²⁷⁰.

Руни бичигт хөшөөний урьдчилсан судалгааг С.Г.Кляшторный нийтлүүлсэн²⁷¹ бөгөөд одоо хүртэл бүрэн хэмжээгээр тайлан уншсан судалгаа хараахан алга бололтой байна.

Харин уйгур бичээсийг А.М.Щербак тайлан уншсан²⁷² ба Э.Вандуй монгол хэлнээ орчуулсан байдаг²⁷³.

С.Г.Кляшторный руни, уйгур бичээст гэрэлт хөшөөний он цагийн хамаадал, түүхэн үйл явдлын талаар хожмын бүтээлдээ дурджээ²⁷⁴. Нэрт түүхч Л.Н.Гумилев Долоогойдойн бичээсийн талаар товч өгүүлсэн нь буй²⁷⁵.

Төмөр цоргын түрэг бичээс

Увс аймгийн Сагил сумын нутаг “Төмөр цорго” хэмээх газар, нэгэн өвөлжөөний хаднаа руни бичээс байхыг археологич Д.Цэвээндорж олж илрүүлсэн ажээ²⁷⁶.

Доктор Д.Цэвээндорж уул бичээсийн талаар “Түүхийн судлал” сэтгүүлд нийтлүүлж анх мэдээлсэн байна²⁷⁷.

Доктор Л.Болд 1990 онд хэвлүүлсэн номд дээрх мэдээллийг хэвээр нь оруулж судлаачдад толилуулсан байдаг²⁷⁸.

Ц.Баттулга энэхүү бичээсийг уншиж тайлсан судалгаа хэвлүүлжээ.²⁷⁹

²⁶⁷ С.Харжаубай, Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүд, -Хэл зохиол, Tom.XVI, fasc.8, Улаанбаатар, 1987, 79-80 дугаар тал.

²⁶⁸ Ц.Баттулга, Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм, -Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Tom.2 (208), 85-90 дугаар тал.

²⁶⁹ Ц.Доржсүрэн, Долоогойдойн булш ба түүний хөшөө, -Шинжлэх ухаан, техник, Улаанбаатар, 1957, №5-6, 25 дугаар тал.

²⁷⁰ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.41.

²⁷¹ С.Г.Кляшторный, К историографической оценке Уланкомской надписи, -Эпиграфика Востока 14, Москва, 1961, стр. 26-28.

²⁷² А.М.Щербак, Надпись на древнеуйгурском языке из Монголии, - Эпиграфика Востока, Том 14, Москва, 1961, стр. 23-25.

²⁷³ Э.Вандуй, Увсын Хар Усны гэрэлт хөшөө, -Шинжлэх ухаан, техник, №3, Улаанбаатар, 1958, 45-47 дугаар тал.

²⁷⁴ С. Г. Кляшторный, История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.282-288.

²⁷⁵ Гумилев Л.Н., По поводу интерпретации Уланкомской надписи, -Советская археология, № 1, Москва, 1963, стр. 24.

²⁷⁶ Д.Цэвээндорж, 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайлан, -Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1982.

²⁷⁷ Д.Цэвээндорж, Новые надписи Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур Цорго, -Studia Historica, Tom.VIII, fasc. 1-13, Улаанбаатар, 1984, 124-126 дугаар тал.

²⁷⁸ Л.Болд, Төмөр Цоргын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 109 дүгээр тал.

²⁷⁹ Ц.Баттулга, Төмөр Цоргын бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, Боть IX (126), IV дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1997, 22-23 дугаар тал.

Ховд аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Дарвийн түрэг бичээс
Өвөр дөрөлжийн түрэг бичээс
Ханын хадны бичээс

Дарвийн түрэг бичээс

Ховд аймгийн Дарви сумын нутагт “Шар булаг” хэмээх уулын өмнөд бэл этгээд “Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой” гэдэг газар эртний бичээс буй аман мэдээг 1959 онд Х.Пэрлээ гуай мөшгин хүрч руни бичээс болохыг тогтоожээ²⁸⁰. Б.Ринчен академич 1968 онд Ховд аймгийн Байшин үзүүрийн их бичээс, бага бичээс нэртэйгээр дээрх бичээсийн гэрэл зургийг нь нийтлүүлжээ²⁸¹. Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх-соёлыг судлах шинжилгээний ангийнхан 1969-70 онуудад уг бичээсийг үзэж судалжээ.

Тус хээрийн шинжилгээний ангид ажилласан түрэг судлаач М.Шинэхүү энэ бичээсийг уншиж судалсан байна²⁸².

Дарвийн бичээсийг уншиж тайлсан энэ судалгаанаас өөрөөр уншсан уншлага буюу дахин нягтлан шинжилсэн судалгаа одоогоор гараагүй байна.

Өвөр дөрөлжийн түрэг бичээс

Ховд аймгийн төвөөс урагш Сонгинотын ард, Өвөр дөрөлж хэмээх газар худгийн амсарын хашлага чулуун дээр нэгэн мөр руни бичээс байсныг германы эрдэмтэн Э.Хэйниш 1928 онд Хантайшир, Улиастайд явсан тухай (герман, монгол орчуулгатай) тайландаа тэмдэглэжээ²⁸³.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт “*Б.Ринчен, Германы эрдэмтэн Э.Хэйништэй хамт Улиастай, Ховдоор явсан тайлан*” гэсэн хавтас дотор Өвөр дөрөлжийн бичээсийн чулууны хэмжээ, бичээсийг маш тодорхой хуулбарласан хоёр гар зураг бий²⁸⁴.

Б.Ринчен академичийн бүтээлд “Ховд аймгийн төвөөс урагш орших Өвөр дөрөлжийн худгийн ард байгаа чулууны түрэг бичээс” гэсэн нэртэйгээр дээр өгүүлсэн гар хуулбарын зураг буруу харан хэвлэгджээ²⁸⁵.

Эрдэмтэн Б.Базылхан 1969 онд эл бүтээлд хэвлэгдсэн гэрэл зурагт тулгуурлан уншиж тайлсан байна²⁸⁶.

Судлаач С.Харжаубай мөн бичээсийг дахин нягтлан судалсан нь Б.Базылханы уншлага орчуулгаас маш их зөрүүтэй болжээ²⁸⁷.

²⁸⁰ Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Studia Museologica, Улаанбаатар, 1968, 11 дүгээр тал; Академич Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР,- Эрдэм шинжилгээний өгүүллүүд II, Улаанбаатар, 2001, 20-27 дугаар тал.

²⁸¹ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.38-39.

²⁸² М.Шинэхүү, Дарвиын эртний түрэг бичээс, -Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, Tom.V, fasc.3-13, Улаанбаатар, 1971, 135-147 дугаар тал.

²⁸³ Э.Хэйниш 1928 онд Хантайшир, Улиастайд явсан тухай, ХН.20а, 1928, 27 тал, -Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

²⁸⁴ Б.Ринчен, Германы эрдэмтэн Хэйништэй хамт Улиастай, Ховдоор явсан тайлан, ХН.21б, 2 гар зураг, -Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

²⁸⁵ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.43.

²⁸⁶ Б.Базылхан, Өвөр дөрөлжийн түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №1, Улаанбаатар, 1969, 28-29 дүгээр тал.

С.Харжаубай гуай өгүүлэлдээ Археологийн хүрээлэнд хадгалагдаж байгаа бичээсийн гар хуулбарын эхний хоёр үсгийн дараах тусгаарлах хоёр цэг, зургаа дахь үсгийг огт оруулаагүй байдаг. Бидний санахад германы болоод монголын нэрт эрдэмтэн өтгөсийн гар хуулбар илүү үнэн бодитой болов уу.

Доктор Л.Болд дээрх судалгаануудаас С.Харжаубайн уншлага судалгааг илүү зөв хэмээн үзжээ²⁸⁸.

Юутай ч Өвөр дөрөлжийн бичээсийг дахин нягтлан судлах зайлшгүй шаардлагатай юм.

Ханын хадны бичээс

Ховд аймгийн Үенч сумын нутаг, Ямаан усны хавцалд Ханын хад хэмээх гэрийн ханын дайтай том, хавтгай толигор хадтай уул бий.

Ханалж тогтсон өвөрмөц тогтоц бүхий хадтай энэ ууланд хадны зураг, олон тамга, эртний бичээс буйг 1973 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Хадны зураг, бичээс судлал”-ын хэсгийн эрдэмтэд олж илрүүлжээ*.

Ханын хаданд I мянган жилийн тэргүүн хагасаас нийтийн он тооллын VIII-V зуун хүртэлх түүхийн олон үеийг хамарсан зургууд байгааг тэмдэглэжээ²⁸⁹.

Ямаан усны Ханын хадны зургаас сүйх тэрэг, түүний бодит дүрслэл, морьтой түрүү, хотөч нарын дээл хувцас, морины явдал зэргийг харуулсан нэгэн зураг бусдаас нэн алдартай билээ.

Түрэг судлаач, нэрт эрдэмтэн Э.Р.Тенишев Ханын хадны бичээсийг Э.А.Новгородовагийн гар хуулбар, гэрэл зурагт тулгуурлан тайлж уншин шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна²⁹⁰. Нутгийн олон бичээс, хадны зураг бүхүй уг газрыг “Ханын хад” гэх ба анх судалсан эрдэмтэд ч “Ханын хад” гэж нэрлэсэн байдаг. Харин хожим судалгааны ном зохиолд Ханан хад, Ханан хадны бичээс гэж андуу бичигдэх болжээ.

²⁸⁷ С.Харжаубай, Монгол нутгаас шинээр олдсон түрэг бичээсүүд, -Хэл зохиол судлал, 16-р боть, 1-19-р дэвтэр, Улаанбаатар, 1987, 82-83 дугаар тал.

²⁸⁸ Л.Болд, Өвөр дөрөлжийн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 81-82 дугаар тал.

* Уг хээрийн шинжилгээний ангийг М.Шинэхүү, Э.А.Новгородова нар удирдан ажиллажээ.

²⁸⁹ Д.Дорж, Э.А.Новгородова, петроглифы Монголии, Улан-Батор, 1795, стр.14-15.

²⁹⁰ Э.Р.Тенишев, Э.А.Новгородова, Новые рунические надписи в горах Монгольского Алтая, -История и культура центральный Азии, Москва, 1983, стр.208.

1.4.2. ХАНГАЙ, ХЭНТИЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Архангай аймаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Бугатын гэрэлт хөшөөний бичээс
Билгэ хасанд босгосон гэрэлт хөшөөний бичээс
Их Хануй нуурын бичээс
Колтигинд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс
Тайхар чулууны бичээс
Тариат /Тэрх/-ын бичээс
Хар балгасын бичээс
Харбалгасын хоёрдугаар хөшөө

Бугатын гэрэлт хөшөөний бичээс

Архангай аймгийн Их Тамир сумын нутаг, сумын төвөөс 25 км-т Хойт Тамирын голын зүүн цутгал, Баянцагаан голын баруун хөвөөнөөс археологич Ц.Доржсүрэн 1956 онд анх олж илрүүлсэн²⁹¹, оройн хэсэг нь хүүхэд хөхүүлж буй чонын сийлбэр бүхүй, гурван талдаа согд, нэг талдаа брахми бичээстэй, чулуун яст мэлхийнд суурилуулсан уг дурсгал “Бугатын гэрэлт хөшөө” нэрээр алдаршсан байна. Бугатын гэрэлт хөшөөний согд бичээсийг С.Г.Кляшторный, В.А.Лившиц нар тайлан уншсан бөгөөд тэдний судалгаа англи, турк зэрэг олон хэлээр орчуулагдан гарчээ²⁹². Мөн түүнчлэн эл дурсгалын талаар М.Мори (Masao Mori)²⁹³, Л.Базен (Louis Bazin)²⁹⁴, О.Прицак (Omeljan Pritsak)²⁹⁵, Жан Поль Ру (Jean Paul Roux)²⁹⁶, С.Чагатай (Saadet Çağatay), С.Тезжан (Semih Tezcan)²⁹⁷ нарын эрдэмтдийн судалгаа, танилцуулга гарчээ.

Монгол-Японы хамтарсан “Бичээс” төсөлийн хүрээнд ажилласан эрдэмтэн Такао Мориясу (Takao Moriyasu), Тошио Хаяаши (Toshio Hayashi)²⁹⁸ нар Бугатын гэрэлт хөшөөт тахилын цогцолбор, сүмийн археологийн судалгааны тоймыг, Ютака Ёшида (Yutaka

²⁹¹ Ц.Доржсүрэн, 1956-1957 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай, Улаанбаатар, 1958.

²⁹² В.А.Лившиц, “Согдийская надпись из Бугута, - Олон улсын монголч эрдэмтний II их хурал, I боть, Улаанбаатар, 1973; С.Г.Кляшторный, В.А.Лившиц, “Согдийская надпись из Бугута, -Страны и народы Востока, Вып.10, Москва, 1971, стр.121-146; С.Г.Кляшторный, В.А.Лившиц, Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии, -Археология и этнография Монголии, Новосибирск, 1978, стр.37-60; S.G.Kljaštornij & V.Livšic, The Sogdian Inscription of Bugut Revised, -Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1972, pp.69-102, +8 pls; S.G.Kljaštornij, V.Livšic, Bugut 'aki sogdca kitabe'ye yeni bir bakış, -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 1987, Ankara, 1992, s.201-241, +14 pls; S.G.Kljaštornij & V.Livšic, Une inscription inédite turque et sogdienne, -La stèle de Sevrey (Gobi méridional), Journal Asiatique 259-1/2, pp.11-20, + 3pls

²⁹³ M.Mori, A New Materials on the Sogdians in the Tu-chüeh Empire, -Shigaku-Zasshi, LXXXI/ 2, February 1972, pp.77-86.

²⁹⁴ L.Bazin, Turcs et Sogdiens: Les Enseignements de L'Inscription de Bugut (Mongolie), -Mélanges Linguistiques Offerts à Émile Benveniste, Collection Linguistique, publiée par la Société de Linguistique de Paris, LXX, Paris, 1975, pp.37-45.

²⁹⁵ O.Pritsak, The Old Turkic Title “γwγ'p'nt””, -Studia Turcologica, Memoriae Alexii Bombaci Dicata, Napoli, 1982, pp.403-406.

²⁹⁶ J.Paul Roux, Les inscriptions de Bugut et de Tariyat sur la religion des Turcs, -Studia Turcologica, Memoriae Alexii Bombaci Dicata, Napoli, 1982, pp.451-461.

²⁹⁷ S.Çağatay, S.Tezcan, Tanıtımlar:Köktürk tarihinin çok önemli bir belgesi. Soguçta Bugut yazıtı, -Türk Dili Araştırmaları Yıllığı-Belleten 1975-1976, Ankara, 1976, s.245-252.

²⁹⁸ 森安孝夫 林俊雄:ブグト遺蹟 -モンゴル国現存遺蹟- 碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takao Moriyasu, Toshio Hayashi, Site of Bugut, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 121.

Yoshida), Такао Мориясу нар согд бичээсийг дахин нягталж япон, англи хэлээр орчуулжээ²⁹⁹.

Уг гэрэлт хөшөөний брахми бичээсийг уншиж судалсан зүйл одоогоор байхгүй нь бичээс элэрт долрон уншихуйаа нэн бэрх болсонтой ч холбоотой буй за.

Бугатын гэрэлт хөшөөний В II-ийн 6 дугаар мөрнөө “βγυ mγ'n ty) [.....s](γ)wn ptywšt w δ'r ty γγwšk sδy (.) [...] (.w'št” (С.Г.Кляшторный, В.А.Лившиц нар), “β(γ)υ m(γ') [t' (p) 'r x' γ'n] m(s) ++ [nβ] (y-r)' k ptywšt w δ'r ty xγ-(γw)šk sδy (x) w t' w '(kr) [ty]” (Ютака Ёшида, Такао Мориясу нар) гэж буй нь уг бичээсийн он цагийг тогтоох сэжим болж байна. Бичээст дурдагдаж буй туулай жил 559, 571, 583, 595, 607, 619 онуудад тохиолдох боломжтой бөгөөд энэ мэдээнд тулгуурлан уг гэрэлт хөшөөг 572 анх үйлдэж эхлээд юутай ч 580 оноос өмнө дурсгалыг бүтээж бүрэн дуусгасан гэж үздэг³⁰⁰.

Руни бичгээр бичигдээгүй ч түргийн хаант улсад холбогдох дурсгал тул, нөгөө талаар түрэг судлалын ном бүтээлд руни бичгийн нэгэн адил авч үзэсэр ирсэн уламжлалыг дагаж энд товч өгүүлэв.

Көлтигинд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс
Билгэ хаанд босгосон гэрэлт хөшөөний бичээс

Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам хэмээх газар байх Түрэгийн хоёрдугаар хаант улсын хаан Билгэ*, түүний дүү Көлтигин* нарт зориулан босгосон тэрхүү

²⁹⁹ 吉田 豊・森安孝夫・ブグト碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Yutaka Yoshida, Takao Moriyasu, Bugut inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 122-125.

³⁰⁰ S.G.Kljaštorniy & V.Livšic, The Sogdian Inscription of Bugut Revised, -Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1972, pp. 73; S.G.Kljaštorniy, V.Livšic, Bugut'taki sogdca kitabe'ye yeni bir bakış, -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 1987, Ankara, 1992, s.205-206.

* Түрэгийн түүхэнд Билгэ хаан (毗伽可汗 pi jia ke han, 苾伽可汗 pi jia ke han) хэмээн алдаршсан Илтириш хааны том хүү Могилян 684 онд Инь Шань (阴山 yin shan) буюу Инь нэрт уулын тэнд төржээ. Билгэ хэмээх цол, өргөмж нэрийг нангиад сурвалжид “ Mo-ki-lien, mo-chic-lien, Mo-gi-lan, me(k)-ki-len” гэж тэмдэглэсэн нь монгол хэлний “мэргэн” гэх үгийн үгчлэсэн дуудлагатай дүйдэг. Билгэ улс торийн үйл хэрэгт анх 14 настайгаасаа оролцож 697 онд Тардушийг захирах шадаар томилогдох байжээ. Тэрбээр авга ах Түрэгийн хаан Капганы хүү Инелийн хамт цэргийн баруун жигүүрийг удирдаж 716 онд буюу Капган хааныг нас эцэслэх үе хүртэлх хугацаанд зүүнш Шар мөрөн болон Шантуны тал, баруунш Төмөр хаалга, Көгмэний уулын умард нийт 25 удаа дайлаар мөрдсөн байна. Жишээ нь, 703 онд Билгэ хаан Басмилын Иди-Кут цолтой удирдагчийг алба татвар өгсөнгүй хэмээн довтолсон, 705 онд гол дайсан хятадын Sha-to Chung (𐰽𐰺𐰍𐰏𐰤𐰆) Šača sāñqin Чача Сэнгүн)-тэй байлдаж ялсан, 710 онд Киргиз рүү довтолж ялсан, 713 онд Бешбалыкт Басмылтай, 714 онд бослого өдөөсөн Карлук нартай, 715 оны хавар Огуз нартай тус байлдаж тэдний гаргасан бослого хөдөлгөөнийг дарсан зэрэг түүхэн мэдээ гэрэлт хөшөөний бичээст тодорхой тэмдэглэгджээ. Капган хаан нас эцэслэсний хойно түүний том хүү Инел хаан суусан ч төдөлгүй хорлогдож түүний ор залгамжилсан дүү нь ч мөн алагдаж, тэдний хаан суудлыг Капганы ах Кутлуг Илтириш хааны том хүү Билгэ эзлэн 716-734 оны хооронд хаан суужээ. Билгэ хаан Буюруг Чор нэрт нэгэнд хорлогджээ. Буюруг Чор хэд хэдэн удаа Тан хаант зочилж байсан гэдэг мэдээ баримт байдгаас үүдэн хятадуудын нөлөө орсон байж болох талтай гэж үздэг. Билгэ хаан хорлогдсон даруйдаа нас эцэслээгүй бөгөөд Буюруг Чурд хорлогдсоноо ухаарч түүнийг гэр бүлээр нь хөнөөсөн гэдэг. Тэрээр 734 оны 11 сарын 25-ны өдөр тэнгэрт хальсан ба онго тахилгыг 735 оны 6 сарын 22-нд үйлдэжээ. Монгол, Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу 1997 оноос эхлэн Туркийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (TICA-Turkish International Cooperation Administration) санхүүжүүлээр хэрэгжүүлсэн “Орхоны хондиг дэх түрэгийн үеийн зарим хөшөө, дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах” төслийн хүрээнд Билгэ хааны онгоны газар 2001 оны зун хийсэн малллага судалгаагаар нийтдээ 17 төрлийн 1878 ширхэг мөнгөн эдлэл, 20 төрлийн 78 ширхэг алтан эдлэл, 6 төрлийн 26 ширхэг эрдэнийн чулуу зэрэг зүйлс олджээ. Хэлбэр дүрээ алдаагүй бүтэн эдээс гадна эвдэрч гэмтсэнээ юунд зориулсан, ямар эдлэл болох нь мэдэгдэхгүй болсон зүйл, хайлж урссан мөнгөн бөмбөлгүүд, төмөр эдлэлийн хэлтэрхийг ч байна. Нимгэн, алтаар цэцэг ургамлын дүрст хээ хөөлгөн гаргаж эрдэнийн чулуу шигтгэж дэлбээтэйгээр урлан хийсэн титэм олдсон нь нилээд ховор чухаг олдворт тооцогдоно. Уг алтан титэмийн голд далавчаа дэлгэн сууж буй махир хоншоортой бүргэд мэт шувууны дүрсийг товойлгон дүрээлж шувууны аманд алтан утас зуулган уг утсанд эрдэнийн чулуу нүхлэн хийж тогтоосон байжээ. Мөнгөөр хийсэн бугын дүрс хоёр олдсны нэг нь бүтэн, нөгөө нь толгой хузүүн хэсгээрээ бүтэн үлдэж бусал

гайхамшигт хөшөөг үе үеийн эрдэмтэд судлан шинжилж олон ном бүтээл туурвисаар иржээ*.

Тариат /Тэрх/-ын бичээс

Архангай аймгийн Тариат сумын төвөөс баруун тийш, Тэрхийн голын хойт биед, Долоон модны ам хэмээх газрын тушаа байсныг 1956 онд археологич Ц.Доржсүрэн анх олж илрүүлжээ³⁰².

Чулуун мэлхий суурьтай, 2 м гаруй урт (гурван хугархай нийлээд) энэ гэрэлт хөшөөг Тариатын гэрэлт хөшөө, Тэрхийн гэрэлт хөшөө гэж хоёр янзаар нэрлэсээр иржээ.

Уг гэрэлт хөшөөний бичээсийг М.Шинэхүү³⁰³, Б.Базылхан³⁰⁴, С.Г.Кляшторный³⁰⁵, Т.Текин³⁰⁶, С.Харжаубай³⁰⁷, А.Катаяма³⁰⁸ нарын эрдэмтэд уншиж судалсан байна.

Их Хануй нуурын бичээс

Их Хануй нуурын дурсгал Эрдэнэмандал сумын төвөөс баруун урагш 9 орчим км-т, Хануй нуураас холгүй тэгш талд байдаг билээ.

нь хайлжээ. Мөн алт, мөнгөөр хийсэн тахил тайлгын жижиг сав суулга, таваг, домбо, цэцэгн хээтэй алт, мөнгөн товруу, бүсний алтан чимэглэл, ээмэг, сүлбээр цагираг зэрэг үнэт олдвор олдсон ажээ. Хамгийн олон тоотой нь найман дэлбээт цэцэг хэлбэрт мөнгөн товруу 1822 ширхэг, тэдгээрийн зарим нь хадаасны нүхтэй, нүхэнд таарах хүрэл халдас 304 ширхэг олдсон аж. Алт, мөнгөн сав суулга, бүсний чимэглэл, титэм зэрэг нь хүн эдлэл хэрэглэдэг ердийн зүйлсээ хэт жижиг байгааг тайлга, тахилын ёслолд зориулан үйлдсэн байх гэж эрдэмтэд үзжээ. Билэг хааны онгоны үнэт олдворууд Монголын Үндэсний Түүхийн Музейд хадгалагдаж байна.

* Эцэг Ил Тириш хааныг 692 онд нас барахад долоон настай байсан хэмээх мэдээнд тулгуурлан Көлтгийн (開特勤 jue te qin)-ийг 685 онд Инь Шань (阴山 yin shan)-ын орчим төржээ гэж үздэг. Тэрээр 731 оны хонин жилийн хоёрдугаар сарын 27-нд 47 настайдаа тэнгэрт хальсан бөгөөд мөн оны арваногдугаар сарын 1-нд оршуулж, онгон (гэрэлт хөшөө, хүн чулуу, хонь, арслан тэргүүт амьтад, тахилын чулуун эдлэл гэх мэт), тахилын сүмийг нь 732 оны бичин жилийн наймдугаар сарын 21-нд дуусгажээ. Сонирхолтой нь, гэрэлт хөшөөний нангиад бичээснээ “бичин жилийн наймдугаар сарын нэгэн”, харин руни бичээснээ “ бичин жилийн наймдугаар сарын хорин нэгэн” хэмээн зөрүүтэй тэмдэглэгджээ. Түрэгтийн хоёрдугаар хаант улсын түүхэнд асар их гүйцэтгэсэн, цэрэг, улс төрийн нэрт зүтгэлтэн Көлтгийн 716-731 оны хооронд Төлийн шад байжээ. Түүний гавъяа зүтгэлийг гэрэлт хөшөөнийх нь бичээснээ тодорхой өгүүлдсэн буй.

* Билэг хаан, Көлтгийн гэрэлт хөшөөтэй холбогдох судалгааны тойм, бичээсийн үсэг, үгийн галиг, эрдэм шинжилгээний монгол орчуулга, үгийн хэлхээ (index), толь бичиг дагалдуулан ном болгон гаргахаар зэхсэн тул судалгааны тойм давхардах учир энд эе өгүүлэв.

³⁰² Ц.Доржсүрэн, 1956-1957 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай, Улаанбаатар, 1958.

³⁰³ М.Шинэхүү, Памятник рунической письменности из Тариата, -Роль кочевых народов в цивилизации Центральной Азии, Улаанбаатар, 1974, 327-331 дүгээр тал; М.Шинэхүү, Тариатын орхон бичгийн шинэ дурсгал, - Studia Archaeologica, Tom.VI, fasc.1, 1975, 219 хуудас; М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Tom.VIII, fasc.1, Улаанбаатар, 1980, 83 хуудас.

³⁰⁴ Б.Базылхан, Тэрхийн түрэг бичээс, -Studia Mongolica, Tom.VIII (16), fasc.12, Улаанбаатар, 1980, 163-175 дугаар тал.

³⁰⁵ С.Г.Кляшторный, Терхинская надпись (предварительная публикация), -Советская Тюркология, №3, стр. 82-95; S.G.Klyashtorny, The Terkhin Inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Tom. XXXVI, fasc.1-3, 1983, pp.335-366, -18 pls.

³⁰⁶ Talat Tekin, Kuzeý Moǧolistan'da yeni bir uyur anıtı: Taryat (Terkhin) kitabesi, - Türk Tarihi Kurumu, Belleten, Tom.XLVI, № 184, s.895-838; Talat Tekin, The Tariat (Terkhin) inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Tom. XXXVII (1-3), 1983, pp.43-68.

³⁰⁷ С.Харжаубай, Второй Памятник Ель-Етмиш Бильге кагана (Терхинская (Тариатинская) стела), - Объединенный каганат Тюрков в 745-760 годах (по материалам рунических надписей), Астана, 2002, стр.32-32-52.

³⁰⁸ 片山章雄・タリят碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Akio Katayama, Tariat Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 168-176.

Археологийн судалгаа

Д.А.Клеменц 1891 онд анх олж илрүүлсэн ба С.М.Дудин уг дурсгалын талаар археологийн товч тодорхойлолт бичжээ³⁰⁹.

Финийн шинжилгээний ангийн Сакари Пэлсийн (Sakari Pälsi) 1909 оны тайлангийн гэрэл зургууд тахилын байгууламжийн анхны байрлал, хэлбэрийг тогтоох чухаг баримт болсоор байна³¹⁰.

1927 онд Б.Бамбаев уг бичээсийн гар хуулбар үйлдэж археологийн тодорхойлолт хийсэн байна³¹¹.

Ин Хануй нуурын эл бичигт тахилын байгууламжийг В.Войтов³¹², хүн чулуудыг нь доктор Д.Баяр³¹³ нар тус тус судалсан ажээ.

Бичээсийн судалгаа

Их Хануй нуурын бичээсийг В.Радлов анх тайлан уншиж бичээсийн үсэг, үгийн галиг, герман орчуулгын хамт "Die Inschrift vom Ichi-Chanyun-Nor" нэртэйгээр³¹⁴, Х.Н.Орхун "Ihi-Nanin-Nor-yazit" гэж нэрлэн газрын байрлалыг маш товч дурдаж орчин цагийн турк хэлнээ орчуулж³¹⁵ тус тус хэвлүүлжээ.

С.Г.Кляшторный бичээсийг дахин нягтласан³¹⁶ ба түүний уншлага орчуулгыг Л.Болд монгол хэлнээ буулган бүтээлдээ оруулжээ³¹⁷.

Монгол-Японы хамтарсан "Бичээс" төслийн хүрээнд хоёр талын эрдэмтэд судалснаас Такаши Оосава (Takashi Ōsawa) бичээсийн үсэг, үгийн галигийг япон, англи орчуулгын хамт³¹⁸, Л.Болд монгол хэлнээ орчуулан³¹⁹ нийтлүүлсэн билээ.

Тайхар чулууны бичээс

Архангай аймгийн Их Тамир сумын нутагт орших хэзээнээс алдартай Тайхар чулуунаа руни бичээс буйг Д.А.Клеменц анх олж мэдээлсэн бөгөөд В.В.Радлов уншиж судалсан байна³²⁰.

³⁰⁹ W. Radloff, Die Altürkischen Inschriften Der Mongolei, St.Peterburg, 1894 (1987), pp.259; В.В. Радлов, Предварительный отчет о результатах снаряженной с Высочайшего соизволения Императорской Академии Наук экспедиции для археологического исследования р.Орхона, -1892. Вып.1стр.1-12; Д.А. Клеменц, Объяснительная записка к рисункам и эстампажам, -Атлас древностей Монголии-Санктпетербург, 1893. Вып.2 хуудасны дугааргүй

³¹⁰ Memoria Saecularis Sakari Pälsi, - Aufzeichnungen von einer Forschungsreise nach der nördlichen Mongolei im Jahre 1909, -Soomalai-Ugrilainen Seura- Société Finno-Ougrienne, Kansatieteellisiä julkaisuja X; Travaux ethnographiques X, Helsinki, Harry Hälén (ed.), 1982, pp.182.

³¹¹ Б.Бамбаев, Предварительный краткий отчет Бамбаев Бальджи о работе в этнологическом отряде научной экспедиции АН СССР по исследованию Внешней Монголии и Танну-Товы составленный в 1927 г.- Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг,Ф-IX, Т.10, ХН.20-21.

³¹² В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв.- Государственный Музей Востока, Москва, 1996, стр.114-115.

³¹³ Д.Баяр, Монголын төв нутаг дахь Түрэгийн үеийн хүн чулуу, Улаанбаатар, 1997,

³¹⁴ W.Radloff, Die Altürkischen inschriften der Mongolei, St.Petersburg, 1894 (1987), pp.259.

³¹⁵ H.N.Orkun, Eski Türk yazitları I I,Istanbul 1938 (Eski Türk yazitları,1987), s.103 (295).

³¹⁶ С.Г.Кляшторный, Храм изваяние и стела в древнетюркских текстах (К интерпретации Ихе-Хануйн-норские надписи), - Тюркологический сборник 1974, Москва, 1978, стр.238-256.

³¹⁷ Л.Болд, Их Хануй нуурын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 38-39 дүгээр тал.

³¹⁸ 大澤 孝・イフ=ハヌイ=ノール遺跡・銘文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月(Takashi Ōsawa, Site and Inscription of Ikh-Khanui-Nor, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp.137-140.

³¹⁹ Л.Болд, Их Хануй нуурын бичээс, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 232 дугаар тал.

³²⁰ W. Radloff, Die altürkischen inschriften der Mongolei, St.Peterburg, 1894 (1987), pp.260-268.

х.Н.Орхун³²¹, С.Е.Малов³²² нар турк, англи хэлнээ орчуулж, өөрсдийн судалгааг нэмэрлэсэн ажээ. Мөн Д.Д.Васильевийн судалгаа буй³²³.

Б.Ринчен академич уг бэхэн бичээсийг гэрэл зургийн аргаар хэвлүүлжээ³²⁴. Хөдөөгийн Пэрлээ гуай гар хуулбар хийж “Тайхир чулуу” хэмээх бяцхан товхимолдоо оруулсан нь өмнөх эхүүдээс нилээд зөрүүтэй³²⁵ болжээ.

Л.Болд бүтээлдээ С.Е.Маловын номд орсон эхийг баримтлан монгол хэлнээ орчуулсан аж³²⁶.

С.Харжаубай, О.Ф.Серткая нар Тайхар чулууны хорин бичээсийг уншиж хэвлүүлсэн нь урьд аравхан бичээс байдаг мэтээр ойлгодог байсан андуу ташааг зассан шинэлэг ажил болжээ³²⁷.

Бидний судалгаагаар гуч гаруй бичээс буй нь тодорхой болсон тул цаашид дахин нягталж тодорхой өгүүлэх болно³²⁸.

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал номд Тайхар чулууны руни, монгол зэрэг олон бичээсийн талаар товч дурджээ³²⁹.

Хар балгасын бичээс

Архангай аймгийн Хотонт сумын нутагт, Хархорин хотоос баруун хойш 45 км-т орших Хар балгас хэмээн нэрийдэх эртний Уйгур улсын нийслэл хотын туйр бий.

Тан улсын Тянь Баогийн 751 онд байгуулагдсан гэж сурвалж бичигт тэмдэглэгдсэн уг хотын туйранд руни, согд, нангиад гурван зүйл үсгээр бичсэн гайхамшигт хөшөө байсныг Н.М.Ядринцев 1889 оны 7-р сард олсноор “Орхоны бичиг”-ийг анх нээсэн түүхтэй³³⁰. Ала-ад Дин Ата-Малык Жүвэни (“Ala-ad-Din ‘Ata-Malik Juvaini”) Уйгурын

³²¹ H.N.Orkun, Eski Türk yazitlari II, İstanbul, 1938 (Eski Türk yazitlari ,1987), s.109-117 (299-309).

³²² С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр. 46-54.

³²³ Д.Д.Васильев, Графические особенности памятников Хойто-Тамира, - Вопросы восточного литературоведения и текстологии, Москва, 1975.

³²⁴ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc. I, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36.

³²⁵ Х.Пэрлээ, Тайхир чулуу, - Studia Archaeologica, Tom.I, fasc.IV, Улаанбаатар, 1960, 26 тал.

³²⁶ Л.Болд, Тайхар чулууны монгол бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 90-92 дугаар тал.

³²⁷ Sertkaya O.F, Harcavbay S, Hoyto Tamir (Moğolistan)dan yeni yazitlar (öñ neşir), -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 2000, Ankara, 2001, s.313-346.

³²⁸ Бичээс судлалын тайлан, -МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим, гар бичмэлийн сан хөмрөг, 2004.

³²⁹ Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 222 дугаар тал.

³³⁰ Н.Ядринцев, Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, -Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892, стр.27-40; Н.Ядринцев, Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд. Географического Общества, - Сборник трудов Орхонской экспедиции I, Санкт-Петербург, 1892; Н.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году, - Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр.1-54.

* Ала-ад Дин Ата-Малык Жүвэни хижра [товч: х.]-гийн 623 он буюу нийтийн тоолол [товч: н.т.]-ын 1226 онд төржээ. Аргун хааны итгэлт хүний нэг байсан бөгөөд тэрээр Аргун (х. 641 (н.т.1243) он)-аас Хулагу (Külağu) Иранд ирэх (х. 654 (н.т.1256) он) хүртэл Хоросан, Мазендеран, Энэтхэгийн зарим хэсэг, Иран, Перс, Лор, Азерб. Гүрж, Мусул, Халер зэрэг улс, аймаг мужуудад Монгол ноёдын төлөөнөө төрийн хэргийг шийтгэн явуулахад тусалж байжээ. Анх удаа Аргун хааны үед х. 644 (н.т.1246) – х. 645 (н.т. 1247) онд Монголд иржээ. Хоёрдахь удаа эцэг Баха ад-Дин Мухаммедын хамт замд гарсан боловч Таразад ирэх үед Гүюг хаан нас барсан тухай мэдээ авч тэндээ хүлээж байгаад төдөлгүй аян замын хугасаас бушжээ. Хижрагийн 647 (нийтийн тооллын 1249) онд Аргун хааны хамт Хархорин хотод дахин иржээ. Бослого, самуун дэгдсэн мэдээ ирснээр Аргун хаан Иран руу буцсан байна. Гуравдахь удаагаа Мөнхийг хаан сууринд суулгах ёслолд оролцохор Аргун хааны хамт х. 649 оны жемазийелахир (jemā-ziyū'l-ābir) (н.т. 1251 оны 9-р сар)-т иржээ. Сурвалжид Хархорин хотод х. 650 оны сафер (safer)-ийн 20 (н. т. 1252 оны 5-р сарын 2)-нд ирээд х.651 оны режеб (rejeb) (н.т.1253 оны есдүгээр сар)-т буцсан хэмээн тэмдэглэгджээ. 1251 оны наймдугаар сард Аргун

Орду-Балык тухайн үеийн Маву- Балык (Maḡu baliḡ [-balḡasun]) одоогийн Хар балгасыг үзсэн [хижрагийн 649, 650, 651 (нийтийн тооллын 1251, 1252, 1253) оны үед бололтой. Ц.Б.] тухайгаа “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх (*Ta'rikh-i-Jahan-Gush*)” хэмээх алдарт бүтээлд тэмдэглэн үлдээсэн ажээ. Энэ мэдээ шинжлэх ухааны эргэлтэд орж тэмдэглэгдээгүй нь уг сурвалж Европын хэлнээ хожуу орчуулагдсан хийгээд гэрэлт хөшөөний бичээсийг Хятан (*Qitay*) бичиг хэмээснээс үүдэн Уйгурын үед холбогдох ерийн нэгэн нангиад бичээст хөшөө гэж ойлгон (ач холбогдолтойд тооцоогүй) тоомжиргүй хандсан ч байж болох юм.

Ата-Малык Жүвэни “... өөр нэгэн голын хөвөөнд эртнээс Орду-Балык, одоо Маву-Балык хэмээгдэх нэгэн хот байна. Энэ хотын ойролцоох чулуу (үгчилбэл: хад)-нуудад бичиг бичжээ. Би түүнийг үзэв. Өгэдэй хааны үед тэр чулуунуудын доорх (газар)-ыг малтжээ. Тэндээс цагаан саарал чулуун дээр бичсэн хөшөөгөөр таглагдсан нэгэн суваг гарчээ. Хөшөө чулуун дээрх бичээсийг үзсэн хаан, бичээсүүдийн утгыг асуухад хажуудахас (хажуу дахь хүмүүс) уншиж чадсангүй. Өөр хүмүүс ирэв. Тэд нар ч бас уншиж чадсангүй. Тиймээс Хятан (*Qitay*)-аас эрдэмтэн (*‘ālim*) дуудацаав. Энэ бичээс тэдний бичээс байсан юм. Хөшөө (хад)-нд ийн бичжээ: Тэр үед Хархорум голуудын хооронд Тула (*Tuglha*) ба Сэлэнгэ (*Selenge*) нэртэй хоёр гол байв. Эдгээр голууд Хамланчу (*Qamlanchu*) хэмээх нэгэн газар нийлдэг. Тэр хоёр голын хооронд бие биенээс холгүй орших хоёр мод байсан гэнэ. Түүний нэгийг нь хуш (*Qusuq*) (*Siberian cedar*) мод хэмээгэнэ. Энэ мод нарс (*Pinus*) модтой адил, жимс (борогшой) нь ч түүнийх шиг. Арц (нэгэн зүйл арц**Cupressus sempervirens*) мэт өвөл навчаа гөвөхгүй. Нөгөө модны нэр нь “тур” хэмээнэ [Жич: англи орчуулгад: *toz* (i.e. the Birch, reading TWZ wich E for the TWR of the text), турк орчуулгад: *tur* гэж бичээд ямар нэгэн орчуулга, тайлбар хийгээгүй байна.]. Тэр моднуудын ойролцоо хоёр том уул байжээ. Нэгэн өдөр тэнгэрээс тэр хоёр уулын хооронд гэрэл буужээ. Түүний улмаас (шалтгаанаар) уулс өдрөөс өдөрт томорч эхэлжээ. Энэ ер бусыг үзсэн уйгурууд маш их гайхацгаажээ...”³³¹ хэмээгээд чинагш уйгуруудын модноос үүссэн тухай домгийг өгүүлжээ.

Уйгурын их нийслэл хотын тухай нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт бүтээлдээ өгүүлжээ³³².

Уг гэрэлт хөшөөний руни бичээсүүдийг В.Радлов уншиж тайлсан бөгөөд тэрээр хөшөөний оройн хэсгийн том бичээсийг анх сэргээснээс гадна түүнээс тусдаа дөрвөн хэсэг бичээсийн үеэс, үгийн галиг хийж орчуулсанаас гадна үгийн тайлбар толь хийсэн бөлгөө³³³.

В.Радлов Хар балгасын гэрэлт хөшөөний нангиад бичээсийг В.П.Васильевын уншсанаар бүтээлдээ оруулсан³³⁴ ба уйгур (согд) бичээсийн талаар хараахан судалж амжаагүйг ч тодорхой дурдсан ажээ.

хаан Хархоринд байсан нь тодорхой, тэгээд ч Мөнх х. 649 оны ребиюлахир (*rebi' u-l-ābir*)-ийн сс (н.т.1251 оны 5-р сарын 28)-нд хаан ширээнд суусан гэдэг тул дээрх мэдээ зохиогчийн санамсаргүй алдаа юу, эвээс бичээчийн мадаг уу гэдэг нь тодорхойгүй. Тэрбээр 10 жил монгол, уйгурын нутаг, туркистан, Хөх мөрөн хийгээд хятадын нутгаар аялжээ. Ала-ад Дин Ата-Малык Жүвэни х. 650 (н.т.1252) оны үед “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” номоо эхээд х. 658 (н.т.1252) онд дуусгажээ. Тэрээр х.673 оны зилхижээ (*zi' l-hijje*)-гийн 25 (н.т.1275 оны 6-р сарын 21) -нд Туеугийн ойролцоох Радакан хэмээх газар насан өөд болсон гэдэг.

³³¹ ‘Ala-ad-Din ‘Ata-Malik Juvaini, *The History of the World-Conqueror*, Translated from the text of Mirza Muḡammad Qavini by John Andrew Boyle, Manchester University Press, 1958, pp.55-61; Alaadin Ata Melik Cüveyni, *Tarih-i Cihangüşa I, Çeviren Mürsel Öztürk, Kültür ve Turizm Bakanlığı Yayınları: 880, Ankara, 1988, s.111-121*(*Tarih-i Cihangüşa II, Kültür ve Turizm Bakanlığı Yayınları: 881, Tarih-i Cihangüşa III, Kültür ve Turizm Bakanlığı Yayınları: 946, Ankara. 1988*).

³³² G.I. Ramstedt, *Uyḡur ulus-un huriyangyui teüke*, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг (монгол бичгээр) Ф.IV. ХН.16.Т.56. 1924; G.I. Ramstedt, *Uyḡur ulus-un teüke-yin tobci*, -Улсын төв номын сан (монгол бичгээр) Ф.IV. ХН.16.Т.56. 1924.

³³³ W.W.Radloff, *Das Uigurische Denkmal von Kara-Balgassun,- Die alttürkischen Inschrift der Mongolei, St.Petersburg, 3.Lieferung 1895; Neue Folge 1897; Zweite Folge 1899* (in 2 vols: Osnabrück 1987), pp.283-298; W.W.Radloff, *Атлас древностей Монголии, Труды Орхонской экспедиции, (Atlas der Alterthümer der Mongolei. Arbeiten der Orchon-Expedition).* 1. Lieferung 1892; 2. Lieferung 1893; 3. Lieferung 1896; 4. Lieferung 1899, Taf. XXXI, Taf.u.XXIV, Fig.1,2,3,

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун Хар балгасын гэрэлт хөшөөний магнайн бичээсийг “Uyug yaziti” нэрээр хэвлүүлэхдээ бусад хэлтэрхий нь руни бичээсээс тодорхой утга илэрхийлэх нь тун бага болохыг тэмдэглэжээ.

Тэрээр тус бичээсийг В.Радловын уншлага, галигийг хэвээр авч орчин цагийн турк хэлнээ орчуулсан байна³³⁵.

Манай эрдэмтдээс Ю.Болдбаатар³³⁶, Л.Болд³³⁷ нар нэгдүгээр буюу гэрэлт хөшөөний магнайн бичээсийг судалсан байна.

Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд Т.Хаяаши, Т.Мориясу нар Хар балгасын археологийн шинжилгээ хийгээд холбогдох бусад сурвалжийн талаар тодорхой өгүүлж³³⁸ гэрэлт хөшөөний нангиад, согд, руни бичээсийг Т.Мориясу, Ю.Ёшида, А.Катаяма нар уншиж судалсан байна³³⁹.

Хар балгасын хотын туйрыг 1933-34 оны үест Д.А.Букинич, 1949 онд С.В.Киселев³⁴⁰, Х.Пэрлээ³⁴¹ нар гүймэг малтан шинжилсэн тухай монголын эртний хот балгадын талаарх тайлан, судалгааны бүтээлд тэмдэглэгдсэн байна.

Ю.С.Худяков Хар балгасын элбэг олдвор болох ваар хийгээд уйгурын соёлын тухайд өгүүлсэн нь буй³⁴².

Мөн Г.И.Рамстедт³⁴³, Е.Шаван (Chavannes)³⁴⁴, Г.Жиро (Rene Giraud)³⁴⁵ нарын эрдэмтдийн бүтээлүүдэд энэ хотын тухай түүхэн сурвалжийн мэдээ баримтууд цөөнгүй бий.

³³⁴ W.P.Wassiljeff, Die chinesische Insschrift des zerstörten Denkmals von Kara-Balgassun nach der Zusammenstellung des Herrn Gesandten Shu-King-Cheng, - Die alttürkischen Inschrift der Mongolei, St.Petersburg, 3.Lieferung 1895; Neue Folge 1897; Zweite Folge 1899 (in 2 vols: Osnabrück 1987), pp.286-291.

³³⁵ H.N.Orkun, Eski Türk Yazitları I, Istanbul, 1936 (Eski Türk Yazitları, Ankara 1987), s.85.

³³⁶ Ю.Болдбаатар, Хар балгасын I руни бичээсийг уншиж тайлах оролдлого, -Монгол хэл шинжлэл, Том.III (XXV), fasc.1-13, Улаанбаатар, 1997, 60-69 дүгээр тал.

³³⁷ Л.Болд, Хар балгасын орхон бичээс, - Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 51 дүгээр тал.

³³⁸ 林俊雄・森安孝夫・カラ=バルガス官城と都市遺址・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Toshio Hayashi, Takao Moriyasu, Palace and City of Qara-Balgasun, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 199-208.

³³⁹ 森安孝夫・吉田豊・片山章雄・カラ=バルガス碑文・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takao Moriyasu, Yutaka Yoshida, Akio Katayama, Qara-Balgasun Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp.199-224.

³⁴⁰ С.В.Киселев, Древние города Монголии, -Советская Археология, №2, Москва, 1957, стр.91-101; С.В.Киселев, Древне Монгольские города, Москва, 1965.

³⁴¹ Х.Пэрлээ, Монгол ард улсын эрт, дундал үеийн хот суурины товчоон, Улаанбаатар, 1961. 46-52 дугаар тал.

³⁴² С.Ю.Худяков, Керамика Орду-Балыка, -Археология Северной Азии, Новосибирск, 1982, стр.85-94; С.В.Киселев, Памятники уйгурской культуры в Монголии, -Центральная Азия и соседние территории в средние века, Новосибирск, 1982, стр.84-89.

³⁴³ G.I. Ramstedt, Uyïyur ulus-un tũike-yin tobci, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн гар хомрог (монгол бичгээр) Ф.IV, ХН.16.Т.56. 1924; G.I. Ramstedt, Uyïyur ulus-un tũike-yin tobci, -Улсын төв номын сан (монгол бичгээр) Ф.IV, ХН.16.Т.56. 1924.

³⁴⁴ E.Chavannes, Documents sur les Tou-Kieue (Tures) occidentaux, Saint-Petersbourg, 1903, pp.198.

³⁴⁵ Rene Giraud, L'Empire des Turcs Celestes, Les Règnes d'Elterisch, Qapghan et Bilgä (680-734), Paris, 1960; Rene Giraud, Göktürk İmparatorluğu (İlteriş, Kapagan ve Bilge'nin Hükümdarlıkları, 680-734), çeviren: İsmail Mangaltepe, Istanbul, 1999, s.248-249

Харбалгасын хоёрдугаар хөшөө

Харбалгасын хоёрдугаар хөшөөг Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Уйгурын Хар балгасаас 8 орчим км холуур урсах Жарантай (Жирмэнтэй) голын хөвөөнөөс тус сумын сургуулийн түүхийн багш Мягмарсүрэн 1973 онд анх олжээ. Хожим 1975 онд Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан шинжилгээний ангийн бичээс судлалын хэсэг руни бичигтэй болохыг нь тогтоож улмаар 1976 онд Улаанбаатар хотод авчирсан байна.

М.Шинэхүү гуай 12 мөрөөс бүтэх уг бичээсийг тайлан уншиж

Кунчи (Акунчи) буюрук байв би.

Дорныг ачлан тэтгэв би.

Өрнийг өслөн түлхэв би.

Хөх тэнгэрт хувь заяа минь нимгэн болов.

Хөрст дэлхийд зорчих суух минь охорхон болов.

Хөвгүүн Бука миний нэр

*Хөнөн мөхөх болов*³⁴⁶ хэмээн монгол шүлгийн хэлбэрт оруулан буулгажээ.

Японы эрдэмтэн Такаши Оосава бичээсийг судлан нягтлаад япон, англи хэлээр орчуулсан байна. Тэрбээр уг бичээсийг англи хэлнээ;

1-2: *I was Qunč Buyquqi*

3-5: *I protected and shoved the peoples of the eastern areas.*

I used to pursue after the peoples of the western areas.

6-10: *In the blue Tānri, my happiness turned out to be slight.*

On the brown Earth, my way (i.e. life) turned out short,

11-12: *Buqa, my son's name was worthy of my act.*³⁴⁷ хэмээн орчуулсан ажээ.

Он цагийн уртад бичээсийн улам элэрч баларсаар цөөн хэдэн үсэг мэдэгдэх тэдүй үлджээ.

³⁴⁶ М.Шинэхүү, Карабалгасунаас шинээр олдсон руни бичээс, -Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, (Археологийн судлал, Tom.VIII, fasc.1), 42-43.

³⁴⁷ 大澤孝・カラ=バルガズン第二碑文・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takashi Ōsawa, Qara-Balgasun Inscription II, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 143-145.

Булган аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Арханангийн бичээс
Гурвалжин уулын бичээс
Моюнчурын гэрэлт хөшөөний бичээс
Хангидайн хадны бичээс
Хөл Асгатын бичээс
Сүүжийн бичээс

Ар Ханангийн бичээс

Энэхүү бичгийн дурсгал Булган аймгийн Хишиг-Өндөр сумын төвөөс урагш 40 орчим км-т орших Ар Ханан уулын нэгэн өвөлжөөний хаданд буй.

Польшийн нэрт эрдэмтэн Э.Трыярски анх 1964 онд тайлан уншсан байна³⁴⁸. Түүний дараа 1966 онд О.Намнандорж гуай уг бичээсийг биечлэн үзэж гар хуулбар хийн, гэрэл зураг авсан³⁴⁹ ба 1968 онд академич Б.Ринчен бичээсийн гэрэл зургийг³⁵⁰ хэвлүүлэн судалгааны эргэлтэд дахин оруулжээ.

1977 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг уг дурсгалыг үзэж судалсан байна*. Бичээсийг судалсан судалгааны ажлын үр дүнгээ С.Харжаубай 1980 онд³⁵¹, С.Г.Кляшторный, Э.Трыярски нар 1990 онд³⁵² тус тус хэвлэн нийтлүүлжээ. Л.Болд номондоо бичээсийн судалгааны тоймыг дурдсан байна³⁵³. Ц.Баттулга уул бичээсийг дахин нягтлан судалж өгүүлэл бичсэн ажээ³⁵⁴. Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал³⁵⁵ болон Монгол-Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу хэрэгжсэн төслийн “Бичээс судлал”-ын тайланд³⁵⁶ уг бичээсийн талаар товч өгүүлсэн байна.

Гурвалжин уулын бичээс

Булган аймгийн Гурванбулаг сумын төвөөс зүүн өмнө зүг 17 км-т орших, Тарнын голын баруун талд Гурвалжин нэрт багахан шовх уулын баруун бэлд, 130 х 98 см хэмжээтэй хавтгай саарал боржин дээрх нэг мөр бичээсийг эрдэмтэд “*Гурвалжин уулын бичээс*” гэж нэрлэдэг билээ.

³⁴⁸ E. Tryjarski L'inscription runiforme d'Arkhanen, en Mongolie, -Ural- Altaische Jahrbücher, Tom. XXXVI, fasc.3-4 (1964), 1965, pp.423-428.

³⁴⁹ О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 38-41 дүгээр тал.

³⁵⁰ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.37.

³⁵¹ Хэрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд А.Очир, С.Харжаубай, С.Г.Кляшторный нар ажилласан байна.

³⁵² С.Каржаубай, Надпись на скале Арханана,- Хэл зохиол судлал, Tom.XIV, fasc.15, Улаанбаатар, 1980, 90-93 дугаар тал.

³⁵³ Л.Болд, Ар Ханангийн түрэг бичээс, - БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 17-18 дугаар тал.

³⁵⁴ Ц.Баттулга, Ар Ханангийн бичээсийг дахин нягтлах нь, -Монголын түүхийн сурвалж судлал: Өнөөгийн байдал, судалгааны асуудлууд, Боловсролын Их Сургууль, Улаанбаатар, 2004, 23-29 дүгээр тал.

³⁵⁵ Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 203 дугаар тал.

³⁵⁶ Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmalarını (Work for the Project Turkish Monuments in Mongolia in yer 2001), - Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.343-345.

Эл бичгийн дурсгалын гар хуулбарыг анх мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав хийж Судар бичгийн хүрээлэнгийн захирал Жамсрангийн Цэвээнд өгсөнд тэрбээр 1929 онд Оросын түрэг судлаач эрдэмтэн А.Н.Самойловичид илгээжээ.

А.Н.Самойлович уг хуулбарт тулгуурлан “teṅri qulı bitidim-Тэнгэрийн боол бичив би” гэсэн утгатай болохыг тайлж 1934 онд хэвлүүлсэн ажээ³⁵⁷.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун “Gürbelçin kaya yazıtı” нэртэйгээр А.Н.Самойловичийн нийтлүүлсэн эх, уншлагад тулгуурлан орчин цагийн турк хэлнээ “Tanrı kulu yazdim” гэж хөрвүүлжээ³⁵⁸.

О.Намнандорж 1966 онд энэ бичээсийн тухай мэдээлсэн ба³⁵⁹, Б.Ринчен академич бүтээлдээ уг бичээсийн гэрэл зургийг нийтлүүлсэнд³⁶⁰ уг гэрэл зургийн эхэд тулгуурлан 1969 онд Б.Базылхан уул бичээсийг уншсан байна³⁶¹.

1975 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх, соёл, бичиг судлалын хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлалын хэсэг” Гурвалжин уулын бичээсийг үзэж судалжээ³⁶².

С.Г.Кляшторный абугайн орос орчуулгын судалгааг доктор Л.Болд монгол хэлнээ буулган бүтээлдээ оруулсан байна³⁶³.

Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал номонд Гурвалжин уулын хэмээгдэх эл бичээсийн талаар товч дурджээ³⁶⁴.

Монгол-Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй “Орхоны хөндий дэх түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах төсөл”-ийн хүрээнд Ататурк их сургуулийн багш Жэнгиз Алийлмзын хамт уул бичээсийг үзэж дахин нягталсан³⁶⁵ ба өмнө нь ч хэд хэдэн удаа очиж судалж байсан билээ.

Могойн шинэ ус (Моюунчур)-ын гэрэлт хөшөөний бичээс

Булган аймгийн Сайхан сум, Архангай аймгийн Хайрхан сумын зааг нутаг, Могойн шинэ ус хэмээх газар буй гэрэлт хөшөөг Сэлэнгийн чулуу, Моюунчурын хөшөө, Могойн шинэ усны бичээс гэх зэргээр нэрлээсээр иржээ.

Нэрт эрдэмтэн Г.И.Рамstedт уг хөшөөг анх олж илрүүлэн уншиж судалсан³⁶⁶ байна. Орой, углуургыг оруулаад нийтдээ 394,5 см өндөр уул хөшөө өдгөө хоёр хэсэг болон хугарч унасан бөгөөд он цагийн уртад нар, салхинд идэгдэн тамгатай нүүрэн хэсгээс бусад

³⁵⁷ А.Н.Самойлович, Новые тюркские руны из Монголии, - Известия Академии Наук СССР, Отделение общественных наук, № 8, Москва, 1934.

³⁵⁸ H.N.Orkun. Eski türk yazitlari II, Istanbul,1938, s.163.

³⁵⁹ О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 38-41дүгээр тал.

³⁶⁰ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.37.

³⁶¹ Б.Базылхан, Гурвалжин уулын түрэг бичээс, -ШУА-ийн мэдээ, №4, 1969, 14-15 дугаар тал.

³⁶² С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии, -Тюркологический сборник, Москва, 1975, стр.155.

³⁶³ Л.Болд, Гурвалжин уулын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 23-24 дүгээр тал.

³⁶⁴ Монголын нутаг дахь түүх соёлын дурсгалт (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 207 дугаар тал.

³⁶⁵ Cengiz Alyılmaz, Epigrafik belgelemeler ve yüzey arařtırmaları, -Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.338-339.

³⁶⁶ Г.И.Рамstedт, Как был найден Селенгинский камень, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том IV, Вып.1, Санктпетербург, 1914; Г.И.Рамstedт, Перевод надписи Селенгинского камня, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том XV, Вып.1, Санктпетербург, 1914; G.J.Ramstedt, Zwei uigurische Runenschriften in der Nord-Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Vol.XXX, N 1, Helsinki, 1913; Gustav John Ramstad, Seven Journeys Eastward (1898-1912) , Translated from the Swedish & edited by John R.Krueger, The Mongolia Society, 1978, Bloomington, Indiana; G.J.Ramstedt , J.G.Granö und P.Aalto, Materialien zu den alttürkischen Inschriften der Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Vol.LX, N 3, Helsinki, 1958.

талын үсгүүд ихээр элэрч долорсноос зарим хэсэгтээ бараг үсэггүй болжээ. Тахилын зарим элемент (хүн чулуу, хонь, зэл чулуу гэх мэт) дагалдуулаагүй, томоохон хиргисүүрийн өмнө мэлхий чулуун суурьтай босгосон эл гэрэлт хөшөөний бичээсийг Н.Орхун³⁶⁷, С.Е.Малов³⁶⁸, Г.Айдаров³⁶⁹, Т.Мориясу³⁷⁰ нарын эрдэмтэд судалжээ. Мөн С.Пэлси³⁷¹, В.Өгэл³⁷², Е.И.Убрятова, Б.Базылхан³⁷³ нарын эрдэмтдийн тайлан, тойм судалгаа ч буй.

Хангидайн хадны бичээс

Булган аймгийн Дашинчилэн сумын төвөөс баруунш 28 орчим км-т Хангидай нэрт, хадан цохиот бэсрэг толгой бий. Тэрхүү хадан цохионы нөмөр нөөлөгт шүтэж эртнээс нааш айл хунар өвөлжсөөр ирсэн бөлгөө.

Цохио хаднаа зураг, руни, монгол, төвд бичээс цохисон нь нэн эртнээс хүн оршин сууж байсны гэрч, ул мөр гэлтэй.

Хангидай хэмээн нэрлэгдэх уг толгойн хаднаа руни бичиг байгааг анх О.Намандорж гуай үзэж мэдээлсэн байна³⁷⁴. Хурц үзүүртэй зүйлээр хялгас мэт нарийхан зурж бичсэн "зураасан, зурчмал" бичгийн төрөлд хамаарах руни бичээс эл хаднаа буй.

Б.Ринчен академичийн нийтлүүлсэн³⁷⁵ гэрэл зураг, хуулбарт түшиглэн эрдэмтэн Б.Базылхан уншиж судалжээ³⁷⁶.

1974-1975 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги уул бичээсийг дахин нягталсан байна.

Тус хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан эрдэмтэн М.Шинэхүү дахин уншиж монгол хэлнээ орчуулан гаргажээ³⁷⁷.

Мөн хээрийн судалгааны ангийн ахлагч С.Г.Кляшторный бичээсийг өөрийн хувилбараар уншиж орос хэлнээ орчуулан хэвлүүлсэн³⁷⁸ ба хожмын номдоо оруулсан

³⁶⁷ H.N.Orkun, Eski Türk Yazitlari I, 1936, (I.Baski: 1936, 1938, 1940, 1941; 2. Baski: Ankara, 1987; 3. Baski: Ankara, 1994) s.161-185.

³⁶⁸ С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва Ленинград, 1959, стр.30-44.

³⁶⁹ Г.Айдаров, Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века, Алма-Ата, 1971, 339-352 дугаар тал.

³⁷⁰ 森安 孝夫, シネウス遺蹟・碑文・モンゴル国現存遺蹟・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takao Moriyasu, Saite and Inscription of Šine-Usu, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 177-196.

³⁷¹ Memoria Saecularis Sakari Pälsi, Aufzeichnungen von einer Forschungsreise nac der Nördlichen Mongolei im Jahre 1909, -Suomalais-Ugrilainen Seura- Societé Finno-Ougrienne, Kansatieteellisiä julkaisuja X- Travaux ethnographiques X, arbeitet und herausgegeben von Harry Halén, Helsinki, 1982.

³⁷² Bahaddin Ögel, Šine Usu yazitının tarihi önemi (Kutluk Bilge Külkagan ve Moynçur), Türk Tarih Kurumu Belleten, cilt: XV, Sa.59, Ankara, 1951.

³⁷³ Е.И.Убрятова, Б.Базылхан, Эртний тюрк бичээсийг судалсан дүнгээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1963, 71-74 дүгээр тал.

³⁷⁴ О.Намандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 38-41 дүгээр тал.

³⁷⁵ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc. 1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.37.

³⁷⁶ Б.Базылхан, Хангидайн хадны түрэг бичээс, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1968, 96-97 дугаар тал.

³⁷⁷ М.Шинэхүү, Хангидайн хадны түрэг бичээсийг дахин нягталсан нь, -Хэл зохиол судлал, Том.XIII, fasc.8, Улаанбаатар, 1979, 6-69 дүгээр тал.

³⁷⁸ С. Г. Кляшторный, Наскальные рунические надписи Монголии, "Тюркологический сборник 1975", Москва, 1975, стр.151-159.

байна³⁷⁹. Монгол-Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу хэрэгжсэн төслийн “Бичээс судлал”-ын тайланд³⁸⁰ уг бичээсийн талаар товч өгүүлсэн байна.

Бидний судалгаагаар уул бичээсийн талаарх судалгаанууд нилээд мадагтай нь тодорхой болсон тул энэ тухай дахин өгүүлэх болно.

Хөл Асгатын бичээс

Булган аймгийн Могод сумын нутаг, Түлээ уулын зүүн хойд хормойд орших энэ дурсгалыг эрдэмтэд “Их Асгатын, Хөл Асгатын” хэмээн ялгаатай нэрлэсээр иржээ. Бичээсийг В.В.Радлов анх уншиж судалсан байна³⁸¹.

Х.Н.Орхун³⁸², С.Е.Малов³⁸³ нар турк, орос хэлнээ орчуулсан нь өмнөх судалгаанаас төдий ялгарах зүйлгүй юм.

Манай эрдэмтдээс О.Намнандорж гуай “Арван өдрийн шинжилгээний аялал”³⁸⁴-ын тайландаа, Б.Ринчен академич бүтээлдээ бичээсийн гэрэл зургийг хавсаргаснаас³⁸⁵ гадна доктор Н.Сэр-Оджав уул бичээс бүхий дурсгалын археологийн тодорхойлолт хийж С.Е.Малов орос орчуулгын талаар саналаа дурдсан ажээ³⁸⁶.

Доктор Л.Болд эхний бүтээлдээ эрдэмтдийн судалгааг тоймлож, удаах номдоо дурсгалын үг хэллэгийг монгол түрэг хэлний хүрээнд харьцуулан тайлбарласан байна³⁸⁷.

Сүүжийн бичээс

Нэрт эрдэмтэн Г.И.Рамstedт 1898-1912 оны хооронд Дорно зүгийн олон газраар аялан явж түүх, аман зохиол, хэл аялгууны асар их эх хэрэглэгдэхүүн цуглуулсан ажээ.

Монгол хэлээр маш сайн ярьдаг байснаас монголчуудад “Монгол ламын сүнс” хэмээн ихэд хүндлэгдсэн, эрдэм төгс тэрбээр үсэг бичигт хөшөө дурсгалыг зорин очиж үздэг байсныг аян замын тэмдэглэлээс нь тодорхой мэдэж болно³⁸⁸.

Тийнхүү аман зохиол, хэл аялгуу судлахын зэрэгцээ гэрэлт хөшөөний сурвалжлан эрсний үр дүнд Могойн шинэ усны дурсгал буюу Моюнчурын гэрэлт хөшөөний бичээс, Сүүжийн давааны бичээсийг анх нээж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна.

³⁷⁹ С. Г. Кляшторный, Надпись на скале Хангыта-хат, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.75-76.

³⁸⁰ Cengiz Alyilmaz, Epigrafik belgelemeler ve yüzey arařtırmaları, -Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in Year 2001), Т.С. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.343-345.

* Бичээс судлалын дадлагын тайлан, -МУИС монгол хэл соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим, гар бичмэлийн сан хөмрөг, 2004.

³⁸¹ W.Radloff, Die Altürkischen inschriften der Mongolei, St.Peterburg, 1894 (1987), pp.260-268.

³⁸² H.N.Orkun, Eski Türk yazıtları II, İstanbul, 1938. (1.Baskı: 1936, 1938, 1940, 1941; 2.Baskı: Ankara, 1987; 3. Baskı: Ankara, 1987) s.107-123.

³⁸³ С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр. 46-54.

³⁸⁴ О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 39 дүгээр тал.

³⁸⁵ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI. fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36.

³⁸⁶ Н.Сэр-оджав, Их Асгатын хөшөөт булш, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №1, Улаанбаатар, 11963, 91-95 дугаар тал; Н.Сэр-оджав, Эртний түрэгүүд (YI-YIII зуун), Улаанбаатар, 1970, 43-46 дугаар тал; Н.Сэр-оджав, Монголын эртний түүх (Археологийн найруулал), Улаанбаатар, 1977, 141 дүгээр тал.

³⁸⁷ Л.Болд, Хөл асгатын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 135-137 дугаар тал; Л.Болд, Хөл Асгатын орхон бичээсийг уншсан тэмдэглэл, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 66-85 дугаар тал.

³⁸⁸ G.J. Ramstedt, Seven Journeys Eastward 1898-1912, Tr. from the Swedish & ed. By J.R.Krueger, Bloomington, 1978.

Сүүжийн давааны бичээсийг одоогийн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Намнан уулын Сүүжийн даваа гэдэг газраас олжээ³⁸⁹. Г.И.Рамstedт эл бичээсийг анх нээж олсон, бас магадгүй уг хөшөөг хамгийн сүүлд харсан судлаач болсон байна. Учир нь Г.И.Рамstedтээ хойш энэ хөшөөг олж судлахаар зоригсод бүгд ганзага хоосон буцаагааж аа аргагүй алга болсон нь тодорхой болжээ.

“Qıǵız oylı qutluı baya tarqan öǵä buıuqı qutluı yarıan” хэмээх нэрээс улбаалан эрдэмтэд бичээсийг киргизийн үед холбогдоно гэж үздэг.

Эл хөшөөний бичээсийг Г.И.Рамstedтийн хуулбар, уншлагад түшиглэн Х.Н.Орхун³⁹⁰, А.Зуев³⁹¹, С.Е.Малов³⁹², С.Г.Кляшторный³⁹³, Г.Айдаров³⁹⁴, У.Мараззи (Ugo Marazzi)³⁹⁵, Л.Болд³⁹⁶ нарын эрдэмтэд хэл, түүх, эх бичиг судлалын үүднээс судалсан байна. Сүүжийн бичээсийг анх олж илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж нийтлүүлсэн эхээс үзвэл ихэнх үеэс тодорхой байсан хэдий ч дараа дараагийн судлаачдад нарийвчлан үзэх бололцоо гараагүй байна.

Завхан аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Зүрийн овооны бичээс

Завхан аймгийн Баянтэс сумын ойролцоо орших Зүрийн овоо гэдэг газраас эртний нэгэн бичээсийг 1915 онд нэрт эрдэмтэн Б.Я.Владимирцов анх олж судлан нийтлүүлэхэд бэлтгэжээ³⁹⁷. Алексей Бурдуковт “..Би нэлээд сайн, сайхан явж ирлээ. Зөвхөн бороо л их орж тав тух алдуулав. Тэс дэх Орхон бичээсийн цаасан хэвийг нь авч чадсангүй. Учир нь уг бичээсийг засаж янзлаагүй хадан дээр бичсэн учир гэрэл зургийг нь авч хуулж бичих төдийгөөс хэтэрч явчсангүй. Энэ бичээс хэдийгээр жижигхэн боловч маш сонирхолтой юм. Би бүгдийг нарийвчлан үзлээ. Ихэд чармайн эрсэн боловч энэ бичээсээс өөр бичиг олсонгүй. Харин олон тооны сонирхолтой хиргисүүрийг үзлээ. Эдгээр газруудаас өөр иймэрхүү бичээс олноо гэдэгт эргэлзэхгүй байна” гэж Б.Я.Владимирцов захидал бичсэнийг “Шинэ ба хуучин Монголд” номонд хавсарган хэвлэжээ хэмээн доктор Л.Болд тэмдэглэсэн байдаг³⁹⁷. Уг бичээсийг 1969, 1971, 1975 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хэзрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг очиж дахин

³⁸⁹ G.I. Ramstedt, Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1913, pp. 30-3, 63, +3pls; Г.И.Рамstedт, Как был найден Селенгинский камень. Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том IV, Вып.1, Санктпетербург, 1914; Г.И.Рамstedт, Перевод надписи Селенгинского камня, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том XV, Вып.1, Санктпетербург, 1914, стр.34-39, 40-49.

³⁹⁰ H.N.Orkun, Eski Türk Yazıtları II, Istanbul, 1939 (Birinci Baskı: 1936, 1938, 1940, 1941; İkinci Baskı: Ankara, 1987; Üçüncü Baskı: Ankara, 1987) s.107-123.

³⁹¹ А.Зуев, Киргизская надпись из Сужды, -Советское Востоковедение, Москва, 1958, №2, стр.133-135.

³⁹² С.Е.Малов, Енисейская письменность тюрков, Москва-Ленинград,1952, стр.84-90.

³⁹³ С.Г.Кляшторный, Историко-культурное значение Суджинской надписи, -Проблемы Востоковедения, 1959, №5, стр.162-169.

³⁹⁴ Г.Айдаров, Язык памятников древнетюркской письменности VIII века, Алма-Ата, 1971, стр.353.

³⁹⁵ Ugo Marazzi, Alcuni problemi relative alla diffusione del manicheismo presso i Turchi nei secoli XIII-IX, Annali dell' -Istituto Orientale di Napoli, 39(N.S.XXIX)/2, Napoli, 1979, pp.239-252.

³⁹⁶ Л.Болд, Сүүжийн Орхон бичээсийн үгийн сангийн харьцуулсан судалгаа, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 154-175 дугаар тал.

³⁹⁷ “Ленинградын Дорно дахиныг судлах хүрээлэнгийн түрэг-монголын тасгийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй В.Я.Владимирцовын бүтээлийн цуглуулга дотор “В.Я.Владимирцов, Небольшая тюркко-енисейская надпись на р.Тесе. Западная Монголия гэсэн нэрээр хадгалагдаж буй ажсуу. Уг өзүүлэл 410-416 гэсэн дугаартай, зөвхөн нэг талд нь барласан хэвлэлийн 7 дараас хуудас юм” гэж М.Шинэхүү абугай тодорхойлсон байна.

³⁹⁷ Л.Болд, Зүрийн овооны түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1999, 35 дугаар тал.

судалж шинжилгээний ажлын үр дүнгээ С.Г.Кляшторный 1975 онд³⁹⁸, М.Шинэхүү 1977 онд³⁹⁹ тус тус хэвлүүлжээ.

Нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный 2003 онд хэвлүүлсэн бүтээлдээ эл бичээсийн талаар дахин өгүүлсэн байна⁴⁰⁰.

Өвөрхангай аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Онгийн гэрэлт хөшөө
Өвөрхангайн бичээс
Хутаг уулын түрэг бичээс

Онгийн гэрэлт хөшөө

Онгийн голын хөвөөнөөс тахилын томоохон байгууламж, гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгалыг анх Н.М.Ядринцев олж илрүүлсэн бөгөөд В.В.Радлов бичээсийн хэв дардсыг авсан байна.

Энэхүү дурсгал нь одоогийн Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Мааньтын Бүрд хэмээх газар байжээ. Анх олж илрүүлэх хийгээд хэв дардас авах үед бүрэн бүтэн байсан тэрхүү хөшөө хожим аянганд ниргэгдэн хэдэн хэсэг болж бутарч унажээ. Гэрэлт хөшөөний бичээс золоор В.В.Радловын “атлас”-т гэрэл зураг, хэв дардсаар тодорхой үлдсэн байна. Хөшөөнөөс үлдсэн хоёр хэсэг бичигтэй хугархай Өвөрхангай аймгийн Орон нутгийг судлах музейд хадгалагдаж байгаа боловч уншиж судлах боломжгүй болсон байна.

Онгийн гэрэлт хөшөөний цогцолбор дурсгалын археологийн болон бичээс судлалын үүднээс Н.М.Ядринцев⁴⁰¹, В.В.Радлов⁴⁰², Х.Н.Орхун⁴⁰³, С.Пэлси⁴⁰⁴, П.К.Козлов⁴⁰⁵, С.Е.Малов⁴⁰⁶, Ж.Клоузон⁴⁰⁷, Э.Трыарски⁴⁰⁸, Т.Оосава⁴⁰⁹, В.Е.Войтов⁴¹⁰, Д.Баяр, Л.Болд⁴¹¹ нарын зэрэг олон эрдэмтэд судлан шинжилсэн байна.

³⁹⁸ С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии (Тэс, Гурвалжин-Ула, Хангита-хат, Хэнгэй), -Тюркологический сборник 1975, Москва, 1978, стр.151-159.

³⁹⁹ М.Шинэхүү, Тэсийн эртний түрэг бичээсийг дахин нягталсан нь, -Археологийн судлал, Том.VII, fasc.9, Улаанбаатар, 1977, 113-120 дугаар тал.

⁴⁰⁰ С.Г.Кляшторный, Надпись на р.Тэс, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.72-74.

⁴⁰¹ Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в южной Хангае в 1891году, -Сборник трудов Орхонской экспедиции, V, Санкт-Петербург, 1901, 43.

⁴⁰² W.W.Radloff, Das Denkmal am Ongin, - Die alttürkischen Inschrift der Mongolei, St.Petersburg, 3.Lieferung 1895; Neue Folge 1897; Zweite Folge 1899 (in 2 vols: Osnabrück 1987), pp.243-256.

⁴⁰³ H.N.Orkun, Eski Türk yazitlari I, Istanbul, 1936,(Birinci Baski: 1936, 1938, 1940,1941; İkinci Baski: 1987; Üçüncü Baski: 1994) s.127-132.

⁴⁰⁴ Memoria Saecularis Sakari Pälsi, Aufzeichnungen von einer Forschungsreise nach der nördlichen Mongolei im Jahre 1909, Helsinki, 1982, Harry Halén ed.

⁴⁰⁵ П.К.Козлов, Путешествие в Монголию (1923-1926), Москва, 1949, стр.167.

⁴⁰⁶ С.Е.Малов, Онгинский памятник,-Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр.7-10.

⁴⁰⁷ G.Clauson, The Ongin inscription, -Journal of the Royal Asiatic Society, 1957-3/4, pp.175-192.

⁴⁰⁸ E.Tryjarski, Die heutige Mongolei und ihre alten Denkmäler.& The Present State of Preservation of Old Turkic Relics in Mongolia and the Need for their Conservation, -Ural-altaische Jahrbücher 38, pp.154-158 & pp.158-173, + many pls; E.Tryjarski, On the Archaeological Traces of Old Turks in Mongolia, -East and West, 1971, N.S.21-1, pp.121-135; Some Remarks on the Monument of the Orkhon Turks, - Türk Kültürü El Kitabı, Istanbul, 1972, pp.35-43, 418-422; E.Tryjarski, Zur neueren Geschichte des Ongin-Denkmal, -Sprache, Geschichte und Kultur der Altaischen Völker, (Schriften zur Geschichte und Kultur des Alten Orients 5), Berlin, 1974, 629-630; E.Tryjarski, Zwyczaje pogrebowe ludow tureckich na tie ich zenizen, -Polska Akademia Nauk Komitet Nauk Orientalistycznych, Warszawa, 1991, pp.50, 54,77; E.Tryjarski & P.Aalto, Two Old Turkic Monuments of Mongolia, -Mémoires de la Société Finno-Ougrienne, 1973, pp.413-420, -3 pls.

Хутаг уулын түрэг бичээс

Өвөрхангай аймгийн Баруун Баян улаан сумын нутаг Хутаг ууланд хадны зураг болон эртний бичээс буйг 1972 онд Монгол оронд ажилласан тухайн үеийн Ардчилсан Герман улсын геологичид олж илрүүлжээ⁴¹².

Энэхүү лавтай мэдээллийн мөрөөр Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн бичээс, хадны зураг судлах хэсэг 1973 оны зун уг бичээсийн газар очиж судалсан байна⁴¹³.

Е.Триварски, Ж.Хамилтон нар 1975 онд⁴¹⁴ М.Шинэхүү 1976 онд уул бичээсийг уншиж судалсан дүнгээ нийтлүүлсэн⁴¹⁵ ажээ.

Өвөрхангайн бичээс

Өвөрхангай аймгийн музейд хадгалагдаж байгаа энэхүү бичээсийг Мааньтын Бүрд хэмээх газраас авчирсан аман мэдээ байдаг ажээ.

1978 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги үзэж мэдээлснээр доктор Л.Болд уншиж судалсан байна⁴¹⁶.

⁴⁰⁹大澤 孝・オンギ碑文・-モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takashi Osawa, Ongi Inscription-Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999). pp.129-136.

⁴¹⁰ В.Е.Войтов, Онгинский памятник. Проблемы культуроведческой интерпретации. -Советская Тюркология, №3, Москва, 1989, стр.34-50; В.Е.Войтов, Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв., Государственный Музей Востока, Москва, 1996, стр.28-32.

⁴¹¹ Д.Баяр, Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу, Улаанбаатар, 1997, дүгээр тал.

⁴¹² D.Laur, Archäologische Beobachtungen aus dem Bajan-Chongor-Aimack der Mongolischen Volksrepublik, Felszeichnungen und Inschriften -"Ethnographisch-Archäologische Zeitschrift", Veb Deutscher verlag der Wissenschaften, 1972, H.1, s.1-38.

⁴¹³ Уг хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, хоёр оюутны хамт; Зөвлөлтийн ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Новгородова нар оролцжээ.

⁴¹⁴ E.Tryjarski, J.H.Hamilton, L'inscription turque runiforme de Khtuk-ula.-Journal Asiatique, Paris, 1975.

⁴¹⁵ М.Шинэхүү, Хутаг уулын эртний түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1976, 36-42 дугаар тал.

⁴¹⁶ Л.Болд, Шингээр олдсон түрэг бичээс, -Хэл зохиол судлал, Том.XVI, fasc.1-19, Улаанбаатар, 1987, 68-71 дүгээр тал; Л.Болд, Өвөрхангайн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 83-84 дүгээр тал; Л.Болд, Өвөрхангайн орхон бичээс-Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 254-257 дугаар тал.

**Хөвсгөл аймгийн нутаг дахь руни бичгийн
дурсгалын судалгааны тойм**

*Орюк хадны бичээс
Тэсийн гэрэлт хөшөө*

Тэсийн гэрэлт хөшөө

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс” судлалын хэсгийнхэн Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын Өвөр булгийн Хөх толгой хэмээх газраас Тэсийн гэрэлт хөшөөг анх олжээ⁴¹⁷.

Тэсийн гэрэлт хөшөөний бичээсийн бусад хэсэг хугархай оллоогүйгээс бичээсийн бүрэн утга агуулгыг тодорхойлон өгүүлэхэд бэрхтэй юм.

С.Харжаубай⁴¹⁸, С.Г.Кляшторный⁴¹⁹, Т.Текин⁴²⁰, Т.Оосава⁴²¹ нарын эрдэмтэд уул бичээсийг уншиж судалсан байна.

Доктор Л.Болд бүтээлдээ уг бичээсийн судалгааны тойм хийгээд зарим үг хэллэгийн тухай өгүүлжээ⁴²².

Бид 1997 онд профессор А.Очирын хамт Тэсийн гэрэлт хөшөөний суурь гэгдэх Хөх толгойн Авдрантын тахилын байгууламж, хашлага чулууг үзэж гүймэг судалсан хийсэн билээ.

Орюк хадны бичээс

Хөвсгөл аймгийн Ринчинлхүнбэ сумын нутагт, Шишгэд голд цутгасан Харанга ой голын дээд аманд, Хээргийн боом гэдэг хадан хясааны дээд талд, доод Тошдог уулын ард Орюк хад нэртэй багахан хаданд руни бичээс буйг 1986 онд Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Л.Болд очиж судлан шинжилжээ⁴²³. Одоогоор Л.Болд докторын өгүүллээс өөр эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа үгүй байна.

⁴¹⁷ С.Харжаубай, А.Очир, Тэсийн гэрэлт хөшөөний шинэ дурсгал, -Шинжлэх ухаан амьдрал, №3, Улаанбаатар, 1977, 75 дугаар тал.

⁴¹⁸ С.Харжаубай, Тэсийн гэрэлт хөшөө, -Хэл зохиол судлал, Том.ХIII, fasc.1-25, Улаанбаатар, 1979, 117-124; С.Харжаубай, Первый памятник Ель-Етмиш Бильге кагана (Тэсинская стела), -Объединенный каганат тюрков в 745-760 годах (по материалам рунических надписей), Астана, 2002, стр.20-31.

⁴¹⁹ S.G.Klyashtorny, The Tes Inscription of the Uighur Bögü Qaghan, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1985, 39-1, pp.137-156, +5 pls; S.G.Klyashtorny, Tes äbidesi (ilk nesri), - Türk Kültürü Araştırmaları, Tom. XXIV, № 2, Ankara, 1986, s.151-171; С.Г.Кляшторный, Тэсинская стела (Предварительная публикация), -Советская Тюркология, №6, 1983, стр.76-90.

⁴²⁰ Talat Tekin, Nine Notes on the Tes Inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1988, 42-1, pp.111-118.

⁴²¹ 大澤 孝・テス碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takashi Osawa, Tes Inscription, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp.158-167.

⁴²² Л.Болд, Тэсийн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 113-117 дугаар тал; Л.Болд, Тэсийн Орхон бичээсийг дахин уншсан тухай тэмдэглэл, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 210-231 дүгээр тал.

⁴²³ Л.Болд, Орюк хадны түрэг бичээс (урьдчилсан тайлан), -Дорно дахины судлалын асуудал, №2 (17), Улаанбаатар, 1987, 87-91 дүгээр тал; Л.Болд, Орюк хадны түрэг бичээс, - БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 78-80 дугаар тал.

Төв аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Көл ич чурын гэрэлт хөшөөний бичээс
Туныюукийн гэрэлт хөшөөний бичээс

Туныюукийн гэрэлт хөшөөний бичээс

Туныюукийн гэрэлт хөшөөний бичээсийн талаар олон арван бүтээл гарсныг өмнө бид нийтлүүлсэн билээ⁴²⁴. Удахгүй “Туныюукийн гэрэлт хөшөөний бичээсийн судалгаа” хэмээх бүтээл хэвлэгдэх бөгөөд уг номд энэ дурсгалын талаар судалгааны дэлгэрэнгүй бүртгэл буй.

Көл ич чурын гэрэлт хөшөөний бичээс

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг, Хөшөөн тал хэмээх газар буй энэ дурсгалыг тусгай дэвтэр болгон хэвлүүлэхээр зэхсэн тул судалгааны тоймыг дурдаагүй болно.

Улаанбаатар хотод хадгалагдаж байсан руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Номын баринтгийн тээг дээрх бичээс

Улсын нийтийн номын санд хадгалагдаж байсан “Гучин хоёр модон хүний үлгэр” гэх номын баринтгийн оосорт буй чулуун тээг дээрх хоёр мөр бичээсийг 1956 онд академик А.Лувсандэндэв гуай тайлж уншсан байна⁴²⁵.

Тэрээр 1960 онд герман хэлээр өгүүлэл нийтлүүлж⁴²⁶ түрэг судлаачдын сонорт энэ бичээсийг дахин сонордуулсан ажээ.

Б.Ринчен академич “БНМАУ-ын Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтагийн оосрын чулуун тээгний түрэг бичээс” нэртэйгээр нийтлүүлсэнээс⁴²⁷ гадна нэгэн өгүүлэл франц хэлнээ хэвлүүлжээ⁴²⁸.

1959 онд Г.И.Константин⁴²⁹, 1960 онд С.Г.Кляшторный⁴³⁰, 1971 онд Г.Айдаров⁴³¹ нар тус тус өгүүлэл нийтлүүлжээ.

Доктор Л.Болд бүтээлдээ А.Лувсандэндэв гуайн судалгааг бараг хэвээр сийрүүлжээ⁴³².

Түрэг судлаач нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный уг бичээс хуурамч зүйл мөн хэмээн 2003 онд хэвлүүлсэн бүтээлдээ⁴³³.

⁴²⁴ Ц.Баттулга, Туныюукийн гэрэлт хөшөөний судалгаа, -Түүхийн сэтгүүл, Ephemeris Historiae, Academia Doctrinae Mongolia, Tom.IV, fasc.1-23, Улаанбаатар, 2003, 29-39 дугаар тал.

⁴²⁵ А.Лувсандэндэв, Шинээр олдсон тюрк бичээсийн тухай, Улаанбаатар, 1956, 7 хуудас.

⁴²⁶ A.Lubsangdendüp, Über eine in der Mongolei neu entdeckte türkische Runeninschrift aus dem 13.Jh., - Ural-altaische Jahrbücher, Wiesbaden, 1960, pp.122-123.

⁴²⁷ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbaator), 1968, pp.43.

⁴²⁸ B.Rintchen, La Mention du Nom de Činggis Qagan en écriture des turcs d'Orkhon, - XXIV International Orientalisten -Kongress Arbeitsplan und Mitgliederverzeichnis, München, 1957, pp.42.

⁴²⁹ G.I. Constantin, A late Kōk-Türkic runic inscription on a semi-precious stone, found in Mongolia, - Archiv Orientalni, Prag, 1959, pp.427-437.

⁴³⁰ С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана, -Проблемы Востоковедения, Москва, 1960, № 1, стр.173-175.

⁴³¹ Г.Айдаров, Шингис Ханннц атына баялансти ескерткиш туралы, -Қазақ Епиграфикасы, Алматы, 1971, стр.156-160.

⁴³² Л.Болд, Номын баринтагийн тээг дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын хадны бичээс, Улаанбаатар, 1990, 72 дугаар тал.

Хэнтий аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Рашаан хадны бичээс
Цэнхэрмандалын бичээс

Цэнхэрмандалын бичээс

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас холгүй, “Бургастайн бичигт цохио” хэмээх газар хоёр мөр руни бичгийн дурсгал буй бөгөөд манай судалгааны ном зохиолд “Цэнхэрмандалын бичээс” нэрээр орос, туркийн эрдэмтэд “Хэнтийн бичээс” гэж өөр өөрөөр нэрлэжээ.

Д.А.Клеменц Дорнод Монголоор аялахдаа 1895 оны 5-р сард энэ бичээсийг анх олсон тухай доктор Л.Болд бүтээлдээ тодорхой өгүүлжээ⁴³⁴.

Б.Ринчен академич “Үнэн” сонинд ажиллаж байхдаа “Новости Монголии” сонинд уг бичээсийн тухай мэдээлэл нийтлүүлсэн гэдэг.

Уул мэдээллийн мөрөөр С.Е.Киселевийн удирдсан шинжилгээний анги 1949 онд ирж үзэж нягтлан гэрэл зураг, гар хуулбар авчээ*.

Угсаатны зүйч К.В.Вяткина 1958 онд эл бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор мэдээлсэн байна⁴³⁵.

К.В.Вяткина гуайгаас авсан гэрэл зурагтаа дулдуйдаж Фэн Цзя-шэн хоёр мөр эл бичээсийг уншиж тайлсан судалгаагаа 1959 онд хэвлүүлсэн аж⁴³⁶.

Б.Ринчен академич 1968 онд⁴³⁷, Х.Пэрлээ академич 1974 онд⁴³⁸ Цэнхэрмандалын бичээсийн гэрэл зураг болон гар хуулбарыг нийтлүүлжээ.

Дорнод Монголоос нилээд эрт үед олдож мэдэгдсэн энэ бичээсийг 1975 оны зун Монгол-Зөвлөлтийн хээрийн шинжилгээний анги үзэж дахин нягтлан судалсан байна*.

Тус хээрийн шинжилгээний ангид ажилласан түрэг судлаач С.Г.Кляшторный 1978 онд⁴³⁹, М.Шинэхүү 1977 онд⁴⁴⁰ Цэнхэрмандалын бичээсийг уншиж тайлсан судалгааны дүнгээ хэвлэн нийтлүүлсэн ажээ.

2003 онд хэвлүүлсэн номдоо С.Г.Кляшторный уг бичээсийн талаар тухайлан оруулсан байна⁴⁴¹.

⁴³³ С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингиз-Хана-История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.75, 269-281.

⁴³⁴ Л.Болд, Цэнхэр Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 139-142 дугаар тал.

* Энэ хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд нэрт эрдэмтэн С.Е.Киселев, К.В.Вяткина болон МУИС-ийн оюутан Х.Лувсанбалдан (хожмын тод үеэж бичиг судлаач, нэрт эрдэмтэн), И.Шарав-Иш нар оролцсон гэдэг.

⁴³⁵ К.В.Вяткина, Кентейская руническая надпись, -Филология и история Монгольских народов, Москва, 1958, стр.217-218.

⁴³⁶ Фэн Цзя-шэн, Руническая надпись из Восточной Монголии, -Советская этнография, №1, Москва, 1959, стр.3-6.

⁴³⁷ Rintchen, Les designs pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. 1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.43.

⁴³⁸ Х.Пэрлээ, Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс), -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.

* Тус хээрийн шинжилгээний ангийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, ЗХУ-ын ШУА-ийн Ленинградын салбарын Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Г.Кляшторный нар удирдан ажиллажээ.

⁴³⁹ С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии (Тэс, Гурвалжин -Ула, Хангыта- Хата, Хэнтий), “Тюркологическая Сборник 1975”, Москва, 1978, стр.151-159.

⁴⁴⁰ М.Шинэхүү, Цэнхэрмандалын эртний түрэг бичээсийг дахин уншсан нь, -Археологийн судлал, Tom. VII, fasc.8, Улаанбаатар, 1977, 97-111 дүгээр тал.

⁴⁴¹ С.Г.Кляшторный, Хэнтийская надпись, -История Центральной Азии и памятники рунического письма, Санктпетербург, 2003, стр.75-77.

Дээрх бичээсийг хамтран үзэж судалсан түрэг судлаач М.Шинэхүү, С.Г.Кляшторный нарын судалгаа зарим талаар зөрүүтэй байсанд бид 2004 онд уг бичээсийг дахин үзэж нягталсан билээ*.

Рашаан хадны бичээс

Нэрт түүхч Х.Пэрлээ Хэнтий аймгийн Биндэр сумын Рашаан хаданд олон зүйл тамга тэмдэг, бичээс байсныг олж илрүүлсэн бөгөөд судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах үүднээс 1974 онд эртний бичээсийнх нь талаар хэвлэн нийтлүүлсэн байна⁴⁴².

Профессор Ц.Шагдарсүрэн 1987 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд ажиллаж байх үедээ Рашаан хадны дурсгалыг очиж судалжээ⁴⁴³.

Түрэг судлаач С.Харжаубай Рашаан хадны руни бичээсийг уншиж судлан эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн⁴⁴⁴ бөгөөд түүний хэвлүүлсэн зураг, эх дурсгал бичээсийн үсэг тэмдэгтээс багагүй зөрж байсныг тэмдэглэе*.

* Цэнхэрмандалын бичээсийн хуулбар, гэрэл зураг МУИС-ийн Түрэг судлалын тэнхмийн гэрэл зураг, хэв дардасын цуглуулгад буй.

⁴⁴² Х.Пэрлээ, Дорнод монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологийн тэмдэглэлээс), -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 71-74 дүгээр тал.

⁴⁴³ Ц.Шагдарсүрэн, 1987 оны шинжилгээний ангийн тайлан, -Хэл зохиолын хүрээлэн, гар бичмэлийн сан.

⁴⁴⁴ С.Харжаубай, Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүд, -Хэл зохиол, Tom.XVI, fasc.8, Улаанбаатар, 1987, 83-84.

* Проф. Ц.Шагдарсүрэн багш Рашаан хадны руни бичгийн маш тод, тодорхой гарсан нэгэн гэрэл зураг эрдэм судлалын ажилд тус санаж өгсөн нь Түрэг судлалын тэнхмийн гэрэл зургийн цуглуулгад хадгалагдаж байгаа билээ.

1.4.3. ТАЛ ХЭЭРИЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Баянхонгор аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Бөмбөгөрийн бичээс
Гурванмандалын бичээс

Бөмбөгөрийн бичээс

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын төвөөс баруун өмнө зүгт, 11 орчим км-т Тайн нурууны төгсгөл, Шивээт хэмээх намхан уулын эхэнд эл бичигт хөшөө, дурсгал бий. Бөмбөгөрийн бичээс хэмээх гэрэлт хөшөө нь нүүрэн талдаа 4 мөр бичээс, баруун хажуудаа нэг мөр бичээс, 34 тамгатай хөшөө юм. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв гуай 1986 онд анх үзэж тусгай хамгаалалтанд авахыг зөвлөж байжээ.

Гэрэлт хөшөөний бичээсийг Ц.Баттулга тайлж уншсан байна⁴⁴⁵.

Гурванмандалын бичээс

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт Мандалын голын сав дагууд орших Гурванмандал хэмээх цувраа гурван уулнаа руни бичгийн дурсгал байгааг 1987 онд Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Дашцэвэл, Р.Бямба нар үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулахыг зорьжээ.

Гурванмандал уулын руни бичгийн дурсгалыг доктор Л.Болд анх уншиж судалсан байна⁴⁴⁶.

Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн судалгааны ангийн “Бичээс судлал”-ын хэсэг 1989 онд гүймэг судалгаа хийсэн байна⁴⁴⁷.

Доктор Д.Баяр Гурванмандал уулын хадны бичээс тамга, тэмдгийг тухайлан судлан “Гурванмандалын хадны зураг” хэмээх өгүүлэл нийтлүүлжээ⁴⁴⁸. Доктор Б.Напил Дундмандалын бичээсийг Т.Санжмятав гуайн хуулбарт тулгуурлан уншиж казак хэлнээ орчуулсан байна⁴⁴⁹.

Ц.Баттулга “Гурван Мандалын бичээсийг дахин нягтлах нь” хэмээх өгүүлэлдээ уул бичгийн дурсгалыг өмнөх судалгаанаас нилээд зөрүүтэй уншиж тайлсан байна⁴⁵⁰.

⁴⁴⁵ Ц.Баттулга, Бөмбөгөрийн бичээс, -Acta Mongolica, Vol. IV (326), Ulaanbaatar, 2005.

⁴⁴⁶ Л.Болд, Р.Бямба, Гурван Мандалын түрэг бичээс, - Дорно дахины судлалын асуудал, №1 (18), Улаанбаатар, 1988, 103-108 дугаар тал; Л.Болд, Гурван Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 25-27 дугаар тал; Ц.Баттулга, Гурванмандалын эртний бичээс, -Археологийн судлал, Улаанбаатар, 2005

⁴⁴⁷ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан ажлын тайлан, - Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

Жич: Үг ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, Зөвлөлтийн талаас түрэг судлаач С.Г.Кляшторный, археологич В.Е.Войтов нар оролцож ажилласан байна.

⁴⁴⁸ Д. Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Том.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 89-102 дугаар тал.

⁴⁴⁹ Н.Базылханұлы, Монголияда жанадан табылган түрик бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр. 78.

⁴⁵⁰ Ц.Баттулга, Гурванмандалын бичээсийг дахин нягтлах нь, -Археологийн судлал, Том. XXII, fasc. 6, Улаанбаатар, 2005, 125-135 дугаар тал.

1.4.4. ГОВИЙН БҮС НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Говь-сүмбэр аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Чойрын бичээс

Хүн чулуун дээр бичигдсэн энэхүү өвөрмөц бичгийн дурсгал одоогийн Говь-Сүмбэр аймгийн Чойр өртөөнөөс баруун тийш 15 орчим км-т орших Бага Сансар уулын нэгэн хиргисүүрт булш, булшны дараас овоолгот чулуун дотор байсан гэдэг.

Энэ бичигт хүн чулууны тухай 1895 онд В.А.Обручев анх үзэж тэмдэглэсэн ажээ⁴⁵¹. Хожим 1928 оны 9-р сард Эрдэмбаяр хиргисүүрт булш, хөшөөний анхны байрлал зэргийг тодорхой харуулсан гэрэл зураг авч харин утасны хорооны Цэндсүрэн гэх нэгэн Улаанбаатар хотод тээвэрлэн хүргэж ирсэн түүхтэй. Судар бичгийн хүрээлэнгээс уг бичээсийн гар хуулбарыг 1928 онд ЗХУ-ын Шинжлэх ухааны академид илгээжээ⁴⁵².

Ж.Цэвээн гуайгаас 1933 оны 5-р сард С.Е.Маловт Чойрын бичээсийн гэрэл зураг, гар хуулбар дахин илгээсэнд тэрээр уншиж судлан хэвлүүлсэн байна⁴⁵³.

С.Г. Кляшторный биеэр үзэж судалсны хувьд эрдэм шинжилгээний томоохон өгүүлэл бичсэн нь хэд хэдэн удаа нийтлэгдсэн ажээ⁴⁵⁴.

С.Г.Кляшторный гуайн судалгааг доктор Л.Болд монгол хэлнээ буулган бүтээлдээ оруулжээ⁴⁵⁵.

1998 онд Туркийн эрдэмтэн С.Ф.Серткаая эл бичээсийг дахин уншиж судлан турк, герман хэлээр хэвлүүлсэн байна⁴⁵⁶.

“Монгол нутаг дахь түрэгийн үеийн дурсгалууд” бүтээл⁴⁵⁷ болон бусад олон эрдэмтэд судалгаандаа дурдсан ажээ⁴⁵⁸.

⁴⁵¹ В.А.Обручев, Список древних могил, замеченных на пути из Кяхты в Ургу и Калган, -Сборник трудов Орхонской экспедиции, II,СПб.,1895, стр.76.

⁴⁵² Судар бичгийн хүрээлэнгээс гадаадад явуулсан захидал- Үндэсний түүхийн архив,

⁴⁵³ С.Е.Малов, Новые памятники и турецкими рунами, -Язык и мышление, Том.VI-XII, Ленинград, 1936, стр. 251-259.

⁴⁵⁴ С.Г.Кляшторный, Руническая надпись на каменном изваянии из Чойра, -Проблемы Востоковедения, №5, Москва,1969, стр.46-49; С.Г.Кляшторный, Руническая надпись из Восточной Гоби, -Studia Turcica, Budapest,1971, pp.249-258; С.Г.Кляшторный, Древнетюркская надпись на каменном изваянии из Чойрэна, - Страны и народы Востока, Том.22, Москва, 1980, стр. 90-102.

⁴⁵⁵ Л.Болд, Чойрын бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 143 дугаар тал.

⁴⁵⁶ Osman Fikri Sertkaya.Göktürk harfli Çoyr Yazıtı, -Orkun, Türkçü Dergi, 5.sayı, Temmuz 1998, s.33-38; Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Çoir, Bahşi Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anlässlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg- İstanbul, 1998, pp.349-361.+ 4 pl.

⁴⁵⁷ Osman Fikri Sertkaya, Cengiz Alyılmaz, Tsendiin Battulga, Moğolistan'daki Türk anıtları projesi albümü (Album of the Turkish monuments in Mongolia) - T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başbakanlığı, Ankara, 2001, s.168-169.

⁴⁵⁸ Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie,

-Corpus Scriptorum Mongolorum,Том.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.39; Edward Tryjarski, On the Archaeological Traces of old Turks in Mongolia, - East and West, New Series, 21/1-2, Rome, 1971; E.Tryjarski, Eski Türklerin Moğolistan'daki arkeolojik eserleri üzerine, -Türk Kültürü Araştırmaları, XVI/1-2 (1977-1978), Ankara, s.151-184, s.161; Nejat Diyarbekirli, Orhun'dan geliyorum, - Türk Kültürü, sayı:198-199, yıl:XVII, Nisan-Mayıs 1979, s.382 (62); Erk Yurtsever, Eski Türk yazıtları için bir tavsih ve iki zeyl,-Orkun, Aylık Türkçü Dergi, Kasım 1988, sayı:9, s.18-20;

Дундговь аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Их бичигтийн бичээс
Дэл уулын дурсгал
Ханангийн бууцны бичээс
Тамганы бичээс
Ханангийн бууцны бичээс

Дэл уулын дурсгал

Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг дахь Дэл уул хадны зураг, тамга тэмдэг, үсэг бичгийн дурсгалаараа нэгэнт алдаршжээ.

Дэл уулын хадны зургийг Д.Дорж, Э.А.Новгородова нар анх удаа судалсан байна⁴⁵⁹.

1987 онд МУИС-ийн Түүхийн тэнхмийн эрхлэгч дэд доктор Д.Хүүхэнбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав нар руни бичгийн I, II дурсгалыг олж илрүүлжээ⁴⁶⁰.

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг 1989 оны 7-р сарын дундуур Дэл уулнаа очиж руни бичгийн дурсгалыг судалсан байна⁴⁶¹.

Т.Санжмятав бүтээлдээ Дэл уулын баруун Билүүний хадны зураг, мөн руни бичгийн I,2-р дурсгал зэргийг хамтатган хэвлүүлжээ⁴⁶².

Дэл уулын зүүн Билүүний хятад бичээсийг Ц.Баттулга, Ц.Төрбат нар тайлан уншсан байна⁴⁶³.

Дэл уулнаас одоогоор руни бичгийн дөрвөн дурсгал олдоод байгаа билээ.

Монголын түүх соёлын дурсгал номд зүүн Билүүний хятад бичээс⁴⁶⁴, хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал” тайланд эдгээр руни бичээсийн талаар өгүүлжээ⁴⁶⁵.

Дэл уулын I бичээс

Дэл уулын нэгдүгээр бичээсийг судлаач Ю.Болдбаатар уншиж тайлан эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэд хэдэн удаа нийтлүүлжээ⁴⁶⁶. Ц.Баттулга уг бичээсийг дахин нягтлан судалсан байна.⁴⁶⁷

Б.Напил өмнөх судалгааг казах хэлээр орчуулж зарим үгийн өөрийн хувилбараар орчуулж тайлбарласан байна⁴⁶⁸.

⁴⁵⁹ Д.Дорж, Э.А.Новгородова, Петроглифы Монголии, Улаанбаатар, 1975, 30-31 дүгээр тал, таблиц-X.

⁴⁶⁰ Т.Санжмятав, 1988 оны хээрийн шинжилгээний тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1988.

⁴⁶¹ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

⁴⁶² Т.Санжмятав, Монголын хадны зураг, Улаанбаатар, 1995, 40-42 дугаар тал, таблиц 125-143.

⁴⁶³ Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулаас шинээр олдсон хятад бичээс, - МУИС Монгол судлалын сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, Боть ХҮИ (169) Улаанбаатар, 2001, 103 дугаар тал.

⁴⁶⁴ Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 212 дугаар тал.

⁴⁶⁵ Cengiz Aylılmaz, Tsendiin Battulga, Epigrafik belgelemeler ve yüzey arařtırmaları, -Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), Т.С. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.362-363.

⁴⁶⁶ Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica Vol.10(31), Улаанбаатар, 2000, 219-226 дугаар тал.

⁴⁶⁷ Ц.Баттулга, Дэл уулын нэгдүгээр бичээсийг дахин нягтлах нь, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол хэл соёлын сургууль, Боть ХХII, дэвтэр III, Улаанбаатар, 2004, 12-17 дугаар тал.

⁴⁶⁸ Н.Базылханұлы, Монголияда жаналан табылган түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-71.

Дэл уулын II бичээс
Дэл уулын III бичээс
Дэл уулын IV бичээс

Дээрх бичээсүүдийг Ц.Баттулга уншиж судалсан байна⁴⁶⁹. Б.Напил казах хэлээр орчуулж зарим үгийн өөрийн хувилбараар орчуулж тайлбарлажээ⁴⁷⁰.

Их бичигтийн бичээс

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутаг, Аарагийн хадны салбар Их бичигт хэмээх газраас Ц.Баттулга 1997 онд олж илрүүлэн уншиж судалсан байна⁴⁷¹.

Б.Напил өмнөх судалгааг казах хэлнээ орчуулж судалжээ⁴⁷². “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” ном⁴⁷³ болон Монгол-Туркийн эрдэмтдийн хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсгийн тайланд⁴⁷⁴ дурдагджээ.

Тамганы бичээс

1961 онд Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Лувсанбалдан Дундговь аймгийн орон нутгийг судлах музейд хадгалагдаж буй хүрэл зэвсгийн үеийн элдэв зүйл олдворыг үзэж сонирхож байгаад санамсаргүй тохиолдлоор руни бичиг бүхий тамга байсныг олсон түүхтэй. Нутгийн ардын гарт хадгалагдаж байсан эл түүвэр олдворыг чухам аль сумын нутаг, хэн гэдэг хүний гараас авсныг тэмдэглэсэн зүйл үгүй байжээ.

Х.Лувсанбалдан гуай уг бичээсийн талаар анх 1962 онд мэдээлжээ⁴⁷⁵.

Б.Базылхан руни бичээсийг уншиж “Эртний тюрк бичээстэй мутрын тэмдэг” нэртэйгээр хэвлүүлсэн байна⁴⁷⁶.

Уг дурсгал Б.Ринчен академичийн бүтээлд нийтлэгдсэнээ⁴⁷⁷ гадна түүх соёлын дурсгалын ном⁴⁷⁸, Монгол-Туркийн хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын тайланд дурдагджээ⁴⁷⁹.

⁴⁶⁹ Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний II,III бичээс, -Археологийн судлал, Том.XXXVIII, fasc. Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний II, III бичээс, -Археологийн судлал, Том.XXXVIII, fasc. Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний IV бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол судлалын сургууль, Боть ХIY (151), Улаанбаатар, 1999, 74-79 дугаар тал

⁴⁷⁰ Н.Базылханұлы, Монголияд жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-76.

⁴⁷¹ Ц.Баттулга, Их бичигтийн бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол судлалын сургууль, Боть 10 (122), Улаанбаатар, 1997, 9-13дугаар тал.

⁴⁷² Н.Базылханұлы, Монголияд жаңадан табылған түрік бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000, стр.75-76.

⁴⁷³ Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал(сэдэвчилсэн лавлах),Улаанбаатар,1999, 212 дугаар тал.

⁴⁷⁴ Cengiz Alyilmaz, Tsendiin Battulga, Epigrafik belgelemeler ve yüzey araştırmaları, -Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.356-359.

⁴⁷⁵ Х.Лувсанбалдан, Өчүүхэн түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1962, №4, 68 дугаар тал.

⁴⁷⁶ Б.Базилхан, Эртний тюрк бичээстэй мутрын тэмдэг, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1964, №1, 74-75 дугаар тал.

⁴⁷⁷ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Том. XVI, fasc. I, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.40.

⁴⁷⁸ Монголын нутаг дахь түүх соёлын дурсгал(сэдэвчилсэн лавлах),Улаанбаатар,1999, 219 дүгээр тал.

⁴⁷⁹ Cengiz Alyilmaz, Epigrafik belgelemeler ve yüzey araştırmaları, -Moğolistan'daki Türk Anıtları Projesi 2001 yılı çalışmaları (Work for the Project Turkish Monuments in Mongolia in year 2001), T.C. Başbakanlık Türk İşbirliği ve Kalkınma İdaresi Başkanlığı, Ankara, 2003, s.346-347.

Ханангийн бууцны бичээс

Монгол-Америкийн хамтарсан “Өмнөд Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги 2003 оны зун Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумдын зааг нутаг Бага газрын чулуу хэмээх уулын өмнөд бие, Улаан амны Ханангийн бууц хэмээх газраас олсон байна*.

Ч.Амартүвшин, Ц.Баттулга нар уул бичээсийг уншиж судлан хэвлүүлжээ⁴⁸⁰.

Дорнод аймгийн нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Зоосны бичээс

Археологич Н.Сэр-Оджав гуай 1961 онд Дорнод аймагт хийсэн археологийн хайгуул, шинжилгээний ажлын явцад санамсаргүй тохиолдлоор олжээ⁴⁸¹.

Зоосны руни бичээсийг С.Г.Кляшторный анх уншиж судалсан байна⁴⁸².

Дээрх судалгаа хэвлэгдсэнээс хойш таван жилийн дараа С.Харжаубай руни бичээсийг дахин уншиж монгол хэлнээ орчуулан нийтлүүлжээ⁴⁸³.

Доктор Л.Болд бүтээлдээ дээрх хоёр судлаачийн бичээсийг уншиж тайлсан байдлыг харьцуулан танилцуулсан байна⁴⁸⁴.

* Тус хээрийн шинжилгээний ангид ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ажилтан Ч.Амартүвшин, Америкийн Мичиганы Их сургуулийн багш *W.Honeychurch*, Харвардын Их сургуулийн аспирант *J.Wright* нар ажилласан байна.

⁴⁸⁰ Ч.Амартүвшин, Ц.Баттулга, Ханангийн бууцны бичээс, -Археологийн судлал, Том XII, fasc.3, Улаанбаатар, 2005, 82-86 дугаар тал.

⁴⁸¹ Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх / Түүхэн найруулал/, Улаанбаатар, 1977, 41,42 дугаар тал.

⁴⁸² С.Г.Кляшторный, Монета с рунической надписью из Монголии, -Тюркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338.

⁴⁸³ С.Харжаубай, Эртний гурван бичээс, -*Studia Archaeologica*, Tom.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 32 дугаар тал.

⁴⁸⁴ Л.Болд, Зоосон дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 31-33 дугаар тал.

Өмнөговь аймгийн нутаг дахь руни бичгийн
дурсгалын судалгааны тойм

Сэврэй бичээс

Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт, эртний бичиг бүхий нэгэн чулуу байдаг тухай нутгийн нэгэн залуу багш 1948 онд тус аймгийн нутагт ажилласан палентологийн шинжилгээний ангийнханд мэдээлэхэд тус шинжилгээний ангийн ахлагч И.А.Ефремов бичээсийг үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ⁴⁸⁵.

Б.Ринчен академич бүтээлдээ “Сэврэй бичээс” гэж нэрлэн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлсэн ажээ⁴⁸⁶.

1969 онд Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг анх бичиг судлалын үүднээс нарийвчлан судалсан байна*.

Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд 1997 онд бичээсийг дахин нягталсан ажээ.

Сэврэй цагаан чулууны руни, согд бичээсийг С.Г.Кляшторный, В.А.Лившиц⁴⁸⁷, Ю.Ешида, Т.Мориясу, А.Катаяма⁴⁸⁸ нар уншиж судалсан байна.

⁴⁸⁵ И.А.Ефремов, Дорога ветров. Гобийские заметки. Изд.2-е. Москва, 1962, стр.229.

⁴⁸⁶ Rinchen, Les designs pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, p.42.

* Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Лувсанбалдан, Б.Базылхан, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шингхүү, Оросын эрдэмтэн С.Г.Кляшторный нар оролцон ажилласан байна.

⁴⁸⁷ С.Г.Кляшторный, В. А.Лившиц, Сэврэйский камень, -Советская тюркология, Баку, 1971, №3, стр. 106-112; S.G.Kljaštornyj, V.A.Livšic, Une inscription inédite turque et sogdienne. La stèle de Sevrey (Gobi méridional), "Journal Asiatique", 1971, pp.11-20; С.Г.Кляшторный, В. А.Лившиц, Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии, -Археология и этнография Монголии. Новосибирск, 1978, стр.57-59(37-60).

⁴⁸⁸ 吉田 豊・森安孝夫・片山 章雄・セブレイ碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月(Yutaka Yoshida, Takao Moriyasu, Akio Katayama, Sevrey Inscription. - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998. The Society of Central Eurasian Studies, 1999), pp.125-127.

1.5.0. МАНАЙ ЭРДЭМТДИЙН ТУУРВИСАН РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН ХОЛБОГДОЛТ НОМ

Б.Ринчен, Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл, Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom XVI, fasc.I, Улаанбаатар, 1968, хэвлэлийн нэгж хуудас 13, 73 хуудас.

Эл номын оршил хэсэгт археологич Н.Сэр-Оджав “БНМАУ-д түрэг бичгийн дурсгалыг судалж байгаа нь” гэсэн тоймд 1966 он хүртэл монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалыг оруулсан байна. Руни бичигт гэрэлт хөшөө, хад чулууны нийт 26 бичээсийн гэрэл зураг, гэрэл зургаас дам буулгасан хуулбар зэргийг тус тус хэвлүүлжээ.

М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, -Studia Archaeologica, Tom VI, fasc.I, Улаанбаатар, 1975, хэвлэлийн хуудас 15, 219 хуудас. Эл ном нь,

Оршил, удиртхал,

Монгол нутаг дахь Орхон бичээсийг судалсан тойм

Тариатын гэрэлт хөшөөний төрх байдал

Тариатын гэрэлт хөшөөний үсэг-зурлага, бичээс

Тариатын дурсгалт бичгийн үг, үсгийн галиг ба орчуулга

Тариатын дурсгалт бичгийн үгсийн сангийн судалгаа гэсэн үндсэн хэсгээс бүрджээ.

Тариатын дурсгалт бичгийн үгсийн сангийн судалгаа сэдэв нь дотроо

- хүний нэр,

- ураг төрөл, садан сүлбээ, худ, худгүйн нэр,

- овог аймаг, угсаатан ястан, улс үндэстний нэр,

- аймгийн холбоо, цэрэг-засаглал, түүний тэргүүн нарын цол хэргэм

- албан тушаал, өршөөл хайр, эрэлхэг гавьяаны нэр

- орд өргөө, аж ахуйн нэр,

- оюун сэтгэлгээний нэр

-тоо хэмжээ, цаг хугацаа, их багыг заасан үгс

-өнгө зүс, зүг чигийг заасан нэр

- уул усны нэр

- хүний бие, юмыг заасан нэр

- үйл хөдлөл, байдал байц заасан үгс гэсэн бичил зүйл хуваасан хэсэгтэй ажээ.

Тариатын дурсгалт бичиг дотор гарах үгийг “Орхоны бусад бичээс”-т тохиолдох үгтэй жишиж сонгодог монгол бичгийн хэлтэй харьцуулсан толь хийхдээ монгол, орос орчуулга давхар хадсан нь туйлын сайшаалтай бөгөөд монгол түрэг хэлний харьцуулсан судалгаанд төдийгүй Алтай хэлний судлалд ч чухал эх хэрэглэгдэхүүн болгон ашиглахаар бүтээл болжээ.

М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Том VIII, fasc.I, Улаанбаатар, 1980, хэвлэлийн хуудас 6, 81хуудас.

Энэ номын Удиртгал хэсэгт Орхон-Енисейн бичгийг судлахын учир холбогдол, руни бичгийн нээлт, Орхон бичгийн судалгааны тойм зэргийг оруулсан байна.

1 бөлөгт, руни бичгийн гарал хамаадал, Орхоны руни бичгийн үсэг-зурлага, хэл аялгууны асуудал, Орхоны руни бичгийг дурсган босгосон зарим зан үйл гэсэн сэдэвт хамаарагдах судалгааг боломжийн хирээр оруулжээ.

II бөлөгт, Тариатын руни бичиг, Тэсийн руни бичээс, Карабалгасун [М.Шинэхүү ийн бичсэн болой]-аас шинээр олдсон руни бичээсийн галиг, монгол орчуулга зэргийг оруулсан байна.

III бөлөгт. Тариатын дурсгалт бичгийн түүхэн мэдээ, Тэсийн руни бичгийн түүхэн мэдээ, Харбалгасын руни бичгийн түүхэн мэдээг нангиад болон бусад хэлээрх сурвалж, судалгааны бүтээлийн мэдээ, баримтад тулгуурлан тодорхой өгүүлж тэдгээр дурсгалууд түүхэн чухаг сурвалж болохыг баталсан ажээ.

М.Шинэхүү, Орхон бичгийн атлас, 1976-1980 он

Эрдэмтэн М.Шинэхүү “Орхон бичгийн атлас” зохион хэвлүүлэхээр төлөвлөн ажиллаж байсан ч харамсалтай нь амжаагүй байна. Түүний хийж бэлтгэсэн төлөвлөгөө хожим мөн бичгийн ном, атлас хийхэд магад хэрэг болуужин хэмээн санаж бас түүний хичээл зүтгэлийг үнэлэн харуулахын тул толилуулав.

1976-1980 онд зохион үйлдэх “Орхон бичгийн атлас”-ын бүтцийн нарийвчилсан төлөвлөгөө

I БОТЬ

1. Хянан засварлагчдын үг
2. Оршил
3. Удиртхал
4. Өмнө хавсаргасан 36 бичээс орно

Уг хэсэгт дурсгалын тодорхойлолт, орчны план зураг, хэмжээ, ажиглал, тэмдэглэл, хөшөөний дурсгалыг олон талаас нь авсан гэрэл зураг оруулахаар төлөвлөсөн байна. Барагцаалбал 20 хэвлэлийн хуудас байхаар төлөвлөсөн ажээ.

II БОТЬ

1. Өмнө хавсаргасан 36 бичээсийн дор дурдсан зүйлүүд орно. Үүнд:

А. Транслитерация

Б. Транскрипция

В. Орчуулга:

1. Сонгодог монгол бичгийн хэлтэй жишсэн

2. Орчин цагийн монгол хэлээр найруулсан

3. Үгчилсэн орос хэлний

4. Үгчилсэн англи хэлний орчуулга орж II боть дуусна. Барагцаалбал 15 орчим хэвлэлийн хуудас байна.

III БОТЬ

1. Өмнөх 36 бичээсийн транскрипци /орчуулгад хийсэн зүүлт тайлбар/

2. Толь бичиг /36 бичээсийн бүх үгээр хийсэн/

3. Үгийн хэлхээ /36 бичээсний бүх үгээр хийнэ/

4. Ном зүй

5. Товчилсон үгс

6. Гарчиг / III боть барагцаалбал 10 орчим х.х. байх болно.

Жич өгүүлэх нь: Редакторын үг, оршил, удиртхал, бичээсүүдийн товч тодорхойлолт, орчуулга, зүүлт тайлбар, толь бичиг зэрэг нь монгол, орос, англи 3 хэлнээ байх болно.

Энэ атласыг хянан засварлах редакцийн коллеги нь дурдсан бүрэлдэхүүнтэй байх болов уу гэж санана. Үүнд: Ш.Бира, А.Лувсандэндэв, Э.А.Тенишев, Д.М.Насилов, Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, В.М.Наделяев, Е.И.Убрятова, С.Г.Кляшторный, М.Шинэхүү, Б.Базылхан, Л.Ю.Тугушева.

Дээрх редакцийн гишүүд дотроос ерөнхий редактор нь Ш.Бира, А.Лувсандэндэв, В.М.Наделяев, Н.Сэр-Оджав

Хариуцлагатай редактор нь С.Г.Кляшторный, Е.И.Убрятова, Б.Базылхан, М.Шинэхүү.

Харин редакцийн гишүүд нь атлас тус бүрийн онцлогийг харгалзаж хуваан засварлах болно. Үүнд:

I ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, Н.Сэр-Оджав

Хариуцлагатай редактор нь С.Г.Кляшторный гишүүд нь Х.Пэрлээ, В.М.Наделяев, М.Шинэхүү

II ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, А.Лувсандэндэв

Хариуцлагатай редактор нь Э.Р.Тенишев, Б.Базылхан, гишүүд нь Д.М.Насилов, В.М.Наделяев, М.Шинэхүү, Л.Ю.Тугушева

III ботийн ерөнхий редактор нь Ш.Бира, В.М.Наделяев

Хариуцлагатай редактор нь М.Шинэхүү, гишүүд нь Е.И.Убрятова, С.Г.Кляшторный, Л.Ю.Тугушева. Уг атласыг хийж дуусаад редакцид шилжүүлэхийн өмнө академич Б.Ринчен, Ш.Лувсанвандан, А.Н.Кононов, доктор Чой.Лувсанжав, Э.А.Севортян, Г.Д.Санжеев нарт

үзүүлж зохих санал зөвлөлөгөөн авч түүний нь харгалзан үзнэ гээд төлөвлөгөө боловсруулсан М.Шинэхүү, 1976.1Ү.19 гэж огноолсон байна.

Мөн 1976-1980 онд зохиох “Орхон бичгийн атлас”-ыг хэрхэн үйлдэх ажлын төлөвлөгөө гээд жил бүр юу хийхийг он тус бүрээр нь гарган жагсааж 1976.1Ү.20 гэжээ.

Уг атлас зохиогдож хэвлэгдсэн бол монголын руни бичгийн судлалд төдийгүй түрэг, монгол судлалд үнэлж баршгүй чухал ач холбогдолтой бүтээл болох байсан нь гарцаагүй.

Б.Базылхан, Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтэц, Улаанбаатар, 1984,158 хуудас.

Зохиогч уг номынхоо удиртгал хэсэгт руни бичгийн судалгааны холбогдох ном зохиолыг нилээд дэлгэрэнгүй тоймлон бичжээ.

Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийг а/бүтээвэр, б/залгавар бүтээвэр, в/нийлмэл залгавар бүтээвэр, язгуур үг хэмээн ангилж эртний түрэг хэлний язгуур бүтээвэр нь хэлбэр бүтцийн хувьд “э /V”, “гэ /CV” /бүтэцтэй 104, “э”, “г” гэ” /V”, “С”, “CV”/ гэсэн бүтэцтэй 163 залгавар бүтээвэр байна гээд нийлмэл залгавар бүтээвэр VC,VCV, VCVC, VCC, VCCV, VCCVC, CV -гээр/гийгүүлэгч+эгшгээр/ эхэлсэн CVC, CVCV, CVCVC, CVCCV, CVCCVC, CCVC, CCVCV, CVCVCCVC, CCVCCVCV, CCVCCVCVCVCV гэх мэт загвар бүхий олон хэлбэртэй байхыг дурьдаад “V” бүтэцтэй 8 язгуур бүтээвэр,”CV” бүтэцтэй 71 язгуур бүтээврийн талаар тухайлан өгүүлжээ.

Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс (Түрэг бичгийн дурсгал I), Улаанбаатар,1990, хэвлэлийн хуудас10, 153 хуудас.

Зохиогч энэ номдоо монгол нутгаас олдсон нийт 40 бичгийн дурсгалын судалгааны тоймыг эмхэтгэж оруулсан байна. Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалыг судлагч, сонирхогч бүхний гарын авлага, лавлах ном болсонд уг бүтээлийн гол үнэ цэнэ оршиж байгаа юм.

Л.Болд, “Орхон бичгийн дурсгал II” Улаанбаатар, 2000, хэвлэлийн хуудас 17, 268 хуудас.

Монгол улс дахь Орхон бичиг судлал, Орхон бичгийн дурсгалыг аврагтун, гэсэн удиртгал, санамжаас гадна нийт 13 бичээсийн талаар тухайлан өгүүлсэн байна. Үүнд;

1. Хар балгасын орхон бичиг
2. Хөл Асгатын орхон бичээсийг уншсан тэмдэглэл
3. Онгийн голын орхон бичээсийг сурвалжилсан дүн ба түүний тайлбарууд
4. Күли-чурт зориулан босгосон гэрэлт хөшөөний орхон бичээс
5. Сүүжийн орхон бичээсийн үгийн сангийн харьцуулсан судалгаа
6. Тариатын орхон бичээс
7. Тэсийн орхон бичээсийг дахин уншсан тухай тэмдэглэл
8. Их хануй нуурын бичээс
9. Тэвшийн орхон бичээс
10. Ханан хадны орхон бичээс
11. Хар балгасын II бичээс
12. Өвөрхангайн орхон бичээс
13. Орюк хадны бичээсийн тухай

Мөн зарим бичээсийн хэлзүй, үгийн санг судалсан судалгааны ажлын үр дүнг оруулжээ.

1.6.0. МОНГОЛ НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛЫН БҮРТГЭЛ

Монгол нутагт руни бичгийн хэдэн дурсгал, хаана байдаг талаар хэд хэдэн бүртгэл гарчээ. Тэдгээр бүртгэл мэдээлэл дотор нэр тэмдэглэгдсэн ч чухам аль аймаг, сумын нутаг, ямар нэртэй газар байдаг нь тодорхойгүй бичээс, нэр хаяг тодорхой боловч одоо болтол судалгааны эргэлтэд ороогүй дурсгал нилээд хэд байна. Руни бичгийн дурсгалын дээрх жагсаалтад зарим дурсгалын нэр өөр өөрөөр тэмдэглэгдэж нэрлэгдсэн байх тул үзэгч судлагч нарт тустай хэмээн санаж бүрэн эхээр нь сийрүүлэхийг хичээлээ.

Х.Пэрлээ академичийн бүртгэл⁴⁸⁹

а) Надписи- на надгробных стелах

1. Стела, поставленная в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.
2. Стела, поставленная в честь Бильге или Моглян-хана в районе Кошо-Цайдама.
3. Онгинский (Маанитуйский) памятник, или памятник Гудулу-хану в районе Онгин-гол.
4. Стела, поставленная в честь мудрого Тоньюкука в котловине горы Баянцогту в районе Налайхи.
5. Памятник, поставленный в честь Кули-чура в урочище Ихе-Хушоту.
6. Обломки камней от стел с руническими надписями на развалинах Хара-Балгасуна на берегу реки Орхона.
7. Стела, поставленная в честь Яклагар-хана в местности Суджи на северном берегу реки Селенга (от горы Намнан на запад).
8. Стела, поставленная в честь Моюнчур-хана в урочище Могойн Шингэ-ус, в бассейне реки Селенга.
9. Стела в местности Кюль-Асгат (Их-Асгат) в бассейне реки Орхон.
10. Стоячий камень с руническими надписями у могилы "Долоодоя" в урочище Хар-ус (около города Улангом).
11. Стела в местности Долоон-мод (на северном берегу реки Хойт-Тэрхи).
12. Стела в урочище Сонгинын Турулж (на юг от города Кобдо).
13. Каменное изваяние с руническими надписями из Чойра (находится в экспонатах Центрального Государственного музея в Улан-Батор).
14. Постамент памятника, поставленного в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.
15. Новооткрытые обломки от стелы, поставленной в честь Кюль-Тегина в районе Кошо-Цайдама.

б) Надписи на скалах

16. Надписи на скале г.Гурвалжин-Уул (в районе реки Хар-бухын гол)
17. Надписи на скале в урочище Хадаасангийн Бутуугийн бууц (в среднем течении реки Хар-бухын гола).
18. Надписи на скалах в местности Байшин-узуур (на юго-восточном направлении, надалеко, на северной стороне от автотракта Улан-Батор-Кобдо).
19. Надписи на отдельной скале Тайхар-Чулуу на южном берегу реки Хойт Тамир.
20. Надписи на скале Цохно в поди Бор-бургаасны ама (в районе Цэнхэрмандал).
21. Надписи на скале Рашаан- хада горы Биндэр (в районе реки Онона).
22. Надписи на скале ушелья реки Цагаан гола. (Наран сомон Гоби Алтайского аймака).

в) Надписи на отдельных вещах

23. Надписи на шкатулках, обнаруженных при раскопках в могиле Тоньюкука в урочище Налайхи.
24. Надписи на камешке, привязанном на конце шнура от повязки старой книги << Гэснэг-хааны үлгэр>> (находится в Гос.библиотеке в Улан-Батор).
25. Надписи на бронзовой печати "Кутлуг-хана" (находится в Краеведческом музее Дунд-Гобийского аймака).
26. Надписи на бронзовой монете (находится в археологической лаборатории Института Истории АН. МНР).

⁴⁸⁹ Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Studia Museologica, Tom.I, fasc.1-8, Улаанбаатар, 1968, 11 дүгээр тал; Академич Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Эрдэм шинжилгээний өгүүллүүд (эмхитгэл) II, Улаанбаатар, 2001, 20-27 дугаар тал.

Б.Ринчен академичийн бүртгэл⁴⁹⁰

1. Тайхир чулууны түрэг бичээс
 2. Хангидайн хадны бичээс
 3. Гурвалжин уулын түрэг бичээс
 4. Ар Ханангийн өвөлжөөний түрэг бичээс
 5. Байшин үзүүрийн их бичээс
 6. Байшин үзүүрийн бага бичээс
 7. Жанжин Чойрын бичээс
 8. Кюльтегийн хөшөөний суурь, мэлхий чулууны солгой бөөрцөг дээрх түрэг бичээс
 9. Завхан Тэс сумын нутагт байгаа түрэг бичээс
 10. Тоньюкүкийн тахилгын сүмийн шавасны түрэг бичээс
 11. Улаангомьн хиргисийн түрэг бичээс
 12. Хөл Асгатын түрэг бичээс
 13. Сэврэй сумын зүүн талд байгаа түрэг бичээстэй чулуу
 14. Өвөр дөрөлжийн худгийн ард байгаа чулууны түрэг бичээс
 15. Биндэрийн рашааны хадан дээрх түрэг бичээс
 16. Тэвш ууланд байгаа түрэг бичээс
 17. Цэнхэр-мандалын Бургастайн амны бичигт цохионы түрэг бичээс
 18. Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтагийн оосрын чулуун тээгний түрэг бичээс
 19. Онгийн түрэг бичээс
 20. Тоньюкүкийн гэрэлт хөшөө
 21. Кюльтегин ноёны хөшөөний бичээс
 22. Билгэ хааны хөшөөний бичээс
 23. Байбалагийн хөшөөний түрэг бичээс
- Номод оруулсан дэс дарааллаар, бичигдсэн байдлаар нь сийрүүлэв.

М.Шинэхүү гуайн бүртгэл⁴⁹¹

Түүний “Орхон бичгийн атлас”-т оруулахаар төлөвлөсөн дурсгалын нэрсийн жагсаалтыг толилуулбал,

1. Хөшөө цайдам дахь Бильгэ хаганы дурсгал
2. Хөшөө цайдам дахь Кюльтегин ноёны дурсгал
3. Баянцогтын мэргэн Тоньюкүк жанжины дурсгал
4. Могойн шинэ усны Моюн-чур хаганы дурсгал
5. Их хөшөөтийн Кули-чур хаганы дурсгал
6. Мааньт бүрдийн Кутлуг хаганы дурсгал
7. Тариатын Торян хаганы дурсгал
8. Хөл асгатын Алтан тамган чур хаганы дурсгал
9. Хар балгасуны анхдагч дурсгал
10. Хар балгасуны дэд дурсгал
11. Сүүжийн голын Яглахар хаганы дурсгал
12. Хойт Тамирын Тайхар чулууны бичээс
13. Бөхмөрөний Долоодойн хиргисүүрийн бичээс
14. Арханангийн түрэг бичээс
15. Жүргэрийн цагаан толгойн түрэг бичээс
16. Сэврэй түрэг бичээс
17. Чойрын түрэг бичээс
18. Хангидайн хадны түрэг бичээс
19. Зүрийн овооны түрэг бичээс
20. Бор бургастайн түрэг бичээс
21. Хар аарагийн түрэг бичээс
22. Ямаан усны түрэг бичээс

⁴⁹⁰ Rintchen, Les dessins photographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. I, Улаанбаатар (Oulanbator), 1968.

⁴⁹¹ М.Шинэхүү, гар бичмэл, -ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.

23. Гурвалжин уулын түрэг бичээс
24. Тэвшийн хадны түрэг бичээс
25. Өвөрдөрөлжийн түрэг бичээс
26. Хутуг уулын түрэг бичээс
27. Юлтын түрэг бичээс
28. Баябаликийн түрэг бичээс
29. Кюльтегиний мэлхийн бөөрцөгний бичээс
30. Торян хаганы мэлхийн бөөрцөгийн түрэг бичээс
31. Тоньюкукийн тахилганы сүмийн шавасны бичиг
32. Дундговь аймгийн орон нутгийг судлах музейд буй хүрэл тамганы түрэг бичээс
33. Номын сангийн нэгэн судрын баринтагны чулуун тээгний түрэг бичээс
34. Рашаан хадны бичээс?
35. Лабораторид буй хүрэл зоосны түрэг бичээс
36. Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс? /Хар бухын гол?/

Бид уг эхийг үсэг үггүй хуулсан тул алдаа мадагтай буруу бичсэн гэх зүйл үгүй. Олон жил өнгөрсөн тул зарим нэгэн дурсгалын нэр арай өөрөөр бичигдсэнийг тоочвол,

1. Мааньт бүрдийн Кутлуг хаганы дурсгал → Онгийн бичээс
2. Тариатын Торян хаганы дурсгал → манай судлаачид “Тариат бичээс” хэмээн нэрийдэх авч харь судлаач нар “Тэрхийн бичээс” гэж нэрлэсэн байх
3. Хөл асгатын Алтан тамган чур хаганы дурсгал → Хөл асгатын бичээс, Алтан тамган тарханы бичээс гэж хоёр өөрөөр нэрлэж бичээсэр буй
4. Сүүжийн голын Яглахар хаганы дурсгал → Сүүжийн бичээс
5. Хойт Тамирын Тайхар чулууны бичээс → Монголд Тайхар чулуу гэж алдаршсан хэдий ч гадаадад Хойт Тамирын дурсгал нэрээр мэдмүй
6. Бөхмөрөн Долоодойн хиргисүүрийн бичээс → Долоогойдойн бичээс
7. Жүргэрийн цагаан толгойн түрэг бичээс → Дарвийн түрэг бичээс
8. Бор бургастайн түрэг бичээс → Цэнхэрмандалын түрэг бичээс
9. Хар аарагийн түрэг бичээс → Бигэрийн түрэг бичээс
10. Ямаан усны түрэг бичээс → Ханаан хадны түрэг бичээс
11. Кюльтегиний мэлхийн бөөрцгийн бичээс → Колтигинд зориулан босгосон гэрэлт хөшөөний суурь мэлхий чулууны бичээс
12. Торян хаганы мэлхийн бөөрцгийн түрэг бичээс → Тариатын гэрэлт хөшөөний мэлхий чулууны бичээс

Л.Болд гуайн бүртгэл⁴⁹²

1. Арханангийн түрэг бичээс
2. Бигэрийн түрэг бичээс
3. Бугатын бичээс
4. Гурвалжин уулын түрэг бичээс
5. Даривын эртний түрэг бичээс
6. Долоодойн түрэг бичээс
7. Зоосон дээрх түрэг бичээс
8. Их Хануй нуурын түрэг бичээс
9. Күли-чурт зориулсан гэрэлт хөшөөний түрэг бичээс
10. Күли-тегинд зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс
11. Күли-тегиний мэлхий чулууны түрэг бичээс
12. Могилан (Билгэ) хаанд зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс
13. Мокон-чур хагаанд зориулсан гэрэлт хөшөөний түрэг бичээс
(мөн Сэлэнгийн чулуу ч гэдэг)
14. Мутрын тэмдэг дээрх эртний түрэг бичээс
15. Номын баринтгийн тээг дээрх түрэг бичээс
16. Өвөрдөрөлжийн түрэг бичээс
17. Онгийн голын түрэг бичээс
18. Рашаан хадны түрэг бичээс
19. Сүүжийн түрэг бичээс
20. Сэрвэйн түрэг бичээс
21. Тайхар чулууны түрэг бичээс (мөн Хойт Тамирын түрэг бичээс ч гэдэг)

⁴⁹² Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1983, №3, 65-87 дугаар тал.

22. Тэрхийн түрэг бичээс (мөн Тариатын түрэг бичээс ч гэдэг)
23. Тоньюкут зориулан босгосон гэрэлт хөшөөний түрэг бичээс (Тоньюкут I)
24. Тоньюкут II
25. Төмөр цоргын түрэг бичээс
26. Тэвшийн түрэг бичээс I
27. Тэвшийн түрэг бичээс II
28. Тэсийн түрэг бичээс I
29. Тэсийн түрэг бичээс II
30. Ханан хадны түрэг бичээс
31. Хангидийн хадны түрэг бичээс
32. Хар балгасны түрэг I бичээс
33. Хар Балгасны түрэг II бичээс
34. Хар Цагаан усны түрэг бичээс
35. Хөл асгатын түрэг бичээс
36. Хутаг уулын түрэг бичээс
37. Цахирын эртний түрэг бичээс
38. Цэнхэр мандалын түрэг бичээс
39. Чагтан дээрх түрэг бичээс
40. Чойрын түрэг бичээс

Д.Д.Васильевын бүртгэл⁴⁹³

Түрэг судлаач Д.Д.Васильевын 1976, 1978 онуудад хэвлүүлсэн өгүүлэлдээ монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалыг тоочсон байх бөгөөд тэрээр тухайн үед лавтай мэдэгдэж олоод байсан 33 бичээсийг нэрлэжээ.

О.Ф.Серткаягийн бүртгэл⁴⁹⁴

О.Ф.Серткаяга Монгол улс дахь руни бичгийн дурсгалтай холбогдох археологи, хэлний судалгааны тоймыг 1982, 1984 онуудад тус тус хэвлүүлжээ. Тэрээр нийтдээ 33 бичээсийг судалсан судалгааны тойм, номзүйг хавсаргасан байна.

О.Ф.Серткаягийн бүртгэл (1996)⁴⁹⁵

Göktürk devri (550-745) yazitlari

Хөхтүрэгийн үеийн (550-745) бичээсүүд

- | | |
|---|--|
| 1. Bugut Yaziti | – Бугатын бичээс |
| 1. Çoyr yaziti: 6 satir | – Чойрын бичээс: 6 мөр |
| 2. Ongin yaziti: 19 satir | – Онгийн бичээс: 19 мөр |
| 3. Köl-İç-Çor (İhe-Höşötü) yaziti: 29 satir | – Көл Ич Чорын (Их Хөшотү) бичээс: 29 мөр |
| 4. Köl Tudun inisi Altun Tamgan Tarkan (İhe Aşete) yaziti: 10 satir | – Көл Тудуны дүү Алтан Тамган Таркан /Их Ашете/ бичээс: 10 мөр |
| 5. Köl Tigin (Orhon-I) yaziti: 71 satir | – Көл Тигиний (Орхон-I) бичээс: 71 мөр |
| 6. Bilge Kağan (Orhon-II) yaziti: 79 satir | – Билгэ Хааны (Орхон-II) бичээс: 79 мөр |
| 7. Tonyukuk yazitlari: İki tařta 62 satir | – Тоньюкукийн бичээсүүд: Хоёр чулуунаа 62 мөр |
| 8. Ulug Hanoy Gölü (İhe Hanuin Nur) yaziti: 6 satir | – Улуг Ханой Гөлийн (Ихэ Хануйн Нур) бичээс: 6 мөр |
| 9. Hangiday yaziti: 4 satir | – Хангидийн бичээс: 4 мөр |

Uygur devri (745-840) yazitlari

⁴⁹³ Д.Д.Васильев, Памятники тюркской рунической письменности Азиатского ареала, I, -Советская Тюркология, Москва, 1976, №1, стр.71-81; Д.Д.Васильев, Памятники тюркской рунической письменности Азиатского ареала, II, -Советская Тюркология, Москва, 1978, №5, стр.92-95.

⁴⁹⁴ O.F.Sertkaya, Köl Tigin'in kitâbesinin dikilmesinin 1250. yıl dönümü dolayısı ile Moğolistan Halk Cumhuriyetindeki Köktürk harfli metinler üzerinde yapılan arkeolojik ve filolojik çalışmalara toplu bir bakış, -Türk Kültürü, XXI/234, Ankara, 1982, s. 747(17)-756 (32); O.F.Sertkaya, Köl Tigin'in ölümlünün 1250. yıl dönümü dolayısı ile Moğolistan Halk Cumhuriyetindeki Köktürk harfli metinler üzerinde yapılan arkeolojik ve filolojik çalışmalara toplu bir bakış, -Belleten, Türk Tarih Kurumu, XLVII/185 (Ocak 1983), Ankara, 1984, s. 67-85; O.F.Sertkaya, -Göktürk Tarihinin Meseleleri, Türk Kültürü Araştırma Enstitüsü, yayınları: 131, Seri:IV, Sayı: A.40, Ankara, 1995, s.313-334.

⁴⁹⁵ O.F.Sertkaya, Göktürk yazitlari, -ORKUN, Mart, 1996, 1.say, s.24-25.

Уйгурын үеийн (745-840) бичээсүүд

1. Tes yazıtı: 22 satır – Тэсийн бичээс: 22 мөр
2. Terh (Taryat) yazıtı: 30 satır – Тэрх (Тариат)-ийн бичээс: 30 мөр
3. Bayan Çor veya Moyun Çor (Şine-Usu) yazıtı: 55 satır - Баян Чор буюу Моюн Чор(Шинэ- Ус)-ын бичээс: 55 мөр
4. Hoytu-Tamir yazıtları:10 ayrı yazıt – Хойт-Тамирын бичээсүүд: 10 хэсэг бичээс
5. Kara Balgasun (Orhon-III) yazıtı: 6 satır –Кара Балгасун (Орхон- III)-ы бичээс: 6 мөр
6. Üç köşe (Gurvaljin) yazıtı:1 satır – Үч хөше (Гурвалжин)-гийн бичээс: 1 мөр
7. Somon-Tes yazıtı: 1 satır – Сомон-Тэсийн бичээс: 1 мөр

Kırgız devri (745-840) yazıtları

Киргизийн үеийн (745-840) бичээсүүд

1. Bel (Suci) yazıtı:11 satır – Бел (Сүжи)-ийн бичээс: 11 мөр

Tarihi ve devresi belli olmayan yazıtlar

Түүх, он цаг нь тодорхойгүй бичээсүүд

1. Aru Han yazıtı: 3 satır – Ару Ханын бичээс: 3 мөр
2. Ak-Baş Dağı (Çagan-Tolgoı-I) yazıtı:1 satır – Ак-Баш уул(Чаган-Толгой-I)-ын бичээс
3. Ak-Baş Dağı (Çagan-Tolgoı-II) yazıtı:1satır -Ак-Баш уул (Чаган-Толгой-II)-ын бичээс
4. Öbör-Dörölji yazıtı: 1 satır – Өвөр Дөрөлжийн бичээс: 1 мөр
5. Hentey-I yazıtı: 2 satır –Хэнтий бичээс I: 2 мөр
6. Arts Bogdo (Arka Bogdo, Tövş) yazıtı:1 satır- Арц Богдо (Ар Богдо, Төвш)-ийн бичээс: 1 мөр
7. Beger yazıtı:3-4 yazıtta 4 veya 5 satır – Бэгерийн бичээс: 3-4 бичээсээс 4-5 мөр
8. Kutug-Ula yazıtı: 4 satır – Кутуг –Ула-ийн бичээс: 4 мөр
9. Keçinin Suyu (Yamani-us) yazıtı: 2 satır – Кечин Суюу (Яманы-ус)-ны бичээс: 2 мөр
10. Hentey-II yazıtı: 1 satır – Хэнтий II бичээс: 1 мөр
11. Kutlug yazılı mühür yüzük yazıtı:1 kelime - Кутлуг бичээст тамганы бичээс: 1 үг
12. Gökürk harfli para yazıtı: 1 satır: -Хөхтүрэг үсэгтэй зоосны бичээс: 1 мөр
13. Öruk (İgde) yazıtı: 4 satır –Өрүк (Игдэ)-ийн бичээс: 4 мөр
14. Tömör-Tsorgo yazıtı: 1 satır – Төмөр-Цоргийн бичээс: 1 мөр
15. Tsahir yazıtı:.....satır –Цахирын бичээс:мөр
16. Aчит Nur (Acı Gö1) yazıtı: 1 satır -Ачит Нур (Ажы Гөл)-ын бичээс: 1 мөр
17. Aчит Nur (Acı Gö1) yazıtı: 1 satır -Ачит Нур (Ажы Гөл)-ын бичээс: 1 мөр
18. Arts-Bogdo (Tövş) yazıtı: 1 satır -Арц-Богдо (Төвш)-ын бичээс: 1 мөр
19. Arts-Bogdo (Tövş) yazıtı: 3 satır -Арц-Богдо (Төвш)-ын бичээс: 3 мөр
20. Gurvan-Mandal yazıtı I: 2 satır -Гурван-Мандалын бичээс: 2 мөр
21. Gurvan-Mandal yazıtı II: 2 satır -Гурван-Мандалын бичээс: 2 мөр
22. Gurvan-Mandal yazıtı III: 3 satır -Гурван-Мандалын бичээс: 3 мөр

İsimleri bilinip henüz yayımları yapılmayan metinler

Нэрс мэдэгдэж буй ч хэвлэгдэж нийтлэгдээгүй дурсгалууд

1. Yazıt parçası yazıtı: 3 satır –Бичигт хэлтэрхийн /хугархайны/ бичээс: 3 мөр
2. Hotol-us (Tepe suyu) yazıtı: 1 satır - Хотол- ус (Тепе суюу)-ны бичээс: 1 мөр
3. Nogon-Tolgoı yazıtı: 2 satır – Ногон- Толгойн бичээс: 2 мөр
4. Deel-uul yazıtı: 2 satır – Дээл-уулын бичээс: 2 мөр
5. Hatuv-su yazıtı:.....satır –Хатув-сугийн бичээс.....мөр
6. Hara-Mangday (Kara alın) yazıtı: 1 satır- Хара-Мангдай (Кара Алын)-н бичээс: 1 мөр
7. Olon-Nur (Çok Gö1) yazıtı: 1 satır – Олон-Нур (Чок Гөл)-ын бичээс: 1 мөр
8. Dellun Somon (Ortalık) yazıtı: 1 satır -Дэллүн Сомон (Товийн)-ын бичээс: 1 мөр

Дээр дурдсан бүртгэл нь тухайн цаг үедээ Монгол нутгаас олдсон руни бичгийн талаарх мэдээг эрдэмтэн судлаачид хийгээд олон нийтэд хүргэж байснаараа ихээхэн ач холбогдолтой юм. Гэвч тэр цагийн байдал болоод бусад шалтгаанаас үүдэн зарим нэг учир дутагдал буйг тэмдэглэе.

Б.Ринчен академичийн хэвлүүлсэн жагсаалтад буй “Байбалагийн хөшөөний бичээс”-ийг уншиж судалсан зүйл үгүй, бас бичигт чулуу ч алга болсон бололтой (Алга болсон дурсгалууд хэсгээс лавлан үзнэ үү). Бичээсүүдийн нэрийн хувьд бага зэрэг зөрүүтэй байгаа ч огт өөр нэрээр нэрлэж тэмдэглэсэн нь үгүй байна.

Б.Ринчен академичийн мэдээллийн мөрөөр Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс” судлалын хэсгийнхэн замнаж ажилласан гэдгийг дурдах хэрэгтэй.

М.Шинэхүү гуайн гаргасан жагсаалт харьцангуй үнэн зөв, бодит эх сурвалжид тулгуурласан хэмээн үзэж байна. Тэрээр “Орхон бичгийн атлас” зохиохоор төлөвлөж монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын нэрсийн жагсаалт гаргахдаа тухайн үеийн Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс” судлалын хэсгийн олон жилийн ажлын тайлан, эх хэрэглэгдэхүүнд тулгуурласнаас гадна өөрийн биеэр очиж үзсэн нь лавтай. Эл жагсаалтад буй “Юлтын түрэг бичээс”, “Битүүгийн өвлөжөөний түрэг бичээс? (Хар бухын гол)” гэх хоёр дурсгалын талаар ямар ч мэдээлэл алга. Уг бичээс хаана, ямар аймаг сумын нутагт байдаг талаар ч мэдэх зүйл үгүй (Нэр тодорхой ч судлагдаагүй дурсгал хэсгээс лавлан үзнэ үү).

Л.Болд гуайн бүртгэлд зарим нэгэн мадагтай мэдээлэл оржээ. Жишээ нь, “Тэсийн түрэг бичээс II, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Хужирт бригадын нутагт буй Ногоон толгой гэдэг газарт байсан, эдүгээ ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологи этнографийн лабораторид буй” гэжээ. Эшлэл зүүлтээс үзвэл энэ нь Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хужирт бригадын нутаг Авдрантын хөндий гэдэг газраас олдсон Тэсийн бичээс мөн байна.

“Тэвийн түрэг бичээс II, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэви ууланд буй түрэг бичээс, Окладников А.П, Петроглифы центральной Азии Хобд-сомон (Гора Тэви) Л.,1980, стр.52, табл.116” гэж тэмдэглэсэн, “Хар цагаан усны түрэг бичээс, 1982 онд Увс аймгийн Баруун турууны САА-н нутаг Хар цагаан ус гэдэг газарт буй, Цэвээндорж Д, Монголын төмөр, хүрэл зэвсгийг судлах шинжлэгээний ангийн тайлан, УБ.,1980 (гар бичмэл), БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн фонд” хэмээн дурдагдсан эл хоёр бичээсийн талаарх өгүүлсэн тодорхой байрлал, судлагдсан эсэх талаар бидэнд ямар ч мэдээлэл байхгүй байна.

Туркийн эрдэмтэн О.Ф.Серткаяа “Köktürk Yazitlari /Хөхтүрөгийн бичээсүүд” хэмээх нийтлэлдээ монгол нутаг дахь руни бичгийн дурсгалыг жагсаасныг үгчлэн орчуулж дурсгалын нэрсийг кирилл үсгээр үсэгчилэн буулгав. Уг жагсаалтад зарим газар, дурсгалын нэрийг нилээд алдаа мадагтай бичсэн нь учир үл мэдэх нэгэн ташааран будилахад хүргэхээр байна.

Мэдээж хэрэг, хэрхэн яаж бичих, нэрлэх нь зохиогчийн хэрэг мөн боловч газар ус, дурсгал бичээсийн нэрийг дур мэдэн өөрчлөх, орчуулан хэрэглэх нь ташаарал, андуур арвитгаж шинжлэх ухаанд багагүй маргаан, төөрөгдөл үүсгэдгийг анхаарах хэрэгтэй мэт санагдана.

Хэдийбээр зарим нэрийг шаардлагын дагуу орчуулан хэрэглэх нь буй боловч газар усны нэрийг тухайн нутгийнхны эртнээс нааш нэрлэсээр ирсэн уламжлалыг даган баримтладаг нь эрт эдүгээгийн соёл ёс төдийгүй шинжлэх ухаанд ч бүртгэн тэмдэглэхдээ энэ зарчмыг баримталдаг бөлгөө.

1.6.1. Дахин нягтлан судлууштай дурсгалууд

Монголын руни бичгийн дурсгалуудаас, нэн ялангуяа бага бичээсийн нилээд дурсгалыг дахин нягтлан судлууштай байна. Судлахад бэрхтэй, судалгаа нь маргаантай бичээсийн заримыг XIX зууны үед, тодруулбал В.В.Радловын үед судалгааны эргэлтэд орсон ч өнөө хүртэл дахин нягталж үзээгүй, шүүн шинжлэх эрдэмтдийг хүлээсээр байна.

Нэгэнт шүүн нягталсан чамбай бүтээл үгүй тул шинэ тутам олон ном, бүтээл гарч байгаа ч өмнөх судалгааг дахин хуулах, даган баримтлах нь түгээмэл болжээ.

Ерөнхийд нь авч үзвэл хэд хэдэн учир шалтгаантай бололтой. Үүнд;

- өмнөх эрдэмтдийн судалгааг сайн болсон гэж үзэж даган баримтлах,
- газар усны холоос ирж судлах боломжгүй учир аргагүйн эрхэнд дам хуулбарт шүтэж дагах,
- нар салхи, цас бороо зэрэг байгалийн сүйтгэлд автсанаас уг бичээсийг дахин уншиж судалсан ч өмнөх судалгааг давах хангалттай баримт нуталгаатай шинэлэг ажил болоогүй,
- эх буюу уг дурсгал алга болсон зэрэгтэй шууд холбоотой юм.

Нэг талаас, дээр өгүүлсэн зүйл үнэний хувьтай ч яг газар дээр нь уул бичиг, бичээсийг уншиж судлахаар зорин очигсад, дорвитой судалгаа хийгсэд цөөн аж. Дахин нягтлан судлууштай дурсгал олон байгаа ч энэ удаад зөвхөн Монголын төв нутгаар буй зарим бага бичгийн дурсгалыг жишээ болгон өгүүлсү.

Үүнд,

- Хөл асгатын бичээс
- Тайхар чулууны бичээс
- Чойрын бичээс
- Зөвхөн нэг судлаач судалсан бүх бичээс орно.

Үсэг бичгийн, судалгааны зөрүүтэй санал бүхүй эдгээр дурсгалуудаас гадна орчуулгын ташаарал, мэдгийг арилган дахин нягтлан орчуулуштай цөөнгүй бичээс буй.

Бичээсийг уншиж галиглах нэг хэрэг боловч түүнийг зөв оновчтой орчуулж, тайлбарлах нь зарим тохиолдолд уншихаас илүү нарийн нягт, бэрх хэцүү чимхлүүр ажил болой. Үүний учир Монголын руни бичиг, дурсгалтай холбогдох шилдэг судалгааг монгол хэлнээ зөв орчуулах нь дахин нягтлах, судлах ажлын салшгүй нэг хэсэг болохыг манай эрдэмтэд, судлаачид анхаарах буй за.

Хөл Асгатын бичээс

Булган аймгийн Могод сумын нутаг, Түлээ уулын хормойд орших тахилын онгон дурсгалыг эрдэмтэд Их Асгатын бичээс, Хөл Асгатын бичээс хэмээн нилээд ялгаатай нэрлэсээр ирсэн байна. В.Радлов анх судлан үсэг, үгийн галиг хийж герман орчуулгын хамт хэвлүүлсэн байна⁴⁹⁶.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун орчин цагийн турк хэлнээ. В.Радловын уншлага, орчуулгаас хөрвүүлжээ⁴⁹⁷. Хожим С.Е.Малов дахин уншиж судлан орос хэлнээ орчуулжээ⁴⁹⁸.

⁴⁹⁶ W.Radloff, Die Inschrift von Iche-As'chete, -Die alttürkischen inschriften der Mongolei, Dritte Lieferung (Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, die übrigen Denkmäler des Orchon-Beckens und die Denkmäler im Flußgebiete des Jenissei) Neudruck der Ausgabe St.Petersburg, 1895, (Osnabrück, 1987), pp.256-258.

⁴⁹⁷ H.N.Orkun, Ihe Aschete yaziti, -Eski Türk Yazitlari II, İstanbul, 1938, s.122-127. s.313-319.

⁴⁹⁸ С.Е.Малов, Памятники Ихе-Асхете, -Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр. 44-46.

Манай эрдэмтдээс Б.Ринчен академич бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлсэн⁴⁹⁹ ба доктор Н.Сэр-Оджав уул цогцолбор дурсгалын хэмжээ байршил, хүн чулууны хэлбэр хийц зэргийг товч тодорхойлоод бичээсийн хувьд С.Е.Маловын уншлага, орчуулгад ташаарсан зүйл мэр сэр байгааг тэмдэглэж өөрийн саналаа дурджээ⁵⁰⁰.

Доктор Л.Болд Хөл Асгатын бичээсийн талаар эхний бүтээлдээ эрдэмтдийн судалгааг тоймлон дурдаж удаах номдоо бичээст гарах үгийг монгол түрэг хэлний хүрээнд харьцуулан тайлбарласан байна⁵⁰¹.

Тайхар чулууны бичээс

Тайхар чулууны руни бичээсийг В.В.Радловоор удирдуулсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Д.А.Клеменц анх гар хуулбар хийж тэмдэглэснээр "Хойт Тамирын бичээс" хэмээн нэршиж эрдэм шинжилгээний эргэлтэд оржээ. Тэдгээр бэхэн бичээсийг анх В.В.Радлов уншиж судалсан⁵⁰² бөгөөд түүний уншлага нийтлүүлсэн эх хуулбар хийгээд уншлага орчуулгыг Х.Н.Орхун орчин цагийн түрэг хэлнээ хөрвүүлжээ⁵⁰³.

С.Е.Малов эл бичээсийг дахин нягтлаад орос хэлнээ орчуулжээ⁵⁰⁴.

П.Аалто нарын "Монгол дахь эртний түрэгийн хөшөө дурсгалын эх хэрэглэгдэхүүн"⁵⁰⁵ –д Тайхар чулууны бичээсийн талаар дурдсан байдаг. Академич Б.Ринчен бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлэсэн ажээ⁵⁰⁶. Нэрт түүхч Х.Пэрлээ гуай "Тайхар чулуу" хэмээх тусгай товхимолдоо руни бичээсийн өмнөх хуулбаруудаас зөрүүтэй байгаа хэд хэдэн хуулбарыг хэвлүүлсэн байна⁵⁰⁷.

Д.Д.Васильев "Хойт Тамирын дурсгалын бичээсийн онцлогууд" өгүүлэлдээ бэхэн бичээсийн эл дурсгалын үсэгзүйн онцлогийн талаар тухайлан өгүүлсэн байна⁵⁰⁸. Туркийн эрдэмтэн проф. О.Ф.Серткайа түрэг судлаач С.Харжаубай нар "Hoytu Tamir (Moğolistan)dan yeni yazitlar (ön neşir)" хэмээх өгүүлэлдээ нийтдээ 21 бичээсийн үсэг, үгийн галиг, орчин цагийн турк хэлнээ орчуулсан нь Тайхар чулууны бичээсийн талаар нийтэлсэн хамгийн сүүлийн судалгаа болох юм⁵⁰⁹.

Тайхар чулууны эртний бичээсүүд он цагийн уртад нар салхи, цас борооны усанд идэгдэж муудснаас гадна ухвар мөчид хүмүүсийн сүйтгэлд ихээхэн өртөж судлахад нэн бэрхтэй болжээ. Тиймээс ч Тайхар чулууны руни бичээсийн талаар харилцан адилгүй санал

⁴⁹⁹ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, --Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. I, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp. 34-36.

⁵⁰⁰ Н.Сэр-Оджав, Их Асгатын хошоот булш, -ШУА-ийн мэдээ №3, Улаанбаатар, 1965, 91-95 дугаар тал; Н.Сэр-Оджав, Эртний түрэгүүд (YI-YIII зуун), Улаанбаатар, 1970, 43-46 дугаар тал; Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх, Улаанбаатар, 1977, 141 дүгээр тал; Н.Сэр-Оджав, Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар, 2003, 239-243 дугаар тал.

⁵⁰¹ Л.Болд, Хөл Асгатын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 129-134 дүгээр тал; Л.Болд, Хөл Асгатын Орхон бичээсийг уншсан тэмдэглэл, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 67-85 дугаар тал.

⁵⁰² W.Radloff, Die Inschriften am Choito-Tamir, -Die alttürkischen inschriften der Mongolei, Dritte Lieferung (Verbesserungen, Zusätze und Bemerkungen zu den Denkmälern von Koscho-Zaidam, die übrigen Denkmäler des Orchon-Beckens und die Denkmäler im Flußgebiete des Jenissei) Neudruck der Ausgabe St.Petersburg, 1895, (Osnabrück, 1987), pp.260-268.

⁵⁰³ H.N.Orkun, Hoytu-Tamir yazitlari, -Eski Türk Yazitlari II, Istanbul, 1938, s.107-117. s.299-309.

⁵⁰⁴ С.Е.Малов, Памятники Хойто-Тамира, - С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва-Ленинград, 1959, стр. 46-54.

⁵⁰⁵ P.Aalto, G.J.Ramstedt, J.G. Granö, Materialien zu den alttürkischen Inschriften der Mongolei, - Journal de la Société Finno- Ougrienne, LX/7, Helsinki, 1958, pp.3-91.

⁵⁰⁶ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, --Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. I, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36.

⁵⁰⁷ Х.Пэрлээ, Тайхар чулуу, -Studia Archaeologica, Tom. I, fasc. IV, Улаанбаатар, 1960, 1-26 дүгээр тал.

⁵⁰⁸ Д.Д.Васильев, Графические особенности памятников Хойто-Тамира, - Вопросы восточного литературоведения и текстологии, Москва, 1975, стр.100-109.

⁵⁰⁹ O.F. Sertkaya, S.Harcaybay, Hoytu Tamir (Moğolistan)dan yeni yazitlar (ön neşir), -Türk Dili Araştırmaları Yıllığı Belleten 2000 , Ankara, 2001, s.313-346.

гарч байгаа юм. Бидний судалгаагаар 30 орчим руни бичээс байгааг олж тогтоосон бөгөөд удахгүй хэвлэн нийтлэх гэж байна⁵¹⁰.

Чойрын бичээс

Дорноговь аймгийн Чойр өртөөнөөс баруун тийш 15 орчим км-т орших Бага Сансар уулаа байсан нэгэн хиргисүүрт булш, булшны дараас овоолгот чулуун дотор байсан хүн чулууны цээж, өвөрт сийлсэн бичээсийг судалгааны ном зохиолд “Чойрын бичээс” хэмээн нэрлэн тэмдэглэсээр иржээ. Улаан хүрэн өнгөтэй хүрмэн чулууг засаж янзлан хүний зөвхөн нүүрэн хэсгийг маш тодорхой, бодит байдлаар нилээд ур хийцтэй дүрсэлсэн байх бөгөөд харин бичээсийг эмх журам, дараалал муутай сийлсэн байна. Нутгийн ард “Жанжин Чойрын хөшөө” гэж нэрлэж байсан хэмээнэ. Манай монголчууд Дэмчигбурмын хөшөө (Өвөрхангай аймгийн Баруун-Баян Улаан сумын нутаг, Хутаг уулын Зосын Сайр хэмээх газар буй), Даян баатрын хөшөө (Баян-Өлгий аймгийн Сэгсай сумын нутаг, Даян нуурын хөвөөнд буй), Далха Вандад (Булган аймаг, Ингэтолгой сангийн аж ахуйн ойр буй), Гэлэн хөшөө (Хэнтий аймгийн Өндөрхаан хотын нисэх онгоцны буудлаас баруун урагш 3 км орчимд буй) гэх мэтээр хүн чулуунд нэр өгөх нь элбэг бөлгөө. Эртний түүх домог, цадиг намтар, түүгээр дамжин уламжлагдсан аман түүхийн гэрч нь хөшөө чулуу байдаг бөгөөд өвөг дээдсийн тэдэнд хайрласан нэрс түүнтэй салшгүй холбоотой төдийгүй бас нарийн ухааж ойлгож чадвал зарим судлаачийн дэмий хоосон таамаглалаас ч илүү их үнэ цэнэтэйг өгүүлэх юун.

Чойр нэр бидний санахад ᠴᠣᠶᠢᠷ chos- ном, ᠢᠷᠢ gi -уул гэсэн хоёр үг хоршиж “номтой уул, бичигтэй уул” хэмээх нэр бүтээсэн бололтой. Хуучин цагт, үсэг, бичиг бүрийг ялгалгүй ном хэмээн дээдлэн хүндэтгэж байсны илрэл буй за.

Энэхүү бичигт хүн чулууг В.А.Обручев 1895 онд анх үзэж тэмдэглэсэн ажээ⁵¹¹. Хожим 1928 оны 9-р сард Эрдэмбаяр хиргисүүр, хөшөөний анхны байрлал зэргийг тодорхой харуулсан гэрэл зураг авч харин утасны хорооны Цндсүрэн гэх нэгэн Улаанбаатар хотод тэвэрлэн хүргэж иржээ.

Ж.Цэвээн гуай хүсэлт гаргаж улмаар түүний заавраар энэ ажлыг гүйцэтгэсэн гэдэг. Судар бичгийн хүрээлэнгээс уг дурсгал, бичээсийн 4 ширхэг гэрэл зураг, хүн чулуун дээрх бичээсийн гар хуулбар зэргийг 1928 онд ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академид илгээсэнд⁵¹² анх А.Н.Самойлович гардан авсан байна. Тэрээр өөрөө уншиж судалсан эсэх нь тодорхойгүй, юутай ч С.Е.Маловт тэр захидал бичээсийн тухай мэдээллийг дамжуулан өгсөн гэх аман мэдээ л үлджээ.

Ж.Цэвээн гуайгаас 1933 оны 5-р сард С.Е.Маловт Чойрын бичээсийн гэрэл зураг болон гар хуулбар дахин ирсэнд “нөхрийн сайн үйлст энэ тусыг бодож” 1936 онд урьдчилсан уншлага судалгаагаа хэвлүүлсэн⁵¹³ ажээ.

Чойрын бичээсийг нүдээр үзэж судалсны хувьд С.Г. Кляшторный⁵¹⁴ тухайлсан эрдэм шинжилгээний өгүүлүүд нийтлүүлсэн байна.

Тэрээр бичээсийг;

1. ... ilig yty säbin baryu

⁵¹⁰ Бичээс судлалын дадлагын тайлан, -Түрэг судлалын тэнхмийн гар бичмэлийн сан, 2004.

⁵¹¹ В.А.Обручев, Список древних могил, замеченных на пути из Кяхты в Ургу и Калган, -Сборник трудов Орхонской экспедиции, II, СПб., 1895, стр.76.

⁵¹² Архив. Судар бичгийн хүрээлэнгээс гадаадад явуулсан захидал.

⁵¹³ С.Е.Малов, Новые памятники с турецкими рунами, -Язык и мышление, Том. VI-XII, Ленинград, 1936, стр. 251-259.

⁵¹⁴ С.Г.Кляшторный, Руническая надпись на каменном изваянии Из Чойра, - Памятники письменности и проблемы истории и культуры народов Востока, Ленинград, 1969, стр.46-49; С.Г.Кляшторный, Руническая надпись из Восточной Гоби, -Studia Turcica, Budapest, 1971, pp.249-258; С.Г.Кляшторный, Древнетюркская надпись на каменном изваянии из Чойрэна, - Страны и народы Востока, Вып.22, Кн.2, Москва, 1980, стр. 90-102.

2. ältäris qayanqa
3. tun bilgä
4. tun jägän irkin
5. jäti qa (aqa?) adyrylmaz tutunuz da
6. toñ [uquq]... [i] tdim yuquçun (?) äb ayul baña... гэж галиглан орос хэлнээ

1. ...государь (меня) послал: "Радуйся и иди!" (он сказал)

2. От Эльтэриш-кагана

3. (вы) Тун-бильгэ,

4. Тун-йеген-иркин,

5. вы, семь родичей (братьев?) смотрите не отделяйтесь же

6. Я, Тонь [юкук], (государство?) привел в порядок (создал).

Ради предсказания (? ради <моего> предвидения? за <мои> советы?) дома и загоны для скота мне... хэмээн орчуулжээ.

С.Г.Кляшторный аругайн орос орчуулгыг доктор Л.Болд монгол хэлнээ

1.улс (намайг) илгээв. үг нь очиж...

2. Елтирис хагаанаас

3. Тун-Билгэ

4. Тун-йегин-иркин

5. долоон ах бүү салтугай

6. Тонькук би...илгээв... (урьдчилан хэлсэн ёсоор) гэр бэлчээрт минь⁵¹⁵ хэмээн буулгажээ.

Эл орчуулгаас гадна доктор Ё.Жанчивын үгчлэн буулгасан бас нэгэн орчуулга буйг сийрүүлбэл;

1. ...хаан (намайг) илгээв: "Хөөрөн баяс, явж од!" (тэр өгүүлэв)

2. Эльтериш хаанаас

3. (Та) Тун-бильгэ,

4. Тун-йеген-иркин,

5. Та нар, долоон төрөл садан (эсвэл нэг овгийнхон Ё.Ж) (ахан дүүс?) харцгаа, бүү салан од!

6. Би, Тонь [юкук], (улсыг?) эмх журамд оруулав (үүсгэн байгуулав). Урьдчилан хэлсэн ёсоор

(? <миний> урьдчилан харсан ёсоор? <миний> зөвлөлгөөнөөр?) гэр ба малын хашаа надад...

Чойрын гэрэлт хөшөөний бичээсийн утга агуулгыг судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд С.Г.Кляшторный уншлага орчуулгад тулгуурлан тайлбарлаж, эшлэсээр ирсэн билээ.

Харин 1998 онд Туркийн эрдэмтэн О.Ф.Серткая эл бичээсийг дахин уншиж судлан турк, герман хэлээр хэвлүүлсэн нь бичээсийг дахин нягтлан судлах шаардлагатайг харуулж байна. Бичээсийг эмх замбараа муутай тойруулан бичсэн нь судалгааг ихээхэн маргаантай болгож байгаа юм. Судалгааг харьцуулан үзээсэй хэмээж С.Ф.Серткая профессорын сэргээсэн руни бичгийн эх, галиг орчуулгыг толилуулья.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;

1. 𐰉𐰺𐰽𐰾 𐰺𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾

2. 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾

3. 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾

4. 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾 𐰽𐰾𐰽𐰾

5. 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾 // (?) 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾

6. 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾 𐰽𐰾

Үгийн галиг;

1. tulku b(i)t(i)d[d](im) irk (a)çu (a)yg(i)l b(a)nga

⁵¹⁵ Л.Болд, Чойрын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 143-145 дугаар тал.

2. (a)d(r)(i)lm(a)z t(a)t b(a)rda /// /// ///
3. tun y(i)g(e)n (i)rk(i)n (i)
4. tun b(i)lge şad
5. ilt(i)r(i)ş k(a)g(a)nka (i)ç(i)k(i)ng üç(ü)nç (a)y y(i)ti ka
6. ögünü sebini baring[(i)z]

Орчин цагийн турк хэлээрхи хөрвүүлгэ;

1. Taş baba üzerine yazdırdım. Fal açarak söyle bana!
2. Birbirinden ayrılmayan yabancı [düşman] olduğu zaman
3. Tun Yiğen İrkin
4. Tun Bilge Şad
5. İltiriş Kağan'a tabi olun (?). Üçünc(ü) ay(i)n yedi(nci) günün)de
6. sevinerek gidin(iz)⁵¹⁶

Бичээсийн герман хэлээрх орчуулга;

1. Zeile: Ich habe (es) auf die Stein-Baba schreiben lassen. Sag mir, indem Du wahrsagst.
2. Zeile: İndem Fremde (Feinde), die zusammenhalten, zugegen sind.
3. Zeile: Tun Yiğen İrkin
4. Zeile: Tun Bilge Schad
5. Zeile: Sei untergeben dem Khagan, İltiriş (?) Am 7. Tag des 3. Monats.
6. Zeile: Gehen Sie fröhlich⁵¹⁷ ийм болой.

О.Ф.Серткааягийн орчуулгыг монгол хэлнээ үгчлэн буулгавал;

1. Хүн чулуун дээр бичүүлэв би. Мэргэлээд надад хэл!
2. бие биенээс үл хагацах харь (дайсан) байх цагт
- 3.Тун Ийген Иркин
4. Тун Билгэ шад
5. Илтириш хаанаа захирагд (а-гтун). Гуравдугаар сарын долоо (дахь өдөр)-т
6. баярлан (баясан) явцгаа (та нар).

Уг бичээсийн хоёрдугаар мөрийг уншсан уншлага, турк, герман орчуулгын аль алийг нь ухаарч ойлгоход бэрхтэй, монгол хэлнээ буулгахад ч төвөгтэйг онцлон хэлье.

Түүрэг судлаач нэрт эрдэмтэд С.Г.Кляшторный, О.Ф.Серткаая нарын хэн нь зөв уншсан, хэн нь юун дээр алдаж оносон зэргийг шинжлэх ухааны үүднээс бодитой үнэлж дүгнэсэн дараа дараагийн судлагаанаас улам тодорхой болох биеэ. Чойрын бичээсийг уншиж судалсан дээрх бүтээлээс гадна бас бусад судалгаа ч буй⁵¹⁸.

⁵¹⁶ Osman Fikri Sertkaya, Göktürk harfli Çoyr Yazıtı, -Orkun, Türkçü Dergi, 5.sayı, Temmuz 1998, s.33-38; Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Çoir, Bahşi Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anlässlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg: İstanbul 1998, pp.349-361.+ 4 pl.

⁵¹⁷ Osman Fikri Sertkaya, Die Runen-Inschrift von Çoir, Bahşi Ögdisi Festschrift für Klaus Röhrborn anlässlich seines 60.Geburtstags, Sonderdruck, Türk Dilleri Araştırmaları Dizisi:21, Freiburg: İstanbul 1998, pp.349-361.+ 4 pl.

⁵¹⁸ Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968; Edward Tryjarski, On the Archaeological Traces of old Turks in Mongolia, - East and West, New Series, 21/1-2, Rome, 1971; E.Tryjarski, Eski Türklerin Moğolistan'daki arkeolojik eserleri üzerine, -Türk Kültürü Araştırmaları, XVI/1-2 (1977-1978), Ankara, s.151-184, s.161; Nejat Diyarbekirli, Orhun'dan geliyorum, - Türk Kültürü, sayı:198-199, yıl:XVII, Nisan-Mayıs 1979, s.382 (62); Erk Yurtsever, Eski Türk yazıtları için bir tavsih ve iki zeyl, -Orkun, Ayhık Türkçü Dergi, Kasım 1988, sayı:9, s.18-20.

1.6.2. Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал

Эрдэмтдийн хэвлүүлсэн руни бичгийн дурсгалын нэрсийн жагсаалт, эрдэм шинжилгээний тайлан, цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээс үзэхэд бичээсийн нэр тодорхой байгаа боловч өнөө хэр уншиж судлаагүй, мэдээллийн мөрөөр дахин шалгаж үзээгүй, аль аймаг, сумын нутагт байдаг нь тодорхой бус дурсгал нилээд хэд байна.

Зарим мэдээллийг бичиг судлаач нар хараахан олж үзээгүй, мэдээллийг олж сонссон нэгэн тэдгээр бичээсийн газар хүрч судлах боломж бололцоо багатай, зорин очивч ганц нэг мөр бичээсийг хэд хичнээн км үргэлжлэх уул, нуруу, хад асга дундаас олж судлах нь амаргүйгээс зарим тохиолдолд ганзага хоосон буцсан нь буй.

Тиймээс монгол нутагт руни бичгийн яг хэдэн дурсгал байгааг баттай, нуталгаатайгаар тодорхой тоогоор хэлэхэд нэн бэрхтэй.

Үүний учир нэр мэдэгдэж буй судлагдаагүй зарим дурсгалын талаар товч өгүүлье.

Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгалуудад одоогийн байдлаар доорхи 9 бичээсийг оруулж байна. Үүнд:

1. Байбалагийн хөшөө
2. Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс? /Хар бухын гол/,
3. Юлтын түрэг бичээс
4. Хөтөл усны бичээс
5. Ногоон толгойн бичээс
6. Цахирын бичээс
7. Далан уулын бичээс
8. Бигэрийн бичигт хадны бичээс
9. Дэлүүн сумын төвийн бичээс

Байбалагийн хөшөөний түрэг бичээс

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын төвөөс баруунш 11 км гаруй, Сэлэнгэ мөрнөөс хойш 2 км орчим зайтай голын хөндий, хойд уулсын хормойн дэвсэц уулзвар болох хуурай тэгш дэнжид Бийбулагийн балгас буюу эртний Байбалык хотын туйр (Газарзүйн байрлал: Хойд өргөргийн 49° 23' 38", зүүн уртрагийн 102° 30' 21", далайн төвшинөөс дээш 1127 м өндөрт) бий⁵¹⁹. Худалдаа арилжаа, шашин соёлын нэгэн төв болж байсан эртний энэ хотыг байгуулсан тухай мэдээ руни бичгийн сурвалжид анх тэмдэглэгдсэн байна⁵²⁰.

Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедтийн “Уйгур улсын хураангуй түүх” (Улсын Үндэсний номын сангийн хэвлэмэл эхэд энэ нэрээр, харин ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт буй гар бичмэлд “Уйгур улсын түүхийн товч” гэсэн нэрээр буй)⁵²¹.

⁵¹⁹ Д.Баяр, Н.Ширайши, Ц.Баттулга, Бийбулагийн балгасыг судалсан хээрийн шинжилгээний хэсгийн тайлан, 1998, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг; Монгол-Япон улсын хамтарсан “Бичээс” төслийн археологийн хэсгийн тайлан, 1997, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

⁵²⁰ G.J.Ramstedt, Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, Mémoires de la Société Finno-Ougrienne Helsinki, 1913-1918, Vol. XXX N 1; Г.И.Рамстедт, Перевод надписи Селенгинского камня, -Труды Троицкосавско-Кяхтинского отделения Императорского Русского географического общества. Вып. I, Санкт-Петербург, 1914; Ц.Баттулга, Орхоны руни бичгийн сонгодог дурсгалд нэр тэмдэглэгдсэн гурван хот, -Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, ХҮШ боть, МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 109-118 дугаар тал.

⁵²¹ G.I. Ramstedt, Uiyür ulus-un teike-yin toböi, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг (монгол бичгээр) Ф.IV, ХН.16,Т.56. 1924; G.I. Ramstedt, Uiyür ulus-un teike-yin toböi, -Улсын төв номын сан (монгол бичгээр) Ф.IV, ХН.16,Т.56. 1924.

д болон хожмын түүхч, археологич нарын судалгааны бүтээлд⁵²² уг хотын талаар нилээд тодорхой дурджээ.

Байбалькийн туйрын газар бичигт хөшөө байсан мэдээ баримтыг анх Б.Ринчен академич толилуулсан⁵²³ билээ.

Доктор Д.Баяр “Уйгурын Байбальк хотын тухай тэмдэглэл”-ийнхээ “Бичигт хөшөөний тухай” хэсэгт “Академич Юншээбүү Ринчен авгай 1968 онд хэвлүүлсэн “Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл” хэмээх нэмдэр руни үсгийн тэмдэгт болон тамгын дүрс бүхий нэгэн хөшөөний бүдэгхэн гэрэл зураг, хуулбарыг нийтэлж “Байбалькийн хөшөөний түрэг бичээс, тамгын зүйл” гэсэн тайлбар бичсэн байна. Түүнчлэн түрэг судлаач С.Г.Кляшторный 1977 онд Пенжикент хотноо зохиогдсон эрдэм шинжилгээний хуралд толилуулсан “Монголын эртний хотууд” илтгэлдээ 1975 онд Байбалькт очиж хайгуул судалгаа хийх үед хэрмийн зарим байгууламжийн хашаан дотор руни бичиг болон тамга бүхий хөшөөд байлаа гэж тэмдэглэсэн нь буй”⁵²⁴ гэж тодорхой өгүүлжээ.

Б.Ринчен академичийн хэвлүүлсэн “Байбалагийн хөшөөний бичээс, тамгын зүйл” хэмээх нилээд тод, 12 үсэг тэмдэгт бүхий хөшөө чулууны гэрэл зураг, бас ганц тамгын зураг хавсаргасан байх бөгөөд хөшөө чулууны гэрэл зураг дээрх бичээсийн зарим үсэг тэмдэгт, гэрэл зургаас дам буулгаж хамт хадсан хуулбарын үсэг тэмдэгтээс зөрүүтэй ажээ. Уг бичээсийг нарийвчлан үзвээс Билгэ хааны тахилын онгоны бичигт зэл чулуу мөн болох нь тодорхой байна. Тухайн үед андууран “Байбалагийн хөшөөний бичээс”-ийн оронд дурдсан зэл чулууны бичээсийн зургийг тавьж ташаарсан бололтой.

Байбальк хотын туйр, одоогийн Бийбулагийн сүмийн газар бичигтэй, ядаж ганц нэг үсэгтэй хөшөө чулуу байхгүй бөгөөд он цагийн нар салхинд үсэг бичиг нь элэрч долорч уанснаас огт мэдэгдэхгүй болсон байж мэднэ.

Доктор Д.Баярын тэмдэглэсэнчлэн “энд нарийвчилсан хайгуул хийхээс өмнө уг хөшөө үрэгдэж алга болсон буюу эсвэл цаашид хаа нэгтэйгээс олдож болохыг үгүйсгэх аргагүй”⁵²⁵ юм.

Юутай ч 1975 онд уг бичигт хөшөө байсныг нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный гуайн мэдээлэл баталж байна. Байбальк хотын туйрын талаар Тошио Хаяши, Норикоки Ширайши, Койчи Мацуда нарын судалгаа буй билээ⁵²⁶.

⁵²² Х. Пэрлээ, Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон, Улаанбаатар, 1961, 51-52 дугаар тал; Х.Пэрлээ, Монголын эртний сөнөсөн хот, суурины түүхийн асуудалд, Улаанбаатар, 1956; С.В. Киселев, Древние города Монголии, -Советская Археология, №2, 1957, стр. 97; Ю.С.Худяков, Памятники уйгурской культуры в Монголии, -Центральная Азия и соседние территории в средние века, Новосибирск, 1990.

⁵²³ Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc.1, Oulanbator, 1968, pp.69.

⁵²⁴ Д.Баяр, Уйгурын Байбальк хотын тухай тэмдэглэл, -Studia Archaeologica, Tom.(I) XXI, fasc. 1-16, Улаанбаатар, 2003, 96 дугаар тал; С.Г. Кляшторный, Древние города Монголии, Древние города, -Материалы к Всесоюзной конференции, Культура Средней Азии и Казахстана в эпоху раннего средневековья (Пенджикент, Октябрь 1977г.) Ленинград, 1977, стр.65.

⁵²⁵ Д.Баяр, Уйгурын Байбальк хотын тухай тэмдэглэл, -Studia Archaeologica, Tom.(I) XXI, fasc. 1-16, Улаанбаатар, 2003, 97 дугаар тал.

⁵²⁶ 林俊雄・白石典之・松田孝一・バイバリク遺蹟 -モンゴル国現存遺蹟 -碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Toshio Hayashi, Noriuki Shiraishi, Site of Bay-Balīq, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp.196-198.

Битүүгийн өвөлжөөний түрэг бичээс

М.Шинэхүү “Битүүгийн өвөлжөөний бичээс (Хар бухын гол?)”⁵²⁷ гэж тэмдэглэсэнээ үзвэл өөрийн биеэр очиж үзээгүй байж магадгүй.

Х.Пэрлээ гуайн “Хадаасангийн Битүүгийн бууц”-ны бичээс⁵²⁸ хэмээнээс дам авсан байж мэднэ.

Энэ бичээс нь Хар бухын голоор баримжаалбал Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт байдаг бололтой. Одоогийн засаг захиргааны хуваариар өөр өөр сумын нутагт харьяалагдаж байгаа хэдий ч 100-150 км-т газар Хангидайн хадны бичээс, Арханангийн бичээс, Гурвалжин уулын бичээс зэрэг уйгурын үед холбогдох хэд хэдэн дурсгал байгаа нь Дашинчилэн сумын нутагт Битүүгийн өвөлжөөний бичээс байх бүрэн үндэслэлтэйг харуулж байна.

Юлтийн түрэг бичээс

Юлт нэртэй газар хаана байх талаар бид асууж сурагласан боловч хараахан тодорхой мэдэж амжсангүй. М.Шинэхүү гуай “Орхон бичгийн атлас”-т⁵²⁹ оруулахаар бичээнийг болоход уг бичээсийг өөрийн нүдээр үзсэн нь мэдээж бөгөөд харин уншиж тайлсан эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл байхгүй байна.

Монгол улсын газар усны нэрийн тольд ч Юлт хэмээх уул, гол ус тэмдэглэгдээгүй байна. Юлтийн түрэг бичээсийг манай судлаач нар сурвалжилж мэдээд уншиж тайлах буй за.

Хотол усны бичээс

О.Ф.Серткаягийн нийтлүүлсэн жагсаалтад *Hotol-us* (Төпө суу) *yazıtı*: I *satır* гэж байх бөгөөд тэрээр 1960-д оны үед Арбогдын бичээстэй хамт Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумнаас олсон болохыг тэмдэглэжээ⁵³⁰. Манай эрдэмтдийн нийтлүүлсэн жагсаалт, судалгааны бүтээлд эл бичээсийн тухай огт дурдаагүй ажээ.

Ногоон толгойн бичээс

Энэ бичээсийн талаар О.Ф.Серткаягийн жагсаалтад⁵³¹ байх бөгөөд манай эрдэм шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүнд тэмдэглэсэн зүйл алга байна. Энэ бичээс нь 2 мөр гэж тэмдэглэсэнээ үзэхэд нилээд баттай сурвалжаас авсан бололтой байна.

1977 онд Хэнтий аймгийн Дархан сумын Ногоон Толгой гэдэг газраас Х.Пэрлээ анх олсон гэжээ.

Жич, проф. О.Ф.Серткаягийн “(Arts Bogdo (Arka Bogdo, Tövş)- үгчлэн орчуулбал, Ар богд, Төвш) I *satır*, Arts-Bogdo (Арц Богдо) (Tövş) *yazıtı* II: I *satır*, Arts-Bogdo (Арц Богдо) (Tövş) *yazıtı* III: 3 *satır*” гэсэн гурван бичээсийг бид “Тэвшийн бичээс”-ийг нэрлэсэн олон хувилбар нэр хэмээн үзэж тухайлан оруулаагүй болохоо тэмдэглэе.

⁵²⁷ М.Шинэхүү, гар бичмэл, -Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

⁵²⁸ Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, -Studia Museologica, Tom. I, fasc. 1-8, Улаанбаатар, 1968, II дүгээр тал; Академич Х.Пэрлээ, Карта рунических письмен на территории МНР, - Эрдэм шинжилгээний өгүүлэлд (эмхэтгэл) II, Улаанбаатар, 2001, 20-27 дугаар тал.

⁵²⁹ М.Шинэхүү, гар бичмэл- Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

⁵³⁰ O.F.Sertkaya, Göktürk yazıtları, -ORKUN, Mart, 1996, I.say, s.24-25.

⁵³¹ O.F.Sertkaya, Göktürk yazıtları, -ORKUN, Mart, 1996, I.say, s.24-25.

Далан уулын бичээс

ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн санд Г.Мэнэс нарын 1982 оны археологийн судалгааны ажлын тайландаа руни бичээс олсон тухай мэдээлсэн байна⁵³². Тайланд “Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дахь Далан уулын өмнө биеийн нэгэн салбар жалганаас ганц мөр түрэг бичээсийг оллоо. Уг бичээсийн урт нь 65 см, үсэг зурлагын өндөр нь 6,5 см, өргөн нь 0,9 см. Хадан толгойн дээд хэсэгт байгаа наран тал руу харсан хаданд сийлсэн байна” хэмээжээ. Бичээсийг түрэг судлаач С.Харжаубай

[𐰇𐰏𐰣] 𐰇𐰏𐰣(𐰇𐰏𐰣)𐰇𐰏𐰣 𐰇𐰏𐰣

qirsaq čino idi qutluγ bol[zun]

Кипчакийн чоно онгон нь өлзий буянтай болтугай гэж уншсан урьдчилсан судалгааг бичээсийн гар хуулбартай хамт хавсаргасан байна⁵³³. Археологич Г.Мэнэстэй уулзаж эл бичээсийн тухай асуухад нэгэн бэсрэг бага хаданд руни бичээс байсныг лавтай үзэж хуулснаа хэлсэн билээ. Гэвч Далан уул хэмээх хэдэн мянган гүвээ жалга, аараг адаргаас бүтэх энэ уулын хаана байхыг олж үзнэ гэдэг нэн бэрх. Руни бичээсээс гадна монгол бичгийн дурсгал байдаг тухай мэдээ бас бий.

Цахирын түрэг бичээс

1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайланд “Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг, сумын төвөөс 10-15 км-г Тэсийн голын өргөн хөндийн хойд талаар хөшиглөн тогтсон цайвар өнгийн шаварлаг зөөлөн чулуутай хадан уул толгодыг нийтэд нь Цахир гэнэ. Зүүн, дунд, баруун, рашаантын гэж дөрвөн Цахир бий. Хамгийн баруун талд Цахирын рашааны зүүн талын хэсэг хадны урд зүг харж тогтсон нэгэн ханан хаданд олон тооны хүн амьтны дурс, тамга тэмдэг сийлсний дунд хоёр хэсэг газар 3 мөр руни бичиг хонхойлгон цохижээ. Нэгдэх мөр нь 15, хоёрдох нь 3, гуравдах нь 9 үсэг зурлагаас бүрдэж байна”⁵³⁴ гэж тэмдэглэсэн байна.

Доктор Д.Цэвээндорж шинжлэх ухааны эргэлтэд оруулах үүднээс 1984 онд уг бичээсийн тухай тэмдэглэл нийтлүүлсэн⁵³⁵ бөгөөд хожим “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс” номд⁵³⁶ Цахирын бичээсийн тухай дахин мэдээлсэн ажээ. Бид 1997 оны зун Тэсийн гэрэлт хөшөөний суурийг дахин үзэх далимд Цахирын бичээсийг доктор А.Очирын хамт өдрийн хугас эрсэн боловч “олоогүй” билээ.

Бигэрийн бичигт хадны бичээс

Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт руни бичээсийг судлаачид “Бигэрийн бичээс” хэмээн нэрлэж заншсан ажээ. Харин эл бичээсээс гадна 3 мөр руни бичээс Бигэр сумаас холгүй байх Бичигт хаднаа байсныг эх бичиг судлалын ангийн оюутан Н.Батзаяа хуулж ирсэн билээ. Бид нүдээр үзэж судалсны хойно бичээсийн талаар нийтлүүлэх болно.

⁵³² Г.Мэнэс, 1982 оны Археологийн шинжилгээний тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982, 25 дугаар тал.

⁵³³ Г.Мэнэс, 1982 оны Археологийн шинжилгээний тайлан, - ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982, 25 дугаар тал.

⁵³⁴ Д.Цэвээндорж, 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайлан, -ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1982.

⁵³⁵ Д.Цэвээндорж, Новые памятники Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур цогро, -Studia Historica, Tom.XVII, fasc.1-13, Улаанбаатар, 1984, 124-126 дугаар тал.

⁵³⁶ Л.Болд, Цахирын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 138 дугаар тал.

Дэлүүн сумын төвийн бичээс

1990 оны эхээр ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн археологийн карт зохиох ажлын хүрээнд тус аймгийн нутгаас руни бичгийн нилээд хэдэн дурсгал олж илрүүлсэн билээ. Тэдгээр дурсгалуудын нэг Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвд, нэгэн жолооч айлын хашаанд нэг мөр бичээстэй хөшөө байгааг археологич Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар олж тэмдэглэсэн байна⁵³⁷.

Саарал өнгийн барсгар гадаргатай боржин чулуунд нэг мөр цохимол бичээс байсан нь олон жилийн нар салхи, цас борооны усанд идэгдэж ихэд өгөршсөн тул бичээсийг тайлж уншихад нэн бэрхтэй болжээ. Уг дурсгалыг даруй хамгаалалтад авч уншиж судлах зайлшгүй шаардлагатайг онцлон тэмдэглэе.

Хар цагаан усны бичээс

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт байдаг бололтой⁵³⁸. Уг бичээсийн талаар Д.Цэвээндоржийн 1980 оны хээрийн судалгааны ажлын тайланд байдаг хэмээн тэмдэглэжээ. Гэвч дурдсан тайланд бичээсийн талаар мэдээ баримт, тодорхойлолт алга байна⁵³⁹.

Тэвшийн түрэг бичээс II

Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, Тэвш уулнаас олсон бололтой⁵⁴⁰.

Одоогоор уул бичээсийн талаар өгүүлэх тодорхой баримт бидэнд үгүй байна. Өмнөх Тэвшийн бичээстэй андуурсан байж магадгүй.

⁵³⁷ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, 1989 онд Баян-Өлгий аймгийн нутагт явуулсан эртний судлалын хайгуулын ажлын тайлан, Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг; Д.Эрдэнэбаатар, 1990 онд Баян-Өлгий аймагт ажилласан хээрийн шинжилгээний тайлан, Археологийн хүрээлэнгийн сан, хөмрөг; Д.Эрдэнэбаатар, Монгол нутгаас олдсон эртний бичээсүүд, -Ил товчоо сонин, №9 (112), 3-р сар, 1994.

⁵³⁸ Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1986, №3, 65-87 дугаар тал.

⁵³⁹ Д.Цэвээндорж, Монголын төмөр, хүрэл зэвсгийг судлах шинжилгээний ангийн тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1980.

⁵⁴⁰ Л.Болд, БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар, 1986, №3, 65-87 дугаар тал; П.А.Окладников, Петроглифы Центральной Азии, Ленинград, 1980, стр.52, табл.116.

1.6.3. Алга болсон дурсгалууд

Монгол нутагт аж төрж төр улсаа байгуулан мандаж мөхөж асан эртний олон аймаг, улс бичиг соёлын асар их өв дурсгал үлдээсэн нь лавтай ч тун цөвхөн хэсэг нь цагийн шалгуурыг давж өнөө үед уламжлагдан үлдсэн байна.

Гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь нилээд хэд байгаа ч түүн дээр байсан бичигт хөшөө ор сураггүй болжээ.

Монгол нутгаас олдсон эртний бичгийн зарим дурсгал үл мэдэгдэх шалтгаанаар алга болсон тохиолдол хэд хэд бий. Бичгийн дурсгалууд хоёр зүйлийн шалтгаанаар алга болж байна.

Нэгдүгээрт, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалд он удаан жил болсноор хөшөө чулуу өгөршин муудаж түүн дээр байсан бичээс холрон унаж сүйдэх,

Хоёрдугаарт, санаатайгаар алга хийх, хулгайлан бусдад өгснөөр ор мөргүй алга болох

Цаашид энэ мэт шалтгаанаар эртний бичгийн дурсгалыг алга хийх, үрэгдүүлэхийг таслан зогсоох зайлшгүй шаардлагатай байна.

Монголын төдийгүй Төв Азийн, ер дэлхийн түүх, соёлын чухаг үнэт сурвалжид хэтэрхий хайнга хандсан, харамсаар жишээг өгүүлэхээс аргагүй байна.

Нэгэнт алга болсон дурсгалуудыг эрэн сурвалжилж олох, байгаа дурсгалуудаа байгалийн гамшиг болон ухвар мөчид хүний аюулаас хамгаалах цаг нэгэнт болжээ.

Ор сураггүй болсон дурсгалуудын нэрсийг дурдвал;

-Зоосны бичээс

- Налайхаас олдсон шавар эдлэлийн хэлтэрхий дээрх бичээс

- Номын баринтгийн тээг дээрх бичээс

Эрэн сурвалжилбал олдож болзошгүй дурсгалууд

-Байбалькийн бичээс

-Сүүжийн бичээс

- Нэгэн хэлтэрхий дээрх бичээс зэргийг дурдаж болно.

Зоосны бичээс

Археологич Н.Сэр-Оджав гуай 1961 онд Дорнод аймагт хийсэн археологийн хайгуул, шинжилгээний ажлын явцад, нэг зоос санамсаргүй олсон нь хурц үзүүртэй зүйлээр зурчиж бичсэн нэг мөр руни бас нангиад бичигтэй байжээ. Тэрбээр уг зоосыг “Элэгдэж хар болсон зоосны өрөөсөн нүүрэнд хятад бичээстэй бөгөөд нөгөөд нь түрэг бичээстэй, бичээсний дээгүүр татсан хэд хэдэн зураас байна. Хан улсын “У-шу” зоосон...” хэмээн тодорхойлсон байдаг⁵⁴¹. Эртний бичигт зоосны диаметр 25 мм, зузаан нь 1мм бөгөөд доторх дөрвөлжин 10x10 мм, руни бичгийн 21 үсэг зурлагыг хурц үзүүртэй зүйлээр бичсэн гэх ба үсгийн өндөр 4-5 мм байжээ.

Зоосны руни бичээсийг түрэг судлаач, нэрт эрдэмтэн С.Г.Кляшторный анх уншиж судалсан байна. Тэрээр бичээсийг “Qum³š b⁴qšy qut^uγ bolzun” гэж уншаад “Да будет благословен Кумаш-Бакши!”⁵⁴² хэмээн орчуулжээ. С.Г.Кляшторный “Qumaš-Qumač” нэр Кумаш-бай (уйгурын хуульзүйн бичиг), Кумач атабек Санджара (огуз-салчукин захирагч,1096он), Ала ад-дин Кумач (Балхын төр баригч, 1153 он), Кумаш-хан (Ак-Орда, 1521он) гэх мэтээр түүхэн хүний нэрээр тохиолдохоос гадна “qumaš-qumač –шелковая

⁵⁴¹ Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх (Түүхэн найруулал). Улаанбаатар, 1977, 41-42 дугаар тал.

⁵⁴² С.Г.Кляшторный, Монета с рунической надписью из Монголии, -Тюркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338.

ткань, одежда; красная хлопчатобумажная ткань; товар” гэсэн утгатайг ч тэмдэглэсэн байна. Мөн удаах үг болох “baqᡕy- буддийский вероучитель, наставник- буддын (бурханы) сургаал айлдагч, багш ” гэсэн утгатай бөгөөд уйгур нарын X зууны үеийн бурхан шашны холбогдолт ном сударт, бас согд хэлний “p’ᡑᡕᡅᡤᡅᡨ- советник, наставник- зөвлөгч, зөвлөх, багш” гэх үг VIII-IX зууны үеийн манихей бичигт сурвалжид тус тус тохиолдож байгааг дурджээ. Руни бичгийн сурвалжид “baqᡕy” хэмээх үг анх удаа тохиолдож байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Зоосны бичээсийг тайлж уншсан дээрх судалгаа хэвлэгдсэнээс даруй таван жил өнгөрсний хойно С.Харжаубай руни бичээсийг дахин уншиж монгол хэлнээ орчуулан нийтлүүлжээ. С.Г.Кляшторный, С.Харжаубай нарын судалгаа, орчуулга “тэнгэр газар” мэт зөрүүтэй юм. Учир иймд, харьцуулан үзэхэд дөхмийг санаж С.Харжаубайн өгүүллийг ямар нэгэн засвар хийлгүй, бүрэн эхээр нь сийрүүлье. Хасаж засварласан зүйлгүй, угаас маш товчхон болохыг давтан дурдах нь зүйтэй байх.

Эртний гурван бичээс

<< Эртний түрэг бичээсийн түүхэн эрин үед холбогдох янз бүрийн хэд хэдэн дурсгал ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн археолог-этнографийн лабораторид хадгалагдаж байна. Тэдний дундаас Хан улсын зоосон дахь түрэг бичээс, Тоньюкукийн тахилгын сүмийн шаваасны бичээс удаа дараа нийтлэгдсэн боловч, тайлан уншигдаагүй учир өдий хүртэл нууцаа хадгалсаар байгаа юм. Бид эл хоёр бичээсийн хамт Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулнаас олдсон түрэг бичээсийг дахин нягталж тайлан уншихыг оролдов.

1. Хүннүгийн үеийн зоосны бичээс

“Доктор Н.Сэр-Оджав 1961 онд Дорнод аймагт археологийн хайгуул хийж явах үед уг зоосыг олсон байна. Зоосны нэг тал нь эртний түрэг бичээстэй бөгөөд нөгөө тал нь хятад бичээстэй юм. Сэр-Оджав эл зоосыг Хан улсын үеийн “У-шу” зоос болохыг тогтоосон юм. Зоосон дээр дундах дөрвөлжин нүхийг тойруулан 17 үсэг хурц үзүүртэй зүйлээр зурчин бичсэн байгаа учир уншихад нилээд бэрхшээл тулгарч байсан юм.

Уг бичээсийг сийрүүлбээс:

𐰽𐰺𐰍𐰏𐰤𐰣𐰏𐰤𐰣𐰏𐰤𐰣𐰏𐰤𐰣𐰏𐰤

Галиглан буулгаваас:

altun edis edigin altid. taᡑiᡕ olur

Үгчлэн орчуулбаас:

Алтан эрдэнэс сайн нь, алтан ширээнд /хааны/ байна

Утгачлан буулгаваас:

Үнэт алтан эрдэнэс, хааны алтан ширээнд /санд/ байна.

Эл бичээсийн хэлний зүйн зарим онцлогийг ажихад: Орчин цагийн түрэг хэлнүүд хийгээд монгол хэлний олон тооны дагаварууд “-S, -D, “хүннү нарын үед мөн нэгэн адил олон тооны дагаварын утгыг илтгэж байв. Харин хүннүгийн үеийн IN хэмээх 3-р биеийн хамаатуулахын дагавар орчин цагийн ихэнх түрэг хэлэнд -IN хэлбэрээр хадгалагдан үлдсэн ба монгол хэлэнд -INÜ, -INÜ хэлбэртэй болсон бололтой байна⁵⁴³>> хэмээн өгүүллийн зоосны бичээсийг тайлж уншсан хэсэг төгсчээ.

С.Харжаубай энэ зоосыг хүннүгийн үеийнх бөгөөд руни бичгээр түрэг хэлээр бичсэн, тодруулбал хүннү нар руни бичигтэй, түрэг хэлтэн байсан гэж үзсэн нь илэрхий байна. С.Г.Кляшторныйн нийтлүүлсэн гэрэл зураг, гэрэл зургаас дам буулгасан хуулбартай С.Харжаубайн сийрүүлсэн гар хуулбар, үсэг тэмдэгт (Кляшторный 21 үсэг тэмдэгт, Харжаубай 17 үсэг тэмдэгт буй гэжээ) зөрж байгаа нь нэн хачирхалтай байна.

Л.Болд бүтээлдээ С.Г.Кляшторныйн галиг орчуулгыг дурдаад “Үүний дараагаар уг бичээсийг уншихад и.Харжаубай өөрийн хөдөлмөрийг зориулсан байна. Судлаач харин өөрийн ажилдаа уг бичээсийн талаар өмнө гарсан дээрх судалгааны ажлыг ашиглаагүй нь хачирхалтай...Уг бичээсийг уншсан эхүүд ийнхүү хол зөрүүтэй байгаа нь уг түрэг бичээсийг дахин нягтлан үзэх, гэхдээ зөвхон орчуулга, тайлбарыг бичи, эжинхэнэ эхийг нь нягтлан үзэхийг шаардаж байна. Ийм судалгааг дахин хийсний дүнд эдгээр орчуулга, дүгнэлтүүдийн аль нэгийг зөвтгөх буюу эсвэл үнэнд аль болохоор илүү ойртсон гурав дахь

⁵⁴³ С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 32 дугаар тал.

дүгэлтийг хийх хэрэгтэй юм”⁵⁴⁴ гэж зоосны бичээсийг судалсан судалгааны талаар өөрийнхөө саналыг бичсэн байна. С.Г.Кляшторный гуайн судалгааг тэр бүр олж уншигч нь дөөн, тэгээд ч түүхийн зарим ном, сурах бичигт С.Харжаубайн уншлага орчуулгыг оруулснаар оюутан сурагч, түүх сонирхогч нар уг зоосны бичээсийн утга агуулгыг түүний мадагтай уншлага орчуулгаар буруу ташаа ойлгож байгаа нь туйлын харамсалтай. Далимд тэмдэглэхэд, хойшид ч чамбай сайн судлагдсан, шинжлэх ухааны баттай мэдээ баримтыг нийтийн боловсролд зориулсан ном, сурах бичигт оруулахыг анхаарууштай юм. Мэдээж хэрэг, эрдэмтдийн судалгааны асар их зөрөөг шинжлэх ухааны үүднээс нягтлан судалж зөв бурууг нутлан тайлбарлах ганц зөв арга зам бол уг эх дурсгалыг “өөрийн гараар барьж нүдээр үзэж” судлах явдал юм. Гэвч ховор чухаг тэр ор сураггүй алга болжээ. Руни бичигт зоос байсныг мэдэх хүн олон, алга болсонд халаглан харамсагч олон ч байхгүй болгосон этгээдийг олж шүүн шийтгэсэн нь энэ хэр огт үгүй юм.

Номын баринтгийн тээг дээрх бичээс

Улсын нийтийн номын санд хадгалагдаж байсан “Гучин хоёр модон хүний үлгэр” гэх номын баринтгийн оосорт буй чулуун тээг дээрх хоёр мөр бичээсийг 1956 онд хожмын академич А.Лувсандэндэв гуай тайлж уншсан нь монгол хүн анх удаа руни бичгийг судалсан судалгаа, монгол эрдэмтдийн руни бичгийн судлалын эхлэл байлаа. Тэрбээр бичээсийг 1.Чиниз хаан, 2. баатар хаан байсан гэж уншаад “... уул өгүүлбэрийг хэлзүйн талаар ажиглавал өгүүлэхүүнийг нь илтгэсэн үйлт нэр нь өнгөрсөн цагт (баатар хаан) байсан гэж байна. Үүнээс үзэхэд энэ бичээсийг Чингис хааныг үхсэний дараа бичжээ. Энэ нь эртний түрэг бичиг Чингисээс хойш үед ч хэрэглэгдэж байсныг гэрчилж байна” хэмээн дүгнэсэн⁵⁴⁵ байдаг.

Тэрбээр 1960 онд герман хэлээр нэгэн өгүүлэл нийтлүүлж⁵⁴⁶ түрэг судлаачдын сонорт дахин хүргэж мэдээлсэн ажээ.

Б.Ринчен академич “БНМАУ-ын Нийтийн номын санд байгаа нэг судрын баринтгийн оосрын чулуун тээгний түрэг бичээс” нэртэйгээр хэвлүүлсэн байна⁵⁴⁷.

Б.Ринчен академич мөн “La Mention du Nom de Činggis Qagan en écriture des turcs d’Orkhon (Орхоны түрэгүүдийн бичээсэнд Чингис хааны нэрийг дурдсан нь)”⁵⁴⁸ хэмээх илтгэл хэвлүүлсэн байдаг.

1959 онд Г.И.Константин “ A late Kōk-Türkish runic inscription on a semi-precious stone, found in Mongolia (Монгол нутгаас олдсон, жирийн нэгэн чулуун дээрх хожуу үед холбогдох Хөхтүрэгийн руни бичээс)”⁵⁴⁹, 1960 онд С.Г.Кляшторный “К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана”⁵⁵⁰, 1971 онд Г.Айдаров “ Шингис Ханның атына баялансти ескерткиш туралы” (Чингис хааны нэртэй холбогдох нэгэн дурсгалын тухай)⁵⁵¹ зэрэг өгүүлэл нийтлүүлж XIII зууны үед руни бичиг хэрэглэгдэж байсан эсэх, цаашлаад уг бичээс үнэхээр жинхэнэ эсэх асуудал сөхөгдсөн байна.

⁵⁴⁴ Л.Болд, Зоосон дээрх түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 31-33 дугаар тал.

⁵⁴⁵ А.Лувсандэндэв, Шинээр олдсон тюрк бичээсийн тухай, Улаанбаатар, 1956, нийт 7 хуудас болой.

⁵⁴⁶ A.Lubsangendüp, Über eine in der Mongolei neu entdeckte türkische Runeninschrift aus dem 13.Jh. - Uralaltaische Jahrbücher, Wiesbaden, 1960, pp.122-123.

⁵⁴⁷ Rinchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. 1, Улаанбаатар (Oulanbator) 1968, pp.69.

⁵⁴⁸ B.Rintchen, La Mention du Nom de Činggis Qagan en écriture des turcs d’Orkhon, -XXIV International Orientalisten -Kongress Arbeitsplan und Mitgliederverzeichnis, München, 1957, pp.42.

⁵⁴⁹ G.I. Constantin, A late Kōk- Türkish runic inscription on a semi-precious stone, found in Mongolia, - Archiv Orientalni, Prag, 1959, pp.427-437.

⁵⁵⁰ С.Г.Кляшторный, К вопросу о подлинности древнетюркской надписи с именем Чингис хана, -Проблемы Востоковедения, Москва, 1960, № 1, стр.173-175.

⁵⁵¹ Г.Айдаров, Шингис Ханның атына баялансти ескерткиш туралы, -Қазак Епиграфикасы, Алматы, 1971, стр.156-160.

1. : (a)nça: öt(ü)nm(i)ş(i)n k²
2. : B²YZ: ZG¹ wK²S²G² wKN²? T²G² R²...
2. :biz: (a)z(i)g: (ü)k(ü)ş(ü)g ök(ü)n ? t(e)g (e)r..
3. :K²Ş²: YŞ²G²: B²R²T²NK: T²Y²N²: Y¹

3.: iş(i)g: b(i)rt(i)ng: t(i)y(i)n: y¹

1. Tercüme: öylece: arzettiğini...
2. Tercüme: Biz azı (ve) çoğu: ükünür gibi i[...]
3. Tercüme: ??: işig verdin tiyerek..." хэмээн руни бичгийн эхийг сийрүүлж үсэг, үгийн галиг хийж орчин цагийн турк хэлнээ хөрвүүлсэн байна.

Орчин цагийн турк хэлнээ хөрвүүлснийг үгчлэн орчуулбал:

1. Тийнхүү: хүсээнийг ...
2. Бид цөөхөн (ба) олуул: бөөн мэт [...]
3. ??: хүчээ өгсөн хэмээж ..." энэ мэт болох ба хэсэг бусгаг учир тоймтой зүйл хэлэх боломжгүй юм.

Ийм боловч нэгэн гэрэлт хөшөөний хэлтэрхий байсан нь гарцаагүй. Цаашид тухайн үед ажиллаж байсан өтгөс, буурлуудаас асууж лавлан эрэн сурвалжилбал хэдэн онд хаанаас олдсоныг тогтоож болох юм.

Лавтайяа, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөг, Үндэсний түүхийн музейн сан хөмрөгийн аль алинд нь үгүй билээ.

*Хад чулуу, гэрэлт хөшөөний бичээс нь
Хамгийн үнэн, бодитой түүхэн сурвалж мөн.*

Төв Азийн өндөрлөгт аж төрж асан эртний олон улс, угсаатны түүх, соёлын эрдэнэсийн их сан нь Монгол нутагт буй. Эрдэнэсийн тэр их санд хүн төрөлхтний үсэг бичиг, түүх соёлын гэрч болох олон арван чулуун судар хадгалагдан үлджээ. Бид олон зүйл үсэг бичиг, хэлээр буй тэрхүү гайхамшигт сурвалжуудаас зөвхөн эртний түрэг, уйгур нарт холбогдох "руни бичгээрх" чулуун ном судрыг уншиж судалсныхаа багахан хэсгээс илтгэхийг хичээлээ.

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛУУД (Эх бичгийн судалгаа)

- 1. АРХАНАНГИЙН БИЧЭЭС**
- 2. БӨМБӨГӨРИЙН БИЧЭЭС**
- 3. ГУРВАЛЖИН УУЛЫН БИЧЭЭС**
- 4. ГУРВАНМАНДАЛЫН БИЧЭЭС**
 - Дундмандалын бичээс
 - Адагмандалын бичээс
- 5. ДЭЛ УУЛЫН БИЧЭЭС**
 - Нэгдүгээр бичээс
 - Хоёрдугаар бичээс
 - Гуравдугаар бичээс
 - Дөрөвдүгээр бичээс
- 6. ИХ БИЧИГГИЙН БИЧЭЭС**
- 7. ИХ ХАНУЙ НУУРЫН БИЧЭЭС**
- 8. НАЛАЙХЫН БИЧЭЭС (Шавар ваарын хэлтэрхий дээрх бичээс)**
- 9. СЭВРЭЙН БИЧЭЭС**
- 10. ТАХИЛЫН ШАВААСНЫ БИЧЭЭС**
- 11. ТЭВШИЙН БИЧЭЭС**
- 12. ХАНАНГИЙН БУУЦНЫ БИЧЭЭС**

АРХАНАНГИЙН БИЧЭЭС

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын төвөөс урагш 40 орчим км-т Арханан гэх нэгэн багавтар уул буй. Тэрхүү уул нь ар өвөр, суга хажуугаараа олон хаваржаа, өвөлжөөтэй бөгөөд баруун хойт талд орших бууцыг Арханангийн бууц, өвөлжөө хэмээнэ.

Эл өвөлжөөний хаданд байх бичээсийг судлаачид “Арханангийн түрэг бичээс” хэмээн нэрлэж тэмдэглэсээр иржээ. “Арханан” гэх нэр уг газрын байрлалыг тодотгон тодорхойлж, уулын ард, ханан хадтай газар болохыг илэрхийлнэ.

Ханан хад нь ойролцоогоор 16 м орчим үргэлжлэх бөгөөд 50-80 см өндөр, араараа тэгш, нүүрэн талдаа эгц хана үүсгэсэн өвөрмөц тогтоцтой, цайвардуу бор шаргал өнгөтэй аж. Дурсгалын байршлын цэг: 1292 m. 48U 0408787, UTM 5323955

Судалгааны тойм

Арханангийн хэмээх нэрээр түрэг судлаачдын танил болсон эл бичээсийг анх Польшийн нэрт эрдэмтэн Е.Трыарски 1964 онд тайлан уншсан байна¹.

О.Намнандорж гуай 1966 онд уг бичээсийг очиж үзээд гар хуулбар хийж, гэрэл зураг авчээ².

Б.Ринчен академич бүтээлдээ³ Арханангийн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлэн судалгааны эргэлтэд оруулж улмаар бичээсийг дахин унших, нягтлан судлах ажлыг эхлүүлсэн бөлгөө.

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг 1977 онд уг дурсгалыг үзэж судалсан байна⁴. Уг бичээсийг судалсан судалгааны ажлын үр дүнгээ С.Харжаубай 1980 онд, С.Г.Кляшторный 1990 онд тус тус хэвлэн нийтлүүлжээ.

С.Харжаубайн судалгаа

С.Харжаубай уг бичээсийг гурван мөр, нийтдээ 140 үсэг тэмдгээс бүрдэх бөгөөд I мөр 83 үсэг тэмдэгтэй, урт нь 107 см, II мөрийн урт нь 36 см, III мөрийн урт нь 30 см, харин үсгийн өндөр дунджаар 1,5 см гэж тодорхойлсон байна⁴.

¹ E. Tryjarski, L'inscription runiforme d'Arkhanen, en Mongolie, -Ural-altaische Jahrbücher 36, fasc.3-4 (1964), 1965, pp.423-428

² О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, Шинжлэх ухаан амьдрал, №5, Улаанбаатар, 1966, 38-41 дүгээр тал.

³ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les stèles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.37.

⁴ Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд А.Очир, С.Харжаубай, С.Г.Кляшторный нар ажилласан байна.

⁴ С.Каржаубай, Надпись на скале Арханана, -Хэл зохиол судлал, XIV боть, 1-25 дэвтэр, Улаанбаатар, 1980, 90-93 дугаар тал.

С.Харжаубай бичээсийг,

1. Теңир екин qunčuj jüzi (1) batur ič...örkim... ...qa.... jılqa бүткөдүк...(2) aj jana Kül-Tarqan күдегү (3) айız erti. But anta qaja etin bek bolzun.
2. ...bekü bitik bitidim, qaja теңир екин qutluy bolun!
- 3...qulačqın qutluy bolun! Qıřın bedizdim гэж үгчлэн галиглаад, орос хэлнээ

1.Небом рожденного принца (священного) лица скрылось (улетело). Высочеству.....к.....в году мы (обряды погребения) совершили.

...Лунного первого месяца зятю Кюль-тархана жертвоприношение принесли. Бирюзой украшали, навек погребли насыпью.

2. ...тщательно надпись написал я. Небом рожденный скале. Пусть будет благодатным!

3. ...твоя сажень ((тело)) пусть будет благодатным!. Вырезаль, начертил я гэж орчуулжээ.

С.Харжаубайн галиг, уншлага нь С.Г.Кляшторный, Е.Трыарский нарын судалгаанаас нилээдгүй зөрүүтэй байна.

С.Г.Кляшторный, Е.Трыарский нарын судалгаа

Дээрх эрдэмтэд бичээсийг

Line 1. t^aırⁱk^an qunč^uy: yig^an butur [botor? botur? butor?] irkⁱn y^as¹ [y^as^{au}? y^as¹?] q^azγ^an t^urđi: q^aııi kül [köl?] t^arq^an: k^ald^ak ök^uz [ög^uz?] ^crti b^u nča [...] ikin q^aya t^agdik bolz^un

Line 2. b^an bitⁱg: bitⁱdⁱm q^aya: t^aırⁱk^an qutl^uy bolz^un [...] lr

Line 3. ir[k]^a in^a y s l [y^as^{au}? y^as¹]: [...] qutl^uy bolz^un qırurtⁱm гэж галиглан амилуулж, англи хэлнээ,

Line 1: Her Sacred Majesty Princess Yigän, Butur (Botor, Botur, Butor) Irkin, Yasal Qazyan pitched here (their) camp. Her (?) father (is) Kül (Köl) Tarqan. We arrived. There was a river. We penetrated (so far) as (these) two rocks. Let it be (known).

Line 2: I wrote the inscription (in) the rock. May Her Sacred Majesty enjoy divine favour (...)

Line 3: May Irkin (?) Yasal (?...) enjoy divine favour⁵ хэмээн орчуулсан бөлгөө.

Эх бичээс, бичээсийн хэв дардастай харгуулан нягталж үзэхэд дээрх эрдэмтдийн судалгаа нилээд мадагтай болжээ. Эрдэмтэд алдаа мадагтай уншсан нь уг бичээсийг олон удаа очиж үзэх боломж хомс бага байсантай холбоотой буй за.

Олон зууны нар салхи, цас борооны усанд, ялангуяа нэгдүгээр мөрийн бичээс ихэд идэгдэн гэмтэж уншихад нэн бэрхтэй болжээ.

Тиймээс бичээсийн газар 1998, 2001, 2003, 2004 онуудад очиж хэв дардас авч нарийвчлан судалсан билээ.

⁵G.Kljaštornyj, Tryjarski, An Improved Edition of the Arkhanen Inscription, Rocznik Orientalistyczny, Tom.XLVII, Warszawa, 1990, pp. 65-68.

Бичээсийн уншлагын зөрүүг хүснэгтээр харуулбал:

С.Г.Кляшторный, Е.Трярский	С.Харжаубай	Бидний уншлага
I мөр		
tänrikän qunčuy	teñir ekin qunčuj	tänrikän qunčuy
yigän butur	jüzi (1) batur	yigän butur
irkin yasal	ič...örkim.... qa... jılqa	irkin balıq
qazyan turdi	Bütkedük.....	eri bolı turdi
qañi kül tarqan	(2) aj jana Kül-Tarqan	yañi kül tarqan
Kaldak	küdegü	kü edgü
oküz (ögüz) erti	(3) ayız erti	kelirti
bu nča	but anta	buna ..süg
[...] ikin qaya	qaja	..iki.. qaya
tägdik bolzun	etin bek bolzun	teg bek bolzun
II мөр		
bän bitig bitidimbekü bitik bitidim	bitič bitdim
qaya täñrikän	qaja teñir ekin	qaya täñrikän
qutluy bolzun [...] lr	qutluy bolun!	qutluy boluñ
III мөр		
ir[k]a ina y s l [...]qulačqñ	qul ačoqa (ačuqa)
qutluy bolzun	qutluy boluñ!	qutluy boluñ
Qirurtim	qırın bedizdim.	qaya urturtum

Тайлбар:

Тайлбар

ЛНТ★ битиџ- бичээч гэх үгийг 5 удаа ★ /b/ үсэг зурцсаны эцэст бичсэн, ↓DН хэмээн үгийг D/Y/ үсгийг орхиж бичээд дараа нь ↓DН гэж нөхөж бичсэн зэргийг эс тооцвол бичгийг нэгэн хаднаа сийлсэн болох нь тодорхой байна.

“Тэнгэрхэн гүнж” хэмээн өргөмжлөгдсөн нэгний зээ Бутур иркин цол балгас (хот)-ын цэрэг болон суусан хийгээд (магадгүй) түүнээс Күл (Көл) Тархан цолд өргөмжлөгдсөн сайн мэдээ, чимээ ирүүлсэн тухай эхний буюу нэгдүгээр мөрнөө өгүүлжээ.

Удаах мөрүүдэд бичээч, түүний (Ачукагийн) даалгаснаар Хад тэнгэрхэн, боол (ноён) Ачука (Ачока) өлзийтэй байх болтугай хэмээн “Тэнгэр, газартаа залбиран даатгасан сэтгэлийн үг”-ийг нь хаднаа сийлснээ дурджээ.

Арханангийн бичээст “Согд гаралтай түрэгжсэн Күл-тархан ноёныг нас барахад эртний нүүдэлчдийн заншил ёсоор хойллого үйлдэн оршуулсан тухай

өгүүлж байна”⁶ хэмээн үзсэн нь эх бичиг болон түүхэн баримтаар огт нутлагдахгүй, ямар ч үндэслэлгүй болохыг далимд тэмдэглэе.

ᠮᠠᠨᠭᠢᠨ tānrikān. tānᠭi + kān Уйгур улсын үеэс энэ нь нилээд өргөн дэлгэр хэрэглэгдэх болсон цол юм. Уйгурын Хар балгасын гэрэлт хөшөөний бичээст тохиолдож байгаагаас үзвэл хаан, хаан язгуурт хүнд “тэнгэрээс болгоогдсон, тэнгэрээс заяат болох”-ыг тодруулан “тэнгэрхэн” хэмээх өргөмж цол олгодог байсан бололтой.

ᠳᠠᠩᠭᠡᠨ qunčuy 公主 gong zhu гэх нангиад үг. Түрэг, монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан хаан, ноён язгууртны охиныг нэрлэх нэр юм.

ᠶᠡᠭᠢᠨ yigān – зээ. Уг үг Көличурын гэрэлт хөшөөнөө yigān čur гэж бусад дурсгалуудад yigān külüg sañun, yigān qara, yigān qñᠭul sañun гэм мэтээр цол хэргэмийн утгаар бас тохиолддог болохыг толь бичигт⁷ тэмдэглэжээ.

ᠪᠠᠳᠤᠷ butur – хүний нэр

ᠶᠡᠷᠬᠡᠮ irkin – түрэг, уйгурын үед хэрэглэгдэж байсан дээд албан тушаалтанд олгодог цол. Эрхэм, эрхэм хүндэт гэж хэлэлцэж буй нь утгаа “irkin ~erkin” цол, хэргэмээс үүсэлтэй байж болох юм. Хожим цол, хэргэм зэргийн утгаа алдаж төрийн болоод албаны хүнийг дуудах нэр болж хувирсан бололтой.

“Эрхэм” гэх үгийг голдуу төрийн хар хүн, албан тушаалтан нарт холбогдуулан хэлж ярьж, бичихээс бус “лам, хувраг”-ийг дууддаггүй нь цаанаа “irkin ~erkin-erkin” цолын язгуур утга санаа агуулагдаж буйтай холбоотой байж мэднэ.

ᠬᠣᠲᠤ balıq хот суурин, балгад, балгас гэх үг. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад олонтоо тохиолддог. Эдүгээ “хот” гэх утгаа алдаж эртний хотын туйрыг нэрлэх нэр болжээ.

ᠲᠦᠷᠦᠭ turdi монгол нутгаас олдсон руни болоод уйгур бичгийн дурсгалд ер тохиолддоггүй үг. Орчин цагийн турк болоод түрэг төрөл хэлүүдэд “dur~tur” хэлбэрээр “зогс-, бай-, орш-” гэх утгаар идэвхтэй хэрэглэгдэж буй.

Академич Ш.Лувсанвандан Нагаржунайн найман үгүйсгэлийн утгыг задлан тайлбарлахдаа “Хуучин монгол сударт арвин тохиолддог түridkü-ügei, törükü-ügei, möngke-ügei, tasural-ügei, irekü-ügei, odqu-ügei, öber-e činartu busu, nigen činartu busu гэсэн Нагаржунын найман үгүйсгэлийг сайн ойлгохын тулд ойролцоо утгатай янз бүрийн үгээр сольж хэлбэл 1. түridkü-ügei- törükü-ügei гэсэн нь эвдрэхгүй-бүтэхгүй, үрэхгүй-төрөхгүй, бий болохгүй-үгүй болохгүй, 2. möngke ügei-tasurqui ügei буюу үргэлжлэхгүй-тасрахгүй, үүсэхгүй-төгсөхгүй, 3. irekü-ügei - odqu-ügei гэсэн нь илрэхгүй-арилахгүй, орохгүй-гарахгүй, 4. öbere činartu busu-nigen činartu busu гэсэн салахгүй-нийлэхгүй, сарнихгүй-хурахгүй, хагацахгүй-учрахгүй гэсэн жишээтэй болно”⁸ хэмээн байна. Дээрх жишээнээс үзвэл түridkü-ügei буюу түridkü нь turdi гэх үгтэй гарал язгуур нэг байж болох үндэстэй байна. Монгол хэлнээ агшин, хоромхоноо зогсоохийх гэсэн утгатай “~~ᠲᠦᠷᠦᠭ~~ tür-түр” гэх үг ч мөн холбоотой биз ээ.

⁶ С.Каржаубай, Надпись на скале Арханана, Хэл зохиол судлал, XIVботь, 1-25 дэвтэр, 90-93 дугаар тал; Болд Л, Ар Ханангийн түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 17 дугаар тал.

⁷ Древнетюркский словарь, Ленинград, стр. 252.

⁸ Ш.Лувсанвандан, Монгол хэлний авианзүйн онол практикийн асуудлууд. Дөтгөөр дэвтэр, Улаанбаатар, 2002, 192 дугаар тал.

Нᠢ sū -цэрэг. Монгол хэлнээ “сүр, сүр үзүүлэх, сүр хүч” гэх үгс буй бөгөөд энэ нь эртний түрэг хэлний “ᠠ Нᠢ sū er- цэрэг эр ” гэх хоёр үгнээс үүссэн бололтой. Түүнээс гадна олноор цугларсан, бөөгнөрснийг “сүрэг, сүрэлэх” гэдэг нь мөн л “sū” язгууртай холбогдоно.

ᠶ᠋ᠭᠢᠪᠡᠭᠡᠨ (bök^(e)-bük^(e)) Түрэг, монгол хэлний нийт дундын үг бололтой орчин цагийн монгол хэлнээ “бэх, бат бөх” гэх үндсэн утгаараа буй.

ᠠᠯᠢᠲᠢ bitič- Сяньбигийн үеийн албан тушаалын нэрийн дотор “ri-tö-tchen” гэх цол тэмдэглэгдэн үлджээ. Уг үгийн талаар Л.Лигети аругай “ri-tö-tchen, эртний хятадын “b’ji-t k-t’sen bi-tikčün” “бичээс” гэж уншина. Үүнд түрэг хэлний тайлбар ямар ч хамаагүй. Түрэгийн хамгийн эртний хэлбэрүүд bitigüci, bitikäci бөгөөд bitikči гэдэг нь нилээд саяхан үүссэн болно гээд чинагш Юань, Мингийн үеийн хятад галигт монголоор biseci “бичээч” гэж тохиолдохоос гадна араб үсгээр бичигдсэн толиудад, сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн монгол хэл халимаг, ордос, халх, буриад аялгууны жишээг дурдаад монголоор bičigeči, bitigeči нь biči “бич” biti –гээс, манжийн bitxesi, bitegeci-bitxe-bitege сяньбийн нэгэн аялгуунаас гарсан бололтой”⁹ хэмээн тэмдэглэжээ. Тэгэхээр бич-iči~ bičig~ bičigeči) гэх үг язгуур үүслийн хувьд их эрт үед хамаарагдах лавтай. Өгүүлэн бүхүй бичээснээ 5 удаа ᠠ /b/ үсэг зурчсаны дараа эл үгийг бичсэн байна.

Бичээст гарах үгийн толь

ᠲᠠᠨᠷᠢᠬᠡᠨ tānrikän – ᠲᠠᠨᠷᠢᠬᠡᠨ tngriken, тэнгэрхэн

ᠭᠦᠨᠵᠢ qunčuy- ᠭᠦᠨᠵᠢ gūnjū, гүнж

ᠶᠡᠭᠡᠨ yigän – ᠶᠡᠭᠡᠨ jige, зээ

ᠪᠤᠲᠤᠷ butur – ᠪᠤᠲᠤᠷ butur, хүний нэр

ᠢᠷᠬᠢᠨ irkin – ᠢᠷᠬᠢᠨ erkin, цол

ᠪᠠᠯᠢᠴᠢ baliq – ᠪᠠᠯᠢᠴᠢ balγasun, хот балгас

ᠡᠷ er – ᠡᠷ er-e, эр цэрэг

ᠪᠣᠯᠢ bolī

bol – ᠪᠣᠯᠢ bolqu болох

b.- ī- болоод

ᠲᠤᠷᠳᠢ turdī-

tur – ᠲᠤᠷᠳᠢ, ᠪᠠᠶᠢᠴᠢ sayuqu, baiqu, суух байх

t.- dī, суув

ᠶᠠᠨᠢ yañi- ᠶᠠᠨᠢ šin-e, шинэ

ᠬᠦᠯ kül – ᠬᠦᠯ kül, кол, күл (цол, хэргэм)

ᠲᠠᠷᠬᠠᠨ tarqan- ᠲᠠᠷᠬᠠᠨ darqan, цол

ᠬᠢ kī – ᠬᠢ, ᠰᠤᠷᠠᠭ suray, aldar čuu suray, алдар цуу

ᠰᠠᠶᠢᠨ edgū – ᠰᠠᠶᠢᠨ sayin, сайн, сайтар

⁹ Л.Лигети, Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь, -Хэл зохиол судлал, Том.VII, fasc.9, орчуулсан Л.Маналжав, Улаанбаатар, 1970, 236-237 (227-241) дугаар тал.

ᠬᠡᠯᠢᠷᠲᠢ kelirti [kelürti]

kel -  irekü, ирэх

k.- irti, ирүүлэв

ᠪᠤᠨᠠ buna

bu -  ene, энэ

b.-na  ende, энд

ᠰᠦᠭ süg

sü -  čerig, цэрэг

s.- g, цэргийг

ᠢᠬᠢ iki -  qoyar, хоёр

ᠶᠠᠶᠠ qaya -  qada хад, чулуу

ᠮᠡᠲᠦ teg -  metü, мэт шиг

ᠪᠠᠲᠤ bek -  batu, beki, бат бэх

ᠪᠣᠯᠠᠵᠤᠨ bolzun -  boluq, болог

bol-  bol-, бол-

b.- zun, болог

ᠪᠢᠲᠢᠴᠢᠨ bitič -  bičigeči, бичээч

ᠪᠢᠲᠢᠳᠢᠮ bitdim

bit -  biči-, бич-

b.- dim- бичив би

ᠶᠤᠯᠤᠭ qutluy

qut -  öljei, qutuy өлзий (хутар)

q.-luy, өлзийтэй

ᠪᠣᠣᠯ qul -  boγul, боол

ᠠᠴᠣᠴᠠ ačoqa -  ačiq-a хүний нэр

ᠤᠷᠲᠢᠵᠢᠷᠲᠤᠮ ur[t]urtum)

ur-  čoqi, цохи-

u.- [t]urtum- цохиулав би

БӨМБӨГӨРИЙН БИЧЭЭС

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын төвөөс баруун өмнө зүгт, 11 орчим км-т Тайн нурууны төгсгөл, Шивээт хэмээх намхан уулын оройд бичээс, тамга бүхий гэрэлт хөшөөг дурсгал буйг нутгийн ард түмэн Шивээтийн эхний “Шивээ” хэмээн нэрлэдэг байна. Эл шивээ анх хэрэмтэй байсан гэх ба хэрмийн чулууг сумын төвд зөөж хашаа, байшин барихад хэрэглэсэн ажээ. Нилээд эрт үед шивээг гол дунд нь малтаж нилээд гүнзгий хонхорхой үүсгэсэн байх бөгөөд бүр хожуу малтсан ул мөр ч ажиглагдаж байна. Уйгурын үед уул, толгойн орой зэрэг өндөрлөг газарт их хэмжээний чулуу овоолон шивээ байгуулдаг ёс байсан бололтой юм.

Жишээ нь, мөн үед холбогдох Тарнын голын хүн чулуут шивээ¹⁰, Шивээт улааны тамгат хөшөө бүхий цогцолбор (хүн чулуу, хонь, арслантай)¹¹ зэрэг судалгааны эргэлтэд хэдүйнээ мэдэх болсон олон дурсгалыг дурдаж болно.

Түүнчлэн Архангай аймгийн Хашаат сумын нутаг хөгшин Орхоны хөвөө, Хөшөө Цайдамд буй түрэгийн Билэг хаан, түүний дүү цэргийн нэрт жжнжин Көлтигин нарын гэрэлт хөшөөнөөс өмнө зүгт мөн томоохон шивээ байх бөгөөд ойролцоох хаднаа янгир зэрэг хэдэн тамга сийлсэн байдгыг бас тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Шивээт улааны цогцолбороос өөр тухайлан гэрэлт хөшөөнөө олон (24) тамга сийлсэн дурсгал одоогоор монгол нутгаас олдоогүй байна. Харин магнайдаа 4 мөр, баруун хажуудаа нэг мөр руни бичээстэй, нийт 34 тамганаас бүрэлдэх Бөмбөгөрийн бичиг, тамгат хөшөө олон тамгатай удаах дурсгалд зүй ёсоор тооцогдоно. Гэхдээ хөшөөнөө нэг тамгын олон хувилбар зонхилж байгааг дурдалтай. Хөшөөний магнайн бичээсийн доор голлож бусдаас илүү томоор цохисон тамга нь Карлук нартай холбогдох нь мэдээж бөгөөд бусад хувилбар тамгууд худ ураг болон тэдний бүрэлдэхүүнд багтагсадтай холбоотой буй за.

Бид тамга тэмдгийн судалгааг гол болгосонгүй, зөвхөн бичгийн дурсгалын судалгааг толилуулж байна.

Шивээн нуруу хэмээн нутгийнхан нэрлэдэг, тал хээрийн үргэлжилсэн намхан уулын эх, молцог толгойн орой (Газрын байршил: N 46° 07' 07,9", E 099° 31' 51,6" солбилцлын цэгт, далайн төвшнөөс дээш 1525м)-д байгуулсан “шивээ”-ний өмнө талд, овоолго чулуун дотор Бөмбөгөрийн гэж нэрлэгдэх бичиг, тамгат хөшөөг босгосон байна. Уг цайвар шаргал боржин чулуун хөшөөний магнайд 4 мөр бичээс байх бөгөөд хөшөөний оройн хэсэг холцрон унасан тул мэдэгдэж буй дөрвөн мөрөөс дээш тамга болоод бичиг байсан эсэх талаар таамаглан хэлэх боломжгүй юм. Нэгдүгээр мөрийн эхний гурван үсэг нь хагас дутуу, харин төгсгөлийн нэг үсэг тодорхой мэдэгдэж байна. Түүнчлэн 2,3,4-р мөрийн үсэг тэмдэгтүүд маш тодорхой ажээ. Хөшөөний баруун хажууд цохисон нэг мөр бичээсийн эхний хоёр үсгийн дараагийн гурав, дөрвөн үсэг холцорч унасан хэдий ч бусад үсэг тэмдэгтүүд маш тод юм. Уг хөшөө тахилга булшны овоолго чулуунд нөмөрлөгдөж, тал хэсэг нь

* Их чулуу овоолон үйлдсэн нэгэн зүйл тахилын онгон. Голдуу уулын оройд байдаг онцлогтой.

¹⁰ Д.Баяр, Монголын төв нутаг дахь түрэгийн үеийн хүн чулуу, Улаанбаатар, 1997, 91 дугаар тал.

¹¹ Ц.Доржсүрэн, Шивээт Улаан гэдэг юу вэ?, -Шинжлэх Ухаан, Техник, Улаанбаатар, 1957, №1, 46-47 дугаар тал; С.Харжаубай, Шивээт Улааны цогцолбор дурсгалан, -Археологийн судлал, Том XIX, fasc. 2, Улаанбаатар, 1979, 15-23 дугаар тал; С.Харжаубай, Шивээт Улааны тухай дахин өгүүлэх нь, -Түүхийн судлал, Том X, fasc. 7, Улаанбаатар, 1982, 103-120 дугаар тал.

далд дараастай байсан тул бичээсийн үсэг тэмдэгтүүд харьцангуй сайн хадгалагдан үлдсэн байна¹².

Хошооний магнайн бичээс

Эх бичиг;

1. 4..... [4]ᠬᠤ[4]
2. ʎᠢᠶᠢᠶᠡ ↓<ᠬᠢ
3. ↓ᠬᠢᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡ
4. ʎᠢᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡᠶᠢᠶᠡ

Үсгийн галиг;

1. [L]W T [R]..... ʎ
2. ʎ Y nc W wQ g l s b l i
3. T W LT N i: L W Q R L wQ
4. wQ W B R p: T W LT N L D i

Үгийн галиг;

1.
2. ilbis ilig qunčuyiŋ
3. tultonī: alu qarluq
4. qub arīp: tulton aldī

Үгчилсэн орчуулга;

1.
2. Илбис Илиг гүнжийн
3. бэлэвсрэлийн хувцсыг авруун Карлук
4. хурж бэлэвсрэлийн хувцас авав.

Утгачилсан орчуулга;

- 1.....
2. Илбис Илиг гүнжийн
3. гашуудалд /хойллогод/ Карлук
4. хурж гашуудав /бэлэвсрэв/.

¹² Ц.Баттулга, Бөмбөгөрийн бичээс, -Acta Mongolica, Vol.4 (236), Ulaanbaatar, 2005, 117-124 дүгээр тал.

(Илбис гүнжийн *бэлэвсрэлийн хувцасыг авч*) гээд уг санаагаа батлан лавшруулж *qarluq qubranip tulton aldī* (Карлукууд цуглаад *бэлэвсрэлийн хувцасыг авлаа*) [*гүнжийн бэлэвсрэлийн хувцасыг авч... бэлэвсрэлийн хувцасыг авлаа*]) хэмээн тодотгосон ажээ. Энэ жишээнээс үзэхэд ямартаа ч монгол, түрэг хэлэнд үг давтаж уг зүйлийг бататган лавшруулж бичих нэгэн зүйл уламжлал, зүй тогтол байсан бололтой.

Хөшөөний баруун талын бичээс *üzä* (дээд) гэж эхэлж байгаа ч дараагийн үсэг, үг сийлсэн хэсгээс эмтэрч унажээ. Удаах өгүүлбэр *asra yerkä* (доод газарт) гэж буй тул эмтэрсэн хэсэгт [tʃrik]ä гэсэн үг байсан болов уу хэмээн үзэж байна. “*üzä teŋrikä asra yerkä*-дээд тэнгэрт, доод газарт” гэх тогтсон хэллэг, хэлц нь монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад байнга давтагддаг онцлогтой.

Үүкүн *yükün* -Уг үг бөхийх, гудайх, тонгойх, мэхийх гэсэн утгаар Билгэ хааны гэрэлт хөшөөний хойт талын 10, зүүн талын 3,13, 16-р мөр, Көлтигиний гэрэлт хөшөөний зүүн талын 2,15-р мөрнөө тус тус тохиолддог. Жишээ нь Билгэ хааны гэрэлт хөшөөний хойт талын 10-р мөрнөө “*bašlīyū yūküntürtüm tizligig sökürtüm* –толгойтыг бөхийлгөв би, өвдөгтийг сөхрүүлэв би” хэмээн гарч байна.

Хожим уг үгийн утга шилжиж, мөргөх, залбирах гэсэн утгатай болсон бололтой. Уйгур нар маанийн болон бурханы шашинд орж “Алтан гэрэл” тэргүүт судар ном орчуулснаас эл үгийн утга шилжихэд хүрсэн байж болох юм. Уйгур “Алтан гэрэл” сударт уг үгийг ихэвчлэн “бурханд мөргөх, залбирах, мөргөх, шүтэх” гэсэн утгаар олон удаа гарч байна¹⁶.

Хижрагийн 466 он буюу нийтийн тооллын 1072-3 оны хооронд Кашгарын Махмудын зохиосон толь бичигт “*yükün*” хэмээх үгийн утгыг нилээд олон жишээ гарган дэлгэрэнгүй тайлбарлажээ. Тухайлбал, “*Teŋrige yūkün*” гэсэн үгийг “*Allaha secde et demektir*- Аллахад залбирал үйлд гэсэн үг”¹⁷ хэмээн тайлбарласан байна. Мөн “*qul teŋride yūkündi*-боол тэнгэрт залбирав”, “*toyun burxanqa yūkündi*- тойн бурханд залбирав” гэх мэт жишээ дурдсан ажээ. Бас

Yüküntüp maŋa imledi

Közüm yašin yamlađı

Bayım bašin emledi

*Elkin bolup ol kecer...*¹⁸ гэсэн дөрвөн мөр шүлэг хадаж уг үгийн “бөхийх, мэхийх” гэдэг утгыг тайлбарласан ажээ.

“Махмудын тайлбарт тулгуурлан эл шүлгийг;

Мэхийн тэр намайг ажиглалаа

Мэлмэрэх нулимсийг минь [тэр] арчлаа

Зүрхний минь гунигийг [тэр] эмчиллээ [эмчилчхээд]

Зүгээр л явж одлоо тэр, зочлон ирчихээд...” хэмээн утгачилан орчуулж болох мэт.

¹⁶ Cevle Kaya, Uygurca Altun Yarik, giris, metin ve dizin. Türk Dil Kurumu Yayınları: 607, Ankara, 1994, s. 825-826.

¹⁷ Divanü-Lûgat-it Türk, Türk Dil Kurumu Yayınları:522, çeviren Besim Atalay, Cilt II, 4.baskı, Ankara, 1998, s.167.

¹⁸ Divanü-Lûgat-it Türk, Türk Dil Kurumu Yayınları:523, çeviren Besim Atalay, Cilt III, 4.baskı, Ankara, 1999, s.84-85.

ᠪᠠᠰᠮᠢᠯᠢᠭᠤᠨᠪᠣᠳᠤᠨ-ᠪᠠᠰᠮᠢᠯᠢᠭᠤᠨ Basmilǵy bodun- basmıl gэх нэр Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөө зэрэг хөх түрэгийн бичгийн сонгодог дурсгалууд, Моюнчур, Тариатын зэрэг уйгурын үеийн руни бичгийн дурсгалуудад олонтоо дурдагддаг. Хамгийн сонирхолтой нь -iy гэх нөхцөл юм. -iy~ Iy нь Билгэ хаан, Келтигиний гэрэлт хөшөөний бичээст гарах qaγan- Iy (хаантай), ton- luγ (хувцастай), kedim-lig (тоногтой) гэх мэт үгийн нэгэн адил нэрээс нэр үүсгэх дагавар¹⁹ байж болох юм. Ийн үзвэл уг хөшөөний баруун хажуугийн бичээсийг дан ганц басмыл түмэн биш харин басмыл давамгайлж ноёлсон, бусад овог аймгууд хамтран бичсэн болж таарна. Нөгөө талаар Y(I) давтагдаж ороогүй гэж үзвэл -iy нөхцөл нь заах утгыг илтгэнэ. Тэгвэл басмылыг улс түмэн гэж орчуулж болно. Бид *basmilǵy* гэх үгийг хувиргаж орчуулсангүй, харин цаашид лавлан судлах шаардлагатайг тэмдэглэн үлдээ.

Бичээсийн утгаас үзвэл шивээ, хөшөөг Илбис Илиг хэмээх нэгэн гүнжийн дурсгалд зориулсан болох нь тодорхой байна.

↓ᠵᠢᠨ qarluq-Харлук. Нангиад сурвалж бичигт Карлук хэмээх нэр 143 онд анх удаа тэмдэглэгдсэн гэдэг. Э.Шаванн Карлукийн талаар “D’après le *T’ang chou*, chap. CCXYII, b, p. 6 r⁰, les *Ko-lo-lou* (Karlouk) demeurèrent au nord-ouest de *Pei-t’ing* (près de Goutechen) et à l’ouest du *Kin-chan* (Altai). Ceci ne peut guère s’entendre que s’ils étaient établis sur les bords de la rivière Ouroungou qui se jette dans le lac Kysylbach, appelé aussi lac Ouroungou; c’est en effet entre la rivière Ouroungou et l’Irtych noir que la carte des contrées occidentales à l’époque des *T’ang* (*Si yu t’ou tche*, chap. III, p.8 v⁰ et 9 r⁰) place les Karlouk; cette carte identifie avec l’Irtych noir la rivière *Pou-koutchen* 僕固辰 sur les bords de laquelle, d’après le *T’ang chou* (chap. CCXYII, b, p. 6 r⁰) vivaient les Karlouk. Cf. aussi *Si yu t’ou, tche*, chap. XXY, p. 7 v⁰,²⁰ хэмээн тэмдэглэжээ.

Энэ мэдээнээс үзвэл Карлукууд одоогийн Алтайн уулын баруун тал, Кызыл баш нууранд цутгадаг Өрөнгө голын эрэг хавиар нутаглаж байсан нь тодорхой ажээ. Зарим сурвалжид Карлукууд Алтайн нуруунаас Талас гол, Балхаш, Зайсан нуурын өмнө бие, Дорнод Туркестаны хойд биеэс Иссык-куль нуурын өмнөд тал хүртэлх газар нутгийг эзлэн суудаг хэмээн өгүүлсэн нь буй²¹.

Карлук нэрийг нангиад сурвалжид ko-lo-lu, ka-lo-luk, төвд сурвалжид garlog, араб сурвалжид halluh, harluh, согд сурвалжид үгт-wγт хэмээн тус тус тэмдэглэсээр иржээ²².

Карлук (↓ᠵᠢᠨqarluq) нэр Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээст долоон удаа, Моюнчур, Тариатын гэрэлт хөшөөний бичээст мөн нийжгээд удаа тохиолдоно. Харин монгол сурвалжууд, тухайлбал Монголын нууц товчооны 198-р зүйлд “naiman-u gücülük-qan ui’urtai *qarlu=ud-i* da’arin sarda’ul-un qajar-a cui-müren-e бүкүн qara-kidad-un gür-qan-tur neyilen otcu’ui”²³, мөн 235-р зүйлд “qubilai-noyan-

¹⁹ Cengiz Alyılmaz, Orhun Yazıtlarının Söz Dizimi, Atatürk Üniversitesi Yayınları No:830, Erzurum, 1994, s.15-16.

²⁰ Edourd Chavannes, Documents Sur les Tou-kiue (Tures) Occidentaux, Paris, 1941, pp.33.

²¹ А.Г. Малявкин, Материалы по истории уйгуров в IX-XII вв., Том II, Новосибирск, 1974, стр.97.

²² Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s.421.

²³ Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, pp. 109.

і *qarlu'ut-tur* ca'ura'ulba. *qarlu'ud-un arslan-qan* qubilai-tur elsen irejü'üi"²⁴ хэмээн гарч байна.

Уйгурын хаант улсын үед Харлукууд гурван хэсэгт хуваагдаж байсан ажээ. Үүнд нэг хэсэг нь Өтүкэн /Ц.Б. Хангайн нуруу/-д амьдарч байсан бөгөөд тэд Уйгурын хаант улсын харьяат байв. Хоёрдахь хэсэг /гурван харлук/ нь Иртиш мөрний сав дагуу нутаглаж байсан ба тэд өөрсдийн Ябгутаи буюу эзэн захирагчтай байжээ. Бешбалык хотын ойролцоо нутаглах гуравдахь хэсгийг Тун Билгэ (Тоен Рика Тун) Ябгу захирч байжээ²⁵.

Басмыл (Уᠪᠰᠮᠢᠯ basmil) -ийн тухай түүхэн сурвалжуудад дэлгэрэнгүй мэдээ төдий л олон бус бололтой.

Н.В.Кюнер Басмылийн тухай "Басими (Басмюль) одно и то же, что государство Били. Стала известна во время династии Суй /589-618/. Находится на юг от Бэйтина и Бэйхая /Байкала/, на восток от цэиёгу /хягасов/. На юге примыкают к горам"²⁶ гэж өгүүлсэн байна.

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад Басмыл нэр Карлукийн хамт болон дангаараа цөөнгүй тохиолддог. Жишээ нь, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 25 дугаар мөрд "uegirmi yašima basmil ᠶduq qut uyušum bodun ārti: arqaz ᠶdmaz tiyin süledim- Хорин насандаа Басмыл ариун өлзий /хишиг/-т садан түмэн билээ. Жин ирүүлсэнгүй хэмээн дайлав би" гэсэн нэгэн сонирхолтой мэдээ бий.

741 онд Түрэгийн хоёрдугаар хаант улсын насан бага Тэнгэр (Тэнгри) хааныг хороогоод, түүний авга ах Кутлуг Ябгу хаан ширээг нь эзэлсэн байна²⁷.

742 онд Уйгур, Карлук, Басмыл нар түрэгийн эсрэг босч эхэлсэн²⁸ бөгөөд Басмылууд 744 онд түрэгийн Озмыш хааныг алаад толгойг нь Чанъянд илгээсэн ажээ²⁹.

Түрэгүүдийн зарим нь үүнд ихэд дургүй байсан хэдий ч Басмылын удирдагч байсан нэгэн Түрэгийн хаан ширээнд суусан гэдэг³⁰.

Гэвч төдөлгүй Уйгурууд холбоотон болох Карлук, Басмыл нарыг дарж эрхшээлдээ оруулан төр улс байгуулжээ. Энэ талаар Моюнчурын гэрэлт хөшөөний бичээсэд тодорхой өгүүлснийг дурдвал " /баруун талын 2-р (W2) мөр/... basmil qarluq yoq bolᠲi qony yīlqa...- басмыл, карлук үгүй болов. Хонин жил (755)... хэмээжээ.

Уг мэдээнд тулгуурлан зарим судлаачид Моюнчур 754 оны 10-р сард Карлук, Басмыл нарыг бүрэн эрхшээлдээ оруулан захирсан³¹ гэж үзсэн байдаг.

²⁴ Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, pp. 135.

²⁵ Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s.421-422.

²⁶ Н.В. Кюнер, Китайские известия о народах Южной Сибири, Центральной Азии и Дальнего Востока, Москва, 1961, стр. 49.

²⁷ С.Г.Кляшторный, Т.И.Султанов, Государства и народы Евразийских степей. Древность и средневековье, Санкт-Петербург, 2000, стр.99.

²⁸ Л.Н.Гумилев, Древние Тюрки, Москва, 1993, стр.363.

²⁹ Liu Mau-tsai, Die chinesischen Nachrichten zur Geschichte der Ost Turken, Buch I-II, Wiesbaden, 1958, s.261; Л.Н.Гумилев, Древние Тюрки, Москва, 1993, стр.364.

³⁰ Н.Я.Бичурин, Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена, Москва-Ленинград, 1950-1953, Том.І-ІІІ; Том.І, стр.308.

³¹ Saadetin Gömeç, Uygur Türkləri Tarihi ve Kültürü, (düzeltilmiş, yeniden gözden geçirilmiş 2. baskı,) Ankara, 1998, s.34.


Энэ цаг үеэс хойш Карлук, Басмыл нар дахин энэ газар нутагт ирсэнгүй бөгөөд дундад Азид буцаж суурьшин торгоны замаар Араб, Ойрхи Дорнодын орнуудтай харилцах болжээ³².

Моюнчурын гэрэлт хөшөөний бичээст давхардсан тоогоор Карлук нэр 12 удаа, Басмыл нэр 4 удаа тохиолдож байгаа нь тэд (Карлук, Басмыл нар)Түргэгийн хаант улсын төгсгөл, Уйгурын хаант улсын эхэн үеийн түүхэн хэрэг явдалд ихээхэн идэвхтэй оролцож байсныг нутлан харуулж байна.

Сурвалжуудын дээрх мэдээ баримт, тухайн үеийн түүхэн хэрэг явдлуудтай харгуулан үзвэл 744-755 оны үед уг бичээс бичигдсэн байж болохоор байна.

Монгол нутгаас Карлук, Басмыл нарт холбогдох руни бичгийн дурсгал анх удаа олдож байгаагаараа ихээхэн онцлогтой болохыг тэмдэглэе.

Бичээст гарах үгийн толь

ᠶᠢᠶᠢᠶᠡ ilbis ilig -  ilbis ilig, Илбис Илиг (хүний нэр)

↓ <<ᠳᠦ qunčuyiᠭ-  günjü-yin, гүнжийн

ᠲᠤᠮᠤᠳᠤ tultonī – бэлэвэрэлийн хувцсыг

-tul-  belbisün, бэлэвсэн

-ton-  qubčasu, хувцас

-t.i

ᠶ᠋ᠯ alu –  abqu, авах

↓ ᠵᠠᠷᠯᠤᠭ qarluq-  qarluq, Карлук

ᠶᠠᠪᠠᠷᠢᠫᠤᠯᠤᠭ qubarip-  quraju, čuyaju, хурж цуглаад

ᠲᠤᠮᠤᠳᠤ tulton- бэлэвэрэлийн хувцас

ᠲᠤᠮᠤᠳᠤ aldī –  abuba, авав

ᠲᠤᠮᠤᠳᠤ üzä-  degedü, дээд

ᠲᠤᠮᠤᠳᠤ [tjrik]ä –  tngri, тэнгэр

ᠲᠤᠮᠤᠳᠤ asra –  door-a, доор

ᠲᠤᠮᠤᠳᠤ yerkä –  yajar-tu, газарт

ᠲᠤᠮᠤᠳᠤ yükünüküm –  jalbaril mini, залбирал минь

ᠬᠤᠰᠢ bar –  bayıqu, байх

ᠮᠠᠷᠲᠢᠨᠠᠳᠤᠮᠤᠳᠤ ärti –  bölüge, бөлгөө

ᠲᠤᠮᠤᠳᠤ yañiltuqim –  buruyudaysan mini, буруутсан минь

ᠲᠤᠮᠤᠳᠤ yoq –  ügei, үгүй

ᠴᠢᠮᠤᠳᠤ basmīlīy-  basmīl-i, Басмылыг (Басмылтай, басмыл голлосон)

ᠲᠤᠮᠤᠳᠤ bodun-  arad tümen, ард түмэн

³²Hüseyin Salman, Karluklar, -Türkler 2, Yeni Türkiye Yayınları, Ankara, 2002, s. 422.

ГУРВАЛЖИН УУЛЫН БИЧЭЭС

Булган аймгийн Гурванбулаг сумаас зүүн өмнө зүг 17 км-т Гурвалжин нэрт багахан шовх уулын бэлд, Тарнын голын баруун талд нэг мөр бичээс буйг судлаачид “Гурвалжин уулын бичээс” гэж нэрлэсээр иржээ.

Дурсгалын байршлын цэг; 1176 т. 48 Т 0391591, УТМ 5276223.

Судалгааны товч

Эл бичгийн дурсгалыг анх мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав гар хуулбар хийж Судар бичгийн хүрээлэнгийн захирал байсан Жамсрангийн Цэвээн гуайд өгсөн гэдэг. Мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав гуай тухайн үедээ нилээд боловсролтой нэгэн байсан гэдгийг түүхийн олон баримтууд нуталдаг билээ.

Тэрээр Франц улсад суралцсан анхны монгол оюутнуудын нэг бөгөөд лавтай мэдэхээс монгол, төвд хэл бичигт нэвтэрсэн тэрээр уг бичээс түүхийн чухаг эх хэрэглэгдэхүүн мөн учир утга агуулгыг мэдэж таниваас зохилтой хэмээн санаж хуулбарлан авсан нь магад буй за.

Ж.Цэвээн гуай 1929 онд Оросын эрдэмтэн А.Н.Самойловичид энэ бичээсийн гар хуулбарыг илгээсэн байна. А.Н.Самойлович хүргүүлсэн хуулбарт тулгуурлан “*tenri quli bitidim*-Тэнгэрийн боол бичив би” гэсэн утгатай болохыг тайлж 1934 онд хэвлүүлсэн ажээ³³.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун “*Gürbelçin kaya yazıtı*” нэртэйгээр А.Н.Самойловичийн нийтлүүлсэн эх галигийг хэвээр нь авч, орчин цагийн турк хэлнээ “*Tanrı kulu yazdım*” гэж хөрвүүлжээ³⁴.

Манай судалгааны ном зохиолуудад нилээд хожим олдож мэдэгдсэн мэтээр тэмдэглэсээр ирсэн билээ. О.Намнандорж гуай 1966 онд Архангай, Булган, Өвөрхангай аймгийн нутгаар 10 хоног аялал, судлалаар явахдаа нутгийн ард Аравжирийн мэдээллийн мөрөөр энэ дурсгалыг үзэж гэрэл зураг авч товч тодорхойлолт бичсэн ажээ³⁵.

Б.Ринчен академич “*Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*” бүтээлдээ уг бичээсийн гэрэл зургийг нийтлүүлсэн байна³⁶. Б.Ринчен академич нийтлүүлсэн гэрэл зургийн эхэд тулгуурлан 1969 онд Б.Базылхан уншиж судалжээ.

Тэрбээр уул бичээсийг “Тенри кулы амысде ит” гэж галиглан монгол хэлнээ “Тэнгэрийн боол одоо эрэл сурал хий” гэж орчуулсныг үзвэл нилээд ташаа уншсан байна³⁷. Судлаач бичээсийг нүдээр үзээгүй нь ташаарах шалтгаан болсон биз ээ. 1975 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх, соёл, бичиг судлалын хэргийн шинжилгээний ангийн “Бичээс судлалын хэсэг” энэхүү Гурвалжин уулын

³³ А.Н.Самойлович, Новые тюркские руны из Монголии, - Известия Академии Наук СССР, Отделение общественных наук, № 8, Москва, 1934.

³⁴ H.N.Orkun, Ulan-Bator (Urga) kiremit yazıtı, -Eski Türk yazıtları II, İstanbul, 1938, pp.161-162, (Birinci Baskı: 1936, 1938, 1940, 1941, İkinci Baskı: 1987, Üçüncü Baskı: 1994, Ankara, pp.353-354).

³⁵ О.Намнандорж, Арван өдрийн шинжилгээний аялал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 38-41 дүгээр тал

³⁶ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc I, Улаанбаатар (Oulan bator), 1968, pp.37.

³⁷ Б.Базылхан, Гурвалжин уулын түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, № 4, 1969, 14-15 дугаар тал.

Гурвалжин уулын хэмээн нэрлэгдэх ганц мөр энэ бичээс уйгуруудын тэнгэрийг шүтэх шүтлэг, тухайн үеийн язгууртан болон бичгийн хүний өөрийгөө бусдад танилцуулах, өөрийнхөө тухай бичих ёс журмын талаар тодорхой мэдээлэл өгч байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Тэнгэрийг шүтэх ёс зөвхөн нүүдэлчид төдийгүй эртний нангиад зэрэг суурьшмал соёл иргэншилт улс гүрэнд ч байсныг түүхийн сурвалжууд баталдаг.

Тэнгэрийн шүтлэг нь магадгүй бөө мөргөл, шашин үүсэхээс өмнө байсан хүн төрөлхтний хамгийн эртний нийтлэг шүтлэг байсан бололтой.

Эртний нүүдэлчид, нэн ялангуяа Хүннү нарын үеэс тэнгэрийг шүтэх шүтлэг, түүнтэй холбогдох ёс заншлын талаар бичмэл болон археологийн сурвалжуудаас бага сага зүйлийг мэдэж болох бөгөөд хожмын түрэг, уйгур улсын үеэс энэ тухай харьцангуй тодорхой тэмдэглэгдсэн байдаг.

Уйгурууд хэдийгээр маанийн шашин шүтэж байсан, маанийн шашинд орсон гэх боловч язгуурын шүтлэг нь тэдний оюун санаанд хуучны адил үнэ цэнэтэй хэвээр хадгалагдсаар байсныг тэдний үлдээсэн чулуун судрын бичээс баттай нуталдаг билээ.

Энэ бичээсээс жишээлэн үзвэл тэр үед уйгурын дээдэс ихэс, язгуурт ноёд ч тэнгэрийн боол, боол би гэж тэнгэрийн агуу их суу, сүр хүчний өмнө өөрсдийгөө өчүүхэн дорд, доройд үзэх үзэл, тийн бичих ёс түгээмэл байсан бололтой.

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт байх “Арханангийн бичээс”-д мөн л “Тэнгэрийн боол” хэмээх үг тохиолдож байгаа зэрэг нь үүний давхар нуталгаа, гэрч гэлтэй.

Манай бичгийн уламжлалд ч мөхөс, дорой хэмээн өөрийгөө танилцуулж бичдэг нь магадгүй эрт цагаас улбаалсан өв уламжлал, өнө эртний бичиг соёлын нөлөө тусгалтай холбоотой буй за.

ГУРВАН МАНДАЛЫН БИЧЭЭС

Судалгааны тойм

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт оройг нь тэгшилж тайрсан мэт нэн өвөрмөц тогтоц бүхий сөнөсөн гурван галт уул буйг “Мандал Хайрхан” буюу Гурван Мандал хэмээн нэрлэдэг байна. Гурван Мандал уул сумын төвөөс 42 орчим км-т баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон, Эхэн Мандал, Дунд Мандал нь хормой нийлэн орших ба харин Адаг Мандал нь хол саахалтын зайтай байх ажээ. Уулын оройн, толигор хар өнгийн ханан хаднаа олон зүйл зураг, тамга, руни бичиг сийлжээ. Уулын оройгоос өнхөрч бэлд тогтсон толигор гадаргатай том бага, үхэр хонин хаданд ч зураг сийлсэн байна.

1987 оны 8-9 сард ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Дашцэвэл, Р.Бямба нар Гурван Мандалын дурсгалыг анх олж судлаач нарт мэдээлсэн байна⁴¹.

Доктор Л.Болд нар эл бичээсийг уншиж тайлан “Гурван мандлын түрэг бичээс” нэртэйгээр хэвлүүлсэн бөгөөд улмаар “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс” номдоо оруулжээ⁴².

Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн “Бичээс судлал”-ын ангийнхан 1989 онд гүймэг судалгаа хийсэн бөлгөө⁴³.

Доктор Д.Баяр Гурван Мандал уулын хадны бичээс тамга, тэмдгийг тухайлан судлан “Гурван Мандалын хадны зураг” хэмээх өгүүлэл нийтлүүлжээ⁴⁴.

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал номд “Гурван Мандалын бичээс”-ийг Л.Болд гуайн уншлага, орчуулгаар оруулсан байна⁴⁵.

Бид 2003 оны 10 дугаар сард Гурван Мандал уулыг зорин очиж хадны зураг, эртний бичээс, тамга тэмдгийг судалсан бөгөөд нэгэн сэдэвт ном гаргахаар зэхэж байгаа болно.

⁴¹ Л.Болд, Р.Бямба, Гурван Мандалын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал.

⁴² Л.Болд, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 25-27 дугаар тал.

* Уг ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МУИС-ийн оюутан З.Дараже, Зөвлөлтийн талаас түрэг судлаач С.Г.Кляшторный, археологич В.Е.Войтов, гэрэл зурагчин В.Еремеев, жолооч Р.Бухаров нар оролцож ажилласан байна.

⁴³ Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан ажлын тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1989.

⁴⁴ Д.Баяр, Гурван мандалын хадны зураг, -Археологийн судлал, Том XVI, fasc.1-11, Улаанбаатар, 1996, 89-102 дугаар тал.

⁴⁵ Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 207 дугаар тал.

Дунд Мандалын бичээс

Дунд Мандал уулын баруун урд талд, ханан хаднаа гурван хэсэг руни бичиг, нижгээд тамга буй нь арваад алхмын газраас тодорхой харагдана.

Бичээсийн эхний хоёр мөр тус тус гурван тэмдэгт, гуравдугаар мөр 9 үсэг тэмдэгтэй. Бичээсийг хадны өнгөн хэсгийг холцруулан төдий л гүнзгий бус сийлжээ.

Дунд Мандалын бичээсийг проф. Л.Болд гуай “А” бичээс хэмээн болзоллоор нэрлэж улмаар уншиж тайлсан судалгаагаа нийтлүүлсэн байна⁴⁶.

Доктор Д.Баяр Дунд Мандалын хадны зургийн тухай өгүүлэлдээ эл бичээсийн зургийг оруулан хэвлүүлжээ.

Бидний авсан хэв дардас, гэрэл зураг, бусад эх хэрэглэгдэхүүн проф. Л.Болд гуайн нийтлүүлсэн эх болоод уншлагаас ихээхэн зөрж байгаа тул өөрсдийн судалгааг толилууля.

Дунд Мандалын бичээсийн эхийн сийрүүлэг;

ᠴᠢᠰᠢ .1

ᠯᠢ .2

ᠶᠡᠭᠦᠨᠭᠠᠯᠢᠭ .3

Үсгийн галиг;	Үгийн галиг;	Орчуулга;
1. t B z	1. täbiz / tabiz/	1. Тебиз /Табыз/
2. Qis	2. qis /qiš/	2. өвөл
3. rTWNL᠋ᠯa wQ	3. är tunulī᠋ᠨ /tunulu᠋ᠨ/ elä oq	3. Эр /баатар/ Тунулын гарт сум

Тайлбар

ᠴᠢᠰᠢ täbiz/ tabiz – Тевиз /Табиз/ хэмээх хүний нэр бололтой.

Уг үгийг “tabi~tapī az”⁴⁷ гэж унших боломж, нэгэн хувилбар байж болох бөгөөд хоёрдугаар мөрийн “өвөл” гэх үгтэй холбон “өнтэй бус, тааламжгүй, сайнгүй /зудтайвтар/ ” гэсэн утгатай хэмээн таамаглаж болно. Харин эсрэгээрээ “tapiz” нь “өнтэй, тарган тавлаг” гэсэн үг байхыг ч үгүйсгэх аргагүй. Дараа дараагийн судлаач нар улам тодотгон нягтлах буй за.

ᠶᠡᠭᠦᠨᠭᠠᠯᠢᠭ är tunulī᠋ᠨ /tunulu᠋ᠨ/ ilä oq- үгчлэн “Эр /баатар/ Тунулын гарт сум” гэж монгол хэлнээ орчуулж болох ч утга хараахан бүрэн төгсөөгүй гэлтэй. Эр Тунул нэрийн “эр” нь баатар, зоригтой, эрэлхэг гэх утга агуулсан цолноос үүдэлтэй нь мэдээж ба цол, өргөмж нь хүний нэрийн өмнө тодотгол хэлбэрээр тохиолдох нь монгол түрэг хэлнээ нийтлэг байна.

⁴⁶ Л.Болд, Р.Бямба, Гурван мандлын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал; Л.Болд, Гурван Мандалын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 25-27 дугаар тал.

⁴⁷ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.534.

↓ оq -сум хэмээх үг 1. нум, сумын нум, 2. эртний түрэг, уйгурын бичгийн дурсгалд олонтоо гарах “он ок” буюу “арван овог” гэсэн утгатайг бас санах хэрэгтэй.

↓Y- Хэрэвзээ энэ үгийг “↓-Y el-a(ä)” гэсэн бүтэцтэй нэр үг хэмээн ухаарвал “гар-(н)аа, гар-т” гэж орчуулж болно.

“↓-Y il-a(ä)” үйл үг мөн гэж үзвэл бичээсийн утгад дүйцүүлэн “тавих, илгээх” гэж утгачлан буулгаж болох юм.

Эл үгээс үүдээд уншлагын хоёр хувилбар гарч байгаа юм.

Нэгдүгээрт бидний дээр өгүүлсэн “1. tābiz (tabīz) 2. qis (qīš) 3. ār tunulīn (tunulun) elā oq” буюу ↓Y-г “el-a(ä)~ гар-(н)аа, гар-т” гэх үг гэж үзвэл “1.Тебиз (Табыз) 2. өвөл 3.Эр (баатар) Тунулын гарт сум” гэж тайлах боломж буй.

“Өвөл Эр Тунулын гарт сум” гэснээс үзэхэд аян дайн байлдааны үеэр бичсэн бус харин намрын сүүл, өвлийн эхэн сарын их ав хомрогын үеэр энд бичээс үйлдсэн байх магадлал ихтэйг харуулж байна. Нөгөө талаар, Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын зэрэг бичээсээр жишээлэхэд ер нь хадны бичээс, нэн ялангуяа хадны зураг олонтой газрын бичээс голдуу ан авын тухай өгүүлдгийг бас харгалзан үзэх хэрэгтэй болов уу.

Хадны зурагт олон ан амьтан дүрсэлсэн нь эрт цагаас энд ан ав, гөрөө ихтэй байсны гэрч төдийгүй Мандал уулын ус ундтай, нөмөр нөөлөгт байдал нь ч ан амьтан элбэгтэй байсныг бэлхнээ баталж байна.

Хоёрдугаарт, “1. tābiz (tabīz) 2. qis (qīš) 3. ār tunulīn (tunulun) elā oq” буюу ↓Y “il-a(ä)”-г үйл үг гэж үзвэл бичээсийг “1.Тебиз (Табыз) 2. Акыс (Кыс) 3.Эр (баатар) Тунулун илгээ (тавь) сум” гэж үгчлэн тайлах боломж бас буй.

Аль ч хувилбараар уншсан гуравдугаар мөр бичээсийн гол санааг агуулж буй нь тодорхой байна.

Хоёрдугаар хувилбараар сэргээн уншсаныг “Эр (баатар) Тунулун сум тавив” гэж утгачлан буулгах боломжтой мэт. Ав гөрөөнд ирж анх Эр (баатар) Тунулун (Тунулан) гэгч нум эвшээлгэж сум тавьснаар (ан авласнаар) ав хомрог эхэлснийг тэмдэглэн үлдээсэн байж болох юм.

Тебиз (Табыз), Акыс (Кыс) нь энэ үйл явдлыг гэрчлэгч, оролцогч этгээдүүд буюу эсвээс тэр удаагийн ан хомрогын түүхэн үйл явдлыг хаднаа цохиж үлдээгсдийн нэр ч байж мэднэ.

Уг бичээсийн утга дараа дараагийн судалгаагаар улам лавтай, тодорхой болох буй за. Нэгэнт хоёр хувилбараар буй тул бичээст гарах үгийн толийг мөн хоёр хувилбараар оруулав.

Бичээст гарах үгийн толь

- ᠲᠠᠪᠢᠵᠢ tābiz (tabíz) –  tabiz, хүний нэр
ᠡᠪᠦᠯ ebül, өвөл
ᠠᠬᠢS aqis, qis-  akis, хүний нэр
ᠶ äär –  er-c, bayatur, эр, баатар
ᠲᠤᠨᠤᠯᠤᠭ tunulung, хүний нэр
ᠶᠡᠯ el - гар  yar гар
ᠲᠠᠪᠢᠴᠢ il (ilä, elä)-  talbiqu, тавих
ᠰᠤᠮᠤ oq –  sumu, сум

Проф. Л.Болд уг бичээсийг доорх мэт галиглан уншиж орчуулсан байна.

Үсгийн галиг:

I. т (2) б (1) з

II. к (1) ы (-и) с

III. р (2) т (1) м л (1) нг ч ы (-и) к (1)

Үгийн галиг:

I. ата быз ...

II. ... Акыс ...

III. ер атым Улунгчик (-Олунгчык) 3. эр нэр минь Улунгчык⁴⁸

Орчуулга:

1. ...эцэг бид...

2. ...Акыз...

⁴⁸Л.Болд, Р.Бямба, Гурван Мандалын түрэг бичээс, -Дорно дахины судлалын асуудал, 1988, №1 (19), 103-108 дугаар тал.

Адаг Мандалын бичээс

Адаг Мандалын бичээсийг проф. Л.Болд гуай “Б” бичээс хэмээн нэрлэжээ.

Уг бичээсийг уншиж тайлан тухай өмнөх эрдэм шинжилгээний өгүүлэл болон номд нийтлэгдсэн хуулбар нь эх бичигтэйгээ нилээд зөрж байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг;

ᠬᠠᠲᠤᠮᠠᠨᠳᠠᠯᠠᠨᠪᠢᠴᠡᠭᠡ

ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨ

ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨ

Үсгийн галиг;

1. QTLTWNdrrt
2. nl ükQiz: QRGz: ёQ:k
3. TWnyLG: түртглта: түр QN

Үгийн галиг;

1. Qut altun äd ärtüti
2. Inälük qiz qarayaz açqa iki
3. tunyaluy tör tägi iltä tür qan

Хэдийгээр бичээсийн эхэд дурдсан мэт байрлалтай байгаа ч эхний мөрийн төгсгөл хоёрдугаар мөрийг бараг дарах шахам дууссан нь нэн сонин, хачирхалтай санагдаж байгаа юм. Бичээсийн бичлэгийн хэлбэр, үсэг тэмдэгтийг бичсэн байдал, тамга тэмдэг сийлсэн ур дүйг үзвээс яах аргагүй “руни үсэг бичигт тайлагдаж боловсорсон нэгэн” бичсэн болохыг гэрчилнэ.

Гэтэл чухам яагаад эхний мөрийг “хайнга” дээрээс доош уруудуулан хазгай бичсэн бол гэсэн асуулт зүй ёсоор гарч байгаа юм. Бидний санахад эхлээд олон зүйл тамга тэмдэг сийлсний хойно бичиг бичих санаа төрж улмаар тэдгээр сийлсэн тамганы дундах зайг ашиглаж энэ бичээсийн үйлдсэн бололтой. Тэгэхдээ нэгдүгээр мөрийн дээд талд хоёрдугаар мөрийг, хоёрдугаар мөрийн дээд талд гуравдугаар мөрийг тус тус бичжээ.

Эхний мөрийг тамгатай залгуулан бичсэнээс дараагийн мөрийг бичихэд бэрхтэй болж, хоёрдугаар мөрийг эсвэл тамганы доор, үгүй бол нэгдүгээр мөр бичээсийн дээд талд бичихэд хүрсэн бололтой.

Тамганы доор бичих боломжгүй, хадны барзгар, хагархай, толигор бус хэсэг дайрснаас шууд нэгдүгээр мөрийн дээд талд бичсэн байна. Иймд бичээсийг доорхи дарааллаар мөрлөн дугаарлаж болох юм.

Бичээсийн эхийг зөв дараалалд оруулан сийрүүлбэл;

ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨ

ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨ

ᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠡᠢᠶᠢᠭᠡᠨ

Үсгийн галиг;

1. TWnyLG: түртглта: түр QN
2. nl ükQiz: QRGz: ёQ:K
3. QTLTWNdrrt

Үгийн галиг;

1. tunyaluy tör tägi iltä tür qan
2. Inälük qiz qarayaz açqa iki
3. Qut altun äd ärtüti

Үгчилсэн орчуулга:

1. Хатуу чанга хууль ёс мэт улстай Төр хан
2. Итгэлт охин Карагаз, Ачха хоёр
3. Өлзийт алт, эд агуурс хүргүүлэв

Эх бичиг яруу найргийн хэлбэрээр бичигдсэн тул толгой холбон шүлгийн хэлбэрт оруулан

1. *Чанд хатуу хууль ёст хүчирхэг улстай Төр хан*

2. *Чин итгэлт охин Карагаз, Ачка хоёр*

3. *Өлзийт алтан эд агуурс хүргүүлэв* гэж буулгаж болно.

Гэхдээ чанд хатуу төртэй /хууль ёст/ баг бэх улстай Төр хан, түүний үнэнч охид Карагаз, Ачка хоёр чухам яагаад хэнд өлзийт сайн эд агуурс хүргүүлэх болсон, энэ тухай сэтгэл хангалуунаар бичүүлж үлдээх болсон шалтгааныг лавлан тодруулах зайлшгүй шаардлагатай.

Нэгдүгээрт, эхний хоёр өгүүлбэрийн төгсгөлийн “хан, хоёр” гэсэн үгс ерөнхийлөн хамаатуулахын ө нөхцлөөр хэлбэржсэн байна хэмээн үзэж тайлбарлах.

Эртний түрэг хэлний сурвалжийн хэлний судалгаанаас үзэхэд ерөнхийлөн хамаатуулах нөхцөл ө хэлбэрээр илрэх нь олонтоо байдаг⁴⁹. Нэн ялангуяа яруу найраг, шүлгийн айзамт өгүүлбэрт харьцангуй олон тохиолдоно.

Нэг, хоёрдугаар мөрийн төгсгөлийн үгс ерөнхийлөн хамаатуулахын ө нөхцлөөр хэлбэржсэн гэж үзвэл монгол хэлнээ бичээсийг;

Чанд хатуу хууль ёст хүчирхэг улстай Төр ханаа

Чин Илтгэлт охин Карагаз, Ачка хоёроо

Өлзийт алтан эд агуурс /тай/ хүргүүлэв гэж орчуулж болно.

Хоёрдугаарт, эртний нүүдэлчдийн ёс заншилтай холбон тайбарлаж болох юм. Худ ураг барилдаж охиноо хадамд гаргах, бэлэг сүйд охиноо өгөх, бэлэглэх нь эртний нүүдэлчдийн ёс заншлын нэгэн нийтлэг билээ. Нүүдэлчдийн түгээмэл энэ ёс заншлын талаар руни бичгээр гэрэлт хөшөө чулуунаа тэмдэглэн үлдээсэн нэн чухаг ховор сурвалжийн нэг бол Сүүжийн давааны бичээс юм. Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт 1913 онд Булган аймгийн нутаг Сүүжийн даваа гэдэг газраас олсон энэ бичээсийн 6,7-р мөрөнд “(надад) долоон дүү, гурван хүү, гурван охин бий. Хөвүүд минь гэрлэжээсэн. Охиноо сүйгүйгээр мордуулав...⁵⁰” гэж буй нь тухайн үеийн гэрлэх, охиноо мордуулах ёс ямар байсныг хамгийн бодитой харуулсан гэж үзэж болно.

Сүүжийн давааны бичээсийн дээрх мэдээнд тулгуурлан ёс заншлын улбаа, уламжлалыг харгалзан үзвэл, баян чинээлэг нэгэн өөрийн Карагаз, Ачка нэрт хоёр охиноо, Төр хэмээх хаанд өлзийт сайн эд агуурсын хамт хүргүүлсэн, охиноо хадамд гаргаж мордуулсан тухай энд тэмдэглүүлсэн /бичүүлсэн/ бололтой.

⁴⁹ Cengiz Aylılmaz, Orhun Yazıtlarının söz dizimi, -Atatürk Üniversitesi, Yayınları №830, Erzurum, 1994, s.48.

⁵⁰ G.J.Ramstedt, -Zwei Uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, - Journal de la Soc.Finno-grienne, XXX,3, Helsinki, 1913, p.3-9.

Тайлбар

ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰᠤ tunyluy (tunyalıy) - энэ үгийг бид “бат бэх, тулгууртайн учир хүч чадалтай, тогтвортой” гэсэн утгатай хэмээн үзэж байна. Монголын нууц товчоонд “**tuyal**” гэх үг “...tulu metü beye cinu tulbas odu'asu **tuyal** metü ulus cinu ken-mede'ülkün tede...” (§245, §254)⁵¹ гэж хоёр удаа тохиолдож байна.

Энэ үг (tuyal)-ийн нангиад эхийг үзвэл (§245), 群鳥qúnniāo (“сүрэг шувуу”) (§254) 雀群quèqún (“бязлуухайн сүрэг”) гэсэн утгатай ханз байх юм.

Жич тэмдэглэхэд, “tulu” хэмээх үг эдүгээ бидний мэдэх “тул загас” гэдгийн “тул” бус, харин хятад орчуулгаас үзвэл, 柱脚 zhùjiǎo буюу “багана, тулгуур, суурь” гэсэн үг байгааг дурдууштай.

Мөн **turqag-i, turqaq, turqa'ud-i, turqa'ut** гэх зэрэг үгсийг дурдаж болох ба жишээ нь “dalan **turqag-i** yekes turqa'ut ke'ekdün arqai-yin ba'atud-i ötögüs ba'atud ke'etkün ...” (§230)⁵² гэж гардаг.

Монгол хэлнээ тураг (turaγ) амьтан (амьтны том биетэй нь), тураг мах (амьтны их биеийн ба хар мах)⁵³ гэх үг буй. Бас хүч чадалгүй, эр бяргүй, доожоогүй, тулх, тулгуур муутайг туниагүй, туниа (tuniya) муутай гэж хэлдэг.

Харин туниатай туниат, туниалиг гэх эсрэг утгатай үгс байдаггүй. Туниагүй, туниа муутай гэж голдуу эрэгтэй хүнд хандаж хэлдэг нь бас учиртай мэт санагдана.

Эрт цагт tunyluy (tunyalıy) гэсэн үг тамирлиг, чадалтай, хүч чадалтай, баатар, бат бэх, хатуу чанга гэсэн утгатай байсныг ч бас үгүйсгэх аргагүй.

Чуваш хэлнээ “туя”⁵⁴ нь таяг (tayay) гэх үг бөгөөд тулах, тулгуур гэх язгуур утгаа хадгалан үлджээ. Монгол хэлний таяг (tayay), тулга (tuly-a), чуваш хэлний туя, түрэг хэлний tu-du, tur-dur (turmak, durmak-зогсох) цугаар “tu” язгуураас гаралтай тул, тулах, тулгуур гэх утгатай үгс болно.

Орчин цагийн турк хэлэнд “dayanıklı / *tu<tuny<tu{ ñ /η/}ıq < tayııq < dayanık”⁵⁵ бат бэх, хүчтэй, чадалтай, бэрх гэсэн утгатай үг бий.

Дээрх цухас дурдсан баримт нь “tu” язгууртай үгс нэгдүгээрт их, том, олон, гол, цөм (tulu, tuyal, turaγ), хоёрдугаарт бат бэх, тулгууртай (tunyluy, туя, tayay tuly-a, dayanıklı), гуравдугаарт хүчтэй, чадалтай (том, бат бэх нь хүч чадалтайн баталгаа) гэсэн утга тус тус илэрхийлдэг болохыг нуталж байна. Өгүүлсэн жишээ, эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан дүгнэхэд Tunyuquq, tunyaluy нь бат бэх, хүч чадалтай гэсэн утгатай өргөмж цол бололтой.

ᠲᠦᠷ **tör** -төр. Төв Азийн нүүдэлчид эрт цагт ёс, хууль, ёс журмыг ерөнхийд нь “төр (ᠲᠦᠷ **tör**)” гэдэг байсан нь олон зүйл баримтаар баттай

⁵¹ Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, -Indiana University, Bloomington, 1992, pp. 325; Part I, text, pp. 142, 149.

⁵² Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, - Indiana University, Bloomington, 1992, pp. 324; Part I, text, pp. 133.

⁵³ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 558 дугаар тал; Ts.Norjin, M.Mören, Mongyol kelen-ü toli, Сiyulyatu qayaly-a, 1997, 2421, 2422 дугар тал-a; Seceñçoytu, Mongyol üges-ün ijayur-un toli, 1988.

⁵⁴ Чувашко-русский словарь (25 000 слов), Москва, 1961, стр. 447.

⁵⁵ Türkçe Sözlük, Türk Dil Kurumu, I, A-J, yeni baskı, Ankara, 1988, s. 342.

нутлагдах бөгөөд бидний монголчууд нийтээр дагах ёс, хууль, ёс журмыг соёрхон гаргадаг, ханган сахиулдаг “дээд байгууллага”-ыг нэрлэх болжээ.

Бичээст гарах үгийн толь

ᠠᠨᠠᠭᠠᠨᠠ tunyaluy - ᠠᠨᠠᠭᠠᠨᠠ qatayū, čingy-a, хатуу, чанга

ᠲᠦᠷᠦ tör - ᠲᠦᠷᠦ, ᠲᠦᠷᠦ törü, yosu, төр ёс

ᠮᠡᠲᠦ metü, sig, мэт, шиг

ᠤᠯᠤᠰᠢ /il-tä/ - ᠤᠯᠤᠰᠢ, ᠤᠯᠤᠰᠢ ulus, ulus-tai, улс, улстай

ᠲᠦᠷᠦ түр - ᠲᠦᠷᠦ түр, хүний нэр

ᠬᠠᠨ qan - ᠬᠠᠨ qan, хан

ᠦᠨᠡᠨᠴᠢ inälük /inälik/ - ᠦᠨᠡᠨᠴᠢ, ᠦᠨᠡᠨᠴᠢ ünenči, dotunu, үнэнч, дотно, итгэлт

ᠬᠢᠨ qiz - ᠬᠢᠨ ökin, охин

ᠬᠠᠷᠠᠭᠠᠶᠠᠰ qarayaz - ᠬᠠᠷᠠᠭᠠᠶᠠᠰ qarayas, хүний нэр

ᠠᠴᠠ ačqa - ᠠᠴᠠ ačqa, хүний нэр

ᠬᠡᠶᠢ iki - ᠬᠡᠶᠢ qoyar, хоёр

ᠪᠠᠶᠠᠨ qut - ᠪᠠᠶᠠᠨ, ᠪᠠᠶᠠᠨ öljei, buyan, өлзий, буян

ᠠᠯᠲᠤᠨ altun - ᠠᠯᠲᠤᠨ altan, алт, алтан

ᠡᠳᠦ äd - ᠡᠳᠦ ed, эд, эд агуурс

ᠠᠶᠤᠶᠤᠯᠠᠬᠤ ärürti - ᠠᠶᠤᠶᠤᠯᠠᠬᠤ, ᠠᠶᠤᠶᠤᠯᠠᠬᠤ yabuylqu, oduylqu, явуулах, одуулах хүргүүлэх

Проф. Л.Болд эл бичээсийг доорхи мэт галиглан уншиж орчуулсан байна.

Үсгийн галиг:

I. т (1) м д (2) р (2)

II. н (2) ч к (2) к (1) ы (-и) з к (1) р (1) г (1) з л (2) нг к (2)

III. т (1) о (-у) м л (1) г (1) т (2) ө (-ү) р (2) к (2) г (2) л (2) т (2) а (-е)

Үгийн галиг:

I. ... атым др...

II. еничык Акыз кыргыз елентке

III. ... утумлыг түрк егелтке...

Орчуулга:

1. нэр минь др...

2. еничык Акыз кыргыз улсад

3. ...Утумлыг түргийн эгэл түмэнд...

Дээрх бичээсийн үг хэллэгийн тайлбарыг эртний түрэг хэлний толиудаас лавлан үзнэ үү⁵⁶.

⁵⁶ Древнетюркский словарь, Ленинград, 1969; Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972; Э.В.Севортян, Этимологический словарь тюркских языков,

2. Тамга тэмдэгтийн судалгааны тойм

Гурван Мандалын уулын хаднаа давхардсан тоогоор ная илүү тамга тэмдгийн зүйл тоолсон билээ. Бид тамга тэмдгийн тоо гаргахыг хичээж нэг бүрчлэн тоолоогүй, зөвхөн замд дайралдсан тамга, тэмдгийг бүртгэснээ тэмдэглэе.

Говь-Алтай аймгийн Цагаан гол, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад зэрэг тамга тэмдгээр алдартай дурсгалуудад дөхөж очих олон тооны тамга Гурван Мандалын уулнаа лавтай бий.

Нэн ялангуяа түрэг, уйгурын үед холбогдох тамга тэмдгийн олон хувилбарууд байгааг онцлон дурдууштай.

Доктор Д.Баяр “Энэхүү Гурван Мандал уулын хадны сүг зургийн дотор эртний овог аймгийн тамганы дүрс олон тоотой байх ба эдгээрийг нарийвчлан тодорхойлж сэдэвчлэн ангилахад жич судалгааны ажил шаардлагатай юм.

Эндхийн тамгадын дотор нэн олон тоотой нь онги тамга бөгөөд үүний олон янзын хувилбар байна. Түүнчлэн сэрээ, хайрлага, чагтан болон янгир зэрэг тамга ч байх ажээ” гээд зарим эрдэмтэд хоёр эвэртэй онги тамгыг хүннү нартай холбогдуулан тайлбарласан байдгийг дурджээ⁵⁷.

3. Хадны зургийн судалгааны товч

Доктор Д.Баяр хадны зургийг дотор нь сийлмэл зураг, сараачмал зураг гэж хоёр зүйл хувааж тайлбарласан бөгөөд зургуудыг бүтээсэн цаг хугацааны тухайд “Дээрх байдлаас үзэхэд Гурван Мандалын хаданд буй нэлэнхүйд нь цохих буюу тойруулан хөвөөлж цохих аргаар дүрсэлсэн зургуудын эртнийх нь, судлаачдын сайтар судлан гаргаснаар м.т.ө. II мянган жилийн сүүлийн хагасаас м.т.ө. I мянган жилийн тэргүүн хагаст холбогдохоор байна. Тэгээд ч ан гөрөө хүмүүсийн аж ахуйн үйл ажиллагааг дүрсэлсэн сэдэв хадны зурагт хүрэл төмрийн түрүү үеэс гарч ирсэн байна”⁵⁸ хэмээн тодорхойлжээ.

Бид өвөрмөц дүрслэл бүхий 150 гаруй зургийг сонгон монгол нутгаас олдсон хадны зургууд түүнчлэн бусад ижил төсөөтэй зургуудтай харьцуулан үзэхийг хичээсэн билээ.

Гурван Мандал уулын хадны зурагт хүрэл зэвсгийн үед холбогдох зураг зонхилж байна.

Эцэст тэмдэглэхэд, Гурван Мандал уулнаа хүрэл, төмөр болон Хүннү гүрэн түүнчлэн Түрэг, Уйгур зэрэг Монгол нутагт оршин тогтнож байсан үе үеийн олон улс, аймгуудын түүх, бичиг, соёлын цогц дурсгал хадгалагдан үлджээ.

Москва, 1974; Э.В.Севортян, Л.С.Левецкий, Этимологический словарь тюркских языков, Москва, 1989.

⁵⁷ Д.Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Том.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 92 дугаар тал.

⁵⁸ Д.Баяр, Гурванмандалын хадны зураг, -Археологийн судлал, Том.XVI, fasc. 1-11, Улаанбаатар, 1996, 95 дугаар тал.

ДЭЛ УУЛЫН БИЧЭЭС

Эртний түүх, соёлын нэгэн томоохон цогцолбор дурсгал Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл ууланд буй билээ.

“Түүх соёлын цогцолбор” хэмээн нэрлэхийн учир нь 60 гаруй км үргэлжлэх уг уулнаа хэдэн арван мянгаар тоологдох хадны зураг байхаас гадна руни, нангиад, монгол, төвд бичээс, түүнчлэн булш хиргисүүр, сул хийдийн туйр нэг газар цогцолсонд оршиж байгаа юм. Эрдэмтэд Дэл уулын хадны зургийг голлон судалжээ. Дэл уулын цөөн хэдэн булш хиргисүүрийг малтан шинжилсэн боловч судалгааны ажлын тодорхойлолт, үр дүнгийн талаар ямар ч мэдээлэл байхгүй ажээ.

Дэл уулын дурсгалын цөм хэсэг орших Зүүн Билүүний аманд бидний сайн мэдэхээр хүрлийн үеийн дөрвөлжин булш, түрэгийн үеийн хашлага, зэл /балбал/ чулуутай булш лавтай бий. Сүүлийн жилүүдэд бичгийн дурсгалыг нь илүүтэй судалсан байна. Дэл уулын хадны зургийг Д.Дорж, Э.А. Новгородова нар анх удаа судалсан байна⁵⁹. Энэ судалгаанаас хойш 12 жилийн дараа буюу 1987 онд МУИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч доктор Д.Хүүхэнбаатар, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав нар руни бичгийн I, II дурсгалыг олж илрүүлжээ⁶⁰. Монгол-Зөвлөлтийн түүх, соёл судлалын хамтарсан хээрийн шинжилгээний анги 1989 оны 7-р сарын дундуур Дэл уулнаа очиж руни бичиг болон хадны зарим зургийг хуулбарлан авсан байна⁶¹. Тийнхүү зорин очиж судалсан эрдэмтэд дээрх руни бичээсийг уншиж тайлсан эсэх нь тодорхойгүй байна. Т.Санжмятав “Монголын хадны зураг” хэмээх номдоо Дэл уулын зураг, мөн руни бичгийн I, II дурсгалыг тус тус хэвлүүлжээ⁶². Дэл уулын Баруун Билүүний нэгдүгээр бичээсийг судлаач Ю.Болдбаатар анх удаа уншиж тайлан шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна⁶³. II, III, IV бичээсийг Ц.Баттулга⁶⁴, Зүүн Билүүний хятад бичээсийг Ц.Баттулга, Ц.Төрбат нар тайлан уншжээ⁶⁵. Б.Напил Дэл уулын бичээсүүдийг судлан нийтлүүлжээ⁶⁶. Дэл уулын, уйгуржин хэлбэрийн нэгэн бичээсийг одоо болтол судлаачид тайлж уншаагүй байсаар ажээ.

⁵⁹ Д.Дорж, Э.А. Новгородова, Петроглифы Монголии, Улаанбаатар, 1975, 31дүгээр тал,таблиц-Х.

⁶⁰ Т.Санжмятав, 1988 оны хээрийн шинжилгээний тайлан, -Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1988.

⁶¹ Б.Баяр, Д.Эрдэнэбаатар, МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан тайлан, - Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг, 1989.

⁶² Т.Санжмятав, Монголын хадны зураг, Улаанбаатар, 1995, 40-42дугаар тал, таблиц 125-143.

⁶³ Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica vol. 10(31), Улаанбаатар, 2000, 219-226 дугаар тал.

⁶⁴ Ц.Баттулга Дэл уулын баруун Билүүний II III бичээс, -Археологийн судлал, Том. ХУIII, fasc. 1-16, Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын IV бичээс, -Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол судлалын сургууль, Боть ХIY (151), V дэвтэр, Улаанбаатар, 1999, 74-79 дугаар тал; Ц.Баттулга Ц. Монгол Солонгосын эрдэмтдийн хамтарсан “Дэл уулын дурсгалын судалгаа”-ны урьдчилсан дүнгээс, -Монгол Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний III урал, Улаанбаатар, 2002, 88-98 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын нэгдүгээр бичээсийг дахин нягтлах нь, - Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол, хэл, соёлын сургууль, Боть ХХII (227), Улаанбаатар, 2004, 12-17 дугаар тал.

⁶⁵ Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулаас шинээр олдсон хятад бичээс, - Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС. Монгол судлалын сургууль, Боть ХУIII (169), Улаанбаатар, 2001, 103-105 дугаар тал.

⁶⁶ Н.Базылханцлы, Моңғолияда хянадан табылган түрик бітік жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000. стр.68-78.

1. Тэнгэр эзэн /хан/ минь, өвдсөн (алжаасан) зовлон үгүй
2. Тавин цэргийн тэргүүн Өгү Алук Чаяа баатар жаран хулан авлав. Хавтгай авлав. Хорин чоно авлав.

Тайлбар

1. ᠲᠡᠩᠭᠡᠷ ᠡᠵᠡᠨ /хан/ минь, өвдсөн (алжаасан) зовлон үгүй
үг ямагт ᠲᠡᠩᠭᠡᠷ tenᠭi хэлбэрээр бичигддэг. Харин эл бичгийн дурсгалд ᠲᠡᠩᠭᠡᠷ tānᠭi гэж бичсэн нь бичиг бичигч сийлэгчийн санамсаргүй гаргасан зөв бичихзүйн алдаа юу эсвэл өөрийнх нь дуудлага, аялгууны онцлог уу гэдгийг ялган хэлэх боломжгүй, юутай ч уламжлалт тогтсон бичлэгээс зөрүүтэй бичжээ.

Манай зарим эрдэмтэн судлаачдын туурвисан руни бичгийн талаар судалгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний ном бүтээлд руни бичгийн бага дурсгалуудын өвөрмөц бичлэгтэй, уншиж тайлах, тайлбарлахад бэрхтэй үгийг “Орхон бичгээс өөр аялгуугаар бичжээ гэх буюу Күл-тегин, Тонькук нарт зориулсан хөшөөний бичээсийг бичсэнээс өөр аялгуугаар бичсэн нь нилээд тодорхой байна” гэх зэргээр өгүүлсэн байдаг нь учир дутагдалтай дүгнэлт юм.

Зөв бичихзүйн дээрх мэт өвөрмөц хэлбэр(алдаа мадаг?) бүр, уншиж тайлахад бэрхтэй үг бүхэн нутгийн аялгууны онцлогийг тусгасан баримт болж чадах эсэх нь туйлын эргэлзээтэй хэрэг. Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудыг хаад, ихэс язгууртан нарт зориулан сар, жилийн турш бэлтгэж сийлэх тул алдаа мадагтай байх учир шалтгаан үгүйгээс гадна хаад, ихэсийн бичгийг осолдож буруу бичих нь зүйд нийцэхгүй. Бага бичээсийг хэн нэгний алдар нэр, гавьяа зүтгэлийг мөнхжүүлэх, түүхэн хэрэг явдлыг тэмдэглэх, өөрийн санаа бодол, хүсэл сэтгэлээ илэрхийлэх зорилгоор богино хугацаанд шууд бичиж цохисон буй.

Тиймээс сонгодог бичгийн дурсгалуудыг бага бичгийн дурсгалуудтай харьцуулж, нэн ялангуяа нутгийн аялгууны тухай ярих боломжгүй мэт.

Уг үгийг уйгур, монгол бичгийн сурвалжуудад  tᠭi, дөрвөлжин бичгээр dᠡᠭ-ᠲᠢ⁶⁹ гэж бичиж хэвшин уламжлагджээ.

Уг үгийг уйгур, монгол бичгийн сурвалжуудад  tᠭi, дөрвөлжин бичгээр dᠡᠭ-ᠲᠢ⁷⁰ гэж бичих хэвшиж тогтсон уламжлал бий.

Гэтэл хэмжээ, агуулга, ач холбогдлоороо “Монголын нууц товчоо”-ны дараа орох дундад үеийн монгол хэлний чухал дурсгал “Хуа -и И-Юй (華夷圖)” толь бичгийн доод дэвтэрт захидал харилцааны 12 бичгийг унших хэрэглэгдэхүүн

⁶⁹ Н.Н.Поппе, Квадратная письменность, Москва-Ленинград, 1941; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, -Bibliotheca Mongolica: Monograph II, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2001, (Дөрвөлжин бичиг), 80-114 дүгээр тал; Жанчив Ё, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, Улаанбаатар, 2002; Д.Төмөртогоо, Монголын дөрвөлжин үсэгийн дурасгалын судлагаа, Улаанбаатар, 2002.

⁷⁰ Н.Н.Поппе, Квадратная письменность, Москва-Ленинград, 1941; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, -Bibliotheca Mongolica: Monograph II, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2001, (Дөрвөлжин бичиг), 80-114 дүгээр тал; Жанчив Ё, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, Улаанбаатар, 2002; Д.Төмөртогоо, Монголын дөрвөлжин үсэгийн дурасгалын судлагаа, Улаанбаатар, 2002.

болгон эмхэтгэн оруулсаны бичиг тус бүрд “тэнгэр” үг гэх тохиолдох ба ямагт “tenggiri” гэж бичиж тэмдэглэжээ⁷¹.

Германы нэрт эрдэмтэн Э.Хэниш “Нангиад- Монгол толь I: Хуа-и И-Юй” хэмээх бүтээлдээ уг үгийг

a c d e

tngri tenggiri tenggiri 天 Himmel гэж тайлбарласан⁷² байна. (Жич: а. Уйгуржин монгол эхийн галиг, б. “Уйгуржин дэвтэр”-ийн нангиад галиг, с. 1918 оны барын нангиад галиг, d. Уг нангиад эх, e. Герман орчуулга). Руни бичгийн бага дурсгалд цор ганц удаа “ᠲᠡᠩᠭᠢᠷᠢ” гэж тохиолдож буйг бичигч, сийлээчийн алдаа мадаг, эсвээс аялгууных нь онцлог хэмээн хэлж болох боловч Мин улсын Тайзу хаан 1382 оны тэргүүн сард зохион найруулах зарлиг буулгаж⁷³ ёсоор үйлдэгдсэн толь бичигт “天 ~tenggili ~tenggiri” гэж бичих болсны учир юу билээ гэсэн асуулт гарна. Үүний учрыг хэлшинжлэлийн үүднээс нарийвчлан судалж үзвэл нилээд сонирхолтой дүгнэлтэд хүрч магадгүй юм.

2. ᠳᠠᠩ qan (ᠳᠠᠩ qanīm). Монголын руни бичгийн дурсгалуудад хаан (ᠳᠠᠩ qayan), хан (ᠳᠠᠩ qan) гэх цол олонтоо тохиолдоно. Сонгодог дурсгалуудад ихэвчлэн хаан гэх цол ᠳᠠᠩ (qayan) бичлэгтэй байх бөгөөд зөвхөн Туньюкукийн гэрэлт хөшөөний 2, 3, 28, 33 дугаар мөрүүдэд хан цол, ᠳᠠᠩ (qan) бичлэгтэй буй. Хан цол Хангидайн хадны бичээснээ Баз хан (ᠳᠠᠩᠪᠠᠳ baz qan), Их бичигтийн бичээст Боз хан (ᠳᠠᠩᠪᠠᠳ boz (buz) qan) гэх мэтээр бага бичгийн дурсгалуудад тохиолдоно. Эртний түрэг, уйгур, монгол, солонгос хэл, бичгийн сурвалжуудад хаан (qayan), хан (qan) цол нэн элбэг тохиолдоно.

Эл хоёр цолын тухайд проф. Б.Сумъяабаатар “ “Хаган, Хан” гэдэг нь, “Хаган” нь “Хаган” цолтой, эзэншил (эзэмшил) бүхүй хүн, “Хан ” гэвэл “Хаган” цол хүртээгүй, эзэмшил бүхүй хүнийг хэлдэг байсан байна”⁷⁴ гэсэн дүгнэлт гаргаад

⁷¹ Ё.Жанчив, Ц.Бямбацэнд, Нангиад Монгол “Хуа-И И-Юй” толь “華夷譯語”, Улаанбаатар, 2003, 51-78 дугаар тал.

⁷² E.Haenisch, Sinomongolische Glossare: I. Das Hua-I ih-yü, Berlin, 1957, pp.9.

⁷³ “ Мин Ши-лу (明實錄) буюу Мингийн магад тэмдэглэл”-ийн “Тайзу хааны магад хууль” хэмээх 141-р ботид 1382 оны 1-р сарын 20-ны үйл явдал болгон тэмдэглэсэн нь: “ (Хаан бээр) бичгийн явдлын хорооны асран тайлбарлагч Хуо Юань- Гиз нарт “Хуа-и И-Юй” бичгийг найруулагтун хэмээн зарлиг буулгав. Хаан бээр, Юаньд уулаас бичиг үсэг байхгүй билээ. Зарлиг заавар буулгахад Гоу чангийн (өөрөөр хэлбэл, уйгурын Ё.Ж) үсгийг зээлэн монгол үсэг зохиогоод дэлхий дахины хэлүүдийг нэвтрэцүүлэн авна хэмээн Хуо Юань-Гиз, найруулагч Ма-ша И-хэ нарт зарлиг буулгаж тэдний хэлийг хятадаар орчуулуулбай. Тийнхүү одон орон, газар зүй, хүний явдал, бодисын зүйл, өмсөх идэх, эдлэл хэрэглэл тэргүүтнийг эс бүрдүүлсэн нь үгүй. Дахин “Юаний Нууц Товчоон”-ыг авчран лавлалт болгон үсгүүдийг таслан дуудлага дор нь зохицуулбай. Найруулан төгөсгөгч жуу зарлан хэвлүүлэн тархаажээ. Түүнчлэн элч нар умар гонь орноо одох, ирэхүүд цөм тэдэн лүгээ нэвтрэлцэн чадах болов” гэжээ. Ё.Жанчив, Ц.Бямбацэнд, Нангиад Монгол “Хуа-И И-Юй” толь “華夷譯語”, Улаанбаатар, 2003, 8 дугаар тал.

⁷⁴ Д.Наваан, Б.Сумъяабаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987, 113 дугаар тал; Т.А.Бертагаев, К этимологии хан-хаган, хатун и об их отношении к хат, Тюркологические исследования. Москва, 1976, стр.45-50.

“Хан” гэдэг үгнээ эзэншил утга түлхүү байна гэж тэмдэглэжээ⁷⁵. Дөрвөлжин үсгийн дурсгалуудад Чингис хааны цолыг “jij-(gis) qa_o-nu ba_o q[’]-nu I-6, II-8, III-9, V-8, VIII-9, IX-9, XI-9, XII-5, XIII-9, XIV-9, XVI-9, XVIII-10, XIX-9, XX-10, XXI-9, XXV-10, XXVI-12, XXVII-5, XXIX-8, XXX-6, XXXI-9, XXXII-7, XXXIII-9, XXXIV-9, LXI-6”-д тус тус “хан” хэлбэрээр олон удаа, харин “ġin-gis q[’]-nu ba q[’]-nu IV-9, jij-(gis) q[’]-nu ba_o ja_or-liq-dur VI-7, x-5, XY-7, XVII-8”⁷⁶ хэмээн “хаган” тун цөөн тохиолдож байгааг анхааран үзүүштэй.

Руни бичгийн дурсгалд тохиолдох $\mathcal{N}\mathcal{H}\mathcal{Y}\mathcal{H}$ teŋri qan гэх үгийг “Тэнгэр эзэн”, харин хүний нэрийн хамт буй $\mathcal{N}\mathcal{H}$ qan цолыг хаан ($\mathcal{N}\mathcal{H}$ qaγan) цол хүртээгүй, эзэмшил бүхүй хан хүн хэмээн ойлгож, орчуулбал зохилтой.

3. Нэгдүгээр мөрийн гурав дахь үгийг бид “ $\mathcal{H}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{E}\mathcal{T}$ igittükin” гэж унших саналтай байна. Энэ үгийг задлан үзвэл ig + t + tük +n гэсэн бүтэцтэй, “өвдсөн, өвчилсөн, алжаасан” гэсэн утгатай үг.

ig-өвчин гэх утгатай нэр үндэс

-t- нэрээс үйл үг үүсгэх дагавар

-tük- үйлт нэрийн өнгөрсөн цагийн нөхцөл

-n- харьяалахын тийн ялгалын нөхцөл.

Өгүүлбэр эхлэхдээ тэнгэр эзэн /хан/ минь гэсэн байх тул удаах үгийг мөн нэгдүгээр биед хамаатуулан этүгэн онгон минь гэж бичих учиртай. Гэтэл ийн хамаатуулан бичээгүй байна. Ер нь Монголын руни бичгийн сонгодог дурсгалд $\mathcal{H}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{H}$ /ötükän/ Өтүкэн гэх үгийг “ $\mathcal{H}\mathcal{O}\mathcal{U}$ ” эгшигтэй бичдэг тогтсон уламжлалыг анхаарахгүй байж огт болохгүй.

4. $\mathcal{Y}\mathcal{Y}\mathcal{S}$ buŋik- эл үг buŋ-k гэсэн бүтэцтэй. buŋ- зов-, гуни-, зүд- гэх үйл язгуураас тэмдэг нэр үүсгэх -k дагавар залгаж үүсчээ.

Энэ мэт жишээ Көлтигиний гэрэлт хөшөөний бичээснээ тохиолдохыг emge-k, bulga-k, yaz-uk гэх үгсээр үлгэрлэн өгүүлсэн байдаг⁷⁷. Зөв бичихзүйн үүднээс үзвэл $\mathcal{Y}\mathcal{Y}\mathcal{S}$ buŋay хэлбэрээр бичих байсан биз ээ. Судлаач Ю.Болдбаатар \mathcal{Y} тэмдэгтийг \mathcal{Y} тэмдэгт хэмээн үзэж $\mathcal{Y}\mathcal{Y}\mathcal{S}$ buŋim гэж уншсан байна⁷⁸.

Бидний авсан хэв дардас болон гэрэл зураг, эхэд \mathcal{Y} бус \mathcal{Y} тэмдэгт маш тодорхой, маргаангүй буй.

Эртний түрэг, уйгур хэлнээ зовлон, зүдүүр /зүдгүүр/, гуниг, уйтгар, шаналал гэх утгатай энэ үг МНТ-нд “nökg̃r ċi bürün maši muntanju aisu ajuyu. Ere-yin mun nigen bui je”⁷⁹ гэж тохиолдох бөгөөд монгол хэлний мунгинах /mungginaqu/, бунгинах /bungginaqu/ хэмээх үг(buŋ-bung-mung)-тэй гарал нэг юм. Монгол хэлний тайлбар толь бичгүүдэд мунгинах /mungginaqu/ хэмээх үг будилах,

⁷⁵ Д.Наван, Б.Сумъяабаатар, Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал, Улаанбаатар, 1987, 112 дугаар тал.

⁷⁶ Ё.Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, -Monumenta Mongolica: Tomus III, Centre for Mongol Studies National University of Mongolia, Улаанбаатар, 2002.

⁷⁷ Cengiz Alyilmaz, Orhun Yazitlarının Söz Dizmi, Erzurum, 1994, s.13.

⁷⁸ Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica, Vol. 10(31), Улаанбаатар, 2000, 219-228 дугаар тал.

⁷⁹ Б.Сумъяабаатар, Монголын нууц товчоо, үсгийн галиг. Улаанбаатар, 1990, 115 дугаар тал.

самуурах, төөрөгдөх, мунгинах гэсэн утгатай⁸⁰, бунгинах /bungginaqu/ нь уйгур, түрэг хэлнээ ижил утгатайг тэмдэглэжээ⁸¹.

5. **el||ig er baši**-хоёрдугаар мөрийн эхний үгийг бид **ellig er baši** гэж уншиж байна. Ү-нь ~Ү~Ү гэх нэг тэмдэгтийн хувилбар байх боломжтой.

Мөн “elli-тавь” гэсэн тооны нэр хэлбэржин **ellig** болж тавь гэх үг өмнөх үгээ холбон тодотгож тавин эр, тавин цэрэг гэсэн санааг илэрхийлж байна. Нэгэнт тавин цэрэг гэх үг тодорхой тул “ellig er baši” буюу тавин цэргийн дарга, тавьтын дарга гэж ойлгох бүрэн үндэстэй. Тэгээд ч жаран хулан, хорин чоно авласан нь тавин цэргийн тоотой дүйж байна.

6. **ᠠᠯᠢ ᠠᠲᠢ qulan**, (*Equus hemionus*) хулан. Энэ нэр хул /ᠬᠤᠯᠠ/ **qula**/ хэмээх зүснээс үүссэн нэр үг юм. “Хулан зээр мэт зүсээ нийлүүлж” хэмээн хэлэлцэх нь уг хоёр зүс ойролцоо болохыг хэлсэн хэрэг. Монголчууд хуланг “чихт, чихтэй” хэмээн нэрлэх нь буй. Түрэг хэлнээ чихийг “kulak” гэдэг бөгөөд монгол, түрэг угсаатан ямартаа ч уг амьтны чихийг нь онцгойлон үзэж нэрлэсэн байж болох талтай. Нөгөө талаар “хул” гэх зүс, хулан (**qulaq-kulak** [түрэг.чих]-**quliki** [монгол.чихний хэнгэрэг, чихний дотоодод хуралдсан хаг мэт юм⁸²])-гаасаа үүсэлтэй юу, эсвээс хулан нэр хул гэх зүснээс эхтэй юу гэсэн агуулт аандаа гарна. Монгол хэлний хул, хонгор, ухаа, хоо гэх үгс бүгд язгуур нэг бөгөөд ойрад аман аялгууны “хоо” гэх үгийн тухай доктор Н.Балжинням “Баруун монголд баяд, дөрвөдүүд одоо ч гэсэн адуу, үхэр, тэмээ, буга... зэрэг мал, амьтны цайвардуу, хул шарга зүсийг “ухаа” гэлгүй “хоа” гэж хэлдэг. Монгол бичгийн хэлэнд энэ хоёр үгийг [qow-a] гэсэн ганц дүрсээр тэмдэглээд тухайн нутгийн аялгуунаа -о, -у хоёрын (хоа, хуа) аль дуудлагаар нь тохируулан хэрэглэхэд зориулагджээ. Түүгээр ч үл барам энэхүү “хоа-хуа” үгийг төв халхын аялгуунд [qow-a] гэж бичих боловч ярианд “ухаа” гэдэг нь монгол бичгийн хэлний бас нэг онцлог юм”⁸³ гэж тэмдэглэжээ.

7. **alī āti**- Эх бичигт **ᠠᠯᠢ ᠠᠲᠢ** гэж нилээд тодорхой буй. Бас бидний авсан хэв дардаст ч эдгээр үсэг тэмдэгт мадаггүй харагдана. **ᠠ(L)** үсгийн дараахи **ᠠ(i)** нилээд урт, бөгтөр бичигджээ. **ᠠ(t)** үсэг тэмдэгт дунд хэсгээрээ зурагдаж баларсан нь даруй танихад бэрхтэй болжээ. **ᠠ** үсгийн дараа **ᠠ** үсэг тэмдэгт маш тодорхой буй.

ᠠᠯᠢ ᠠᠲᠢ холбоо үгийн талаар товч өгүүлэе.

В.В.Радловын цуглуулсан түрэг хэл, аялгууны эх хэрэглэгдэхүүнээс үзвэл “al” гэх үг арван нэгэн утга илэрхийлдэг болохыг тэмдэглэжээ.

Жишээ нь, “хитрость, обмань, уловка-Schlaueit, List, Betrug, Strategie” гэх мэт. Мөн “возвышенный, могущественный, лютый-er haben, mächtig, grimmig (in Märchen)” хэмээх салаа утга буйг “лютый волк-der mächtige Wolf” гэсэн

⁸⁰ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 349 дүгээр тал.

⁸¹ Sečencoᠣtu, Mongyol ūges-ün ijaᠣur-un toli, jing jian keu, 1988, 746 duᠣar tal-a.

⁸² Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 728 дүгээр тал.

⁸³ Н.Балжинням, “Монголын Нууц Товчоо”-ны “Гуа” гэдэг үгийн учир, -Эрдэм шинжилгээний бичиг, Боть 7(117), 1-25 дэвтэр, МУИС, Монгол судлалын дээд сургууль, Улаанбаатар, 1996, 49 дүгээр тал.

жишээгээр үлгэрлэн дурджээ⁸⁴. Түрэг хэлний толь бичгүүдэд ч энэ үгийн утгын талаар товч өгүүлсэн байна⁸⁵. Дээрх жишээнээс үзэхэд өгүүлэн бүхүй бичээсийн *al*, *alī* хэмээх үг зальтай, овтой, мэхтэй, мөн түүнчлэн догшин, ширүүн гэсэн утгатай нь тодорхой байна.

āti-eti -нь мах, бие, махбод гэсэн утгатай үг. Догшин, ширүүн (*al,alī*), мах, бие, махбод (*āti-eti*) гэх үгс хоршиж догшин, ширүүн биетэй тэмээ, эдлэгдээгүй, зэрлэг тэмээ гэсэн утга илэрхийлж байна.

alī āti tābi ölürtim- гэж буйгаас тэмээ авласан нь илт ч гаршуулж гэршүүлсэн тэмээ авлаагүй нь мэдээж. Иймд гэршүүлсэн тэмээ(*Camelus bactrianus*)-ээс ялгахын тулд тодотгон “*alī āti-зэрлэг тэмээ (хавтгай)*” гэж бичсэн бололтой. Монголчууд бидний “хавтгай (*Camelus ferus*)” хэмээх зэрлэг тэмээг түрэгүүд “*alī āti tābi*” гэж нэрлэдэг байсныг үгүйсгэх аргагүй юм. Тэмээ, Енисейн дурсгалд, тухайлбал Телее (E-46), Бере (E-11)-ийн бичээснээ “*ᠠᠯᠢ ᠠᠲᠢ ᠲᠠᠪᠢ ᠶᠡᠭᠦᠰᠡᠭᠡ* *ägriṭäbä*” хэмээн тэмдэглэгджээ.

Телеегийн бичээсийн 3-р мөрийг В.Томсен, С.Е. Малов, А.М.Щербак нарын эрдэмтэд⁸⁶ хэд хэдэн хувилбараар уншиж тайлсан байна. И.В.Кормушин эдгээр эрдэмтдийн судалгааг дахин хянан нягталж эл мөрийг “*äldä kišim ägriṭäbä tört butluу jilqim*” гэж галиглаад орос хэлнээ “Мои наложницы, мои верблюды, мой четвероногий скот” хэмээн орчуулжээ⁸⁷. Бере (E-11)-ийн бичээснээ “*är ärdämin ücün alun altun kümüšig ägriṭäbä eldä kiši qazıandım-a* (Благодаря моей доблести мужа-воина отвагой приобрел я золото и серебро, верблюдов, наложниц)” гэж гарах бөгөөд В.Радлов, Х.Н.Орхун, С.Е. Малов, А.М.Щербак, И.В.Кормушин нарын судалгаа буй⁸⁸.

Енисейн бичээсийн энэ баримт гэршүүлсэн тэмээ (*Camelus bactrianus*)-г *ᠠᠯᠢ ᠠᠲᠢ ᠲᠠᠪᠢ ᠶᠡᠭᠦᠰᠡᠭᠡ* *ägriṭäbä* гэж нэрлэдэг болохыг нутлаж байна. Иймд, зэрлэг тэмээ (*Camelus ferus*)-г *ᠠᠯᠢ ᠠᠲᠢ ᠲᠠᠪᠢ* гэж нэрлэдэг байжээ хэмээн үзэх үндэс буй.

alī- язгуур монгол хэлний албин (*albin*), алмас (*almas*)⁸⁹, казах хэлний албасты, тува хэлний албас гэх үгст хадгалагдан үлджээ. Албин, алмас гэдэг нь утгаа зэрлэг, хээрийн амьтан гэсэн үг бололтой. Толь бичигт “албин” -нь уйгур гаралтай үг хэмээн тэмдэглэгджээ⁹⁰.

⁸⁴ В.В.Радлов, Опыт словарь тюркских наречий. Том. I, часть I.Санктпетербургь.1893, стр. 349.

⁸⁵ Древнетюркский словарь. Ленинград,1969, стр.31-32; Clauson Sir Gerard, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford, 1972, pp.120-123.

⁸⁶ V.Thomsen, Turcica. Étude concernant l'interprétation des inscriptions turques de la Mongolie et de la Sibérie, Journal de la Société Finno-Ougrienne, Helsinki, 1916, pp.69; С.Е.Малов, Енисейская письменность тюрков. Москва-Ленинград,1952, стр.83; А.М.Щербак, Памятники рунического письма енисейских тюрков. Народы Азии и Африки, 1964, №4, стр.447-448.

⁸⁷ И.В.Кормушин, Тюркские Енисейские Эпитафии (тексты и исследования), Москва, 1997, стр.225.

⁸⁸ И.В.Кормушин, Тюркские Енисейские Эпитафии (тексты и исследования), Москва, 1997, стр.273.

⁸⁹ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 33 дугаар тал.

⁹⁰ О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь. Улаанбаатар, 1999, 21дүгээр тал; Сеценцоуту, Mongyol üges-ün iyajar-un toli, jing jian keu, 1988, 95 дугаар тал.

Дэл уулын хоёрдугаар бичээс

Газрын хөрснөөс дээш 5-8 см цухуйсан, хэвтээ том хавтгай хүрэн хадан дээр дөрвөн мөр бичээсийг хурц үзүүртэй зүйлээр олон дахин зурж сийлсэн байна.

Нэгдүгээр мөрийн зүүн дээд талд нь янгир, хоёрдугаар мөрийн харалдаа баруун өмнө талд морьтой хүн, дөрөвдүгээр мөрийн доор олон хэрчлээс, зураас, янгир, түүний дор мөн олон хэрчлээс зураас, янгирын зураг буй ажээ⁹¹.

Бичээсийн зүүн дээд талд хэдэн янгир болон бусад амьтны дүрс цохисон нь бичээстэй холбогдолгүй бололтой.

Өөрөөр хэлбэл угтаа амьтны дүрс цохисон хадан дээр бичээс сийлжээ.

Эл бичээс хийгээд зураг “Монголын хадны зураг” номонд хэвлэгдсэн байна⁹². Б.Напил уншиж орчуулжээ⁹³.

Бичээсийн эхийн сийрүүлэг;

НЧДЕГ.1
ҮН.2
ЄТНІІ»ҮҮН.3
[?] > Ү.4

Үсгийн галиг;

Үгийн галиг;

Орчуулга;

1. k g Y R Q
2. t r
3. t η r m s n i g
4. š W [y/k?]

- kig (kik) yaŋiŋ
.....
taŋrim sen igä
aš?

- Антай (ан автай) салаа
.....
Тэнгэр минь та эзэн
[Хоол, хүнс?]...

Тайлбар

Бичээсийн хоёрдугаар мөрнөө “тэнгэр” гэх үгийг эхлэн буруу бичсэнээс орхиод дараагийн мөрөнд дахин шинээр бичжээ.

yaŋiŋ нь монгол хэлний ярах, ирэх гэдэг үгтэй утга язгуур нэг болов уу.

Газар ярагдсанаас салаа хавцал үүсдэг ажээ. Тэрхүү ярагдсан гэх үндсэн утгаар нь түрэг хэлтэн уулын салаа хавцлыг (гуу жалгыг ч) yaŋiŋ хэмээн нэрлэх бөлгөө. Орчин цагийн түрэг хэлнээ yaŋ(ucurum), казак хэлнээ жылга, жыра, тува нар ойык гэх бөгөөд ийм нэртэй газар ч буй ажээ.

Дөрөвдүгээр мөрийн үсэг тодорхой боловч үг болгон уншихад бэрхтэй. Юутай ч бичээсийн агуулгад тулгуурлан “aš -хоол, хүнс” гэсэн үг байж магад хэмээн таамаглаж байна. Босоо ханан зураас эл бичээснээс гадна Шар хошууны хойт хад, Зүүн билүүний хаданд байх бөгөөд чухам ямар учир холбогдолтойг хэлж эс мэднэ.

⁹¹ Ц.Баттулга, Дэл уулын Баруун билүүний II, III бичээс, - Археологийн судлал, Том. XVIII, fasc. 1-16, Улаанбаатар, 1996, 110 дугаар тал.

⁹² Т.Санжмятав, Монголын хадны зураг, Улаанбаатар, 1995, 41 дүгээр тал.

⁹³ Н.Базылханцлы, Монголиада жанадан табылган түрик бітик жазулары, -Хабарлары (Известия), серия общественных наук, 5(229), Август-Сентябрь 2000, Алматы, 2000.68-78.

Бичээсийн ерөнхий утгаас сэжүүрлэн мөчидхөн дүгнэвэл уул бичээст “антай салаа, тэнгэр эзэн минь та олз омгийн үүдийг нээж өглөө хэмээн талархсан эсвээс ан автай салаа, тэнгэр эзэн минь та олз омог ангийн хишиг үүдийг нээж хайрла” гэж гуйж залбирсан сэтгэлээ бичиж үлдээхийг хичээжээ гэлтэй байна.

Бичээст гарах үгийн толь

ᠭᠢᠯᠢᠭ᠎ᠠ kig (kik) –  ang, ав, ан ав

ᠰᠠᠯᠠᠭ᠎ᠠ salay-a –  salay-a,  yuu jilγ-a, салаа, гуу, жалга

ᠲᠡᠩᠭᠡᠷᠢ tngri-  tngri, тэнгэр

»-m- биеийн төлөөний үгийн нэгдүгээр биеийн хамаатуулах нөхцөл

ᠴᠢᠰᠢ sen –  či, чи

ᠶᠡᠭᠡᠨ igā –  ejen, эзэн

ᠬᠣᠯᠠᠭᠤᠨ aš? –  qoyula künesü, хоол хүнс

Дэл уулын гуравдугаар бичээс

Босоо, улаан хүрэн чулуун дээр сийлсэн ганц тамга, 10 үсэг зурлага бүхий нэг мөр эл бичээс II бичээст хадны баруун хойно, алхмын зайтай буй.

Бичээсийн эхний тэмдэгт 1 см, төгсгөлийн тэмдэгт 2.5 см өндөр бөгөөд бичихдээ жижгээр эхэлж жигд томорсоор төгсчээ. Уг бичээсийг буруу харуулан бичсэн байна. Монгол нутгаас руни бичгээр буруу харуулан тонгоруулан цохисон дурсгал олдож байсан нь Өвөрхангайн бичээс билээ⁹⁴.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;

Тонгоруулан зөв дараалалд оруулбал;

Ү ᠢ ᠙ Ү > Н | Н Н

Ү ᠢ ᠙ > Ү > Ч | НЧ

Үсгийн галиг;

RQ : R W I W y i š

Үгийн галиг;

arqa ara ulu yiš

Үгчилсэн орчуулга;

Олон завсар (салаа) их шугуй

Уг бичээснээ газар нутгийн байдлыг тодорхойлон бичсэнээрээ бусад дурсгалуудаасаа нилээд онцлогтой байна.

Бидний санахад энд авлаар ирэгсэд өмнө нь энэ газар нутагт нутаглаж байгаагүй, түүгээр ч үл барам огт ирж байгаагүй бололтой.

Хэрэвзээ энэ орон нутагт авлаар урьд өмнө ирж байсан бол газрын байрлалыг тодорхойлон бичиг, бичээс үйлдэхгүй байсан биз ээ.

Нэгдүгээр бичээснээ “тавьтын дарга /тэргүүн/”, дөрөвдүгээр бичээст “чур” цолтны нэр дурдагдаж байгаа нь санамсаргүй хэрэг огт биш “цэрэг, цэргийнхэн” эл газар нутагт ирсэн болох нь тодорхой байна. Эдгээр бичээсүүдийг бичсэн цаг улирлын хувьд намар цаг байх боломж магадлал бүрэн буй бөгөөд магадгүй цэргийн хүнс төхөөрөх, намрын их ан хомрогод оролцогсод “сэтгэгдэл”-ээ бичиж үлдээжээ гэлтэй.

Бичээст гарах үгийн толь

НЧ arqa –  olan, олон

Ч ara –  jabsur, завсар

> Ү > ulu –  yeke, их

Ү ᠢ ᠙ yiš –  ·  kōndei, si᠕ui, хөндий, шугуй

⁹⁴Л.Болд, Өвөрхангайн түрэг бичээс, - БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 83-84 дугаар тал; Л.Болд, Өвөрхангайн орхон бичээс, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 254-258 дугаар тал.

Дэл уулын дөрөвдүгээр бичээс

Дэл уулын Баруун билүүний IV бичээс II, III бичээст дэл хадны төгсгөлийн өндөрт босгосон овооны зүүн өмнө талд, нар салхи, усанд өгөршсөн, 65 см өндөр хуудсан хөх хадны толигорт байх ажээ. Тодотговол II, III бичээснээс баруун хойш 256 метрт байгаа болно⁹⁵. Бичээсийг хурц үзүүртэй зүйлээр хадны өнгөн хэсгийг бүрхэж тогтсон, түрхэц төдий нимгэн элгэн хүрэн гадаргуунд олон дахин зурчсангүй, шууд бичсэн ба үсэг зурлага нь хүрэн дээр цагаан харагдах тул их л тодорхой. Гэвч зарим үсэг тэмдэгт он цагийн уртад нар салхинд дахин хүрэнтэн харласан тул сайн эс ажваас мэдэгдэхгүй болжээ.

Өгүүлэн бүхий бичээсийн баруун дээд талд T (W?) (L?) di гэсэн үсэг зурлага байх агаад үг өгүүлбэр бичсэн гэхэд бэрхтэй. Бичээсийн төгсгөлд үсэг мэт хэдэн зураас сараачсан нь буй. Уул бичээсийн эхний таван тэмдэгт 2 см хиртэй бусад үсэг зурлага 1-1,5 см орчим өндөр бөгөөд үг, өгүүлбэрийг дундаа тасархай босоо зураасаар тусгаарлажээ. Бид уул бичээсийг уншиж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан бөгөөд анхны судалгаагаа дахин нягтлан толилуулж байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг;

>A
 ↑×(↓)(?)A
 H>H : HAH : HA YOTY .1
 Ч»H YOT H S : Ч»»»»»» : H Y T T : L T Ч H .2
 Ч H A : Ч L Y C Y : Y T A : A Y Ч A : A Ч .3
 |»Ч H > Ч .4

Үсгийн галиг;

- T (W?)
- T (W?) (L?) di
- 1. ši y l TQ: QiTQ: QWQ
- 2. Q W z i č: i r k n: B W L m D m z: B Q a k l t m z
- 3. RT: bzsñT: TiG: ič R G č W R: b n: R...
- 4. R W (t?) R ms...

Үгийн галиг;

- 1. aši yel atiq, aqi atiq uquq
- 2. uquzči irkin bolmadmiz, abqa kältimiz
- 3. ariti biz sänüt [sañun, sänüt] atiy iš [ič] ariy čur bän r...
- 4. ur oturmıs (olurmıs)...[ölürtmis]

Үгчилэн орчуулбал;

- 1. асан дийлэх нэртэйг, өгөөмөр алдартайг ухаараг
- 2. ухааруулагч иркин болцгоосонгүй бид. Ан авд ирцгээв бид
- 3. цэвэр бид. Жанжин цолтой Иш /ич/ Ариг чур би...

⁹⁵ Ц.Баттулга, Дундговь аймгийн Дэл уул, Их бичигтэд хийсэн судалгаа тайлан, Улаанбаатар, 1997

4. цохиж /авлаж/ суужээ /...../

Утгачилан буулгавал;

1. Ялан дийлэх нэр цуутайг, өгөөмөр /их/ алдартайг мэдэг /ойлгог/
2. Зөвлөгч иркин болцгоосонгүй бид. Ан авд ирцгээв бид
3. Шударга бид. Жанжин цолтой шадар Ариг чур би...
4. авласаар бөлгөө ...

Тайлбар

ᠮᠠᠰᠢ-ᠠᠰᠢ – хэмээх үгийг эртний түрэг хэлний толиудад “переходить, пересекать; преодолевать, переваливать”⁹⁶, “to cross (a mountain)”⁹⁷, “aş- aşmak, bir tepeyi öbür yana geçmek”⁹⁸ гэж тус тус тэмдэглэжээ. Монгол хэлнээ мөн ас (asa), асах (асаqu) гэх үг буйг толиудад “asa -degegsi bosqu, abariqu; qadan-du asaqu”⁹⁹, “асax I. өндөр юм өөд авиран гарах 3. хайрлан эрхлүүлэх хүнд хүүхэд авиран эрхлэх буюу улмаар ташууран хэтрүү зан байдал гаргах; миний хүү битгий асаад бай, аав нь ядраад байна, 4.бусдад хүрч халдах; ах захдаа асах”¹⁰⁰ гэх утгатай болохыг тайлбарлажээ. аш-аші-аса- асаqu гэх үгс цөм язгуур гарал нэг мэт санагдана.

ᠶᠡᠷ yel гэх үгийг Кашгарын Махмутын тольд yel-yéndi (давхих), yélür-yélmek, уепмек (ялах, дийлэх)¹⁰¹ гэсэн утгатайг, бусад толиудад энэ үгийн “салхи” гэх утгыг голлон дурджээ.

Уг хоёр үгийн дээрх утгаас үзвэл “ᠶᠡᠷᠮᠠᠰᠢ yel- нь ялан дийл, ялан дийлэх” гэсэн үг байж болох юм. Энэ үгийн дараа “нэртэй, цуутай, алдартай” гэх үг буйг ч бас харгалзахгүй байж болохгүй.

ᠠᠲᠢᠴ- atiq- Толь бичигт “atiq- нь “быть прославленным, знаменитым, atiq kökül- стать знаменитым, прославиться”¹⁰², “to be named, to have a (good or bad) reputation”¹⁰³ (алдартай, цуутай, нэртэй) гэсэн утгатайг тэмдэглэсэн байна.

ᠠᠭᠢ aqi - Эх бичигт гарч буй aqi гэх үгийн утгыг “щедрый”¹⁰⁴, “generous, openhanded”¹⁰⁵, “eli açık, koçak, selek, cömert”¹⁰⁶ хэмээн тайлбарласан байх бөгөөд магадгүй цагаан гэх үгийн язгуураас үүсэлтэй буй за.

⁹⁶ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 62.

⁹⁷ Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972, p. 255.

⁹⁸ Divanü Lûgat-it-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I- IV, Ankara, 1998; Cilt I, III, s. 173-23, 173-21; 261-7, 261-9; Endeks s.42.

⁹⁹ Seçençöyü, Mongyol üges-ün ijaar-un toli, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, Köke qota, 1988, 114 düger tal-a.

¹⁰⁰ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 54 дүгээр тал.

¹⁰¹ Divanü Lûgat-it-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I-IV, Ankara, 1998; Cilt III, s. 64-15, 185-18; 64-13, 185-16; Endeks s.769.

¹⁰² Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 67.

¹⁰³ Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972, p. 47.

¹⁰⁴ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 78.

¹⁰⁵ Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972, p. 78.

ᠠᠯᠠ *uquq*, ᠠᠯᠠᠭᠠᠨ *uquzci* хэмээх үгс “*uqa*-(ухах, мэдэх, ойлгох)” язгуураас үүссэн бөгөөд *uquq*- нь монгол хэлнээ *uquq*- ухаг (ойлгог) хувилбараар тохиолдоно.

Иймд уг үгийг монгол хэлнээ “ухаг, ойлгог, мэдэг” гэж орчуулж байна.

ᠠᠭᠠᠷᠢ (-*ti*-) “чисто”¹⁰⁷, “cleanly”¹⁰⁸ буюу ариун, цэвэр, шударга гэх язгуураас эхтэй эл үг “ᠠᠭᠠᠷᠢ -*ti*” буюу “ариун бөлгөө” гэсэн утгатай байна.

ᠠᠯᠠ *sinjüt* гэх үгийн уншлага, утга тодорхойгүй байна. Цаашид нарийвчлан үзэх нь зүйтэй юм. Махмутын тольд “*sinğüt* -*karşığına bir şey verilmeyen ve geri gönderilmeyen armağan*”¹⁰⁹ хэмээн тайлбарласан ба “*sünğüt*” гэсэн хувилбар буйг ч тэмдэглэжээ.

Эртний түрэг хэлний тольд “*sinjüt*- безвозмездный подарок”¹¹⁰, гэж орчуулсан нь Кашгарын Махмутын толиос авсан ажээ.

Уг үгийг *sanjüt* - (*señün*) гэх цол хэргэмийн баахан ташаарсан бичлэгт хэлбэр гэж мугуйдлаж болох мэт. *Sanjun* (*señün*) нь угтаа 將軍 *jiangjun* хэмээх хятад үг, жанжин гэсэн цол, албан тушаалын нэр билээ.

Бичээст өгүүлэн бүхий үгийн дараа цолтой /нэртэй/ гэж буй тул түүний өмнөх үг эрхбиш ямар нэгэн албан тушаал, хэргэм зэрэг, цолын нэр байх учиртай. Иймд *sanjun* хэмээх үг мөн болов уу хэмээн таамаглана.

Эрдэмтэн судлаачид уг үгийг дахин нягталж тодруулна гэдэгт найдаад энэ удаад санал болгож буй “жанжин” гэх цолын тухай товч өгүүлье.

Нангиад сурвалжид *chiang chün* (*tsaing-kiuan*), *hsiang-wën* (*siang-uën*)¹¹¹, *šän-gün*, цзянь-цзюнь, сян-вэнь¹¹² зэрэг олон хувилбараар тэмдэглэгджээ.

Анх эртний Чин улсын (II-III зуун) үед орон нутгийн захирагч нараас нутаг дэвсгэр, хил хязгаар тогтоон сахиулахаар цэргийн шинжилгээний анги одуулсан ба хожмоо гэр ажилд оролцсон бүх хүмүүсийг “*жанжин*” цолоор хөхүүлэн шагнасан гэдэг. Тухайн үедээ төдийгүй алсдаа ч энэ цол хэргэм гавьяа зүтгэл, эрх мэдлийн илэрхийлэл болон уламжлагдсаар Тан улсын сүүл үеэс цэргийн зэрэг дэв, цол хэргэм болж идэвхитэй хэрэглэгдэх¹¹³ болсон бололтой.

Эл цол түргүүдээс уйгур улсад уламжлагдсан ба уйгур *sayun*¹¹⁴, монгол *senggün* /сэнгүн/¹¹⁵ хэмээх нь угтаа “жанжин” цолоос эх улбаатай байж магадгүйг

¹⁰⁶ Divanü Lûgat-It-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I-IV, Ankara, 1998; Cilt I, s. 90-6; Endeks s.15.

¹⁰⁷ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 53.

¹⁰⁸ Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972, pp. 211.

¹⁰⁹ Divanü Lûgat-It-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I-IV, Ankara, 1998; Cilt III, s. 362-11, 362-13; Endeks, s.524.

¹¹⁰ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр. 501.

¹¹¹ H.Ecsedy, Old Turkic Titles of Chinese Origin, - Acta Orient, Hung, Tom. XVIII, Budapest, 1965, p. 84-91.

¹¹² А.Г.Малаявкин, Материалы по истории уйгуров в IX-XII вв., Том II, Новосибирск, 1974, стр. 127.

¹¹³ H.Ecsedy, Old Turkic titles of chinese origin, -Acta Orient, Hung, Tom XVIII, Budapest, 1965, p. 88.

¹¹⁴ B.Csongor, Chinese in the Uighur Script of the T'ang-period, Acta Orient, Hung. Tom II, Budapest, 1952, pp. 93-97

судлаачид тэмдэглэжээ. Сонирхолтой нь бичээст “Эркин цол хүртэцгээсэнгүй бид” гэж байгаагаас үзвэл тэд эркин цол хүртэх ёстой атал ямар нэгэн шалтгаанаар тэр цол хэргэмээ авч чадаагүй болох нь тодорхой байна.

Хэн нэгэн “эркин цол хүртсэнгүй би” хэмээх бол уг хүнтэй холбоотой гэхсэн. Харин, яагаад бид эркин болцгоосонгүй хэмээсэн нь сонин. Магадгүй эркин цолоор дамжуулан түрэг цол хэргэмээ хүртэцгээсэнгүй, зүүсэнгүй бид гэсэн санаа илэрхийлсэн байж болох юм. Тан улсын эрхшээлд орох үеийн түрэг язгууртан ноёд, захирагч нарын тухай Келтигиний бичээст “*türük bāglār türük atin ü(t)ī: tabγačū bāglār tabγač atin tuturan tabγač qaγanqa körmis*”¹¹⁶ “Түрэг ноёд нэр (цолоо) хаяв. Табгач дахь (дагаар орсон) ноёд табгач нэр (цол, хэргэм) авч табгач хаанаа захирагдав” гэж бичсэн буй. Урьд нутаг дэвсгэрийн дээс, хил хязгаар тогтоон сахиулагч нарт хүртээж асан *chiang chun* (жанжин) мэтийн цолоор дагаар ирсэн түрэг захирагч, ноёдыг хөхиүлэн шагнадаг байсан бололтой.

Харин энэхүү бичээст ноёд бэг (бек) нар ямар алдар нэр, цол хэргэм авч байсныг тодорхой нэрлэсэнгүй аж.

Үнэндээ *chiang chun* (жанжин) цолтон нь нэгдүгээрт: Хятадын хил хязгаарын (*хариуцсан*) эрх тушаалтан мөн болохыг, хоёрдугаарт, түүний эрх мэдэлд байгаа газар нутгийн дээс хүртэл хятадын газар нутаг, хил байгааг далдхан илтгэж байсан хэрэг. Уг цолыг эрх мэдэл, эд баялаг хэлэлтгүй ихээр дагалддаг нь мэдээж бөгөөд Тан улс Түрэгийн зарим овог аймгийн захирагч, ноёдод элч зарж бэлэг сэлт хүргүүлэх, гүнж өгөх, цол хэргэм шагнах зэргээр найр тавин өөрийн талдаа татаж чадсан нь Түрэг улсыг эзлэн авахад ихээхэн дөхөм болсныг түүхчид хэдийнээ тэмдэглэсэн байдаг. Эртний түрэгийн бичээсүүдийг нягтлан үзэхээр явах замдаа Дэл уулын Зүүн билүүний худгийн тагны хаданд нэгэн нангиад бичээс байсныг үзэж хэв дардас, хуулга авч уншихад 665 оны үеийн буюу өөрөөр хэлбэл Тан улсын үед холбогдох бичээс байсан билээ¹¹⁷.

Энэ мэтээс сэжүүрлэхэд Түрэгүүд Тан улсын эрхшээлд орсон уршиг гайгаар язгуурын түрэг цол хэргэм зүүхийг болин хятад цол хэргэм хэрэглэж эхэлсэн үетэй холбогдож болзошгүй. Ийн үзвэл уул цолыг хэлж хэрэглэж хэвшээгүйгээс гадна харь үг тул *sāñüt* хэмээн баахан ташаа, мадагтай бичсэн ч байж болно. Уг үгийн “ч” тэмдэгтийг буруу харуулан сийлжээ.

Ү *iš* [-ič] *ič* – хэмээх үг нь Аригчур хэн болохыг тодотгож байгаагаараа онцлог юм.

Өөрөөр хэлбэл Аригчур нэгд, ах, ахмад хүн, хоёрт, олон түмэн, ард нийтээр түүнийг “*iš, ič*” буюу “эсэвч, эшэвч (зөвлөгч), шадар зөвлөгч (зөвлөх)” гэж цоллон өргөмжилдөг байсныг илтгэж байна. Эл үгийг Алтайн Урианхайн аман аялгууны “*зөвлөх, зааварлах, зөвлөгч, зааварлагч, бүгдийн дарга*” хэмээх утга бүхий “*эсэвчлэх, эшэвч, бүгдийн эш*” гэдэг үгстэй гарал төрөл нэг байж болохыг

¹¹⁵ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, *Studia Archaeologica*, Tom.VI, fasc.1, Улаанбаатар, 1975, 132-133 дугаар тал.

¹¹⁶ T.Tekin, *A Grammar of Orkhun Turkic*, Indiana University, Bloomington, 1968, p.233.

¹¹⁷ Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулаас шинээр олдсон хятад бичээс, - Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс, - Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть XVII (169), МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Улаанбаатар, 2001, 103-105 дугаар тал.

тэмдэглэе. М.Шинэхүү гуай уг үгийг монгол хэлнээ шадар хэмээн хөрвүүлсэн¹¹⁸ ба бид нэгэн өгүүлэлдээ эл үгийн талаар дурдсан билээ¹¹⁹.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Их Хөшөөтөд байх Көли чурын гэрэлт хөшөөний бичээсийн Көли чур нэрийг Көл ич чур хэмээн унших санал зарим эрдэмтэд дэвшүүлж байна¹²⁰.

“Көл ич чур” нэрийг монгол хэлнээ “далай шадар баатар” гэж орчуулж болох юм. Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудаас гадна бага бичээсүүдэд ч тохиолдож байгаа нь уг цол түгээмэл, идэвхтэй хэрэглэгдэж байсныг нуталж байна.

Бичээст гарах үгийн толь

- ᠮᠠᠰᠠ aš-ašī –  asaqu, badaraqu, асах, бадрах
ᠶᠡᠯ yel –  deyilekü, ilaqu, дийлэх, ялах
ᠠᠲᠢᠭ atiq-  aldartu, neretü, алдарт, нэрт, цуут
ᠲᠠᠭᠢ aqī –  ökiyemür, өгөөмөр
ᠠᠶᠠᠭᠠᠷ uquq –  uqayaraq, oyilayaq, medeg, ухаарар, ойлгор
ᠠᠶᠢᠵᠢᠰᠡ uquzīc-  jöblegçi, зөвлөгч (ухааруулагч)
ᠢᠷᠬᠢᠨ irkin –  irkin, иркин цол
ᠪᠣᠯᠮᠠᠳᠢᠮᠢᠵᠢ bolmadimiz-  bolčayaγsan ügei bide, болцгоосонгүй бид
ᠠᠨᠳᠠ abqa –  ang-du, ab-du, анд, авд
ᠬᠠᠢᠲᠢᠮᠢᠵᠢ kältimiz-  irečegebe bide, ирцгээв бид
ᠠᠷᠢᠲᠦ aritü –  siduryu, ariγun, шударга, ариун
ᠪᠢᠵ biz –  bide, бид
ᠶᠠᠨᠵᠢᠨ sänjit [saγun, sänjüt] –  jangjun, жанжин
ᠠᠲᠢᠶ atiy-  čola-tai, цолтой, нэртэй
ᠶᠢᠰ [ič]-  sidar, шадар
ᠠᠷᠢᠶ čur-  ariγ čur, Ариг чур хүний өргөмж нэр
ᠪᠢ bän –  bi, би
ᠤᠷ ur [u]oturmīs (olurmīs)[öläürtmīs]-  ablaysayar бүлүге, авласаар бөлгөө
ᠤᠷ ur –  čokiqu, ablaqu, цохих, авлах
ᠤᠲᠤᠷᠮᠢᠰ oturmīs (olurmīs)[öläürtmīs]-  saγujuquī, сууцгаах бөлгөө, суужухуй

¹¹⁸ М.Шинэхүү, Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, Улаанбаатар, 1975, 124 дугаар тал.

¹¹⁹ Ц.Баттулга, Дэл уулын Баруун билүүний II, III бичээс, - Археологийн судлал, Tom. XVIII, fasc. I-16, Улаанбаатар, 1996, 96 дугаар тал.

¹²⁰ Osman Fikri Sertkaya. Köli Tigin ve Köli-İç-Çor kitabelerinde geçen Oplayu tegmek deyimi üzerine, Göktürk tarihinin meseleleri, Ankara, 1995, s. 153-159.

Эцэст нь тэмдэглэхэд

-Уг бичээс өөрсдийн өгөөмөр их ухаантай, алдар цуутай (цэргийн эрхтэн дархтан) ноёд ан ав хийхээр ирсэн тухай, авах ёстой байсан цол, хэргэм зэргээ авч чадаагүй тухай мэдээлэл лавтай агуулж байна.

-Бичээсийг шадар жанжин Ариг чур гэгч бичсэн буюу бичүүлэх санаа ээдсэн бололтой.

- Бичээсийг бичих үед тэдний ан ав, хомрого дуусаагүй үргэлжилсээр байжээ. Ер Дэл уулын бичээсүүд нэг цаг үед, магадгүй авлаар ирсэн Аригчур тэргүүт, тэдний хамсаатан, эрх дархтан нар бичиж үлдээсэн байж болох юм гэсэн ерөнхий дүгнэлт хийж болохоор байна. Учир нь бичээсүүд нь нэг аргаар үйлдэгдсэн, бүгд зураасан буюу зурчмал бичээсийг төрөлд хамарч байгаагаараа онцлогтой юм.

ИХ БИЧИГТИЙН БИЧЭЭС

Дундговь аймгийн төвөөс зүүн хойш 110 гаруй км-т, Говь-Угтаал сумын 2-р багийн нутагт алдарт Аарагийн хадны салбар уулсад Их бичигт, Бага бичигт хэмээх нэртэй газар байх бөлгөө.

Тэрхүү Их бичигт, Бага бичигт нь хол саахалтын зайтай орших, өндөр байц хадан цохиотой өвөлжөө бууц юм.

Цувран хөшилдөж тогтсон цагаан саарал байц хадны энгэрт төвд, монголоор бичсэн маанийн их үсэг, түрэг, уйгур бичээс, олон зүйл тамга цохисныг үзвээс яах аргагүй “Их бичигт” хэмээн нэрийдэхээс аргагүй мэт.

Харин “Бага бичигт”-д монгол, төвд үсгээр бичсэн харьцангуй цөөн тооны маани, нилээд хэдэн төрлийн тамга буй ажээ.

Их Бичигт хэмээх өвөлжөө бууцны байц хадныг голлон 180 см өндөрт нэг мөр түрэг бичээс, түүний дор залгуулан хоёр уйгур үг, түүнчлэн он цагийн хувьд эрт үед холбогдох морьтой хүний дүрс зураг буй ажээ.

Эдгээр бичээс, дүрс зургийг улаан хүрэн өнгийн хаднаа бичсэн нь улаан хүрэн өнгө түрхэц төдий өнгөцхөн тул үсэг цохихын хирээр цайвар цагаан өнгө тодорч улаан хүрэн дээр цагаанаар бичсэн мэт, ялангуяа түрэг бичээс их тод харагдана¹²¹.

Бичээсийг гүнзгий ухалгүй, хадны өнгөн хэсгийг холцруулан цохиж бичсэн учраас хэв дардас авах боломжгүй юм.

Руни бичээс

Ихэд тод, тодорхой бичсэн нэг мөр түрэг бичээсийн урт нь 61 см, үсгийн өндөр ойролцоогоор 8 см юм.

Уг бичээсийн зүүн дээд талд **ᠳᠠ** (qan) хэмээх үгийг маш бүдэгхэн цохисон ажээ.

Бичээсийн эхийн сийрүүлэг;

ᠳᠠ.1

ᠳᠠᠬᠠᠨ ᠳᠠᠬᠠᠨ ᠳᠠᠬᠠᠨ ᠳᠠᠬᠠᠨ ᠳᠠᠬᠠᠨ ᠳᠠᠬᠠᠨ

Үсгийн галиг;

1. QN
2. BWz QN nči WN Bši btdm

Үгийн галиг;

1. Qan
2. Boz (Buz) qan anči on baši bitidim

Орчин цагийн монгол хэлнээ үгчлэн орчуулбал;

¹²¹ Ц.Баттулга, Дундговь аймгийн Дэл уул, Их бичигтэд хийсэн судалгаа, тайлан, 1997.

1. Хан

2. Боз хан (аа) ингэж аравтын дарга бичив, би хэмээсэн мэт.

ЧУД Боз хэмээх нэрт нэгэн ханд зориулан аравтын дарга ийн бичиг цохиж үлдээсэн бололтой. Бичээсийн тойрон хаднаа цохисон олон зүйл тамга түүний цэргийн бүрэлдэхүүнд багтагсдын овог аймгийн тамга байж болох юм.

Гэхдээ уг бичээсийг чухам юуны учир, ямар шалтгаанаар бичих болсноо тодорхой дурдаагүй ажээ.

Бид өмнө нь уул бичээсийн өмнөх судалгаандаа “Bоз qan anđi una bađi bitidim” гэж галиглаад “Боз хан ингэж зөвшөөрөөд (тохиролцоод) эхлэн бичив би буюу Боз хан би ийнхүү зөвшилцөөд эхлэн бичив” гэсэн утгатай байж болох нэгэн хувилбар уншлага нийтлүүлсэн билээ. Тэрхүү өгүүлэлдээ эл бичээст Боз хан өөрөө оролцон нэгэн асуудлаар хэлэлцэн зөвшилцөөд, тэрхүү зөвшлийнхөө тухай бичиж үлдээхийг зорьсон ба тодорхой шалтгаанаар зөвхөн эхлэн бичээд орхисон ч байж болох юм¹²² хэмээн үзэж асан билээ.

Уйгур бичээс

Их Бичигтийн уйгур бичээс хоёр үгээс бүтнэ.

Үгийн галиг: *tögüs tükä*.

Уул бичээс утгын хувьд хоёр хувилбараар унших боломжтой.

Нэгдүгээр хувилбар:

Төкүс түкэ гэдэг хүний нэр дурдагдаж байна гэж үзэх. Хэрвээ хүний нэр гэж үзвэл энэ нь уг руни бичээсийг бичигч уйгур үсгээр өөрийнхөө нэрийг бичсэн байж болох уу гэдэг асуулт зүй ёсоор гарна.

Уйгурын хаант улсын эхэн үеийн бичгийн дурсгалууд голдуу руни үсгээр байх бөгөөд тэд бас руни, согд хос бичгээр, мөн түүнчлэн руни, уйгур бичгээр хөшөө (Долоогойдойн бичээс) дурсгал босгож үлдээсэн нь өнөө бидний үед уламжлагдаж ирсэн билээ. Энэ бүхнээс үндэслэлд руни, уйгур бичигт нэвтэрсэн нэгэн эл бичээсүүдийг бичсэн гэж үзвэл байж болох л таамаглал юм.

Мэдээж хэрэг, Их Бичигтийн руни, уйгур бичээсийг нэг бичээч бичсэн болохын хангалттай баталгаа, нуталгаа бас байхгүй.

Хоёрдугаар хувилбар:

“Цохиж дуусга” гэсэн утгатай хэмээн үзэх.

Үүний учир нь “*tögüs (tödüs)*-нүдэх цохих”, “*tükä*-дуусгах, төгсгөх; дуусга, төгсгө”¹²³ хэмээсэн утгатай болохыг толь бичиг, сурвалжид тэмдэглэжээ.

Кашгарын Махмуд хижрагийн 466 (нийтийн тооллын 1072-3) онд зохиосон “*Divanü Lûgat-it-Türk*” тольд “*tögüs~ töküş-döğmekte yardım ve yarış etmek*”¹²⁴, “*tüke*

¹²² Ц.Баттулга, Их бичигтийн бичээс, - Эрдэм шинжилгээний бичиг, Боть 10 (122), МУИС Монгол судлалын сургууль, Улаанбаатар, 1997, 9-13 дугаар тал.

¹²³ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.596; Sir Gerard Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish, Oxford, 1972, pp. 479.

¹²⁴ *Divanü Lûgat-it-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I- IV, Ankara, 1998; Cilt II, s.106-2; 106-5.*

(di) -tükenmek, bitmek; yetmek, kifâyet etmek¹²⁵ гэж тэмдэглэсэн нь дээрх утгатай дүйж байна.

Уйгур бичгийн дурсгал манай орноос тун цөөн тоотой олдсныг дурдвал, Долоогойдойн хөшөөний уйгур бичээс, Тайхар чулууны уйгур бичээс, Бичигт Хангайн уйгур бичээс, өгүүлэн бүхүй Их бичигтийн уйгур бичээс эдгээр болно.

745-840 оны хооронд өдгөөх Монгол улсын нутагт төвлөн төр улсаа байгуулан мандаж асан Уйгур нарын уйгур үсгээр бичсэн дурсгал тун ховор олддог нь нэн сонирхолтой. Уйгурын хаант улсын эхэн үед холбогдох бичээс ихэвчлэн руни бичгээр буй. Уйгур хэл, бичгээр бичсэн гэрэлт хөшөө, хад чулууны бичиг олдохгүй байгаа нь уйгур бичгээр бичээс сийлэхэд бэрхтэйдээ бус тухайн цаг үед тэд үйс, цааснаа ихэд шүтэж эдүй тэдүй ном судар зохиож, мөн орчуулан бичих нь элбэгшин дэлгэрсэнтэй холбоотой болов уу.

Их Бичигтийн хоёрдугаар бичээс

Их Бичигтийн бичээст хадны зүүн талд мөн бичээс байсны ул мөр буй бөгөөд сайн мэдэгдэхээс I (s) Ч (R) Д (Y) [Д (Y) Ч (R) I (s)] үсгүүд тодорхой харагдаж буй. Хожмын цагт судлаар хүрэгсэд дахин нягтлан үзэхэд тус санаж “Их Бичигтийн хоёрдугаар бичээс” хэмээн тодотгон нэрлэв. Хонон өнжин сууж, сайн багаж техникийн тусламжтайгаар нягтлан үзвэл уул бичээсийг унших боломж буйг тэмдэглэе.

Он жилийн уртад нар салхи, ус бороонд идэгдэн байгалийн сүйтгэлд өртсөн байна. Бичээсээс гадна мөн нилээд хэдэн тамга буй.

Тамга

Бид бичээсийн тамгатай холбогдох судалгааг дурдахаа энэ удаад түдгэлзэж буй билээ. Тамга нь тухайн овог, аймгийн тухай хамгийн ерөнхий мөртлөө, хамгийн үнэн бодитой мэдээлэл өгдөг, нарийн нягт судалгаа шаардах бичээсийг тайлж уншихын дайтай үнэ цэнэ, ач холбогдолтой тул тухайлан авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Их бичигтийн бичээс бүхий зөвхөн энгэр талын хаднаа 14 тамга буй бөгөөд Ашина овгийн янгир тамга, янгир тамгатай цуг Онгийн гэрэлт хөшөө, Хар балгасын хоёрдугаар гэрэлт хөшөөнөө сийлэгдсэн “дэгээ” тамга*, Туныюкукийн гэрэлт хөшөөний тамгатай ижил тамга зэрэг хэн бүхнээ танил болсон олон тамга байна.

Их Бичигтийн эдгээр олон тамга Боз хэмээх хааны алдар хүнд, түүний нэгтгэсэн овог аймаг, цэргийн бүрэлдэхүүнийг гэрчлэн илтгэх мэт.

¹²⁵ Divanü Lûgat-it-Türk, tercümesi, Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Dil Kurumu Yayınları: 552, çeviren Besim Atalay, 4.baskı, Cilt I-IV, Ankara, 1998; Cilt II, s.106-7; 106-10;107-1; 106-20.

* Ашина овгийн янгир тамгатай цуг сийлэгдсэнээс үзвэл тэрхүү овогтой эн зэрэгцэхүйц нэр нөлөө бүхий, эсвэл худ ураг, холбоотон овгийн тамга байж болох юм.

Бичээст гарах үгийн толь

- Чᠢᠯᠤᠰ boz –  boz, хүний нэр
- ᠵᠠᠨ qan-  qan, хан
- ᠶᠢᠨ аnči –  ,  eyin, teyin, ийн, тийн, ийнхүү, тийнхүү
- ᠠᠷᠢᠪᠠ on –  arba, арав
- ᠲᠤᠯᠤᠭᠠᠢ baši –  ,  toluyai, uduriduyči, толгой, удирдагч
- ᠪᠢᠴᠢᠪᠡᠪᠢ bitidim-  би bičibe bi, бичив би
- bit-бич
- b.di- үйл үгийн өнгөрсөн цаг. (бичсэн)
- m- бисийн төлөөний нэгдүгээр бие. (би)

НАЛАЙХЫН БИЧЭЭС

(Шавар ваарын хэлтэрхий дээрх бичээс)

1930-аад онд Налайхаас руни бичигтэй шавар ваарын нэгэн хэлтэрхий оллодж улмаар уншиж судлан шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна.

Гэтэл төдөлгүй уг бичээс хожуу бичигдсэн хуудмаг бичээс байсан тухай мэдээ нийтлэгдэж нилээд шуугиан тарьжээ. Манай судлаачдын бүтээлд уг бичээсийн талаар урд өмнө “ганц ч үг” дурдаж байсангүй тул нийтэд мэдээлж танилцуулахыг зорилоо. Уг дурсгал Налайхын ойролцоогоос олдсон гэх учир, нөгөө талаар Туньюкукийн тахилын сүмийн хананы шаваасын бичээсээс ялгахын тулд ингэж нэрлэж байжээ. Налайхаас олдсон гэх энэ бичгийн дурсгалын талаар манай эрдэмтдийн гаргасан руни бичгийн дурсгалын жагсаалт, судалгааны тойм болон ер ном бүтээлд урьд өмнө огт дурдаж байсангүй ажээ. Иймд, уг бичгийн дурсгалын талаар танилцуулъя.

Эртний түрэгийн хэл бичигт холбогдох нэгэн дурсгалыг 1930-аад оны үед Налайх хавиас нутгийн малчин ард олж улмаар тухайн үед манай улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнд ажиллаж байсан Зөвлөлт (Орос)-ийн эрдэмтэн Д.Д.Букиничид өгсөн гэдэг¹²⁶. Д.Д.Букинич уг бичээсийн гэрэл зураг, хуулбарыг түрэг судлаач А.Н.Самойловичид илгээсэнд тэрээр тайлж уншаад хэвлэн нийтлүүлжээ.

А.Н.Самойловичийн нийтлүүлсэн уг өгүүлэл тухайн үеийн бодит мэдээ баримтыг агуулж бүхүйд элдэв засвар, тайлбар хийлгүйгээр шууд ишлэвэл “В сентябрь этого года я получил от Д.Д.Букинича, работающего при Научно-исследовательском комитете Монгольской народной республики в Улан-Баторе, сообщение следующего содержания: *“Один из скотоводов доставил мне обломок черепицы, поднятый им где-то у Налайхи (каменноугольные копи в 50 км от Улан Батора на правом берегу Толы). Местонахождение фрагмента он мне не мог точно указать. Так как на черепице имеется часть рунической надписи, то я счел нужным переслать вам зарисовку этой надписи и фотоснимок с фрагмента. Для меня наиболее ценным в найденном фрагменте является изображение охотничьей сцены (сохранилось-часть лука натянутого по направлению к двум козлам). К вашему сведению: подобные черепицы с надписями, по позднейшего происхождения и с геральдическими знаками были находимы мною при раскопках в Монголии на развалинах Цаган-Байшина на Толе и Чин-Тологая. Поэтому вновь найденный фрагмент я склонен отнести также к черепицам, имея в виду еще и наличие на найденном фрагменте на вогнутой стороне фрагмента отпечатка ткани, каковая техника в черепичном деле прослеживается на раскопочном материале из уйгурских городищ (примерно VIII века нашей эры). Размеры фрагмента черепицы в сообщении Д.Д.Букинича не указаны”*¹²⁷ гэжээ.

А.Н.Самойловичийн уншлага, орчуулгыг дурдвал;

¹²⁶ Н.Сэр-Оджав, Шинэ олдсон түүрэг бичээсийн тухай, - Studia Archaeologica, Tom.1, fasc.7, Улаанбаатар, 1958, 3 дугаар тал.

¹²⁷ А.Н.Самойлович, Новые тюркские руни из Монголии, - Известия Академии Наук СССР, Москва, 1934, стр. 631.

1.Umay qatun...	Умай царица...
2.Qan täñrid[ä?]....	На хане-небе...(?)
3.İduq yer suy(?)...	Священная земля -вода...
4.Kögmän s...	Көгмен...

Тэрбээр бичээсийн зарим нэгэн үгтэй холбогдуулан тайлбар хийсэн байна.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун “Eski Türk yazitları”(Эртний түрэг бичээсүүд) хэмээх номдоо уг бичээсийн тухай “Ulan-Bator (Urga) kiremit yaziti” нэртэйгээр А.Н.Самойловичийн хэвлүүлсэн эх, уншлагаас дам авч гэрэл зургийнх нь хамт оруулжээ.

Түүний судалгаанаас үзвэл эл дурсгалын өргөн нь 22.5 см, урт нь 10.8 см, зузаан нь 16 мм, бичээсийн үсэг зурлагын өндөр нь 16 мм¹²⁸ ажээ.

Уул бичээсийн дөрөвдүгээр мөрийг нэг хэмээн тоолон тонгоруулан тэмдэглэсэн нь судлаачдын нийтлүүлсэн гэрэл зурагтай тулган үзвэл харин ч зөв болсон мэт санагдана.

Х.Н.Орхуны уншлага, орчуулга нь;

1. Kögm ⁿ s....	1. Köğmen.....
2. Id ^u k yer suy(?)	2. Mukaddes yer su....
3. K ^a n t ⁿ rid[e]....	3. Han Tanrida.....

Үсэг зурлага маш тодорхой, илэрхий тул судлаачдын уншлага, орчуулгад мадагтай, ташаарсан гэхээр зүйл алга байна. Бичээсийг монгол хэлнээ;

1. Көгмэн
2. Ариун дагшин газар, ус
3. Хан тэнгэр
4. Умай хатан хэмээн орчуулж болох юм.

Оросын нэрт эрдэмтэн, түрэг судлаач С.Е.Малов турк улсын эрдэмтэн Х.Н.Орхуны бичсэн “Eski Türk yazitları” номын шүүмждээ уг бичээс нь хуурамч, дууриалган бичсэн болохыг тэмдэглэжээ. Шүүмжид “В данном случае мне тоже хочется отметить второй подобный факт: я слышал (по моей записи 7 апреля 1937 г.), что руническая надпись из Монголии представляет собой подделку, ученую мистификацию. Проверку этого слуха мне сделать удалось теперь, в 1947 г., -это действительно так: ученая мистификация... Без этого издание Оркуна не может быть признано полным” гэжээ¹²⁹. Шүүмжээс үзвэл өгүүлэн бүхий бичээс хуурамч болохыг хөдлөшгүй баримтаар баталж нуталсангүй нь уг дурсгалыг өөрөө үзээгүйтэй холбоотой байж болох юм. Эл бичгийн дурсгал байсан эсэх нь нууцлагдмал хэвээр байгаатай адил судлаачдын харилцаанд ч нууцлагдмал зүйл байсан бололтой. Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг, Их Хөшөөт хэмээх газар буй Келичурын гэрэл хөшөөний бичээсийг С.Е.Малов дахин нягтлан уншиж хэвлүүлэхдээ А.Н.Самойловичийн нэрийг ч дурдаагүй байдаг билээ¹³⁰.

¹²⁸ H.N.Orkun, Ulan-Bator (Urga) kiremit yaziti, -Eski Türk yazitları II, İstanbul, 1938, s.161-162, (Ankara,1987, 1994, s.353-354).

¹²⁹ С.Е.Малов, Критика и библиография, - Известия Академии Наук СССР, Москва,стр.124.

¹³⁰ С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва, 1959, стр. 25-30.

Көличурын гэрэлт хөшөөг 1912 онд В.Котвич олж илрүүлэн улмаар А.Н.Самойловичтай хамтран тайлан уншиж орчуулсан¹³¹ бөгөөд бичээсийг голлон уншсан судлаачийн нэрийг огт дурдаагүй нь туйлын хачирхалтай.

Мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожавын “Хөгнө Ханы Гурвалжин уулын бичээс”-ийн гар хуулбарыг Жамсрангийн Цэвээн гуай 1929 онд А.Н.Самойловичид илгээсэн бөгөөд тэрээр хуулбарт буй бичээсийг “Teṅṅi qulī bitidim-гэнгэрийн боол бичив би” гэсэн утгатай болохыг тайлж 1935 онд хэвлүүлжээ¹³².

Б.Базылхан¹³³, С.Г.Кляшторный¹³⁴, Л.Болд¹³⁵ нарын эрдэмтэд Гурвалжин уулын бичээсийг уншиж тайлсан судалгаа, эл бичээсийн талаар мэдээлэлдээ А.Н.Самойловичийн судалгааны талаар огт дурдаагүй байдаг билээ.

Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун “Gürbelçin kaya yazıtı” нэртэйгээр А.Н.Самойловичийн уншлага, хуулбарын гэрэл зургийн хамт 1938 онд өөрийнхөө номдоо оруулан хэвлүүлжээ¹³⁶.

А.Н.Самойловичийн судалгааг манай эрдэмтэд олж үзээгүй гэхэд нэн эргэлзээтэй, үнэмшилгүй санагдана.

Руни үсэг бичигт тайлагдсан, эртний түрэг хэлний зохих мэдлэгтэн хэн ч “Тэнгэрийн боол бичив би” гэж шууд уншихаар тодорхой уг бичээсийг хэн анх зөв уншиж судалгааны эргэлтэнд оруулсан болох нь илэрхий, тодорхой байна.

Дээрх баримтаас үзвэл А.Н.Самойловичийн судалгаа, бүтээлийг ашиглахаас “жийрхдэг” бололтой юм. Магад улс төрийн болон бусад шалтгаантай холбоотой биз ээ.

Туньюкукийн тахилын сүмийн хананы шаваасны хагархай дээрх бичээсийн тухай анхны нийтлэл өгүүлэлд “Бидний олсон бичээс нь А.Н.Самойловичийн нийтлүүлсэн бичээс олдсон газраас гарсан боловч түүнийг хуурамч бичээс байж магадгүй гэж эргэлзэх нь илүүц болохыг энд дурдууштай”¹³⁷ хэмээн онцлон тэмдэглэсэн нь буй.

Туньюкукийн тахилын сүмийн хананы шаваасын хагархай дээрх бичээс “А.Н.Самойловичийн нийтлүүлсэн бичээс олдсон газраас гарсан” нь үнэн бол эл хоёр дурсгал нэг газраас олдсон болох нь илэрхий байна.

Гэтэл эл хоёр бичгийн дурсгалын үсэг тэмдэгтийн бичлэгийн хэлбэр, тиг маяг нь өөр зуураа огт таарахгүй харилцан адилгүй юм.

¹³¹ W.Kotwicz et A.Samoilovitch, Le monument turc d'Ikhe-khuchotu en Mongolie centrale, -Rocznik Orientalistyczny, Tom. IV(1926) Lwów, 1928, pp.60-107.

¹³² А.Н.Самойловича, Новые тюркские руны из Монголии, -Известия Академии Наук СССР, Москва, 1934, стр; Н.Н.Оркун, Ulan-Bator (Urga) kiremit yazıtı, -Eski Türk yazıtları II, İstanbul, 1938, s.161-162, (Ankara,1987, 1994, s.353-354).

¹³³ Б.Базылхан, Гурвалжин уулын түрэг бичээс, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №4, Улаанбаатар, 1969, 14 дүгээр тал.

¹³⁴ С.Г.Кляшторный, Наскальные рунические надписи Монголии, -Тюркологический сборник, Москва, 1975, стр. 155; С.Г.Кляшторный, Надпись из Гурвалжин-ула, -История Центральной Азии и памятники рунического письма, Санкт-Петербург, 2003, стр.274-275.

¹³⁵ Л.Болд, Гурвалжин уулын түрэг бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 23-24 дугаар тал.

¹³⁶ Н.Н.Оркун, Eski Türk yazıtları II, İstanbul, 1938, s.163; (Ankara,1987,1994, s.355).

¹³⁷ Н.Сэр-Оджав, Шинэ олдсон түүрэг бичээсийн тухай, -Studia Archaeologica, Tom.I, fasc.7, Улаанбаатар, 1958, 4 дүгээр тал.

Нэг цаг үед бичигдсэн ч бичлэгийн тиг хэлбэр адил байх албагүй, бичигчээс шалтгаалан тухайн үеийн хэрэг явдал, зориулалтаас хамааран өөр өөр байх магадлал бий. Тиймээс зөвхөн үсэг бичгийн зурлага, тиг хэлбэр төдийхөнд дулдуйдаж нэг газраас олдсон байх боломжгүй гэх буюу эсвээс өөр өөр цаг үед хамаарагдах тус тус дурсгал, үгүй бол үсэг бичгийн хэлбэр, бичлэг ялгаатай ч нэг цаг үеийн нэг цогцолбор дурсгалын хоёр бичээс мөн хэмээн батлах нь хэтийдсэн зүйл болох биз.

Хуурамч эсэх нь үл мэдэгдэх бичээсийн талаар илүү сайн мэдэх хүний нэг археологич Н.Сэр-Оджав гуай яах аргагүй мөн тул дээрх мэдээг огт хайхрахгүй өнгөрч болохгүй. Гэхдээ дурдсан мэдээ, өгүүлэн бүхий дурсгалын олдсон газрыг бат нут тогтоох хангалттай баримт болж чадахгүй нь мэдээж.

Налайхын уурхайн цооногийн аль нэгэнд тахилын цогцолбор дурсгал дайрч сүйдсэн байхыг ч үгүйсгэх аргагүй. Мөн малчин ардын нүүдэл суудлыг харгалзан үзвэл тэр хавьд, наанадаж 50-60 км-т эртний, ялангуяа түрэг, уйгурын үеийн хот балгадын туйр, булш бунхан, тахилын цогцолбор байсан, байгаа эсэхийг дахин нягталж үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Бичлэгийн хэлбэр, янгир тамга тэргүүтнээс үзэхэд хуурамч, хуудмаг гэхэд бэрхтэй ч, хуурамчаар бичсэн гэхүл руни бичиг, эртний түрэг хэлний багагүй мэдлэгтэн үйлдсэн болох нь лавтай, тодорхой байна. Тэгээд ч 1930-аад онд руни үсгээр хуурамч бичиг үйлдэх нэгэн манай монголд лав байхгүй байсан билээ.

Бичээст монголын руни бичгийн сонгодог дурсгал (Көлтигин, Туныюкук гэх мэт)-д олонтоо тохиолдох уул усны нэр, шүтлэг бишрэлийн үгс зонхилж байна.

Төгсгөн тэмдэглэхэд;

1. Налайхаас олдсон руни бичээст шавар ваарын хэлтэрхий манай ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн сан хөмрөг, мөн түүнчлэн Үндэсний түүхийн музейд байхгүй байна.

2. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Д.Д.Букиничийн тайланд энэ бичигт дурсгалын талаар ямар ч мэдээ баримт, дурдсан зүйл үгүй юм.

3. Эх дурсгалыг, уг бичээсийг нүдээр үзэж, гараар бариагүйд хуурамч, эсвэл жинхэнэ хэмээн бат нут хэлэх боломжгүй юм.

4. Оросын түүх, археологийн аль нэг музейд уг дурсгал хадгалагдан үлдсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Налайхаас олдсон шавар ваарын хэлтэрхий дээрх бичээсийн хуурамч, жинхэнэ аль нь боловч уг эхийг эрэн сурвалжилж олоод дахин нягталбал олон зүйлийн учир тайлагдах нь магад буй за.

СЭВРЭЙН БИЧЭЭС

Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт эртний бичиг бүхий нэгэн чулуу байдаг тухай нутгийн нэгэн багш залуу 1948 онд тус аймгийн нутагт ажилласан палеонтологийн шинжилгээний ангийнханд мэдээлсэн байна. Уг мэдээллийн мөрөөр тус шинжилгээний ангийн ахлагч И.А.Ефремов бичээсийг үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулахыг зорьжээ¹³⁸.

И.А.Ефремовын удирдсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан нэрт зохиолч Ч.Лодойдамба Сэврэй бичигт чулууг нүдээр үзэж бичээсийг уншиж утгыг нь тайлж эс чадан ярилцаж байсан тухайгаа “Алтайд” хэмээх романд¹³⁹ уран сайхны аргаар тодорхой өгүүлсэн байдаг билээ.

Тиймээс ч “Сэврэй”-н гэгдэх энэ багахан бичээс шинжлэх ухааны эргэлтээс урьтаж уран зохиолоор дамжин нийтэд танигдаж монголын утга зохиолын түүхэнд зохих үл мөрөө үлдээсэн гэж хэлж болох юм.

Харин шинжлэх ухааны үүднээс шинжлэн судлахад зориулж Б.Ринчен академич “Сэврэй бичээс” гэж нэрлэн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлсэн байна¹⁴⁰.

Хорь гаруй жилийн хойно буюу 1969 онд Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Бичээс судлал”-ын хэсэг зорин очиж бичээсийг нягтлан судалсан байна*.

Бид Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд 1997 оны 9 дүгээр сард Сэврэй дурсгалыг үзэн бичээсийг дахин нягталсан билээ¹⁴¹.

¹³⁸ Ефремов И.А. Дорога ветров. Гобийские заметки. Изд.2-е.Москва, 1962, стр.229; Жич: Зөгнөлт зохиолч, эрдэмтний хувьд И.А.Ефремов энэ үсэг бичгийн дурсгалыг тайлж унших, учир утгыг нь мэдэхийг ихэд эрмэлзэж байжээ. Тухайн үед Намын Төв Хороонд ажиллаж байсан нэрт зохиолч Ч.Лодойдамба гуай энэ хээрийн шинжилгээний ангид зохих хэмжээгээр оролцож байсан ба монголын анхны зөгнөлт “Алтайд” роман бичихэд ихээхэн нөлөөлсөн гэдэг.

¹³⁹ “-За тэгээд, бүгдээрээ юу болох нь вэ? гэж Батын амны хөдлөх бүрийг ажиглаж байсан Идэр асуув.

-Хагас дутуу гаргаснаас үзвэл, “зөгс... олон баатар хамаг иргэд, үүнээс цааш... их эзэн тэнгэрийн хувьдүүн Чингэс хааны өмнийг нээгч хөх тугийн өрлөг Зэв” гэж байна- гээд Бат баяр баясгалан гялалзсан нүдээр тойруулан харсан...” Ч.Лодойдамба, Алтайд (роман), нэгдүгээр дэвтэр, Монголын зохиолчдын эвлэл, Улаанбаатар, 1949,104-105 дугаар тал.

“-Бичигт хадны тухай яриа хэдэн цаг үргэлжлэв. Ер нь нэгэн зүйлийн ярианаас бас өөр зүйлийн яриа үүсдэг. Тэрчлэн шинжлэх ухааны нэгэн баримтаас нөгөө зүйлүүд сэдэвлэн олддог юм. Яриа хэдий үргэлжилсэн авч мэдэгдээгүй үгүүд нууц хэвээр үлдэв...” Ч.Лодойдамба, Алтайд (роман), нэгдүгээр дэвтэр, Монголын зохиолчдын эвлэл, Улаанбаатар, 1949,107 дугаар тал.

-Согд бичгээр тул монгол бичигтэй адил санаж унших гэвч огт болохгүй байсан нь тэдний гайхлыг төрүүлж байсан биз ээ. Тиймээс ч нэрт зохиолч уг чулууны бичгийг зориуд сонгон авч шинжлэх ухааны үүднээс судлах шаардалгатайг сануулсан хэрэг буй за.

¹⁴⁰ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968.

* Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Лувсанбалдан, Б.Базылхан, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү, Зөвлөлтийн эрдэмтэн С.Г.Кляшторный нар оролцон ажилласан байна.

¹⁴¹ Yutaka Yoshida, Takao Moriyasu, Akio Katayama, Sevrey Inscription, Runic Part of Sevrey Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998. The Society of Central Eurasian Studies, 1999, pp.225-227.

Дурсгалын байршил; 1545 м өндөрт, хойт өргөргийн 43° 21' 09", зүүн уртрагийн 103° 31' 07" солбилцлын цэгт оршино.

Хөхөлбөр судалтай цагаан гантгич чулууг зориуд тэгшлэн засч толгигор талд нь руни, согд бичээсийг гаргацтай, хичээнгүй, бичлэгийн хэв сайтай сийлжээ.

Руни бичгийн бичлэгийн тиг хэлбэр нь Уйгурын Харбалгасын гэрэлт хөшөөний бичээсийн бичилгэтэй тун ойролцоо юм. Уг дурсгалыг сумын төвд зөөн аваачиж үзмэр болгож байгаад 1990-ээд оны дунд үеэс анх байсан газар буцааж тавьсан бөгөөд сумын төв рүү зөөхдөө "Сэврэйн чулуу"-ны хажууд цементээр суурь хийж "1988 онд цагаан чулууг авав" гэж бичсэн байжээ.

Чулууны өндөр 80 см, бичигтэй талын өргөн 50 см, зузаан 60 см. Анхны байрлалаас хөдөлсөн тул чухам аль зүг бичээс хандаж байсныг тодорхойлоход бэрхтэй. Зориуд тэгшлэж зассан толгигор талд бичээс байх боловч он цагийн уртад нар салхи, цас борооны усанд идэгдэн үсэг тэмдэгт нь тун их бүдгэрч, сайн мэдэгдэхгүй болжээ. Ойр хавьд нь эл чулуутай адил өнгөтэй чулуу болон түрэг, уйгурын үетэй холбогдох дурсгал нэгээхэн ч үгүй бөгөөд өнчин ганц цагаан чулуу байгаа нь зориуд олж сонгон бичиг үйлдсэн болохыг илтгэнэ.

Бичигт чулуу байгаа газрыг Мандалын хошууны Оёдол гэх боловч байгаа газрынх нь нэрээр бус харин эртний аврага амьтны нуруу сэрвээг санагдуулам сүрлэг сэрвэн хадат Сэврэй нурууны өвөрт байдаг тул "Сэврэйн бичээс" хэмээн нэрлэж хэвшжээ.

Сэврэйн чулууны руни бичээсийг эрдэмтэн С.Г.Кляшторный анх тайлж уншсан байна. Тэрээр бичээсийг

1. ... p ... s²(?)nt ...
 2. ... t² m r¹ ... nis² t¹ n²
 3. ... k² ... z ... o n ... nčl¹a: b¹ ... muj¹γ(a?)
 4. ... igü(?) ... s² ... u r¹γ ... ū ...
 5. ... k²ü (l) t¹r¹ ...
 6. ... n¹ l¹ q u t¹ l¹ (γ) ... b¹ ...
 7. i η i j¹ γ l¹ a γ (r) гэж галиглаад орос хэлнээ
3. ...десять (?) ... мятеж (ний?)
 4. ... род (?) ...
 5. Кю (ль) –тар кан ...
 6. ... (ы) нал Кутлу(г)
 7. Инги Яглага (р) хэмээн орчуулсан байна¹⁴².

Тэрээр уул бичээсийг хятдад гарсан Ань Лушань (安史之乱 an shi zhi luan) тэргүүтийн бослогыг дарсан түүхэн үйл явдалтай холбоотой хэмээн үзсэн байдаг*.

¹⁴² С.Г.Кляшторный, В. А.Лившиц, Сэврэйский камень, -Советская тюркология, Баку, 1971, №3, стр. 106-112; S.G.Kljaštornyj, V.A.Livšic, Une inscription inédite turque et sogdienne: la stèle de Sevrey (Gobi Méridional), - Journal Asiatique, 1971, pp.11-20; С.Г.Кляшторный, В.А.Лившиц, Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии, - Археология и этнография Монголии, Новосибирск, 1978, стр.57-59 (37-60).

* Нангиадын Тан улсад Ань Лушаны бослого гарч аргагүйтэхийн эрхэнд Уйгур нараас хаан нь тусламж гуйсан ажээ. Уйгурууд тэрхүү хүсэлт гуйлтыг ёсоор болгож 756, 757, 759, 762 онуудад цэрэг илгээж бослогыг даралцсан түүхтэй.

Тайлбар

[ᠲᠠᠯᠤᠯᠤᠭ ᠪᠣᠯᠠᠭ] ᠲᠠᠯᠤᠯᠤᠭ- qutluγ [bolzun-bolun]- руни, уйгур бичгийн дурсгалд олонтоо тохиолдох ерөөл, бэлгэдлийн утгатай, өлзийтэй болог, өлзийтэй байх болтугай гэсэн үг. Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалуудаас Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг дахь Арханангийн, Архангай аймгийн Их Тамир сумын Тайхар чулууны, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дахь Далан уулын бичээс зэрэг хэд хэдэн бичээсэд ерөөл, аян зам ерөөлийн утгаар тохиолдохоос гадна Дундговь аймгийн нутгаас ᠲᠠᠯᠤᠯᠤᠭ qutluγ гэх үгтэй гарын тэмдэг, тамга олдсон нь нийтэд ихэд дэлгэр, түгээмэл хэрэглэгдэж байсан “эрхэм, бэлгэдлийн үг” мөн болохыг харуулж байна. Бас нэг жишээ дурдахад, дөрвөлжин үсгээр түрэг хэлээр бичсэн цорын ганц дурсгал буй нь 1348 (эсвээс1360) онд Туглугтөмөр гэдэг хүний бичсэн монгол бичгээрх нэгэн захидлын зүүн дээд буланд дарсан тамгын дардас бөгөөд уг дурсгалыг Альберт фон Ле Кох (Albert von Le Coq, 1860-1930)-ын удирдсан Германы шинжлэгээний анги Турфанаас олсон түүхтэй. Түрэг хэл, дөрвөлжин үсгээр бичсэн уг тамгын бичээс нь “ogon qutluq bolzun” буюу “(хаан) ор тань өлзийтэй болтугай” гэсэн утгатай¹⁴⁴ ажээ.

Нэн ялангуяа Уйгурын үеийн бичгийн дурсгалд олонтоо тохиолдож байгаа нь “Алтангэрэл” (санскрит: Suvarnārabhāsa; төвд: གསེར་རྩེᠰᠤ gser'od, монгол:

ᠠᠯᠲᠠᠨᠭᠡᠷᠡᠯᠦ altangereltü; уйгур: *Altun yaruq*; нангиад-金矿 gūn guāng) тэргүүт олон судар шаштирийн орчуулгаар дамжин бичгийн болон аман ярианд уламжлагдан ирсэн буй за.

Эдүгээ ч хутаг өлзий, хутаг өлзий оршиг, өлзий хутаг оршиг гэж хэлэлцээр байна. Монголд Хутаг, Хутуг нэрт уул ч олон байдаг билээ.

ᠲᠢᠭᠢᠨ-tigin; tigin-čigin. Монгол хэлний “čigin” гэх үгтэй гарал нэг бөгөөд хааны бага хүү, отгон хүүг нэрлэх нэр, цол үг. Көлтигин, Билгэ хаанд зориулсан гэрэлт хөшөөний бичээс зэрэг түрэгтийн үеийн дурсгалаас гадна Уйгур бичгийн сурвалжид нилээд олон тохиолдоно¹⁴⁵. Турфаны цуглуулгад 24x15,5cm хэмжээс бүхий нэгэн цааснаа уйгур бичгээр бичсэн шүлгийн хэсэг / Т.М.419 дугаартай/-ийг “Апанчур тигин”-ий шүлэг хэмээн нэрийдэж, түрэг судлалын ном зохиолд түрэгтийн эртний уран зохиолын, нэн ялангуяа яруу найргийн чухаг сурвалж гэж тэмдэглэсээр ирсэн билээ¹⁴⁶. Уйгур Алтангэрэл сударт “tigin” хорь гаруй, “tigit”

¹⁴⁴ E.Haenish, *Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile*, - *Mongolica der Berliner Turfan-Sammlung II*, Berlin, pp.18, 29; Д.Цэрэнсодном, Турфаны цуглуулгын 2-р дэвтрийг судалсан байдал, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, № 2, Улаанбаатар, 1964, 104-107 дугаар тал; А.Дамдинсүрэн, Монгол дөрвөлжин бичиг, Улаанбаатар, 1986 (1985), 228 дугаар тал; Ё.Жанчив, Дөрвөлжин бичиг, -Төв Азийн нүүдэлчдийн бичиг, үсгийн товчоон, Улаанбаатар, 2001, 155-172 дугаар тал; Ц.Шагдарсүрэн, Дөрвөлжин бичиг, -Монголчуудын үсэг, бичгийн товчоон, Bibliotheca Mongolica: Monograph I, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2001; Ё.Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, *Monumenta Mongolica: Tom.III*, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2002, 11 дүгээр тал.

¹⁴⁵ Nobuo Yamada, Juten Oda, Peter Zieme, Hiroshi Umemura, Takao Moriyasu, *Sammlung Uigurischer Kontrakte*, -Osaka University Press, 1993, Band 1-3 (Texte in Transkription und Übersetzung, Bemerkungen, listen, Bibliographie und Wörterverzeichnis), Band 2, Textband Wörterverzeichnis, pp.291.

¹⁴⁶ Reşid Rahmeti Arat, *Eski Türk Şiiri*, (Birinci baskı: 1965.; İkinci baskı:1986; Üçüncü baskı: 991) s. 14-23.

хэлбэрээр арван нэгэн удаа тохиолдож байна¹⁴⁷. Хутагт билиг /Qudatγu bilig/-г “tigin” гэх үг хоёр удаа, уг үгийн олон тоо “tigit” хэлбэрээр цор ганц удаа тохиолдож байна¹⁴⁸. Дээрх баримтаас үзэхүл уйгурын үед “тигин” цол, нэр лавтай түгээмэл байжээ.

Язгуур цол хэргэмээ мартаж гэсэн бололтой, хожуу үеийн түрэгийн түүх, хэлний сурвалжуудад төдий л тохиолдохгүй байгаа нь хожим шашин соёлын харилцаа нөлөөгөөр дамжин перс, араб цол хэргэмийг өргөн дэлгэр хэрэглэх болсонтой холбоотой биз ээ.

Харин Монголчуудын хувьд энэ цол хэргэм отгон, бага хүүд хамаатайгаар XII-XIII зууны үед лавтай хэрэглэгдэж байсныг Монголын нууц товчооны “otčigin, otčigin noyan”¹⁴⁹ хэмээх нэр бэлхэнээ нутлаж байна.

Сэврэйн бичигт чулуу он жилийн уртад нар салхи, хур борооны усанд идэгдэн ихэд өгөршин муудаж үйрэн унасаар одоо цөөн хэдэн үсэг үзэгдэх тэдүй буй. Иймд уг дурсгалыг хамгаалах зайлшгүй шаардлагатайг онцлон тэмдэглэе. Бүрэн гүйцэт уншигдах үг, өгүүлбэр бараг үгүй, хэсэг бусад тул уул бичээстэй холбогдох баттай мэдээ, түүхэн үйл явдлыг тодотгох боломж, баримт туйлын хомс юм.

Төв Азийн нүүдэлчдийн эртний үсэг бичгийн судлалд согд үсэг бичиг багагүй хувь нэмэртэй билээ. Учир нь тэдэнтэй Согдууд эртнээс худалдаа, соёлын маш өргөн харилцаатай байсныг түүх гэрчлэнэ.

Нэн ялангуяа Уйгур улсын үед Согдуудын худалдаа арилжаа, шашин соёлын нөлөө ихэссэн бөгөөд түүний нэг тод жишээ нь Байбалык хотыг барьж байгуулсан явдал юм¹⁵⁰. Тиймээс ч монгол нутагт түрэг, уйгурын үед холбогдох согд бичгийн дурсгалууд цөөнгүй буй бөгөөд манайд Бугатын гэрэлт хөшөөний согд бичээс, Хар балгасын гэрэлт хөшөөний согд бичээс, Сэврэйн согд бичээст дурсгалын талаар өгүүлсэн нь буй боловч уг бичээсийг монгол хэлнээ орчуулж гаргасан, өмнөх эрдэмтдийн судалгааг дахин нягталж уншиж судалсан зүйл барагтайхан тул, энэ далимд Сэврэйн согд бичээсийг уншиж тайлсан хоёр судалгааг толилуулахыг хичээлээ.

В. А.Лившиц нарын Сэврэйн согд бичээсийн судалгаа:

Эхийн галиг;

1.s(r)δ (nwkr) [βʔ]γ[y].....(‘wy)γ(wr) γ(‘) [γ’n.....]
2. (rty pyštr ‘kwʔ ‘y) [n] (‘δ t) [r] (γ’n) (s’r).....
3. (p’r) s’r (‘)kw ‘w(y) [γwr γ’γ] (n ‘YK).....
4. (pyš) trw.....wδ (y).....
5.(γ’γ’n s’r) w’nkw ntyš/kwy/.....

¹⁴⁷ Ceval Kaya, Yugurca Altun Yaruq, Türk Dil Kurumu Yayınları: 607, Ankara, 1994.

¹⁴⁸ Reşid Rahmeti Arat, Kudatgu bilig III. Indeks, Türk Kültürü Araştırma Enstitüsü, Yayınları: 47, Seri: IV, Sayı: A12, Istanbul, 1979, ss.451.

¹⁴⁹ Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, -Indiana University Publications Uralic and Altaic Series, Volume 121, Bloomington, 1972, pp.282.

¹⁵⁰ Уйгур улсыг байгуулсан Кутлуг Билгэ Күл хааны хүү Моюнчур (Баян чур) (Tänride bolmıs iltiris bilgä qaγan 747-759) хаанд зориулан 759 онд босгосон (эдүгээ Архангай аймгийн Хайрхан, Булган аймгийн Сайхан сумдын зааг нутаг, Могойн шинэ ус хэмээх газар буй) гэрэлт хөшөөний бичээсийн баруун талын 5-р мөрд “ соγдаq табаγаqса сälläγädä bay balıq уарıт bertim-Согд, Табгачад Сэлэнгэд баян хот байгуулж өгөв би ” гэж буй билээ.

6.(....)δ'r (nt) [r] (tpy) [štr?...]...

7.pc.....

гэж галиглаад орос хэлнээ,

1.год. Тогда господин уйгурский каган (?).....

2. и затем к (?) Иналь-тархану....

3. и затем (он обратился) к уйгурскому кагану, де мол:.....

4. Потомтам.....

5.к кагану он так обратился.....

6.ониИ затем (?)..... хэмээн орчуулсан байна.

Үүнийг монгол хэлнээ дам орчуулбал;

1. ... он. Тэгэхэд уйгурын эзэн хаан(?) ...

2. ба дараа нь Иналь-тархан руу (?)

3. ба тэгээд (тэр) уйгурын хаан руу (хандсан), гэнэ...

4. Дараа нь ... тэнд...

5. ... тэр бээр хаан руу тийн хандаж ...

6. ... тэд ... түүнчлэн дараа нь (?)... болох мэт.

Эл уншлагаас олон жилийн хойно буюу 26 жилийн дараа Сэврэйн согд бичээсийг Японы эрдэмтэн Ютака Ёшида дахин нягтлан судалж галиг, япон, англи орчуулгатайгаар нийтлүүлжээ¹⁵¹.

Ютака Ёшидагийн судалгаа;

Эхийн галиг;

1.] (m) II BLANK yγ(l)++ γ[]+++++ BLANK (rt)[y?
2.]++s(m)'wtr z-npw ZY 'wδ rw[](t)r'y ZY βtδl' + (pr)'(wtcw'n)++ (c)tδ'rt (ZY)+[
3.]p'ryrn'kw 'w(t)[]y []+t ''p(βrδ)'rt ZY m'γ nwc +++ [
4. p](r)št[']t (δ) [r-]+++++++]
5.](y) L(')[]t s'r (w)' nkw pty+++ttt[
6.]++[]s(')t δ'r('y)m (rt)y δ+++t[
7.]+++++[

Япон хэлнээ;

1. ... 「我々はこの碑文を書いた」クラグ・***...
- 2... 大海の岸の...そしてそこで****と***は***した
3.*** 彼は水を運んだ。そして我々は新しい...
4.準備した...
5.ない....へ次のように....

¹⁵¹吉田 豊・森安孝夫・片山 章雄・セブレイ碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月(Yutaka Yoshida, Takao Moriyasu, Akio Katayama, Sevrej Inscription; Yutaka Yoshida, Sogdian Part of Sevrej Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998. The Society of Central Eurasian Studies, 1999), pp.225-126.

6.我々は....した

7.

Англи хэлнээ;

1. [We wrote this inscription?] Il Yahl*** ...Then... ..

2. the coast of the ocean and there Ru*** and Vatdhal*** ed and

3. *** ...he brought water and we ... new... ..

4. prepared

5. not ... to... thus... ..

6. we*** ed. Then

7. хэмээн тус тус орчуулжээ.

Түүний дээрх орчуулгыг монгол хэлнээ буулгавал;

1.[Бид энэхүү бичээсийг бичсэн?] Il Yahl...тэгээд

2. ...Далайн эрэг орчим болон Ru ба Vatdhal-д ... сан⁴ ба

3. ... тэр ус аваад бид... шинэ...

4... бэлдсэн...

5. ...үгүй... .. түүнийг ...

6. ... бид... сан⁴. Тэгээд ...

7. ... гэжээ.

Сэврэйн чулууны согд бичээсийг уншсан судлаачдын уншлага нилээд зөрүүтэй болох нь дээрх бүтээлүүдээс харагдаж байна. Эл зөрүүтэй уншлагыг цэгцлэх дараагийн судалгаа мөд гарах буй за.

ТАХИЛЫН ШАВААСНЫ БИЧЭЭС

Монгол нутагт эртний түрэгийн үед холбогдох олон арван тахилын байгууламж, цогцолбор дурсгал байдаг билээ.

Тэдгээрийн сонгодог төлөөлөл гэж болохуйц дурсгалын нэг бол Туньюкукийн гэрэлт хөшөөт цогцолбор юм.

Туньюкукийн гэрэлт хөшөө Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Баянцогт уулын баруун хойно, Налайх дүүргээс 17 орчим км-т, далайн түвшнөөс дээш 1528 м өндөрт, уртрагийн N 48T 0685770, UTM 5285348 солбилцлын цэгт оршино.

Түрэгийн хоёрдугаар хаант улсын хаан Билгэгийн хадам эцэг мэргэн сайд Туньюкук гэрэлт хөшөөний бичээст тэмдэглэсэнчилэн *“одор амар эс сууж, шонө амгалан эс унтаж, улаан цус хар хөлсөө асгаруулан байж улсыг улсын дайтай улс, төрийг төрийн дайтай болгож өнчин хүнийг өнөр, үзээгүй хүнийг баян болгосон”* их гавьяат нэгэн байсан ажээ.

Туньюкук нас дээр гарсан ч төрийн хэрэгт урьдын адил оролцон, зарим үед Билгэ хаантай санал зөрж байсан зэрэг “хоорондын зөрчил”-өөс болж “зайлуулагдан” Туул гол савд нутаглах болсон бөгөөд энэ явдалд сэтгэл дундуур үлдсэн Туньюкук Түргийн төрийн төлөө насан туршид зүтгэсэн өөрийнхөө гавьяа зүтгэлээ ард олноо таниулахын тулд гэрэлт хөшөө босгуулсан гэх санал бий.

Юугай ч амьд сэрүүн ахуйдаа гайхамшигт уран хэллэг, тансаг найруулгатай гэрэлт хөшөө босгуулсан нь төр, улсынхаа өмнө, ард түмнийхээ өмнө байгуулсан гавьяа зүтгэлээ тайлагнасан илтгэл шаштир байсан гэж хэлж болох юм.

Цэргийн нэрт зүтгэлтэн, их билигт мэргэн түүний тахилын цогцолборыг археологич Н.Сэр-Оджав нар 1957 онд малтан шинжилсэн байна.

Малтлага судалгааны явцад тахилын сүмийн хананы шаваасны хэсэг хагархай дээр эртний түрэг бичээс буйг олж илрүүлэн улмаар уг бичгийн дурсгалыг шинжлэх ухааны эргэлтэнд оруулах зорилгоор 1960 онд тусгай товхимол болгон нийтлүүлжээ. Бичгийн эл дурсгалын тодорхойлолтыг товхимолд байгаа хэвээр буулгавал *“Улаанбаатар хотоос зүүн тийш 60 орчим км зайтай газар орших эртний түүргийн Тоньюкуг сайдын булшийг 1957 онд Ш.У.Д.Б. (Шинжлэх Ухаан Дээд Боловсрол.Ц.Б) Хүрээлэнгийн Түүх Судлах Газраас эрхлэн малтсан билээ. Булшийг малтахад гарсан тахилын сүмийн хананы шаваасны хэсэг хагархай дээр эртний түүргийн хэдэн бичээс байв...Бидний олсон бичээс нь А.Н.Самойловичийн нийтлүүлсэн бичээс олдсон газраас гарсан боловч түүнийг хуурамч бичээс байж магадгүй гэж эргэлзэх нь шүүц болохыг энд дурдууштай. Бидний олсон бичээсийг анх Тоньюкугийн булшин дээр босгосон тахилын сүмийг босгож гадна талыг шавьж байхад бичсэн бололтой. Бичээс бүхий 10 ширхэг хагархай гарснаас 6 ширхэг нь нийлж 1 хэсэг, өөр хоёр нь бас нэг хэсэг болж тус тус тохирсон бөгөөд үлдсэн 2 хэсэг хагархай нь хоорондоо ба бусад шаваасны алинтай ч нийцэхгүй байна. Бичээстэй өөр шаваас олдож магадгүй гэж нарийвчлан хайсан боловч олдоогүй болно. Тэдгээр бичээс бүхий шавааснууд нь угтаа цагаан өнгөтэй байсан боловч хөрсөн доор удаан дарагдахдаа өнгө зүс үхэж халтар бор болжээ. Дээр дурдсан 6 хэсгээс бүрдсэн хамгийн том шаваас (1-дүгээр зураг) дээр 14 үсэг байна. Ихэнх үсгүүд нь тод тул хуулж буулгахад болохуйц байна. Үсгийн хэлбэр дүрс, урт богинын хэмжээ хоорондоо төсөөтэй байна. Хурц*

үзүүртэй зүйлээр хөнгөн дарж бичжээ. 2 хэсгээс тогтсон нөгөө шаваас дээр гурван (?) үсэгтэй, үсэг нь нэгдүгээр дурдсан бичээсний үсгээс арай нарийвтар голтой байна (2дугаар зураг). Гуравдугаар хэсэг дээр байгаа 2 үсэг нь тод, гурав дахь үсгийн өрөөсөн зураас үлджээ (3дугаар зураг). Бичээсийн хэлбэр дүрс нь нөгөө бичээсүүдээсээ өөр байдалтай. 4-р хэсгийн өрөөсөн захад зэрэгцээ хоёр зураасны үл мэдэг үзүүр үлдсэн байна (4-р зураг).

Бичээсийн хэлбэр дүрс харилцан адилгүй байгааг үзвэл, тахилын сүмийг барилцаж байсан нутгийн хэд хэдэн хүний бичиж үлдээсэн бичээс байж болох юм” хэмээжээ¹⁵². Ийнхүү уг бичээсийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулснаас хойш тухайлан судлаагүй байсаар 1979 онд С.Харжаубай анх тайлан уншсан байна.

Түүний уншлага мадагтай, ташаа болсныг тэмдэглэх хэрэгтэй. Алдаа ташаарлын шалтгаан нь доорхи хэдэн зүйлээс үүдэлтэй бололтой юм. Үүнд:

-Бичээсийг “угаас эвлэх боломжгүй дөрвөн хэсгээс бүрдэж буйг” археологичид цохон тэмдэглэж, гэрэл зургийн хамт хэвлэн нийтлүүлсээр атал нэг мөр болгон уншжээ.

-Гуравдугаар хагархай дээрх (3-р зураг) хоёр бүтэн, нэг хагас тэмдэгтийг нэгдүгээр хагархайн эхэнд тавьж, зурагт хагас тэмдэглэгдсэн үсэг зурлагыг “l- s” хэмээн сэргээсэн байна.

-Нэгдүгээр хагархай дээрх бичээсийн зүүн дээд талд байгаа $\text{A}(\text{?})$ тэмдэгтийг орхисон ажээ.

-Мөн нэгдүгээр хагархай дээрх бичээсийн $\text{A}(\text{?})$ тэмдэгтийг оруулбал долоо дахь “↓ оq” үсэг тэмдэгт “оq, uq, qo, qu” гэж амилдаг. “qa- qačit” гэж галигласан нь ядаж руни үсэг, тэмдэгтийн зөв амилуулах, зөв уншихзүйг ч эс анхаарчээ.

-Хоёрдугаар хагархай дээрх бичээсийн (2-р зураг) хоёр хэсэг тодорхой бөгөөд босоо, хагас зураасан зурлага тод боловч чухам ямар үсэг тэмдэгт болох нь мэдэгдэхгүй байгаа. Гэтэл хоёрдугаар хэлтэрхий дээрх бичээсийн эдгээр үсэг тэмдэгтийг огт оруулаагүй байна (2-р зураг үзнэ үү) .

С.Харжаубайн хэвлүүлсэн өгүүллийн галиг;

Ögü esit qumīd, qačit adīratamīz

Орчуулга;

Ухааран сонс, Уйтгарлагчид! Хөөн зайлуулж устгана бид

Тэрээр “Насан турш нанхиадын эсрэг тэмцэж байсан Түрэгийн мэргэн сайд Тоньюкукын цогцсыг гашуудан, уйтгарлан байж хөдөөлүүлсэн зон олныг тайтгаруулж хэлсэн эл ганц мөр бол тахилган сүмний шавардлагыг хийж байсан жирийн нэг хүний сэтгэлийн үг гэж үзэж хятадын эсрэг өгүүлсэн бичээс болохын хамт эртний түрэг бичээсийг өргөн ашиглаж байсныг нотлох гэрч гэж хэлж болох байна” хэмээн дүгнэжээ¹⁵³ .

Доктор Л.Болд өөрийн бүтээлдээ тахилын шаваасын бичээс гэсэнгүй, харин “Тоньюкуийн II бичээс” нэртэйгээр С.Харжаубайн уншлагыг оруулжээ. Галигийг

¹⁵² Н.Сэр-Оджав, Шинэ олдсон түүрэг бичээсийн тухай, - Studia Archaeologica, Tom. I, fasc. 7, Улаанбаатар, 1960, 3-4 дүгээр тал.

¹⁵³ С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Археологийн судлал, Tom. VII, fasc. 10-18, Улаанбаатар, 1979, 33 дугаар тал.

гэжээ. Уул үгийн утгыг улам лавтай болог хэмээж нуршихийн, хам олон өгүүлбэртэй жишээ татав.

HL -učti (učti) (халих, нисэх) халин одов, нисэн одов гэх утгатай.

Эртний түрэгүүд нас барсныг халин одов, нисэн одов хэмээн тэмдэглэсэн нь руни бичгийн сурвалжуудаас тодорхой мэдэж болно. Түүнээс гадна оршуулгын зан үйл, тахил тайлгын байгууламжид ч шувуу дүрсэлсэн нь бий.

Тухайлбал, Хөл Асгатын дурсгалын тахилын хавтанд гурван хүн дүрслээд баруун гар талд нилээд дээд талд судлаачид “Ашина овгийн тамга” гэж үздэг янгир, түүний дээр шувуу дүрсэлсэн байдаг. Бидний санахад уг шувуу дурсгалд нэр гарч буй Алтан Тамган Тарханы овгийн сүлд, сүлдэр бололтой юм.

Билгэ хааны тахилын онгоноос гарсан алтан титэм дээрх шувуу, Келтигийн чулуун хөшөөний малгай дээрх шувуутай ижил байсан нь санамсаргүй хэрэг огт биш, тэдний язгуур гарал, тотем шувууны дүрс байхыг үгүйсгэх аргагүй билээ.

Нас барсан хүний сүнс овог, аймгаа хамгаалан харж байдаг тул Хаад ихэс болон их хүний сүнс онгон болдог гэх бөгөөд тэр онго сүлд нь овгийн сүлд сүлдэр болдог байсан бололтой. Тэгээд ч түрэгийн оршуулгын зан үйлд шувуу дүрслэх нь элбэг байсан буй за.

Монголчууд ч гэсэн мөн адил халин одов, нисэн одов гэж өгүүлэх нь бий. Жишээ нь, Чингис хааныг нас барахад

Хангинах тэргэний тээш болон одов

Харцгай шувууны жигүүр болон одов хэмээн монгол бичгийн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Ер эртний нүүдэлчдийн хувьд шувуу нь сүнс, сүлдэрийн бэлгэдэл байсан гэж хэлж болно

Ч –ada- хагац, сал, -t-хагацаа, салга, **Ч** **ᠴ** **ᠴ** adartimiz хэмээвэл хагацаав бид, салгав бид гэсэн утгатай болно. **Ч** –miz нь нэгдүгээр биеийн олон тооны нөхцөл.

Монгол хэлний адар (ada ) , адайр (adayir ) , адайрах гэх үгст уул үгийн язгуур хадгалагдаж буй мэт. Хагацаж салах болсны цаад шалтгаан нь адайр байдал, зангаас үүдэлтэй болохыг өгүүлэх юун.

Эртний түрэг хэлний толинд ад, ада (ad, ada) хэмээх үг “бедствие, опасность, несчастье”¹⁵⁵ гэсэн утгатай болохыг тэмдэглэжээ.

НЧ arqa –г биеэ даасан үг гэж үзвэл монгол түрэг хэлний дундын шинжтэй ар, ар тал, ард, хойно гэх утгатай нь үнэн. Өөр үгийн эхний хоёр үсэг үлджээ гэж үзэх бас нэг санаа, хувилбар байж болох юм. Харин түүнийг баталсан тохиолдолд “arqa” хэмээх уншлага худлаа болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Бидний гарт үлдсэн эх хэрэглэгдэхүүнд байгаагаар нь уншвал “arqa” гэхээс өөрөөр унших гарцгүй болно.

Нийтлүүлсэн эх мадаггүй боловч 2-р зурагт буй хэлтэрхий дээрх бичээсийн толгой хөлийг хэрхэн олж тогтоосон, тэр нь хэр баттай, зөв байгааг хэлэхэд хэцүү. Хэлтэрхийг тонгоруулж бичээсийг огт өөрөөр уншиж болно. **НЧ** бичээст хэлтэрхийг тонгоруулбал **Н** болох бөгөөд *öt /s?/ -üt /s? / (?), ötä* гэх язгуурт үг, бас үгийн төгсгөл хоёр үсэг байх боломжтой. Юутай ч бид тонгоруулан уншсан хувилбарыг ч хамтатгав.


¹⁵⁵ Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.7.


Н€ ög – üg, ögü- ügü язгуурт үг эртний түрэгийн бичгийн дурсгалуудын үгийн санд олон утгатай ч “ухаар, ухааран” гэх үг байх магадлал ихтэй.


Түрэг улсыг мандан хүчирхэгжихэд ихээхэн үүрэг гүйцэтгэж, хүчин зүтгэсэн, хаадын зөвлөх, мэргэн сайд Туньокукийг нас барахад хойллого үйлдэн тахилын сүм байгуулж язгууртан дээдсийн ёсоор оршуулснаас үзвэл эл бичээс “тахилын сүмийг барилцаж байсан нутгийн хэдэн хүний бичиж үлдээсэн бичээс”¹⁵⁶ биш “тахилын сүмийн шавардлагыг хийж байсан жирийн нэгэн хүний сэтгэлийн үг”¹⁵⁷ ч бус түүний хүргэн Билгэ хааны болон төрийн ихсээс бичүүлсэн бичиг болох нь эргэлзээгүй.


Бичээст гарах үгийн толь

ᠠ (?)eb - ger, гэр

↓ᠡᠭᠦᠨᠠᠳᠤᠸᠠᠨ toq umaduq-  çadqulang bayiysan ügei, цатгалан (амар амгалан) байсангүй (суусангүй)

ᠬᠤᠯᠢᠪᠠ üçdi (üçdi)-  qaliba, nisbe, халив, нисэв (нисэн одов тэр)

ᠴᠢᠳᠠᠴᠠᠪᠠ adirtimiz-  qaγačaba bide, хагацав (хагацаав, салгав) бид

ᠠᠷᠠᠭᠠ arqa [ötü-(s?) -üt (s?); ötä]-  aruda, aru tal-a, ард, ар талд

Н € ögü-  uqayara, ухаар

¹⁵⁶ Н.Сэр-Оджав, Шинэ олдсон түүрэг бичээсийн тухай, -Studia Archaeologica, Tom.1, fasc.7, Улаанбаатар, 1960, 24 дугаар тал.

¹⁵⁷ С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Археологийн судлал, ТомYII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 33 дугаар тал.

ТЭВШИЙН БИЧЭЭС

Судалгааны ном зохиолд “Тэвшийн түрэг бичээс” гэж нэрлэгдсэн, багахан чулуун дээрх бичээсийг анх 1949 онд Оросын эрдэмтэн А.Н.Окладниковын удирдсан хээрийн шинжилгээний анги олж илрүүлжээ. Б.Ринчен академич 1968 онд бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлснээр¹⁵⁸ эл бичээсийн талаар анхны бодит мэдээ шинжлэх ухааны эргэлтэд орсон байна. Археологич Н.Сэр-Оджав уг бичигт чулууг Улаанбаатар хотод авчирсан бөгөөд эдүгээ ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа билээ.

Н.Сэр-Оджав гуай Тэвшийн бичээсийн анх оршиж байсан газрынх нь тухай “Өвөрхангай аймгийн Богд (хуучнаар Ховд) сумын төвөөс 20 орчим км-ын зайд орших Тэвш гэдэг баруун зүүн тийш хөндөлдсөн хавтгай нурууны өвөрт байсан”¹⁵⁹ гэж тэмдэглэжээ. Тэвшийн бичээс хэмээн нэрлэгдсэн энэ дурсгал нь хоёр мөр бичээс, нэг тамганаас бүрдэх ба 54 x 42 см хэмжээтэй бор хүрэн өнгөтэй чулуунаа сийлэгджээ. Уг бичээсийн нэгдүгээр мөр 32 см, хоёрдугаар мөр 14 см орчим урт, тамганы өндөр 16 см, өргөн нь 16,5 см юм. Нэгдүгээр мөр бичээс 23, хоёрдугаар мөр бичээс 10 үсэг тэмдэгтээс бүрдэж байна. Хадны зурагт нийтлэг тохиолдох хонхойлгон цохиж цоолборлох аргаар зурсан, хүний зураг байх бөгөөд 13,5 см өндөр, 7 см өргөн юм.

Тэвшийн бичээс олон жилийн турш ШУА-ийн Түүхийн хүрээлэн, эдүгээ Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа хэдий ч төдий л сайн судлагдаагүй нь зураасан бичигтэй, үсэг тэмдэгт бүдгэрч харагдахуйяа бэрх болсон, хэмжээний хувьд бага зэргээс шалтгаалсан бололтой.

Анх түрэг судлаач В.М.Наделяев 1974 онд уул бичээсийн зөвхөн эхний мөрийг “Тугчы бургучы Ягыз-чурын тамга” гэж уншаад орос орчуулгын хамт хэвлүүлжээ. Тэрбээр уг чулуунаа бүхүй тамгыг Ягызчурын овгийн тамга гэж үзсэн байна¹⁶⁰.

Хоёрдугаар мөрийн бичээс маш нарийхан сийлэгдсэнээс гадна олон жилийн нар салхинд идэгдэн ихэд бүдгэрсэн тул тодруулах, томруулах багажийн тусламжтайгаар үзэж уншихаас өөр аргагүй юм. Тийм ч учраас энэ мөрийг тэр бүр судалсангүй, орхигдуулсаар иржээ.

С.Харжаубай 1979 онд уул дурсгалыг дахин судлан нийтлүүлэхдээ хоёрдугаар мөрийн бичээсийг анх удаа галиглан орчуулсан байна¹⁶¹.

Гэхдээ нэгдүгээр мөрийн зарим нэгэн үсэг тэмдэгтийг буруу ташаа буулгасан, хоёрдугаар мөрийн зарим үсэг тэмдэгтийг орхисон зэргээс үүдэн уншлага, орчуулга ташаа мадагтай болсон ажээ.

Тэрбээр бичээсийг

¹⁵⁸ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, - Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI, fasc I, Улаанбаатар (Oulan bator), 1968, 43 дугаар тал.

¹⁵⁹ Н.Сэр-Оджав, Монголын эртний түүх. Улаанбаатар, 1977, 141 дүгээр тал.

¹⁶⁰ М.Н.Наделяев, Древнетюркская надпись из Ховд сомона МНР, -Бронзовой и железный век Сибири, Ленинград, 1974, стр.136-150.

¹⁶¹ С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18. Улаанбаатар, 1979, 32-35 дугаар тал.

1. Тууцйи урагаацйи Яауыз- ёур туу ётйи

2. тууцйи бу... гэж үгчлэн галиглаад монгол хэлнээ

1. хэнгэрэгч минь, уриач /дуудагч/ Ягыз-чур хэнгэрэгээ дуугарган /хангинуулан/...

2. Хэнгэрэгч энэ¹⁶²... хэмээн орчуулсан байна.

С.Харжаубайн судалгаанаас үзвэл бичээсийн нэгдүгээр мөрийн тууцйи хэмээх үгнээ “m” нэмж бургаацйи гэх үгийг урагаацйи гэж уншсан байна. Түүнчлэн туурауи хэмээхийг -туу ётйи гэж илтэд ташаа буулгажээ.

Дурсгалын эх бичээсийг үзэхэд цагаан өнгийн бэх(?) -ээр “ ǀ ǀ ” үсгийг “ǀ ǀ ǀ ” үсэг тэмдэгттэй хамтатган нийлүүлж зураад “ ü ” болгосон нь илэрхий байх юм.

Л.Болд доктор 1990 онд хэвлүүлсэн бүтээлдээ С.Харжаубайн судалгааг дурдаад В.М.Наделяевын уншлагыг монгол хэлнээ орчуулан нийтлүүлсэн¹⁶³ бөгөөд “Орхон бичгийн дурсгалууд II” бүтээлдээ мөн судалгааны галигийг хэвээр нь авч монгол хэлнээ орчуулсан авч хоёрдугаар мөрийн талаар юу ч дурдсангүй ажээ¹⁶⁴.

Л.Болд гуай бичээсийг “тууцйи бургуцйи яауыз ёур туурауи” гэж галиглан “тугч, бүрээч Ягыз-чур (хаан)-ны тамга” хэмээн монгол хэлнээ орчуулжээ.

Тэвшийн бичээсийн дээр дурдсан мэт уншлага судалгааны зарим алдаа мадгийг залруулах, хоёрдугаар мөрийг гүйцэд уншиж тайлах зорилгоор бид дахин нягтлан судалсан юм. Судалгааны үр дүнг толилуулбал;

Эх бичээсийн эхийн сийрүүлгэ;

ᠮᠣᠣᠴᠢᠢᠨᠠᠷᠠᠭᠠᠴᠢᠨᠶᠠᠭᠢᠵᠢᠴᠢᠨᠲᠤᠷᠲᠤᠷᠠᠭᠠᠢ 1

[ᠮᠣᠣ]ᠴᠢᠢᠨᠠᠷᠠᠭᠠᠴᠢᠨᠶᠠᠭᠢᠵᠢᠴᠢᠨᠲᠤᠷᠲᠤᠷᠠᠭᠠᠢ 2

Үсгийн галиг;

1. T W G ёi B W R G ёi Y G z ё W R T W G R G i

2. T W G ёi B Wbaš sd [ti]

Үгийн галиг;

1. тууцйи бургуцйи яауыз ёур туурауи

2. тууцйи бу баš esid [ti]

Орчуулга;

1. Тугч бүрээч Ягыз чурын дохио [тамга?] нь

2. Тугч үүнийг эхлэн сонсго [лоо]

¹⁶² С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Studia Archaeologica, Tom.VII, fasc.10-18. Улаанбаатар, 1979, 33 дугаар тал.

¹⁶³ Л.Болд, Тэвшийн бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар, 1990, 110-112 дугаар тал.

¹⁶⁴ Л.Болд, Тэвшийн Орхон бичээс, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 237-241 дүгээр тал.

Бичээст гарах үгийн толь

ᠲᠠᠭᠦᠰᠢ tугүй -  tугүй, тугч

ᠪᠦᠷᠢᠭᠡᠰᠢ burγuᠰi -  бүрээч


ᠶᠠᠭᠢᠵᠢ yaγiz -  Ягыз (хүний нэр)

ᠴᠢᠷ čur -  чур /цол/

ᠲᠤᠮᠳᠡᠭ tamdag -  тамга

ᠲᠢ ti -

ᠪᠤ bu -  ene, энэ

ᠪᠠᠰᠢ baš -  1. толгой, тэргүүн, 2. тэргүүлэн, түрүүлэн, эхлэн

[ᠲᠢ] esid [ti]

esid -  - sonus

e.- ti- sonus [-qaluγ-a] сонсго [лоо]

ХАНАНГИЙН БУУЦНЫ БИЧЭЭС

Археологийн судалгаа

